

**АВТОТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ
ТУХАЙ
ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ ХЭЛЭЛЦЭЭР
БОЛОН КОНВЕНЦИ**

НЭГ. АВТОТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХОЁР ТАЛЫН ГЭРЭЭ, ХЭЛЭЛЦЭЭР

1. Авто тээврээр олон улсын зорчигчид, ачаа тээвэрлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1993.10.22
2. Олон улсын авто тээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн Засгийн газар, Украин Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1995.06.27
3. Олон улсын авто тээврийн харилцааны тухай Оросын Холбооны Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /1996.02.07
4. Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2002.06.02
5. Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2003.12.10/
6. Олон улсын автотээврийн харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр /2004.03.01/
7. Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын автотээврийн хэлэлцээр /2011.06.16/

ГУРАВ. ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИ

1. Замын хөдөлгөөний тухай Конвенци /1968.11.08/

Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл

Хоёрдугаар бүлэг. Замын тэмдгүүд

Гуравдугаар бүлэг. Автомашин ба чиргүүлийг олон улсын Хөдөлгөөнд оролцуулах нөхцөл

Дөрөвдүгээр бүлэг. Автомашины жолооч

Тавдугаар бүлэг. Унадаг дугуй ба мопедыг олон улсын Хөдөлгөөнд оролцуулах нөхцөл

Зургадугаар бүлэг. Төгсгөлийн заалтууд

Хавсралтууд

2. ТИР карнейн хүрээнд барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх тухай конвенци /1975.11.14/

Нэгдүгээр бүлэг. Ерөнхий зүйл

Хоёрдугаар бүлэг. ТИР карнейг олгох баталгаа гаргагч холбоодын
Хүлээх хариуцлага
Гуравдугаар бүлэг. ТИР карней ашиглан барааг тээвэрлэх
Дөрөвдүгээр бүлэг. Конвенцийн заалтыг зөрчих
Тавдугаар бүлэг
Зургадугаар бүлэг. Бусад заалтууд
Долдугаар бүлэг. Төгсгөлийн заалтууд
Хавсралтууд

АВТО ТЭЭВРЭЭР ОЛОН УЛСЫН ЗОРЧИГЧИД, АЧАА ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ КАЗАХСТАН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэж нэрлэнэ/, олон талын харилцан ашигтай харилцааны тааламжтай хөгжлийг анхааралдаа авч,

хоёр орны хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх авто тээврийн харилцааг цаашид хөгжүүлэх эрмэлзлийг удирдлага болгон, дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу хоёр орны хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх зорчигчид /жуулчдыг оролцуулан/, ачааны байнгын болон байнгын бус тээвэрлэлтийг улс хоорондын авто тээврийн харилцааны зориулалтаар нээгдсэн замаар, Монгол Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсад бүртгэлтэй авто тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

I. ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

1.Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын хооронд тохиролцсоны дагуу автобусаар зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохион байгуулна.

2.Зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохион байгуулах тухай саналыг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд бие биедээ урьдчилан өгнө.

Энэ саналд тээвэрлэгчийн нэр, аялалын замнал, хөдөлгөөний цагийн хуваарь, тээврийн хөлс, зорчигчдыг буулгах, суулгах буудал зогсоол, түүнчлэн тээвэрлэлтийг гүйцэтгэх хугацаа, давтамжийн талаарх мэдээлэл агуулагдсан байна.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1.Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийг автобусаар гүйцэтгэхэд энэхүү хэлэлцээрийн 4 дүгээр

зүйлд зааснаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлийг авна.

2.Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд өөрийн нутгаар дайрч өнгөрөх замын тэр хэсэгт зөвшөөрөл олгоно.

3.Хэрэв энэ зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол зорчигчдын байнгын бус тээвэрлэлт автобусаар хийхэд ирэх, очих нэг аялал хийх эрхийн зөвшөөрөл өгнө.

4. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичгийг харилцан тохиролцсон тоогоор жил бүр бие биендээ өгнө. Энэхүү зөвшөөрлийн бичиг нь зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын тамга, тэмдэг, хариуцлагатны гарын үсэгтэй байна.

5.Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд зөвшөөрлийн бичгийг солилцох журмыг өөр хоорондоо тохиролцоно.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Эвдэрсэн автобусыг өөр автобусаар солиход энэхүү Хэлэлцээрийн 3 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг шаардахгүй.

II. АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ

ТАВДУГААР ЗҮЙЛ

1 .Хэлэлцэн тохирогч Талуудан эрх бүхий байгууллагуудын өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр ачааны чиргүүлтэй буюу чиргүүлгүй автомашин, хагас чиргүүлтэй зүтгүүрээр энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

2.Хэрэв энэ зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол ачааны тээвэрлэлт хийхэд очих, ирэх нэг аялал хийх эрхийн зөвшөөрөл өгнө.

3.Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь ачаа тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичгийг харилцан тохиролцсон тоогоор жил бүр бие биедээ өгнө. Энэхүү зөвшөөрлийн бичиг нь зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын тамга, тэмдэг, хариуцлагатны гарын үсэгтэй байна.

4 .Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд зөвшөөрлийн бичгийг солилцох журмыг өөр хоорондоо тохиролцоно.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

1.Энэхүү Хэлэлцээрийн 5 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг дараах тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардахгүй:

а/ Үзэсгэлэн, яармагийн зориулалттай үзмэр, тоног төхөөрөмж, материал;

б/ Биеийн тамирын арга хэмжээг явуулахад зориулагдсан тээврийн хэрэгсэл, амьтан, тэрчлэн төрөл бүрийн хэрэгсэл, эд юмс;

в/ Театрын засал чимэглэл, хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, кино зураг авах болон радио, телевизийн нэвтрүүлэг хийхэд зориулагдсан тоног төхөөрөмж, эд юмс;

г/ Нас барагчийн чандруу, шарил;

д/ Шуудан;

е/ Эвдрэл гэмтэлтэй авто тээврийн хэрэгсэл;

ж/ Нүүж байгаа айлын эд хогшил;

з/ Энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйлийн дагуу тээвэрлэх тусгай зөвшөөрөл авсан ачаа;

и/ Байгалийн гамшиг тохиолдсон үед тусламж үзүүлэхэд зориулагдсан эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хэрэгсэл.

Тэрчлэн техникийн тусламжийн автомашин явахад зөвшөөрөл шаардахгүй.

Энэхүү зүйлд заасан тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа авто тээврийн хэрэгсэл нь бүртгэгдсэн орныхоо тээвэрлэлтийн баримт бичигтэй байна.

2.Энэ зүйлийн 1-ийн а,б,в-д тусгагдсан заалтууд нь зөвхөн тухайн ачааг авто тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн оронд буцааж авчрах буюу гуравдагч орны нутгаар тээвэрлэх тохиолдолд хүчинтэй байна.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

1.Хэрэв ачаатай буюу ачаагүй яваа авто тээвийн хэрэгслийн овор болон жин нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр тогтоосон нормоос хэтэрсэн, мөн түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагуудын тусгай зөвшөөрлийг авна.

2.Хэрэв энэ зүйлийн 1-д дурдсан зөвшөөрөлд авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тодорхой чиглэлээр явахаар тогтоосон бол тээвэрлэлтийг зөвхөн энэ чиглэлээр гүйцэтгэнэ.

III. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

НАЙМДУГААР ЗҮЙЛ

1.Тээвэрлэгчид Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр орших хоёр цэгийн хооронд зорчигч болон ачаа тээвэрлэхийг зөвшөөрөхгүй.

2.Хэрэв тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутгаас гуравдагч орны нутагт, мөн түүнчлэн гуравдагч орны нутгаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт тээвэрлэлт хийж болно.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

1.Энэхүү хэлэлцээрт заасан тээвэрлэлтийг тухайн орны дотоодын хууль тогтоомжийн дагуу олон улсын тээвэрлэлт хийхээр зөвшөөрөгдсөн тээвэрлэгч гүйцэтгэнэ.

2.Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх авто тээврийн хэрэгсэл нь өөрийн улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байна.

АРВДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд, түүнчлэн тэдгээрийн нутгаар дамжуулан Талуудын дотоодын хууль тогтоомжоор хориглосон зэр зэвсэг, сум хэрэгсэл, байлдааны тоног төхөөрөмж, тэсрэх бодис, бусад аюултай ба хортой ачааг тээвэрлэхийг хориглоно.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан ачааны тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ олон улсын хэмжээнд нийтлэг мөрдөж байгаа загварт нийцсэн дагалдах хуудсыг хэрэглэнэ.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

1 .Тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгсэл жолоодох ангилалд тохирсон үндэсний болон олон улсын жолоочийн үнэмлэх, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн баримт бичигтэй байна.

2.Зөвшөөрлийн болон бусад баримт бичиг нь энэхүү Хэлэлцээрийн заалтад нийцсэн байх бөгөөд түүнийг автомашиндаа авч яван хяналт шалгалтын

эрх бүхий байгууллагуудын шаардлагаар үзүүлж байна.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу ачаа болон зорчигчдын тээвэрлэлттэй холбогдож гарсан практик асуудлуудыг Хэлэлцэн тохирогч Талуудын тээвэрлэгчид хоорондоо шууд зохицуулж болно.

Энэ зорилгоор тээвэрлэгчид нь хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлөөр өөрийн төлөөлөгчийн газрыг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт нээн ажиллуулж болно.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх улс хоорондын зорчигчид болон тээшийн тарифыг Хэлэлцэн тохирогч Талуудан эрх бүхий байгууллагууд тохиролцоно.

Тээврийн үнэ хөлсний тооцоог Засгийн газар хоорондын төлбөрийн хэлэлцээр болон хоёр Талын үндэсний банк хоорондын хэлэлцээрийн дагуу хийнэ.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

ЭНЭХҮҮ Хэлэлцээрийн үндсэн дээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутгаар, Хэлэлцэн тохирогч аль нэг Талын тээвэрлэгчийн гүйцэтгэх зорчигчид, ачааны тээвэрлэлт, түүнчлэн энэ тээвэрлэлтийг хийж байгаа авто тээврийн хэрэгсэл нь энэ хэлэлцээрт заасны дагуу зөвшөөрөл олгох болон замын ашиглалт, арчлалт, авто тээврийн хэрэгслийн эзэмшилт ба ашиглалттай холбогдсон татвар хураамж, мөн тэрчлэн тээвэрлэлтээс олох орлого ашгийн татвар хураамжаас чөлөөлөгдөнө.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Энэ тээвэрлэлтийг гүйцэтгэх авто тээврийн хэрэгсэл бүрийг иргэний хариуцлагын даатгалд урьдчилан заавал даатгуулсан нөхцөлд энэхүү хэлэлцээрийг үндэслэн тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Хилийн байцаан өнгөрүүлэх, гаалийн болон хорио цээрийн шалгалтад Хэлэлцэн тохирогч хоёр Талын оролцсон олон талын болон хоёр талын олон улсын гэрээ, хэлэлцээрийг мөрдөх бөгөөд харин эдгээр гэрээ, хэлэлцээрээр зохицуулагдахгүй асуудлыг шийдвэрлэхдээ Хэлэлцэн тохирогч Тал бүрийн дотоодын хууль тог- тоомжийг мөрдөнө.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Зорчигчдын байнгын тээвэрлэлт, хүнд өвчтөн, мал амьтан, түргэн муудах ачааны тээвэрлэлтийг гүйцэтгэхэд хилийн байцаан өнгөрүүлэх, гаалийн болон хурио цээрийн шалгалтыг ээлж дугааргүйгээр хийнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

1 .Энэхүү Хэлэлцээрийг үндэслэн тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг руу тээвэрлэж яваа доорх зүйлийг гаалийн татвар хураамж, зөвшөөрлөөс харилцан чөлөөлнө:

- а) тухайн загварын авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тэжээлийн системтэй технологийн болон зохион бүтцийн талаар холбоо бүхий түлшний саванд байгаа шатахуун;
- б) тээвэрлэлтийн явцад зайлшгүй хэрэглэгдэх хэмжээний тосолгооны материал;

в/ олон улсын тээвэр хийж байгаа авто тээврийн хэрэгслийн засварт зориулагдсан сэлбэг, багаж хэрэгсэл.

2. Хэрэглээгүй сэлбэгийг эргүүлэн тээвэрлэнэ. Харин солигдсон хуучин сэлбэгийг тухайн улсаас авч буцах, эсвэл Хэлэлцэн тохирогч Талын нутаг дээр тогтоогдсон журмын дагуу устгах буюу тушаана.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү хэлэлцээрийн дагуу тээвэр хийх үйл ажиллагааг хөнгөвчилсэн бүхий л арга хэмжээг авч байна.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү хэлэлцээрийг зөрчсөн тохиолдолд тээвэрлэгч орны эрх бүхий байгууллага нь зөрчил илрүүлсэн орны эрх бүхий байгууллагын хүсэлтээр энэхүү хэлэлцээрийн биелэлтийг хангахад шаардагдах арга хэмжээ авна.

Тээвэрлэгч орны эрх бүхий байгууллага авсан арга хэмжээнийхээ тухай нөгөө орны эрх бүхий байгууллагад мэдээлнэ.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү хэлэлцээрийн биелэлтийг хангах зорилгоор Хэлэлцэн тохирогч

Талуудын эрх бүхий байгууллагууд нь шууд холбоо тогтоож, Хэлэлцэн тохирогч аль нэг Талын саналаар зорчигчид, ачаа тээвэрлэлтийн зөвшөөрөл олгох системтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэх зорилгоор зөвлөлгөөн хийх, түүнчлэн олгогдсон зөвшөөрлийг ашиглаж байгаа талаар туршлага, мэдээллийг солилцоно.

IV.ТӨГСГӨЛИЙН ХЭСЭГ

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрээр болон Хэлэлцэн тохирогч хоёр Талын оролцсон олон талын ба хоёр талын олон улсын гэрээ, хэлэлцээрээр зохицуулагдахгүй асуудлыг Хэлэлцэн тохирогч Тал бүрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, мөрдөх явцад гарч болох маргаантай бүх асуудлыг хэлэлцэх болон зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын байгуулсан олон улсын бусад гэрээгээр хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.

ХОРИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

1 .Тухайн орнуудад хэлэлцээрийг хүчинтэй болгоход шаардагдах хууль зүйн үйлдлийг гүйцэтгэсэн тухай Хэлэлцэн тохирогч Талууд бие биедээ дипломат шугамаар мэдэгдсэн өдрөөс эхлэн энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болно.

2. Хэлэлцээрт хавсаргасан гүйцэтгэх протокол болон нэмэлт протокол нь хэлэлцээрийн салшгүй хэсэг болно.

3.ЭНЭХҮҮ Хэлэлцээрийг тодорхой хугацаагүй байгуулсан бөгөөд Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талдаа Хэлэлцээрийг хүчингүй болгох саналаа мэдэгдсэн өдрөөс хойш 90 хоногийн туршид хүчинтэй байна.


ЭНЭХҮҮ Хэлэлцээрийг 1993 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хотноо монгол, казах хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх

бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

МОНГОЛ УЛСЫН
КАЗАСТАН УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫН ӨМНӨӨС
ӨМНӨӨС

БҮГД НАЙРАМДАХ
ЗАСГИЙН ГАЗРЫН

ГАЗРЫН ӨМНӨӨС



ОЛОН УЛСЫН АВТО ТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, УКРАИН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол улсын Засгийн газар болон Украин улсын Засгийн газар /цаашид "Хэлэлцэн тохирогч Талууд" гэж нэрлэнэ/,

Хоёр талын худалдаа-эдийн засгийн харилцааны тааламжтай хөгжлийг анхааралдаа авч,

Хоёр орны хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх авто тээврийн харилцааг цаашид хөгжүүлэх эрмэлзлэлийг удирдлага болгон,

дор дурдсан зүйлийг Хэлэлцэн тохиров.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу авто тээврээр гүйцэтгэх хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх зорчигчид, ачааны байнгын болон байнгын бус тээвэрлэлтийг олон улсын авто тээврийн харилцааны зориулалтаар нээгдсэн замаар хийнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан нэр томъёо нь дараах утгыг илэрхийлнэ.

1."Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд":

Монголын улсын талаас - Монгол улсын Дэд бүтцийн хөгжлийн яам
Украин улсын талаас - Украин улсын Тээврийн яам.

2."Тээврийн хэрэгсэл":

ачаа тээвэрлэлтэд - ачааны автомашин, чиргүүлтэй ачааны автомашин, авто зүтгүүр буюу хагас чиргүүлтэй авто зүтгүүр;

зорчигч тээвэрлэлтэд - автобус, өөрөөр хэлбэл жолоочийн суудлаас гадна наймаас доошгүй суудалтай зорчигч тээвэрлэх зориулалт бүхий авто тээврийн хэрэгсэл, түүнчлэн тээш тээвэрлэх чиргүүл.

3."Байнгын тээвэрлэлт" гэж Хэлэлцэн тохирогч Талуудын урьдчилан тохирсон хөдөлгөөний цагийн хуваарь, эхний болон эцсийн буудал, зогсоолуудыг заасан аялалын замналын дагуу авто тээврийн хэрэгслээр гүйцэтгэх тээвэрлэлтийг хэлнэ.

4."Байнгын бус тээвэрлэлт" гэж бусад бүх тээвэрлэлтийг хэлнэ.

5. "Дамжин өнгөрөх тээвэрлэлт" гэж Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг Талын нутаг дэвсгэрээр дамжуулан гуравдагч улсад гүйцэтгэх тээвэрлэлтийг хэлнэ.

6."Гуравдагч улс" гэж энэхүү Хэлэлцээрт оролцоогүй улсыг хэлнэ.

I. ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын хооронд тохиролцсоны дагуу автобусаар зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохих зөвшөөрлийг үндэслэн зохион байгуулна.

2.Зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохион байгуулах тухай саналыг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд бие биедээ урьдчилан өгнө. Энэ саналд тээвэрлэгчийн нэр, аялалын замнал, хөдөлгөөний цагийн хуваарь, тээврийн хөлс, зорчигчдыг буулгаж суулгах буудал зогсоол, түүнчлэн тээвэрлэлтийг гүйцэтгэх хугацаа давтамжийн талаарх мэдээллийг заавал тусгасан байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1.Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийг автобусаар гүйцэтгэхэд энэхүү Хэлэлцээрийн тавдугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авна.

2.Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллага өөрийн улсын нутгаар дайрч өнгөрөх замын тэр л хэсэгт зөвшөөрөл олгоно.

3.Хэрэв энэ зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол зорчигчдын байнгын бус тээвэрлэлт автобусаар гүйцэтгэхэд ирэх, очих нэг аялал хийх эрхийн зөвшөөрөл өгнө.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Эвдэрсэн автобусыг өөр автобусаар солиход энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлд заасан зөвшөөрөл шаардагдахгүй.

II.АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

1.Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр чиргүүлтэй буюу чиргүүлгүй ачааны автомашин, хагас чиргүүлтэй зүтгүүрээр энэхүү Хэлэлцээрийн долдугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

2.Хэрэв энэ зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол ачаа тээвэрлэлт хийхэд очих, ирэх нэг л аялал хийх эрхийн зөвшөөрөл олгогдоно.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

1.Энэхүү Хэлэлцээрийн зургадугаар зүйлд заасан зөвшөөрлийг дараах тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардахгүй.

а/ үзэсгэлэн, яармагийн зориулалттай үзмэр, тоног төхөөрөмж материал;

б/ биеийн тамирын арга хэмжээ явуулахад зориулагдсан тээврийн хэрэгсэл, амьтан тэрчлэн төрөл бүрийн хэрэгсэл, эд юмс;

в/ театрын засал чимэглэл, хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, кино зураг авах болон радио телевизийн нэвтрүүлэг хийх зориулалтын тоног төхөөрөмж, эд юмс;

г/ нас барагчийн чандруу, шарил;

д/ шуудан;

е/ эвдрэл гэмтэлтэй авто тээврийн хэрэгсэл;

ж/ нүүж байгаа айлын эд хогшил;

з/ байгалийн гамшиг тохиолдсон үед тусламж үзүүлэхэд зориулагдсан эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хэрэгсэл.

Тэрчлэн техникийн тусламжийн автомашин явахад зөвшөөрөл шаардахгүй.

2.Энэ зүйлийн 1-ийн "а","б","в"-д тусгагдсан заалтууд нь зөвхөн тухайн ачааг авто тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн оронд буцааж авчрах буюу гуравдагч орны нутгаар дамжуулж тээвэрлэх тохиолдолд хүчинтэй байна.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

1.Хэрэв ачаатай буюу ачаагүй яваа авто тээврийн хэрэгслийн овор хэмжээ болон жин нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр тогтоосон нормоос хэтэрсэн, мөн түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлийг авна.

2.Хэрэв энэ зүйлийн 1-д дурдсан зөвшөөрөлд авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тодорхой замналаар явахаар тогтоосон бол тээвэрлэлтийг зөвхөн энэхүү замналаар гүйцэтгэнэ.

III.ЕРӨНХИЙ ХЭСЭГ

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

I .Хэлэлцэн. тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийн болон ачаа тээвэрлэлтийн зөвшөөрлийн хуудсыг харилцан тохиролцсон тоогоор жил бүр бие биедээ өгнө.

Энэхүү зөвшөөрлийн хуудас нь зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын тамга, тэмдэг, албан тушаалтны гарын үсэгтэй байна.

2.Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд зөвшөөрлийн хуудсыг солилцох журмыг өөр хоорондоо тохиролцоно.

АРВДУГААР ЗҮЙЛ

1.Хэлэлцэн тохирогч нэг Талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлгүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр орших хоёр цэгийн хооронд зорчигч болон ачаа тээвэрлэхийг зөвшөөрөхгүй.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг Талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын улсын нутгаас гуравдагч орны нутагт тэрчлэн гуравдагч орны нутгаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын улсын нутагт тээвэрлэлт хийж болно.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1.Энэхүү Хэлэлцээрт заасан тээвэрлэлтийг тухайн орны дотоодын хууль тогтоомжийн дагуу олон улсын тээвэрлэлт хийхээр зөвшөөрөгдсөн тээвэрчид гүйцэтгэнэ.

2.Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх авто тээврийн хэрэгсэл нь өөрийн улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байна.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ олон улсын хэмжээнд нийтлэг мөрдөж байгаа загварт нийцсэн дагалдах хуудсыг хэрэглэнэ.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Авто тээврийн хэрэгслийн жолооч нь жолоодож байгаа тухайн авто тээврийн хэрэгслийн ангилалд тохирсон олон улсын хэмжээнд нийтлэг мөрдөж байгаа загварт нийцсэн үндэсний буюу олон улсын жолоочийн үнэмлэх, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн баримт бичигтэй байна.

2.Энэхүү Хэлэлцээрийн заалтуудын дагуу шаардагдах зөвшөөрөл болон бусад баримт бичгийг авто тээврийн хэрэгсэлдээ авч яван хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудын шаардлагаар үзүүлж байна.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1.Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад гарах тооцоо, төлбөрийг хийх, түүнээс чөлөөлөх асуудлыг төлбөр хийгдэж байгаа өдөр Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд үйлчилж буй тооцоо, төлбөрийн тухай Хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

2.Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь харилцан зөвшилцөх ижил тэгш байх зарчмыг үндэслэн татвар, хураамжаас чөлөөлөх хэлбэр хэмжээг тогтооно.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

Тээвэрлэлт гүйцэтгэх авто тээврийн хэрэгсэл бүрийг иргэний хариуцлагын даатгалд урьдчилан заавал даатгуулсан нөхцөлд энэхүү Хэлэлцээрийг үндэслэн зорчигчид, ачааны тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Хилийн шалган нэвтрүүлэх, гаалийн болон хорио цээрийн шалгалтанд Хэлэлцэн тохирогч хоёр Талын оролцсон олон улсын гэрээг мөрдөх бөгөөд харин эдгээр гэрээгээр зохицуулагдахгүй асуудлыг шийдвэрлэхдээ Хэлэлцэн тохирогч Тал бүрийн дотоодын хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Зорчигчдын байнгын тээвэрлэлт, хүнд өвчтөн, тэрчлэн мал амьтан, түргэн муудах ачааны тээвэрлэлтийг гүйцэтгэхэд хилийн шалган нэвтрүүлэх, гаалийн болон хорио цээрийн шалгалтыг ээлж дугааргүйгээр хийнэ.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

1.Энэхүү Хэлэлцээрийг үндэслэн тээвэрлэлтийг гүйцэтгэхэд Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг руу тээвэрлэж яваа доорхи зүйлийг гаалийн татвар хураамж, зөвшөөрлөөс харилцан чөлөөлнө.

а/тухайн загварын авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тэжээлийн системтэй технологийн болон зохион, бүтцийн талаар холбоо бүхий түлшний саванд байгаа шатахуун;

б/тээвэрлэлтийн явцад зайлшгүй хэрэглэгдэх хэмжээний тосолгооны материал;

в/олон улсын тээвэр гүйцэтгэж байгаа авто тээврийн хэрэгслийн засварт зориулагдсан сэлбэг, багаж хэрэгсэл.

2.Хэрэглээгүй сэлбэгийг эргүүлэн тээвэрлэнэ.

Харин солигдсон хуучин сэлбэгийг тухайн улсаас авч буцах буюу эсвэл Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр тогтоосон журмын дагуу устгах буюу тушаана.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талуудын тээвэрлэгчид, авто тээврийн хэрэгсэл нь нутаг дэвсгэрт нь оршиж байгаа тухайн улсынхаа хөдөлгөөний дүрэм болон төрийн бусад хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийг зөрчсөн тохиолдолд зөрчил гаргасан тээвэрлэгчийн Талын эрх бүхий байгууллага нь тухайн зөрчил үйлдэгдсэн нөгөө орныхоо эрх бүхий байгууллагын хүсэлтээр энэхүү хэлэлцээрийн биелэлтийг хангахад шаардагдах арга хэмжээг авна.

Тээвэрлэгчийн Талын эрх бүхий байгууллага нь авсан арга хэмжээний тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагад мэдээлнэ.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1.Хэлэлцэн тохирогч Талууд нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад үүдэн гарах бүх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн Хамтарсан комисс байгуулна.

2.Хамтарсан комисс нь эрх бүхий байгууллагуудын аль нэгний хүсэлтээр Хэлэлцэн тохирогч Талуудын нутагт ээлжээр уулзаж ажиллана.

3.Хамтарсан комисс нь энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, мөрдөх явцад гарч болох маргаантай бүх асуудлыг хэлэлцэх болон зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.Эдгээр уулзалт, зөвлөлгөөн үр дүнд хүрээгүй тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд нь маргаантай асуудлыг Хэлэлцэн тохирогч Талуудад нийцэхүүд бусад аргаар шийдвэрлэнэ.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрээр болон түүнчлэн Хэлэлцэн тохирогч хоёр Талын оролцсон олон улсын гэрээгээр зохицуулагдахгүй асуудлыг Хэлэлцэн тохирогч Тал бүрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч *Талуудын* олон улсын бусад гэрээ хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн заалтанд оруулах нэмэлт, өөрчлөлтийг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцож бичгээр үйлдэнэ.

ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийг тодорхой хугацаагүй байгуулав.

Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоохоор товлож байгаа хугацаанаасаа 6 сарын өмнө энэ тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө Талд дипломат шугамаар мэдэгдэх замаар хэдийд ч уг Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоож болно.

Энэхүү Хэлэлцээрийн үндсэн дээр хүлээсэн үүрэг, байгуулсан гэрээ нь уг Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоохоос өмнө хэрэгжээгүй бол тэдгээрийг бүрэн хэрэгжүүлж дуустал энэхүү Хэлэлцээрийн заалтууд үйлчлэх болно.

ХОРИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр нь түүнийг Хэлэлцэн тохирогч Талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу хүчин төгөлдөр болгоход шаардагдах бүх ажиллагааг гүйцэтгэсэн тухай сүүлчийн мэдээ авснаас хойш 30 хоног өнгөрсний дараагаар хүчин төгөлдөр болно.

Энэхүү Хэлэлцээрийг 1995 оны 6 дугаар сарын 27-ны өдөр Киев хотноо монгол, украин, орос хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

Энэхүү Хэлэлцээрийн агуулгыг тайлбарлах талаар зөрүү гарвал орос хэл дээрх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**УКРАИН УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**

**ОЛОН УЛСЫН АВТО ТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
ОРОСЫН ХОЛБООНЫ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Оросын Холбооны Улсын Засгийн газар болон Монгол Улсын Засгийн газар / цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэж нэрлэнэ/

олон талын харилцан ашигтай хамтын ажиллагааны таатай нөхцлийг анхааралдаа авч,

хоёр орны хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх авто тээврийн харилцааг цаашид хөгжүүлэх эрмэлзлэлийг удирдлага болгон, дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан нэр томъёо нь дараахь утгыг илэрхийлнэ.Үүнд:

a) “Авто тээврийн хэрэгсэл” гэж ачаа тээвэрлэлтэнд ачааны автомашин, чиргүүлтэй ачааны автомашин, авто зүтгүүр буюу хагас чиргүүлтэй авто зүтгүүр.

Зорчигч тээвэрлэлтэд автобус, өөрөөр хэлбэл жолоочийн суудлаас гадна 8-аас доошгүй суудалтай, зорчигч тээвэрлэх зориулалт бүхий авто тээврийн хэрэгсэл, тээш тээвэрлэх чиргүүлийг хэлнэ.

b) “зорчигчийн байнгын тээвэрлэлт” гэж урьдчилан тохиролцсон хуваарь, хөдөлгөөний эхний болон эцсийн буудал, зогсоолуудыг заасан хөдөлгөөний замналын дагуу Хэлэлцэн тохирогч Талуудын авто тээврийн хэрэгслээр гүйцэтгэх тээвэрлэлтийг хэлнэ.

c) “зорчигчийн байнгын бус тээвэрлэлт” гэж бусад бүх тээвэрлэлтийг хэлнэ.

d) “дамжин өнгөрөх тээвэрлэлт” гэж Хэлэлцэн тохирогч нэг Талын нутаг дэвсгэрээр дамжуулан гуравдагч улсуудад гүйцэтгэх тээвэрлэлтийг хэлнэ.

e) “гуравдагч улс” гэж энэхүү Хэлэлцээрт оролцоогүй улсыг хэлнэ.

f) “хорио цээрийн шалгалт” гэж ариун цэвэр, мал эмнэлэг, мөн түүнчлэн ургамал хорио цээрийн шалгалтыг хэлнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх зорчигчдын /жуулчдыг оролцуулан /, байнгын болон байнгын бус тээвэрлэлт, мөн ачааны тээвэрлэлтийг улс хоорондын авто тээврийн харилцааны зориулалтаар нээгдсэн замаар гүйцэтгэнэ.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын хоорондын тохиролцсоны дагуу автобусаар зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохион байгуулна.

2. Зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохион байгуулах тухай саналаа Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд бие биедээ урьдчилан өгнө. Энэ саналд тээвэрлэгчдийн нэр, аялалын замнал, хөдөлгөөний цагийн хуваарь, тээврийн хөлс, зорчигчдыг буулгах, суулгах зогсоол, түүнчлэн тээвэрлэлтийг гүйцэтгэх хугацаа, давтамжийн талаархи мэдээдэл агуулагдсан байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийг автобусаар гүйцэтгэхэд энэхүү Хэлэлцээрийн 5 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлийг авна.

2. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд өөрийн улсын нутгаар дайрч өнгөрөх замын тэр хэсэгт зөвшөөрөл олгоно.

3. Хэрэв энэ зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол зорчигчдын байнгын бус тээвэрлэлт автобусаар хийхэд ирэх, очих нэг аялал хийх эрхийн зөвшөөрөл өгнө.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Эвдэрсэн автобусыг өөр автобусаар солиход зөвшөөрөл шаардахгүй.

II . Ачаа тээвэрлэлт

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр чиргүүлтэй буюу чиргүүлгүй ачааны автомашин, мөн хагас чиргүүлтэй авто зүтгүүрээр энэхүү Хэлэлцээрийн 7 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

2. Хэрэв энэ зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол ачаа тээвэрлэлт хийхэд очих, ирэх нэг л аялал хийх эрхийн зөвшөөрөл олгоно.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн 6 дугаар зүйлд заасан зөвшөөрлийг дараах тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардахгүй.Үүнд:

- a) Үзэсгэлэн, яармагийн зориулалттай үзмэр, тоног төхөөрөмж, материал;
- b) Биеийн тамирын арга хэмжээг явуулахад зориулагдсан тээврийн хэрэгсэл, амьтан, тэрчлэн төрөл бүрийн хэрэгсэл, эд юмс;
- c) Театрын засал чимэглэл, хэрэгслэл, хөгжийн зэмсэг, кино зураг авах болон радио,телевизийн нэвтрүүлэг хийхэд зориулагдсан тоног төхөөрөмж, эд юмс;
- d) Нас барагчийн чандруу, шарил;
- e) Шуудан ;
- f) Эвдрэл гэмтэлтэй авто тээврийн хэрэгсэл;
- g) Нүүж байгаа айлын эд хогшил
- h) Энэхүү Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн дагуу тээвэрлэх тусгай зөвшөөрөл авсан ачаа
- i) Байгалийн гамшиг тохиолдсон үед тусламж үзүүлэхэд зориулагдсан эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хэрэгсэл;

Тэрчлэн техникийн тусламжийн автомашин явахад зөвшөөрөл шаардахгүй.

2.Энэ зүйлийн 1-ийн “а”, “б”, “в”-д тусгагдсан заалтууд нь зөвхөн тухайн ачааг авто тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн улсад буцааж авчрах буюу гуравдагч улсын нутаг руу тээвэрлэх тохиолдолд хүчинтэй байна.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг Талын ачаатай буюу ачаагүй яваа авто тээврийн хэрэгслийн овор болон жин нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр тогтоосон нормоос хэтэрсэн, мөн түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагуудын тусгай зөвшөөрлийг авна.

2. Хэрэв энэ зүйлийн 1-д дурдсан зөвшөөрөлд авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тодорхой замналаар явахаар тогтоосон бол тээвэрлэлтийг энэхүү замналаар гүйцэтгэнэ.

III. Ерөнхий хэсэг

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийн болон ачаа тээвэрлэлтийн зөвшөөрлийн бичгийг харилцан тохиролцсон тоогоор жил бүр бие биедээ өгнө. Энэхүү зөвшөөрлийн бичиг нь зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагын тамга, тэмдэг, хариуцлагатны гарын үсэгтэй байна.

2. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд зөвшөөрлийн бичгийн солилцох журмыг өөр хоорондоо тохиролцоно.

АРАВДУГААР ЗҮЙЛ

1. Тээвэрлэгчийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр орших хоёр цэгийн хооронд зорчигч болон ачаа тээвэрлэхийг зөвшөөрөхгүй.

2. Хэрэв тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан бол Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутгаас гуравдагч улсын нутагт, мөн түүнчлэн гуравдагч улсын нутгаас Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт тээвэрлэлт хийж болно.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Ачаа болон зорчигчийн тээвэрлэлтийг хил орчмын нутагт гүйцэтгэх журмыг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд хамтарч тогтооно.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрт заасан тээвэрлэлтийг тухайн орны дотоодын хууль тогтоомжийн дагуу олон улсын тээвэрлэлт хийхээр зөвшөөрөгдсөн тээвэрлэгч л зөвхөн гүйцэтгэнэ.
2. Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх авто тээврийн хэрэгсэл нь өөрийн улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэг болон гаалийн битүүмжлэл тавих бололцоо бүхий байдлаар тоноглогдсон байна.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү хэлэлцээрт тусгагдсан ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэхэд олон улсын хэмжээнд нийтлэг мөрдөж байгаа загварт нийцсэн дагалдах хуудсыг хэрэглэнэ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Автобус буюу ачааны автомашины жолооч нь тухайн тээврийн хэрэгсэл жолоодох ангилалд болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх загварт тохирсон үндэсний буюу олон улсын жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн улсын гэрчилгээтэй байна.
2. Зөвшөөрлийн болон бусад баримт бичиг нь энэхүү Хэлэлцээрийн заалтад нийцсэн байх бөгөөд түүнийг автомашиндаа авч яван хяналт шалгалтын байгууллагуудын шаардлагаар үзүүлж байна.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү хэлэлцээрийн дагуу ачаа болон зорчигчдын тээвэрлэлттэй холбогдож гарсан практик асуудлыг Хэлэлцэн тохирогч Талуудын тээвэрлэгчид хоорондоо шууд зохицуулж болно.

Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгчид нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт тухайн улсын хууль тогтоомжид тусгагдсан журмын дагуу өөрийн төлөөлөгчийн газрыг нээн ажиллуулж болно.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн үндсэн дээр Хэлэлцэн тохирогч нэг Талын тээвэрлэгчдийн Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээгүүр гүйцэтгэж байгаа зорчигч, ачаа тээвэрлэлт, мөн түүнчлэн энэ тээвэрлэлтийг гүйцэтгэж буй тээврийн хэрэгсэл нь энэхүү Хэлэлцээрт дурдсан зөвшөөрөл өгсний болон зам ашигласан буюу эзэмшсэн, мөн авто тээврийн хэрэгсэл эзэмшсэн буюу хэрэглэсний төлөө ногдуулах татвар, хураамжаас тус тус чөлөөлөгдөнө.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх хүрээнд хийгдэх тооцоо төлбөрийг уг төлбөр хийх өдөр хүчин төгөлдөр байгаа Хэлэлцэн тохирогч Талуудын хооронд байгуулсан тооцоо, төлбөрийн тухай хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу зорчигч, ачаа тээвэрлэлтийг жолоочийн иргэний хариуцлагыг заавал даатгуулсан нөхцөлд л гүйцэтгэнэ. Тээвэрлэгч нь дурдсан тээвэрлэлтийг гүйцэтгэх тээврийн хэрэгсэл бүрийг урьдчилж заавал даатгуулсан байна.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Хилийн шалган нэвтрүүлэх, гаалийн болон хорио цээрийн шалгалтанд Хэлэлцэн тохирогч хоёр Талын оролцсон олон улсын гэрээг мөрдөх бөгөөд харин эдгээр гэрээгээр зохицуулагдахгүй асуудлыг шийдвэрлэхдээ Хэлэлцэн тохирогч Тал бүрийн дотоодын хууль тогтоомжийг мөрдлөгө болгоно.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ

Зорчигчдын байнгын тээвэрлэлтийг автобусаар гүйцэтгэх, мөн түүнчлэн хүнд өвчтөн, мал амьтан, түргэн муудах ачааны тээвэрлэлтэнд хилийн шалган нэвтрүүлэх, гаалийн болон хорио цээрийн шалгалтыг эхний ээлжинд хийж байна.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай доорхи зүйлийг Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг руу тээвэрлэж ороход гаалийн татвараас чөлөөлөгдөнө.

- a) Тухайн загварын авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тэжээлийн системтэй технологийн болон зохион бүтцийн талаар холбоо бүхий түлшний саванд байгаа шатахуун;
- b) Тээвэрлэлтийн явцад авто тээврийн хэрэгслийн хэвийн ашиглалтыг хангахад зайлшгүй хэрэглэгдэх тосолгооны материал;
- c) Олон улсын тээвэр хийж байгаа авто тээврийн хэрэгслийн засварт зориулагдсан сэлбэг, багаж хэрэгсэл;

2. Хэрэглээгүй сэлбэгийг эргүүлэн тээвэрлэнэ. Харин солигдсон хуучин сэлбэгийг тухайн улсаас авч буцах, эсвэл Хэлэлцэн тохирогч тухайн Талын нутаг дээр тогтоогдсон журмын дагуу устгах буюу тушаана.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талуудын тээвэрлэгчид тээврийн хэрэгсэл дэвсгэр нутагт нь тухайн үед байгаа улсын хууль болон замын хөдөлгөөний дүрмийг биелүүлнэ.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү хэлэлцээрийг зөрчсөн тохиолдолд тээвэрлэгч улсын эрх бүхий байгууллага нь нутаг дэвсгэрт нь зөрчил гарсан Хэлэлцэн тохирогч нөгөө талынхаа эрх бүхий байгууллагын хүсэлтээр энэхүү Хэлэлцээрийн биелэлтийг хангахад шаардагдах арга хэмжээ авна.

Тээвэрлэгч улсын эрх бүхий байгууллага авсан арга хэмжээнийхээ тухай нөгөө улсын эрх бүхий байгууллагад мэдээлнэ.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн биелэлтийг хангах зорилгоор Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь шууд холбоо тогтоож, Хэлэлцэн тохирогч аль нэг Талын саналаар зорчигчид, ачаа тээвэрлэлийг гүйцэтгэх зөвшөөрөл олгох системтэй холбогдсон асуудлыг шийдвэрлэх зорилгоор зөвлөлгөөн хийх, түүнчлэн олгогдсон зөвшөөрлийг ашиглаж байгаа талаар туршлага, мэдээллийг солилцоно.

ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрээр болон Хэлэлцэн тохирогч хоёр Талын оролцож байгаа олон улсын гэрээгээр зохицуулагдахгүй асуудлыг Хэлэлцэн тохирогч Тал бүрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХОРИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, мөрдөх явцад гарч болох маргаантай бүх асуудлыг хэлэлцэх болон зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

ХОРИН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Тал бүр энэхүү Хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт оруулах санал гаргаж болно. Хэлэлцэн тохирогч аль нэг тал энэхүү Хэлэлцээрт нэмэлт, өөрчлөлт оруулах санал тавьснаас хойш 60 хоногийн дотор тухайн асуудлаар хэлэлцээ хийнэ.

ХОРИН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын оролцсон олон улсын бусад гэрээгээр хүлээсэн эрх үүргийг хөндөхгүй.

ХОРИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

1.Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болоход шаардагдах бүх ажиллагааг улс бүрд гүйцэтгэсэн тухай Хэлэлцэн тохирогч Талууд дипломат шугамаар бие биедээ мэдээлснээс хойш 30 хоног өнгөрсний дараагаар хүчин төгөлдөр болно.

2.Энэхүү Хэлэлцээрийг тодорхой хугацаагүй байгуулав. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоохоор товлож байгаа хугацаанаас 6 сарын өмнө нь энэ тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө талд дипломат шугамаар мэдэгдэх замаар түүний үйлчлэлийг хэдийд ч зогсоож болно.

Энэхүү хэлэлцээрийг 1996 оны 2 дугаар сарын 7-ны өдөр Москва хотноо монгол, орос хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байна.

**Монгол Улсын Засгийн
Газрыг төлөөлж**

**Оросын Холбооны Улсын
Засгийн газрыг төлөөлж**

ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВРИЙН ХАРИЦААНЫ ТУХАЙ МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР, БҮГД НАЙРАМДАХ ТУРК УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Турк Улсын Засгийн газар (цаашид “Хэлэлцэн тохирогч Талууд” гэнэ),

хоёр талын худалдаа эдийн засгийн харилцааны тааламжтай нөхцлийг анхааралдаа авч,

хоёр орны хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх авто тээврийн харилцааг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэн,

дор дурьдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу авто тээврээр гүйцэтгэх хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх зорчигч, ачааны байнгын болон байнгын бус тээвэрлэлтийг Хэлэлцэн тохирогч талуудын нутаг дэвсгэрт бүртгэлтэй авто тээврийн хэрэгслээр олон улсын авто тээврийн харилцааны зориулалтаар нээгдсэн замаар хийнэ.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан нэр томъёо нь дараах утгыг илэрхийлнэ.
Үүнд:

- a) “хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд” Монгол улсын талаас – Монгол Улсын Дэд бүтцийн яам,

Бүгд Найрамдах Турк Улсын талаас –Бүгд Найрамдах Турк улсын Тээврийн Яам;

- b) “тээвэрлэгч” гэж энэхүү Хэлэлцээр болон Хэлэлцэн тохирогч Талуудын хууль тогтоомжид нийцүүлэн ачаа, зорчигч тээвэрлэлт гүйцэтгэгч аж ахуй нэгж, байгууллага, иргэдийг;

- c) “тээврийн хэрэгсэл” гэж:

- i. ачаа тээвэрлэлтэд – ачааны автомашин, чиргүүлтэй ачааны автомашин, авто зүтгүүр буюу хагас чиргүүлтэй авто зүтгүүр,
- ii. зорчигч тээвэрлэлтэд- автобус, өөрөөр хэлбэл жолоочийн суудлаас гадна наймаас доошгүй суудалтай зорчигч тээвэрлэх зориулалт бүхий авто тээврийн хэрэгсэл, түүнчлэн зорчигчдын тээш тээвэрлэх чиргүүл;

d/ “зорчигч тээврийн байнгын үйлчилгээ” гэж Хэлэлцэн тохирогч Талуудын эрх

бүхий байгууллагуудын урьдчилан тохиролцсон хөдөлгөөний цагийн хуваарь, эхний болон эцсийн буудал, зогсоолуудыг заасан аялалын замналын дагуу автотээврийн хэрэгслээр гүйцэтгэх тээвэрлэлтийг;

e/ “зорчигч тээврийн байнгын бус үйлчилгээ” гэж энэ зүйлийн d) –д зааснаас бусад зорчигчдын бүх тээвэрлэлтийг;

f/ “дамжин өнгөрөх тээвэрлэлт” гэж Хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэрээр дамжин гуравдагч улсуудад гүйцэтгэх тээвэрлэлтийг;

g/ “гуравдагч улс гэж” энэхүү хэлэлцээрт оролцоогүй улсыг;

h/ “зөвшөөрөл” гэж энэхүү Хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч хоёр талын хооронд болон тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэлд харилцан олгох зөвшөөрлийг;

i) “квот” гэж Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагаас олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэлд жил бүр харилцан олгох зөвшөөрлийн тоог хэлнэ.

Нэг . ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын хооронд урьдчилан тохиролцсоны дагуу автобусаар зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохих зөвшөөрлийг үндэслэн зохион байгуулна.

2. Зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохион байгуулах тухай саналыг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд бие биедээ урьдчилан өгнө. Энэ саналд тээвэрлэгчийн нэр, аялалын замнал, хөдөлгөөний цагийн хуваарь, үнэ тариф, зорчигчдыг буулгах, суулгах буудал зогсоол , түүнчлэн тээвэрлэлтийг гүйцэтгэх хугацаа, давтамжийн талаархи мэдээллийг заавал тусгасан байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийг автотээврийн хэрэгслээр гүйцэтгэхэд энэхүү Хэлэлцээрийн тавдугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг авна.

2. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллага өөрийн улсын нутгаар дайрч өнгөрөх замын тар хэсэгт зөвшөөрөл олгоно.

3. Хэрэв энэ зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийг автотээврийн хэрэгслээр гүйцэтгэхэд ирэх, очих нэг удаагийн аялал хийх эрхийн зөвшөөрөл олгоно.

ТАВДУГААР ЗҮЙЛ

Олон улсын зорчигчдын тээвэрлэлт гүйцэтгэж яваад эвдэрсэн тээврийн хэрэгсэлийг өөр тээврийн хэрэгслээр солиход энэхүү Хэлэлцээрийн дөрөвдүгээр зүйлд заасан зөвшөөрөл шаардагдахгүй.

Хоёр. АЧАА ТЭЭВЭРЛЭЛТ

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын өгсөн зөвшөөрлийн үндсэн дээр чиргүүлтэй буюу чиргүүлгүй ачааны автомашин, авто зүтгүүр, хагас чиргүүлтэй зүтгүүрээр энэхүү Хэлэлцээрийн долдугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

2. Хэрэв зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол ачаа тээвэрлэлт хийхэд очих, ирэх нэг удаагийн аялал хийх эрхийн зөвшөөрөл олгоно.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн зургадугаар зүйлд заасан зөвшөөрлийг дараах тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардахгүй. Үүнд:

- a) үзэсгэлэн, яармагийн зориулалттай үзмэр, тоног төхөөрөмж, материал;
- b) спортын арга хэмжээ явуулахад зориулагдсан тээврийн хэрэгсэл, амьтан тэрчлэн бусад төрлийн хэрэгсэл, эд юмс;
- c) театрын засал чимэглэл, хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, кино зураг авах болон радио телевизийн нэвтрүүлэг хийх зориулалтын тоног төхөөрөмж, эд зүйлс;
- d) нас барагчийн чандруу, шарил;
- e) шуудан;
- e) эвдрэл гэмтэлтэй автотээврийн хэрэгсэл;
- f) байгалийн гамшгийн үед тусламж үзүүлэхэд зориулагдсан эмнэлгийн тоног төхөөрөмж, эд хэрэгсэл;
- h) техникийн тусламжийн автомашин.

2. Энэ зүйлийн 1-ийн а),б),с)-д тусгагдсан заалтууд нь зөвхөн тухайн ачааг авто тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн улсад буцааж авчрах буюу гуравдагч улсын нутгаар дамжуулан тээвэрлэх тохиолдолд хүчинтэй байна.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

1. Хэрэв ачаатай буюу ачаагүй яваа автотээврийн хэрэгслийн овор хэмжээ болон жин нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр тогтоосон нормоос хэтэрсэн, мөн түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагын тусгай зөвшөөрлийг авна.

2. Хэрэв энэ зүйлийн 1-д дурдсан зөвшөөрөлд автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг тодорхой замналаар явахаар тогтоосон бол тээвэрлэлтийг зөвхөн тухайн замналаар гүйцэтгэнэ.

2. Хэлэлцэн тохирогч талуудын хооронд түүнчлэн тэдгээрийн нутгаар дамжуулан талуудын дотоодын хууль тогтоомжоор хориглосон зэр зэвсэг, сум хэрэгсэл, байлдааны тоног төхөөрөмж, тэсрэх бодис бусад аюултай ба хортой ачааг тээвэрлэхийг хориглоно.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын авто тээврийн хэрэгсэлд буцах чиглэлийн ачаа олгох үйл ажиллагааг зөвхөн өөрийн хууль ёсны тээврийн төлөөлөгчөөр дамжуулан зохион байгуулна.

Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр ачаа болон зорчигч олох үйл ажиллагааг зөвхөн энэхүү зорилгоор зөвшөөрөл авсан тохиолдолд гүйцэтгэж болно.

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

АРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд нь хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэх авто тээврийн хэрэгсэлд олгох зөвшөөрөлийн бичгийг харилцан тохиролцсон тоогоор жил бүр солилцоно.

Энэхүү зөвшөөрлийн бичиг нь зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын тамга тэмдэг, албан тушаалтны гарын үсэгтэй байна.

2.Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд зөвшөөрлийн бичиг солилцох журмыг харилцан тохиролцоно.

3. Энэхүү зөвшөөрлийн бичгийг тухайн тээвэрлэгч байгууллагын нэг тээврийн хэрэгсэлд олгох бөгөөд түүнийг бусдад дамжуулан хэрэглэхийг хориглоно.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас олгосон зөвшөөрөлгүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр орших хоёр цэгийн хооронд зорчигч болон ачаа тээвэрлэхийг хориглоно.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлгүй бол Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутгаас гуравдагч улсын нутагт тэрчлэн гуравдагч улсын нутгаас хэлэлцэн тохирогч нөгөө талын нутагт тээвэрлэлт хийхийг хориглоно.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрт заасан тээвэрлэлтийг тухайн орны дотоодын хууль тогтоомжийн дагуу олон улсын тээвэрлэлт хийхээр зөвшөөрөгдсөн тээвэрлэгч гүйцэтгэнэ.

2. Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэл нь өөрийн улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байна.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ олон улсын хэмжээнд нийтлэг мөрддөг загварт нийцсэн дагалдах хуудсыг хэрэглэнэ.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Авто тээврийн хэрэгслийн жолооч нь тухайн авто тээврийн хэрэгсэл жолоодох ангилалд тохирсон олон улсын хэмжээнд нийтлэг мөрддөг загварт нийцсэн үндэсний буюу олон улсын жолоочийн үнэмлэх, авто тээврийн хэрэгслийн улсын бүртгэлийн баримт бичигтэй байна.

2. Энэхүү Хэлэлцээрийн дагуу шаардагдах зөвшөөрөл болон бусад баримт бичгийг авто тээврийн хэрэгсэлдээ авч яван, хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудын шаардлагаар үзүүлж байна.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу ачаа болон зорчигчдын тээвэрлэлттэй холбогдож гарсан практик асуудлуудыг Хэлэлцэн тохирогч Талуудын тээвэрлэгчид хоорондоо шууд зохицуулж болно.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутагт тухайн улсын хууль тогтоомжид тусгагдсан журмын дагуу өөрийн төлөөлөгчийн газрыг нээн ажиллуулж болно.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

1. Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх улс хоорондын ачаа, зорчигч, тээшний тээврийн тарифыг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд тохиролцоно.

2. Тээврийн үнэ хөлсний тооцоог Засгийн газар хоорондын төлбөрийн хэлэлцээр болон хоёр талын үндэсний банк хоорондын хэлэлцээрийн дагуу хийнэ.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд нь дор дурьдснаас бусад тохиолдолд хоёр Талын хооронд болон өөрсдийн нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх Хэлэлцэн тохирогч нөгөө Талын тээврийн хэрэгсэлд аливаа экспорт, импортын татвар, хураамж ноогдуулахгүй. Үүнд :

- a) автозам, замын байгууламж (зам, гүүр)-ийг ашигласны төлбөр;
- b) тээврийн хэрэгслийн загвар, техникийн үйлчилгээ, хамгаалалт, тээвэрлэлтийн зохион байгуулалттай холбогдсон үйлчилгээний хураамж;
- c) тээврийн хэрэгслийн жин, овор эсвэл ачаа нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын дотоодын хууль тогтоомжоор тогтоосон хязгаараас хэтэрсэн тохиолдолд ноогдуулах хураамж.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу зорчигч, ачаа тээвэрлэлтийг тээврийн хэрэгсэл ба жолоочийн иргэний хариуцлагыг заавал даатгуулсан нөхцөлд гүйцэтгэнэ.

Тээвэрлэгч нь дурдсан тээвэрлэлтийг гүйцэтгэх тээврийн хэрэгсэл бүрийг урьдчилан заавал даатгуулсан байна.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Хилийн шалган нэвтрүүлэх, гаалийн болон цээрийн шалгалтанд Хэлэлцэн тохирогч хоёр Талын оролцсон олон улсын гэрээг мөрдөх бөгөөд харин эдгээр гэрээгээр зохицуулагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ нутаг дэвсгэрт нь тухайн тээвэрлэлт хийгдэж байгаа Хэлэлцэн тохирогч Талын дотоодын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ

Зорчигчдын байнгын тээвэрлэлт, хүнд өвчтөн, тэрчлэн мал амьтан, түргэн муудах ачааны тээвэрлэлтийг гүйцэтгэхэд хилийн шалган нэвтрүүлэх , гаалийн болон хорио цээрийн шалгалтыг эхний ээлжинд хийнэ.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийг үндэслэн тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг руу тээвэрлэж яваа доорхи зүйлсийг гаалийн татвар хураамж, зөвшөөрлөөс харилцан чөлөөлнө.

- a) тухайн загварын авто тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тэжээлийн системтэй технологийн болон зохион байгуулалт, бүтцийн талаар холбоо бүхий түлшний саванд байгаа шатахуун;
- b) тээвэрлэлтийн явцад зайлшгүй хэрэглэгдэх хэмжээний тосолгооний материал;
- c) олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж байгаа авто тээврийн хэрэгслийн загварт зориулагдсан сэлбэг, багаж хэрэгсэл.

2.Хэрэглэгдээгүй сэлбэгийг эргүүлэн тээвэрлэнэ. Харин солигдсон хуучин сэлбэгийг тухайн улсаас авч буцна. Эсвэл Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэр дээр тогтоосон журмын дагуу устгана.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талуудын тээвэрлэгч, авто тээврийн хэрэгсэл нутаг дэвсгэрт нь оршиж байгаа тухайн улсын хууль тогтоомж, замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдөнө.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгч буюу жолооч нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэр дээр автозамын хөдөлгөөн, тээвэрлэлтийн дүрэм, журмыг зөрчсөн тохиолдолд зөрчил гаргасан тээвэрлэгчийн Талын эрх бүхий байгууллага нь тухайн зөрчил үйлдэгдсэн нөгөө орныхоо эрх бүхий байгууллагын хүсэлтээр энэхүү Хэлэлцээрийн биелэлтийг хангахад шаардагдах зохих арга хэмжээг авна.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талууд нь энэхүү Хэлэлцээрийг хэрэгжүүлэх явцад үүдэн гарах бүх асуудлыг шийдвэрлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын төлөөлөгчдөөс бүрдсэн Хамтарсан комисс байгуулна.

2. Хамтарсан комисс нь Хэлэлцэн тохирогч Талуудын аль нэг талын саналаар Монгол ба Туркэд ээлжээр уулзаж ажиллана.

3. Хамтарсан комисс нь энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, хэрэгжүүлэх явцад гарч болох маргаантай бүх асуудлыг хэлэлцэх болон зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

Эдгээр уулзалт, зөвлөлгөөн үр дүнд хүрээгүй тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талууд нь маргаантай асуудлыг Хэлэлцэн тохирогч Талуудад нийцэхүйц бусад арга замаар шийдвэрлэнэ.

ХОРИНТАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр болон түүнчлэн Хэлэлцэн тохирогч хоёр талын оролцсон олон улсын гэрээгээр зохицуулагдахгүй асуудлыг нутаг дэвсгэрт нь тухайн тээвэрлэлт хийгдэж байгаа Хэлэлцэн тохирогч Талын дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХОРИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын олон улсын бусад гэрээ хэлэлцээрээр хүлээсэн эрх үүргийг хөндөхгүй.

ХОРИН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн заалтанд оруулах нэмэлт өөрчлөлтийг Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд харилцан тохиролцож бичгээр үйлдэнэ.

ХОРИН НАЙМДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээр нь түүнийг Хэлэлцэн тохирогч Талуудын дотоод хууль тогтоомжийн дагуу Хэлэлцээрийг баталсан тухай нот бичиг солилцсоноос хойш 30 хоног өнгөрсний дараагаар хүчин төгөлдөр болно. Хэлэлцээрийг 5 жилийн хугацаатай байгуулав.

2. Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоохоор товлож байгаа хугацаанаасаа 6 сарын өмнө энэ тухайгаа Хэлэлцэн тохирогч нөгөө талд дипломат шугамаар мэдэгдэх замаар хэдийд ч уг Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоож болно.


Хэлэлцэн тохирогч талууд нь нөгөө талдаа энэ тухайгаа мэдэгдэхгүй бол Хэлэлцээрийн хүчин төгөлдөр хугацаа нэг жилээр аяндаа сунгагдана.

3. Энэхүү Хэлэлцээрийг 2002 оны 6 дугаар сарын 2-ны өдөр Улаанбаатар хотноо англи, монгол, турк хэлээр тус бүр хоёр хувь үйлдсэн бөгөөд эх бичвэрүүд

нь адил хүчинтэй байна.

Энэхүү Хэлэлцээрийн агуулгыг тайлбарлах талаар зөрүү гарвал англи хэл дээрх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**



Handwritten signature in cursive script, appearing to read "Tsamtsag". Below the signature is a horizontal line of small dots.

**БҮГД НАЙРАМДАХ ТУРК
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**



Handwritten signature in cursive script, appearing to read "M. J. S.". Below the signature is a horizontal line of small dots.

**ОЛОН УЛСЫН АВТО ТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол улсын засгийн газар, Бүгд Найрамдах Беларусь Улсын Засгийн газар (цаашид Хэлэлцэн тохирогч Талууд гэнэ),

харилцан ашигтай хамтын ажиллагааны таатай нөхцлийг анхааралдаа авч,

хоёр орны хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх авто тээврийн харилцааг цаашид хөгжүүлэхийг эрмэлзэн,

дор дурьдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу Монгол Улс болон Бүгд найрамдах Беларусь Улсын хооронд, тэдгээрийн нутгаар дамжин гуравдагч улсад болон гуравдагч улсаас зорчигчид (жуулчдыг оролцуулан) болон ачааны байнгын болон байнгын бус авто тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг мөрдөнө.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрт хэрэглэгдэх нэр томъёо нь дараах утгыг илэрхийлнэ.
Үүнд:

а) "тээвэрлэгч" гэж Монгол улс, бүгд Найрамдах Беларусь Улсын үндэсний хууль тогтоомжийн дагуу олон улсын зорчигч болон ачаа тээвэрлэлтийг авто тээврийн хэрэгслээр гүйцэтгэх эрх бүхий аливаа хувь хүн болон хуулийн этгээдийг хэлнэ.

б) "тээврийн хэрэгсэл" гэж:

ачаа тээвэрлэлтийн үед ачааны автомашин, чиргүүлтэй ачааны автомашин, авто зүтгүүр буюу хагас чиргүүлтэй авто зүтгүүр;

зорчигч тээвэрлэлтийн үед автобус буюу жолоочийн суудлаас гадна 8-аас доошгүй суудалтай, зорчигч тээвэрлэх зориулалт бүхий авто тээврийн хэрэгслийг хэлнэ.

в) "зорчигчийн байнгын тээвэрлэлт" гэж Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын урьдчилан тохиролцсон цагийн хуваарь, хөдөлгөөний эхний болон эцсийн буудал, зогсоолуудыг заасан хөдөлгөөний чиглэлийн дагуу автотээврийн хэрэгслээр гүйцэтгэх зорчигч тээвэрлэлтийг хэлнэ.

г) “зорчигчийн байнгын бус тээвэрлэлт” гэж зорчигчдын бусад бүх тээвэрлэлтийг хэлнэ.

д) “дамжин өнгөрөх тээвэрлэлт ” гэж Хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэрээр дамжин гуравдагч улсуудад гүйцэтгэх тээвэрлэлтийг хэлнэ.

е) “гуравдагч улс” гэж энэхүү Хэлэлцээрт ороогүй улсыг хэлнэ.

ж) “хорио цээрийн хяналт” гэж ариун цэвэр, мал эмнэлэг, ургамал хорио цээрийн хяналтыг хэлнэ.

з) “эрх бүхий байгууллага” нь Монголын талаас Дэд бүтцийн яам, Беларусийн Талаас Тээвэр, харилцааны яам байна.

ЗОРЧИГЧ ТЭЭВЭРЛЭЛТ

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талууд, мөн нутаг дэвсгэр дээгүүр нь аяллын чиглэл дайрч өнгөрөх улсуудын эрх бүхий байгууллагууд хоорондоо тохиролцож, автобусаар зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохион байгуулна.

2. Зорчигчдын байнгын тээвэрлэлтийг зохион байгуулах тухай саналаа Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд бие биедээ зохих хугацаанд нь ирүүлнэ. Уг санал нь тээвэрлэгчийн нэр, аяллын чиглэл, хөдөлгөөний цагийн хуваарь, үнэ тариф, зогсох цэгүүд, тээвэрлэлтийг гүйцэтгэх хугацаа, давтамжийн талаархи мэдээллийг агуулна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийг автобусаар гүйцэтгэхэд энэхүү Хэлэлцээрийн 5 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлийг авна.

2. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд өөрийн улсын нутгаар дайрч өнгөрөх чиглэлийн тэр хэсэгт зөвшөөрөл олгоно.

3. Хэрэв зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол автобусаар зорчигчдын байнгын бус тээвэрлэлт хийх тохиолдол бүрт ирэх, очих нэг удаагийн аялал хийх эрхийн тусгай зөвшөөрөл олгоно.

ТАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэрэв автобус бүртгэлтэй улсынхаа нутаг дэвсгэр дээрх цэгээс

тээвэрлэлтээ эхэлж мөн улсын нутаг дэвсгэрт буцаж ирэх аяллаа тухайн нэг автобусаар, зорчигчдын бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахгүйгээр зорчигчдын байнгын бус тээвэрлэлт гүйцэтгэхэд зөвшөөрөл шаардагдахгүй.

2. Энэхүү зүйлийн 1-д заасан тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ автобусны жолооч тээвэрлэгчийн бөглөж гарын үсгээр баталгаажуулсан маягтыг зорчигчдын нэрсийн жагсаалтын хамт авч явна.

АЧАА ТЭЭВЭРЭЛТ

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн долдугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагуудын олгосон зөвшөөрлөөр чиргүүлтэй буюу чиргүүлгүй ачааны автомашин, хагас чиргүүлтэй авто зүтгүүрээр Монгол Улс, Беларусь Улсын хооронд, тэдгээрийн нутгаар дамжин, түүнчлэн гуравдагч улс руу болон гуравдагч улсаас ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

2. Хэрэв зөвшөөрөлд өөрөөр заагаагүй бол ачаа тээвэрлэлт хийх тохиолдол тус бүрт зөвхөн очих, ирэх нэг аялал хийх эрхийн зөвшөөрөл олгоно.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн зургадугаар зүйлд заасан зөвшөөрлийг дараах тээвэрлэлтийг гүйцэтгэхэд шаардахгүй. Үүнд:

- а) үзэсгэлэн, яармагийн зориулалттай үзмэр, тоног төхөөрөмж, материал;
- б) биеийн тамир спортын арга хэмжээг явуулахад зориулагдсан тээврийн хэрэгсэл, амьтан болон бусад төрлийн хэрэгсэл, эд зүйлс;
- в) театрын засал чимэглэл, хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, кино зураг авах болон радио, телевизийн нэвтрүүлэг хийхэд зориулагдсан тоног төхөөрөмж, эд зүйлс;
- г) нас барагчийн чандруу, шарил;
- д) шуудан;
- е) эвдрэл гэмтэлтэй авто тээврийн хэрэгсэл;
- ж) нүүлгэн шилжүүлж буй эд хогшил;
- з) энэхүү Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн дагуу тээвэрлэх тусгай зөвшөөрөл авсан ачаа;
- и) гамшиг тохиолдсон үед тусламж үзүүлэхэд зориулагдсан эмнэлгийн тоног төхөөрөмж, эм хэрэгсэл;
- к) чиргүүлийг оролцуулан тээврийн хэрэгслийн хамгийн их жин нь 6 тонноос хэтрэхгүй эсвэл чиргүүлийн хамгийн их даац нь 3.5 тонноос хэтрэхгүй тээврийн хэрэгслээр хийх ачаа тээвэрлэлт.

Түүнчлэн техникийн тусламжийн автомашин явахад зөвшөөрөл

шаардахгүй.

1. Энэхүү зүйлийн 1-ийн “а”, “б”, “и”, “в”-д тусгагдсан заалтууд нь зөвхөн тухайн ачааг авто тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн улсад буцааж авчрах буюу гуравдагч улсын нутаг руу тээвэрлэх тохиолдолд хүчинтэй байна.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

1. Хэрэв Хэлэлцэн тохирогч нэг талын ачаатай буюу ачаагүй яваа авто тээврийн хэрэгслийн овор болон жин нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр тогтоосон нормоос хэтэрсэн, мөн түүнчлэн аюултай ачаа тээвэрлэх үед тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагуудаас тусгай зөвшөөрөл авна.

2. Хэрэв энэ зүйлийн 1-д дурьдсан зөвшөөрөлд авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тодорхой чиглэлийг тогтоосон бол тээвэрлэлтийг тухайн чиглэлээр гүйцэтгэнэ.

ЕРӨНХИЙ ХЭСЭГ

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь зорчигчдын байнгын бус тээвэрлэлтийн ачаа тээвэрлэлийн зөвшөөрлийн бичгийг харилцан тохиролцсон тоогоор жил бүр солилцоно. Энэхүү зөвшөөрлийн бичиг нь зөвшөөрөл олгодог эрх бүхий байгууллагын тамга, тэмдэг, гарын үсэгтэй байна.

2. Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд зөвшөөрлийн бичиг солилцох журмыг харилцан тохиролцоно.

АРАВДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч аль нэг Талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр орших хоёр цэгийн хооронд зорчигч болон ачаа тээвэрлэж болохгүй.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрт заасан тээвэрлэлтийг зөвхөн тухайн орны дотоодын хууль тогтоомжийн дагуу олон улсын тээвэрлэлт хийхээр зөвшөөрөгдсөн тээвэрлэгч гүйцэтгэнэ.

2. Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх авто тээврийн хэрэгсэл нь өөрийн улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байна. Ачааны автомашин, авто зүтгүүрүүд нь Монгол Улсын болон Беларусь Улсын бүртгэлийн дугаартай, таних

тэмдэгтэй байвал чиргүүл ба хагас чиргүүлүүд нь өөр улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байж болно.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэхэд олон улсын хэмжээнд нийтлэг мөрддөг загварт нийцсэн дагалдах хуудсыг хэрэглэнэ.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Автобус болон ачааны автомашины жолооч нь тухайн тээврийн хэрэгсэл жолоодох ангилалд болон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөхүйц загварт тохирсон тээврийн хэрэгслийн үндэсний бүртгэлийн бичиг баримт болон үндэсний буюу олон улсын жолоочийн үнэмлэхтэй байна.

2. Энэхүү Хэлэлцээрийн дагуу тээврийн хэрэгсэлд шаардагдах зөвшөөрлийн болон бусад баримт бичгийг тухайн тээврийн хэрэгсэлд авч явах бөгөөд түүнийг хяналт шалгалтын байгууллагуудын шаардлагаар үзүүлж байна.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрээр Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрээр зорчигч, ачаа тээвэрлэлт гүйцэтгэж буй Хэлэлцэн тохирогч аль нэг Талын тээвэрлэгч, түүнчлэн уг тээвэрлэлтийг гүйцэтгэж буй тээврийн хэрэгслийг харилцан ижил нөхцлөөр төлбөртэй зам, гүүр, хоолойгоос бусад уг Хэлэлцээрт дурьдсан зөвшөөрөл олгосны болон зам ашиглалт, үйлчилгээтэй холбогдсон хураамжаас тус тус чөлөөлөгдөнө.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу зорчигч, ачаа тээвэрлэлтийг гүйцэтгэхдээ тээврийн хэрэгсэл эзэмшигчийн иргэний хариуцлагыг заавал даатгуулсан байна.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Хилийн шалган нэвтрүүлэх, гаалийн болон хорио цээрийн шалгалтанд Хэлэлцэн тохирогч хоёр Талын нэгдэн орсон олон улсын гэрээ, хэлэлцээрийг мөрдөх бөгөөд харин эдгээр гэрээ, хэлэлцээрээр зохицуулагдахгүй асуудлыг шийдвэрлэхдээ Хэлэлцэн тохирогч холбогдох Талын дотоодын хууль тогтоомжийг дагаж мөрдөнө.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Хүнд өвчтөн тээвэрлэх, зорчигчдын байнгын тээвэрлэлтийг автобусаар гүйцэтгэх, мал, амьтан, түргэн муудах ачаа тээвэрлэхэд хил, гаалийн болон хорио цээрийн хяналт шалгалтыг эхний ээлжинд хийнэ.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн дагуу Хэлэлцэн тохирогч Тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг руу тээвэрлэлтийг гүйцэтгэхэд дор дурьдсан зүйлсийг Хэлэлцэн тохирогч тухайн улсын хууль тогтоомжид нийцүүлэн гаалийн татвар хураамжаас чөлөөлнө. Үүнд:

а) тухайн загварын тээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тэжээлийн системтэй технологийн болон бүтцийн талаар холбоо бүхий түлшний саванд байгаа шатахуун, мөн түүнчлэн хөргөх төхөөрөмжид зориулагдсан шингэн;

б) тээвэрлэлтийн явцад тээврийн хэрэгслийн хэвийн ашиглалтыг хангахад зайлшгүй хэрэглэгдэх тосолгооны материал;

в) олон улсын тээвэр хийж байгаа авто тээврийн хэрэгслийн засварт зориулагдсан сэлбэг, багаж хэрэгсэл;

2. Багаж хэрэгсэл, хэрэглэгдээгүй сэлбэгийг эргүүлэн тээвэрлэх бөгөөд харин солигдсон хуучин сэлбэгийг Хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрээс авч буцах буюу гаалийн байгууллагын хараа хяналтын дор устгах эсвэл Хэлэлцэн тохирогч нөгөө талын үндэсний хууль тогтоомжийн дагуу тус байгууллагад тусаах ёстой.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээвэрлэгчид тухайн талын хууль тогтоомж, замын хөдөлгөөний дүрмийг биелүүлэх үүрэгтэй.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийг тээвэр гүйцэтгэгч зөрчсөн тохиолдолд тээвэрлэгч улсын эрх бүхий байгууллага нь нутаг дэвсгэрт нь зөрчил гарсан Хэлэлцэн тохирогч Талынхаа эрх бүхий байгууллагын хүсэлтээр энэхүү Хэлэлцээрийн биелэлтийг хангахад шаардагдах холбогдох арга хэмжээ авна.

Тээвэрлэгч улсын эрх бүхий байгууллага авсан арга хэмжээнийхээ тухай Хэлэлцэн тохирогч нөгөө Талынхаа эрх бүхий байгууллагад мэдээлнэ.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Зөвшөөрлийн тоо хэмжээ, түүний хэлбэрийг тохирох болон энэхүү Хэлэлцээрийн гүйцэтгэлийг хангах зорилгоор Хэлэлцэн тохирогч Талуудын эрх бүхий байгууллагууд нь Хамтарсан Комиссыг байгуулна. Хамтарсан Комиссын уулзалтыг Хэлэлцэн тохирогч аль нэг Талын эрх бүхий байгууллагын саналаар Хэлэлцэн тохиорогч талуудын нутаг дэвсгэрт ээлжлэн зохион байгуулна.

ТӨГСГӨЛИЙН ХЭСЭГ

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрээр болон Хэлэлцэн тохирогч хоёр талын нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрээр зохицуулагдахгүй асуудлыг Хэлэлцэн тохирогч тал тус бүрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах, мөрдөх явцад гарч болох маргаантай бүх асуудлыг хэлэлцээний болон зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

ХОРИН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын нэгдэн орсон олон улсын бусад гэрээ хэлэлцээрээр хүлээсэн эрх үүргийг хөндөхгүй.

ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээр нь түүнийг хүчин төгөлдөр болоход шаардагдах бүх ажиллагааг улс бүрд гүйцэтгэх тухай Хэлэлцэн тохирогч талууд дипломат шугамаар бие биедээ мэдээлснээс хойш 30 дахь хоногоос эхлэн хүчин төгөлдөр болно.


2. Энэхүү Хэлэлцээрийг тодорхойгүй хугацаагаар байгуулав. Хэлэлцэн тохирогч аль нэг Тал нь энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоохоор товлож байгаа хугацаанаас 6 сарын өмнө энэ тухайгаа Хэлэлцэн тохиролцогч нөгөө талд дипломат шугамаар мэдэгдэх замаар түүний үйлчлэлийг зогсоож болно.

Энэхүү Хэлэлцээрийг 2003 оны 12 дугаар сарын 10 –ны өдөр Москва хотноо монгол, беларусь, орос хэл дээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байна. Хэрэв энэхүү Хэлэлцээртэй холбоотой санал зөрөлдөөн гарсан тохиолдолд орос хэл дээрх бичвэрийг баримтална.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ТӨЛӨӨЛЖ**



**БҮГД НАЙРАМДАХ БЕЛАРУСЬ ГАЗРЫГ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**



**ОЛОН УЛСЫН АВТОТЭЭВРИЙН ХАРИЛЦААНЫ ТУХАЙ
МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Киргиз Улсын Засгийн газар /цаашид “хэлэлцэн тохирогч Талууд гэнэ/,

харилцан тэгш эрхтэй байх зарчмын үндсэн хоёр орны хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх ачаа, зорчигч тээврийн харилцааг хөгжүүлэх, хөнгөвчлөхийг удирдлага болгон,

дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиров:

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1.Энэхүү Хэлэлцээрийн дагуу автотээврээр хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх, мөн гуравдагч улс руу ба гуравдагч улсаас гүйцэтгэгдэх ачаа, зорчигч тээвэрлэлтийг Монгол Улс , Бүгд Найрамдах Киргиз Улсын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгслээр гүйцэтгэнэ.

2.Энэхүү хэлэлцээр нь Хэлэлцэн тохирогч Талуудын олон улсын бусад гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн эрх, үүргийг хөндөхгүй.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү хэлэлцээрт тусгагдсан нэр томъёо нь дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:

а)"эрх бүхий байгууллагууд":

- Монгол Улсын Талаас - Монгол Улсын Дэд бүтцийн яам, 7,11,15 дугаар зүйлүүдээр Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яам.

- Бүгд Найрамдах Киргиз Улсын Талаас - Бүгд Найрамдах Киргиз Улсын Тээвэр холбооны яам, 7, 11, 15 дугаар зүйлүүдээр Бүгд Найрамдах Киргиз Улсын Дотоод хэргийн яам.

Хэрэв дээр дурьдсан эрх бүхий байгууллагуудын нэр өөрчлөгдвөл шинэ байгууллагуудын нэрийг хэлэлцэн тохирогч талууд нөгөө талдаа дипломат шугамаар мэдэгдэнэ.

б)"тээвэрлэгч" гэж: хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэр дээр бүртгэлтэй. үндэсний хууль тогтоомжид нийцүүлэн олон улсын ачаа зорчигч тээвэрлэлт гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг;

в)"тээврийн хэрэгсэл" гэж:

зорчигч тээвэрлэлтэд - автобус, өөрөөр хэлбэл жолоочийн суудлыг оруулаад 9-өөс доошгүй хүний суудалтай зорчигч тээвэрлэх зориулалт бүхий автотээврийн хэрэгсэл, түүнчлэн зорчигчдын тээш тээвэрлэх чиргүүл;

ачаа тээвэрлэлтэд - ачааны автомашин, чиргүүлтэй ачааны автомашин, авто зүтгүүр буюу хагас чиргүүлтэй авто зүтгүүр;

г) "зөвшөөрөл" гэж: хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрт бүртгэлтэй тээврийн хэрэгсэл хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрээр тээвэрлэлт гүйцэтгэх эрх олгосон баримт бичиг;

д) "дамжин өнгөрөх тээвэрлэлт" хэлэлцэн тохирогч аль нэг талын нутаг дэвсгэрээр дамжуулан гуравдагч улсуудад гүйцэтгэх тээвэрлэлт;

е) зорчигчийн байнгын тээвэрлэлт" гэж: хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын урьдчилан тохиролцсон хөдөлгөөний цагийн хуваарь, эхний болон эцсийн буудал, зогсоолуудыг заасан аялалын замналын дагуу автотээврийн хэрэгслээр гүйцэтгэх зорчигч тээвэрлэлт;

ж) "зорчигчийн байнгын бус тээвэрлэлт" гэж: "зорчигчийн байнгын тээвэрлэлт" тодорхойлолтонд ороогүй зорчигч тээвэрлэлт;

з) "хорио цээрийн шалгалт" гэж: ариун цэвэр, мал эмнэлэг, мөн түүнчлэн ургамал хорио цээрийн шалгалтыг хэлнэ,

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх зорчигчийн байнгын тээвэрлэлтийг харилцан тэгш эрхтэй байх зарчмын үндсэн дээр хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын тохиролцооны дагуу зөвшөөрөлгүй гүйцэтгэнэ.

2. Зорчигчийн байнгын тээвэрлэлтийг зохион байгуулах тухай саналыг хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд бие биедээ урьдчилан өгнө. Энэ саналд тээвэрлэгчийн нэр, аялалын замнал, хөдөлгөөний цагийн хуваарь, үнэ тариф, зорчигчдыг буулгах, суулгах буудал зогсоол, түүнчлэн тээвэрлэлтийг гүйцэтгэх хугацаа, давтамжийн талаархи мэдээллийг заавал тусгасан байна.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх зорчигчийн байнгын бус тээвэрлэлтийг зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх бөгөөд бүлэг зорчигчдыг нэг автобусаар тээвэрлэх дараах тохиолдлуудад:

а) тээвэрлэлт нь автобус бүртгэгдсэн хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрээс эхэлж, дуусаж байгаа тохиолдолд

б) тээвэрлэлт нь автобус бүртгэгдсэн хэлэлцэн тохирогч нэг талын нутаг дэвсгэрээс эхлэж, эргэж явах нөхцөлтэйгээр хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт дуусаж байгаа тохиолдолд

Мөн түүнчлэн:

а) хоосон автобус буцаж тээвэрлэлт гүйцэтгэх зорилгоор хэлэлцэн тохирогч нөгөө Талын нутаг дэвсгэрээс бүлэг зорчигчдыг тээвэрлэн (энэ зүйлийн 1 дүгээр хэсгийн “б” заалтанд заасан тохиолдол) анхны тээвэрлэсэн цэгт хүргэх тохиолдолд

б)эвдэрсэн автобусыг өөр автобусаар солих тохиолдолд

ТАВДУГААР ЗҮЙЛ

Хоёр улсын хооронд болон тэдгээрийн нутгаар дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлт нь зөвшөөрлийн дагуу гүйцэтгэгдэнэ. Тээврийн хэрэгслүүдийг үндэслэлгүйгээр саатуулах, янз бүрийн хязгаарлалт хийхгүй байх бөгөөд гаалийн бүрдүүлэлт нь зөвхөн үнэт цаасаар баталгаажсан барааны хүрээнд гүйцэтгэгдэнэ.

Энэ журам нь хоосон тээврийн хэрэгслүүдэд мөн хамаарна.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч Талууд нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын тээврийн хэрэгслүүдийг өөрийн нутагт нэвтрэх болон дамжин өнгөрөх, гуравдагч улс руу тээвэрлэлт гүйцэтгэх тааламжтай нөхцөлийг бүрдүүлнэ.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

2. Энэхүү Хэлэлцээрт заасан тээвэрлэлтийг тухайн орны дотоодын хууль тогтоомжийн дагуу олон улсын тээвэрлэлт хийхээр зөвшөөрөгдсөн тээвэрлэгч л зөвхөн гүйцэтгэнэ.

2. Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх автотээврийн хэрэгсэл нь өөрийн улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байна. Чиргүүл ба хагас чиргүүл нь өөр улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байж болох бөгөөд ачааны автомашин, автозүтгүүрүүд нь Монгол Улс болон Бугд Найрамдах Киргиз Улсын бүртгэлийн дугаар, таних тэмдэгтэй байх шаардлагатай.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч нэг талын автотээврийн хэрэгслийн овор болон жин, тэнхлэг дээрхи ачаалал нь хэлэлцэн тохирогч нөгөө талын тогтоосон нормоос хэтэрсэн тохиолдолд тээвэрлэгч нь эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авна.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Аюултай ачааг тээвэрлэхдээ Монгол Улс, Бүгд Найрамдах Киргиз Улсын элссэн олон улсын гэрээ, хэлэлцээрүүдээр тавигдсан болон Хэлэлцэн тохирогч Талуудын дотоодын хууль тогтоомжийн заалтын шаардлагуудыг бүрэн хангана.

АРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгч нь хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр орших хоёр цэгийн хооронд зорчигч болон ачаа тээвэрлэхийг хориглоно.

2. Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгч нь хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан тохиолдолд хэлэлцэн тохирогч нөгөө талын нутгаас гуравдагч улсын нутагт тэрчлэн гуравдагч улсын нутгаас хэлэлцэн тохирогч нөгөө талын нутагт зорчигч болон ачаа тээвэрлэлт гүйцэтгэж болно.

3. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд тусгай зөвшөөрлийн бичгийг солилцох журмын талаар харилцан тохиролцоно. Энэхүү тусгай зөвшөөрлүүд нь зөвшөөрөл олгосон эрх бүхий байгууллагын тамга тэмдэг, албан тушаалтны гарын үсэгтэй байна.

4. Тусгай зөвшөөрөлүүд нь 2 дугаар сарын 1-нээс дараа жилийн 2 дугаар сарын 1 хүртэл бүтэн жилийн турш хүчинтэй байна.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Автотээврийн хэрэгслийн жолооч нь тухайн тээврийн хэрэгслийг жолоодох ангилалд тохирсон олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдөх загварт тохирсон үндэсний буюу олон улсын жолоочийн үнэмлэх, тээврийн хэрэгслийн улсын гэрчилгээтэй байна.

2. Энэхүү Хэлэлцээрийн дагуу шаардагдах зөвшөөрөл болон бусад баримт бичгийг тээврийн хэрэгсэлдээ авч яван, хяналт шалгалтын эрх бүхий байгууллагуудын шаардлагаар үзүүлж байна.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн үндсэн дээр хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээгүүр зорчигч болон ачаа (овор ихтэй, хүнд ачаанаас бусад) тээвэрлэлт гүйцэтгэж байгаа тээвэрлэгч нь төлбөртэй автозам, замын байгууламж, гүүр, хонгил ашигласны төлбөрөөс бусад зам ашигласны төлбөр, хураамжаас харилцан чөлөөлөгдөнө. (ялангуяа хэлэлцэн тохирогч нөгөө Талын тээвэрлэгч)

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн үндсэн дээр тээвэрлэлт гүйцэтгэхдээ хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг руу тээвэрлэж яваа доорхи зүйлсийг гаалийн татвар, хураамжаас харилцан чөлөөлнө.

а) тухайн загварын автотээврийн хэрэгслийн хөдөлгүүрийн тэжээлийн системтэй холбогдсон технологийн болон зохион байгуулалт, бүтцийн талаар холбоо бүхий түлшний саванд байгаа шатахуун, үйлдвэрлэгч заводын тогтоосон чиргүүл болон хагас чиргүүл ба тээврийн хэрэгслийн халаах, хөргөх төхөөрөмжийн ажиллагаанд зориулсан түлшний саванд байгаа шатахуун;

б) тээвэрлэлтийн явцад зайлшгүй хэрэглэгдэх хэмжээний тосолгооны материал;

в) олон улсын тээвэрлэлт гүйцэтгэж байгаа автотээврийн хэрэгслийн засварт зориулсан сэлбэг багаж хэрэгсэл;

2. Хэрэглээгүй сэлбэгийг эргүүлэн тээвэрлэнэ. Харин солигдсон хуучин сэлбэгийг тухайн улсаас авч буцах, эсвэл Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт тогтоогдсон журмын дагуу устгах буюу тушаана.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн дагуу зорчигч, ачаа тээвэрлэлтийг тээврийн хэрэгсэл эзэмшигчийн иргэний болон гуравдагч этгээдийн өмнө хүлээх хариуцлагыг заавал даатгуулсан нөхцөлд гүйцэтгэнэ.

Тээвэрлэгч дурьдсан тээвэрлэлтийг гүйцэтгэх тээврийн хэрэгсэл бүрийг урьдчилан заавал даатгуулсан байна.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч Талуудын тээвэрлэгч нь энэхүү Хэлэлцээрийн заалтуудыг заавал биелүүлэх бөгөөд автотээврийн хэрэгсэл нутаг дэвсгэрт нь оршиж байгаа тухайн улсын дотоодын хууль тогтоомж, ялангуяа замын хөдөлгөөний дүрмийг дагаж мөрдөнө.

2. Хэлэлцэн тохирогч нэг Талын тээвэрлэгч нь хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэр дээр замын хөдөлгөөний дүрэм, тээвэрлэлтийн дүрэм журмыг ноцтой болон давтан зөрчсөн тохиолдолд зөрчил гаргасан тээвэрлэгчийн Талын эрх бүхий байгууллага, зөрчил үйлдэгдсэн нөгөө орныхоо эрх бүхий байгууллагын хүсэлтээр энэхүү хэлэлцээрийн биелэлтийг хангахад шаардагдах бүхий л арга хэмжээг авна.

Тээвэрлэгч улсын эрх бүхий байгууллага авсан арга хэмжээний талаар нөгөө талын эрх бүхий байгууллагад мэдээлнэ.

3. Энэ зүйлийн заалтуудын дагуу тээвэрлэгчид зөрчил гарсан улсын нутаг дэвсгэрийн дотоодын хууль тогтоомжийн дагуу шаардлагатай арга хэмжээ авна.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр болон түүнчлэн Хэлэлцэн тохирогч хоёр талын оролцсон олон улсын гэрээгээр зохицуулагдахгүй асуудлыг нутаг дэвсгэрт нь тухайн тээвэрлэлт хийгдэж байгаа хэлэлцэн тохирогч талын дотоодын хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжилтийг хангах зорилгоор

эрх бүхий байгууллагууд бүхий л ашигтай мэдээллүүдийг харилцан солилцоно. Энэхүү хэлэлцээрийн хэрэгжилтэнд нөлөөлж болох өөр өөрийн улсын дотоодын хууль тогтоомжийн өөрчлөлтийн талаар хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд бие биедээ мэдээлнэ.

2. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрийг тайлбарлах, хэрэглэх явцад гарч болох маргаантай асуудлуудыг хэлэлцэх болон зөвлөлдөх замаар шийдвэрлэнэ.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээрийн хэрэгжүүлэх явцад гарч байгаа асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын хэмжээнд уулзалт зохион байгуулна. Уулзалтыг хэлэлцэн тохирогч талуудын нутаг дэвсгэр дээр ээлжлэн зохион байгуулах бөгөөд уулзалт зохион байгуулах саналаа 1 сарын өмнө дипломат шугамаар хэлэлцэн тохирогч нөгөө талдаа өгнө.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

5 Энэхүү хэлэлцээр нь түүнийг хэлэлцэн тохирогч талуудын дотоодын хууль тогтоомжийн дагуу хэлэлцээрийг баталсан тухай мэдээллийг дипломат шугамаар хүлээж авсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

6. Энэхүү хэлэлцээрийг тодорхой хугацаагүй байгуулав.

Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь энэхүү Хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоохоор товлож байсан хугацаанаасаа 6 сарын өмнө энэ тухайгаа хэлэлцэн тохирогч нөгөө талдаа бичгээр илэрхийлэх замаар хэдийд ч уг хэлэлцээрийн үйлчлэлийг зогсоож болно.

Энэхүү хэлэлцээрийг 2004 оны 3 дугаар сарын 01-ний өдөр Бишкек хотноо монгол, киргиз, орос хэлээр тус бүр 2 хувь үйлдсэн бөгөөд эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**

МОНГОЛИЙ



**БҮГД НАЙРАМДАХ КИРГИЗ
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ**

ТӨЛӨӨЛЖ



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР,
БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ХООРОНДЫН АВТОТЭЭВРИЙН ХЭЛЭЛЦЭЭР**

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар (цаашид "Хэлэлцэн тохирогч талууд" гэх) хоёр улсын эдийн засаг, худалдааны харилцааг амжилттай хөгжүүлэх нь нэн чухал гэж үзээд эрх тэгш, харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр хоёр улсын олон улсын автотээврийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор дор дурдсан зүйлийг хэлэлцэн тохиролцов.

НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу хоёр улсын хоорондын тогтмол болон тогтмол бус хугацаанд хийх зорчигч (жуулчид хамрагдана) тээвэр, байнгын болон түр хугацаанд хийх ачаа тээврийг харилцан тохиролцсон хилийн боомтоор нэвтрэх, тогтоосон тээврийн маршрутын дагуу Монгол Улс, эсхүл БНХАУ-д бүртгэлтэй тээвэрлэгч, түүнд харьяалагдах автомашинаар гүйцэтгэнэ.

1. Энэхүү Хэлэлцээрт хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- 1) "Тээврийн маршрут" гэж хоёр улсын худалдаа, эдийн засгийн хөгжил, хүмүүсийн харилцан зорчих шаардлагаар хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцэн тогтоосон хоёр улсын тээврийн автомашин зорчих замыг хэлнэ. Маршрут нь эхлэх цэг, нэвтрэх боомт, дамжин өнгөрөх газар, дундын зогсоол, хүрэх цэгтэй байна;
- 2) "Зорчигчдын тогтмол тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон эхлэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол, хүрэх цэг бүхий тээврийн маршрут, тээвэрлэлтийн давтамж, цагийн хуваарийн дагуу гүйцэтгэж буй зорчигч тээвэрлэлтийг;
- 3) "Зорчигчдын тогтмол бус тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон эхлэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол, хүрэх цэг бүхий тээврийн маршрутын дагуу гүйцэтгэж буй зорчигч тээвэрлэлтийг;
- 4) "Байнгын ачаа тээвэр" гэж хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон хугацаа, эхлэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол, хүрэх цэг бүхий тээврийн маршрутын дагуу гүйцэтгэж буй ачаа тээвэрлэлтийг;
- 5) Түр хугацааны ачаа тээвэр" гэж Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон эхлэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол, хүрэх цэг бүхий тээврийн маршрутын дагуу гүйцэтгэж буй ачаа тээвэрлэлтийг;
- 6) Олон улсын тээвэр хийх автомашины зорчих зөвшөөрөл" (цаашид "зорчих зөвшөөрөл" гэх) гэж энэхүү хэлэлцээрийн дагуу хэлэлцэн тохирогч нэг тал нь хэлэлцэн тохирогч нөгөө талын автомашиныг өөрийн нутаг дэвсгэрт нэвтрүүлж тээвэрлэлт гүйцэтгэхийг зөвшөөрсөн эрхийн бичгийг;
- 7) "Олон улсын тээвэр хийх автомашины онцгой зөвшөөрөл" гэж (цаашид "онцгой зөвшөөрөл" гэх) энэхүү Хэлэлцээрийн 5 дугаар зүйлд заасан тээвэрлэлт

гүйцэтгэх эрхийн бичгийг;

- 8) "Эрх бүхий байгууллага" гэж Хэлэлцэн тохирогч талуудын олон улсын автозамын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон түүнээс эрх олгогдсон байгууллагыг;
- 9) "Аюултай ачаа" гэж Хэлэлцэн тохирогч талуудын нэгдэн орсон холбогдох олон улсын гэрээ, конвенци болон тээвэрлэлт гүйцэтгэгдэж буй улсын дотоодын хууль тогтоомж, стандартаар аюултайд тооцсон ачааг;
- 10) "Тээврийн автомашин" гэж ачаа тээвэрлэх зориулалтын автомашин, зүтгүүр, чиргүүл болон зорчигч тээвэрлэх зориулалтын 8-аас доошгүй хүний суудалтай (жолооч орохгүй) автобусыг.

ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд дараах зүйлийг хэлэлцэн тохиролцоно:

- 1) Энэхүү хэлэлцээрийг хэрэгжүүлэх протокол;
- 2) хоёр улсын хоорондын тогтмол болон тогтмол бус хугацааны зорчигч тээвэрлэлт, байнгын болон түр хугацааны ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн маршрут зэрэг холбогдох бусад асуудал;
- 3) зорчигчийн зорчих тасалбарын загвар, зорчигч болон ачааны дагалдах хуудасны загвар, агуулга, ашиглалт.

ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээрийн 4 дүгээр зүйлд зааснаас бусад тохиолдолд хэлэлцэн тохирогч нэг талын автомашин хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтрэхдээ хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагаас олгох зорчих зөвшөөрөл, эсхүл онцгой зөвшөөрөл авна.

2. Зорчих зөвшөөрөл болон онцгой зөвшөөрлийн бичгийн төрөл, агуулга, загвар, ашиглалт болон харилцан солилцох зэрэг асуудлыг энэхүү хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан протоколоор тодорхойлно.

3. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд зорчигч болон ачаа тээвэрлэлт гүйцэтгэх тээврийн маршрутыг тохиролцож, зорчих зөвшөөрлийг харилцан тэнцүү тоогоор солилцоно.

4. Жолооч нь зөвхөн зорчих зөвшөөрлийн болон онцгой зөвшөөрлийн бичигт заасан тээврийн маршрутаар тээвэрлэлт гүйцэтгэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Дор дурьдсан ачааг тээвэрлэж буй автомашин энэхүү хэлэлцээрийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан зорчих зөвшөөрлийн бичгийг авах шаардлагагүй:

- 1) үзэсгэлэн, яармаг зохион байгуулахад хэрэглэх үзмэр, тоног төхөөрөмж, материал;

- 2) биеийн тамирын арга хэмжээ зохион байгуулахад шаардагдах тээврийн хэрэгсэл, амьтан болон бусад төрөл бүрийн багаж хэрэгсэл, эд хөрөнгө;
- 3) тайзны засал чимэглэл болон тайзны хэрэгсэл, хөгжмийн зэмсэг, тоног төхөөрөмж, кино зураг авах, радио телевизийн нэвтрүүлэг бэлтгэхэд шаардагдах хэрэглэлүүд;
- 4) нас барагчийн шарил, чандар;
- 5) шуудан;
- 6) нүүж байгаа айлын эд хогшил;
- 7) давагдашгүй хүчин зүйл тохиолдсон үед хэрэглэх хүмүүнлэгийн болон эмнэлгийн түргэн тусламж үзүүлэхэд шаардагдах эд зүйлс;
- 8) хүмүүнлэгийн болон эмнэлгийн түргэн тусламжид ашиглах, эсхүл эвдэрч саатсан зорчигч тээврийн, ачаа тээврийн автомашиныг солиход хэрэглэх зүйлс;
- 9) энэхүү Хэлэлцээрийн 5 дугаар зүйлд заасан онцгой зөвшөөрөлтэй тээврийн автомашин болон түүгээр тээвэрлэж буй ачаа.

ТАВДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгч нь дараахь тохиолдолд хэлэлцэн тохирогч нөгөө талын эрх бүхий байгууллагаас урьдчилан авсан онцгой зөвшөөрөлтэй автомашинаар тээвэрлэлт гүйцэтгэнэ:

- 1) тээврийн автомашины оврын хэмжээ, бүрэн жин болон нэг тэнхлэг дээрх ачаалал нь Хэлэлцэн тохирогч нөгөө талын дотоодын хууль, техникийн стандартад заасан хэмжээнээс хэтрэх үед;
- 2) хэлэлцэн тохирогч нөгөө талын зам, тээврийн техникийн стандартад заасан хэмжээнээс хэтэрсэн, задлаж болдоггүй ачаа, барааг тээвэрлэх үед;
- 3) аюултай ачаа тээвэрлэх үед.

2. Онцгой зөвшөөрлийг олгох, ашиглах, хяналт тавих зэрэг асуудлыг энэхүү Хэлэлцээрийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан протоколоор тодорхойлно.

ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Энэхүү хэлэлцээрийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 10-т зааснаас бусад тээврийн автомашинаар харилцан зорчих асуудлыг Хэлэлцэн тохирогч талуудын холбогдох байгууллагууд хэлэлцэн шийдвэрлэнэ.

ДОЛДУГААР ЗҮЙЛ

1. Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгч болон түүний автомашин нь хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт эхэлж, төгсөх маршруттай тээвэрлэлт гүйцэтгэхгүй.
2. Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгч нь хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг

дэвсгэрээр дамжин гуравдагч улсын хилээр орж, гарах авто замын тээвэрлэлтийг Хэлэлцэн тохирогч талуудын нэгдэн орсон олон талт болон хоёр талын холбогдох хэлэлцээрийн дагуу гүйцэтгэнэ.

НАЙМДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээрт заасан авто замын тээвэрлэлтийг зөвхөн хэлэлцэн тохирогч талуудын өөр, өөрийн улсын дотоодын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн, олон улсын авто замын тээвэр хийх эрх бүхий тээвэрлэгч гүйцэтгэнэ.

2. Хоёр улсын хоорондын тээвэрлэлт гүйцэтгэх автомашин нь өөрийн улсын дугаар, ялгах тэмдэг, тээврийн хэрэгслийн гэрчилгээ, техникийн аюулгүй байдлын хяналтын гэрчилгээтэй байх бөгөөд тээврийн хэрэгслийн гэрчилгээг хэлэлцэн тохирогч нөгөө талын хэл рүү хөрвүүлсэн орчуулгатай байна.

ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Авто замын тээвэрлэлт гүйцэтгэж буй жолооч нь тухайн автомашиныг жолоодох эрх бүхий өөрийн улсын хүчин төгөлдөр үнэмлэх, түүний хэлэлцэн тохирогч нөгөө талын хэл рүү хөрвүүлсэн орчуулгатай байна.

2. Жолооч нь энэхүү хэлэлцээрт заасан зорчих зөвшөөрлийн бичиг, эсхүл онцгой зөвшөөрлийн бичиг болон бусад бичиг баримтыг автомашиндаа авч явах бөгөөд хэлэлцэн тохирогч талуудын зам, тээврийн асуудал эрхэлсэн болон хяналт, шалгалтын бусад байгууллагад шалгуулна.

АРАВДУГААР ЗҮЙЛ

1. Хоёр улсын хооронд зорчигчдын тогтмол тээвэр гүйцэтгэдэг тээвэрлэгч нь хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон эхлэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол, хүрэх цэг бүхий тээврийн маршрут, тээвэрлэлтийн давтамж, цагийн хуваарийн дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

2. Хоёр улсын хооронд зорчигчдын тогтмол бус тээвэр гүйцэтгэдэг тээвэрлэгч нь хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон эхлэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол, хүрэх цэг бүхий тээврийн маршрутын дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

1. Хоёр улсын хооронд ачаа тээвэрлэлт гүйцэтгэдэг тээвэрлэгч нь хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудын харилцан тохиролцсон эхлэх цэг, нэвтрэх боомт, дундын зогсоол, хүрэх цэг бүхий тээврийн маршрутын дагуу тээвэрлэлтийг гүйцэтгэнэ.

2. Хоёр улсын хоорондын ачаа тээвэрлэлтийг байнгын ачаа тээвэрлэлт болон түр хугацааны ачаа тээвэрлэлт гэж ангилна. Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд хоёр улсын хоорондын байнгын ачаа тээвэрлэлтийг хөгжүүлэхийг хөхүүлэн дэмжинэ.

АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

1. Энэхүү хэлэлцээрийн дагуу хоёр улсын хооронд авто замын тээвэрлэлт гүйцэтгэж буй Хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгчийг Хэлэлцэн тохирогч нөгөө тал тээвэрлэлтийн орлого болон ашгийн татвараас чөлөөлнө.

2. Энэхүү хэлэлцээрт заасан хоёр улсын хоорондын авто замын тээвэрлэлтийг гүйцэтгэх үед хэлэлцэн тохирогч нэг талын тээвэрлэгч хэлэлцэн тохирогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтэрсний дараа тухайн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу холбогдох төлбөр, хураамжийг төлнө.

АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ

1.Хэлэлцэн тохирогч талууд энэхүү хэлэлцээрийн дагуу гүйцэтгэж буй хоёр улсын хоорондын авто замын тээвэрлэлтийн явцад дор дурдсан барааг гаалийн татвараас харилцан чөлөөлнө:

- 1) Бүх төрлийн тээврийн автомашины хөдөлгүүрийг ажиллуулахад тохирох, түлшний савны багтаамжийн хэмжээгээр авч яваа шатахуун;
- 2) тээвэрлэлтийн явцад зайлшгүй шаардагдах хэмжээний тосолгооны материал;
- 3) тээврийн автомашины засвар үйлчилгээнд зайлшгүй шаардагдах сэлбэг, багаж хэрэгсэл.

2. Хэрэглэж дуусаагүй шатахуун, материал болон авч яваа багаж хэрэгслийг хилээр буцаан гаргана. Хилээр буцаан гаргахгүй бол тухайн улсын хууль тогтоомжийн дагуу татвар төлөх, эсхүл зохих бусад арга хэмжээ авна.

АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ

Тээвэрлэгч нь энэхүү хэлэлцээрт заасан хоёр улсын хоорондын авто замын тээвэрлэлтийг хийхдээ тээвэр хийгдэж буй улсын дотоодын холбогдох хууль тогтоомжид заасан заавап даатгуулах даатгалд хамрагдсан байна.

Даатгалтай холбоотой тодорхой асуудлыг хэлэлцэн тохирогч талуудын даатгалын байгууллага хэлэлцэн тогтооно.

АРВАН ТАВДУГААР ЗҮЙЛ

1.Хилийн шалган нэвтрүүлэх, гааль, хорио цээр зэрэг хилийн боомтын хяналт, шалгалтын байгууллагууд тээвэрлэлт гүйцэтгэж буй автомашинд болон түүгээр тээвэрлэж буй зорчигч, ачаанд хэлэлцэн тохирогч талуудын нэгдэн орсон олон талт болон хоёр талын холбогдох хэлэлцээрийн дагуу үзлэг, шалгалт хийнэ. Олон талт болон хоёр талын хэлэлцээр байхгүй бол Хэлэлцэн тохирогч талууд өөр, өөрийн улсын дотоодын хууль тогтоомжийн дагуу үзлэг шалгалт хийнэ.

2. Хилийн боомт дээр байгуулсан олон улсын авто замын тээврийг зохицуулах байгууллага нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хилээр нэвтэрч буй олон улсын авто замын тээвэрт тавих хяналт, зохицуулалтыг сайжруулна.

3. Хилийн шалган нэвтрүүлэх, гааль, хорио цээр зэрэг хилийн боомтын хяналт, шалгалтын байгууллагууд болон хилийн боомт дээр байгуулсан олон улсын авто замын тээврийг зохицуулах байгууллага зорчигчдын тогтмол тээвэр гүйцэтгэж буй автомашин, хүнд өвчтөн болон амьтан, ургамал, түргэн муудах бараа, аюултай ачаа тээвэрлэж буй тохиолдолд хийх үзлэг, шалгалтыг эхний ээлжинд хийнэ.

АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохи­рогч нэг талын тээвэрлэгч нь Хэлэлцэн тохи­рогч нөгөө талын нутаг дэвсгэрт нэвтэрсний дараа Хэлэлцэн тохи­рогч нөгөө талын дотоодын хууль тогтоомж, түүний дотор байгаль орчин, автозамын хөдөлгөөний аюулгүй байдал, тухайн орны зан заншлийг хүндэтгэх талаарх холбогдох хууль тогтоомжийг хүндэтгэн дагаж мөрдөх бөгөөд автомашиндаа тээвэрлэж буй бүх төрлийн ачаа, бараа нь Хэлэлцэн тохи­рогч нөгөө талын дотоодын хууль тогтоомжийн шаардлагад нийцсэн байна.

АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохи­рогч талуудын эрх бүхий байгууллагууд жил бүр тодорхой хугацаанд, эсхүл шаардлагатай үед уулзалт хийх бөгөөд хоёр улсын хоорондын авто замын тээвэртэй холбоотой асуудлаар зөвлөлдөнө. Тогтмол хугацаанд хийх уулзалтыг Хэлэлцэн тохи­рогч талуудын эрх бүхий байгууллагууд ээлжлэн удирдаж, дор дурдсан асуудлаар мэдээлэл солилцоно:

- 1) энэхүү Хэлэлцээр, протокол болон хоёр талын эрх бүхий байгууллагуудын уулзалтын протоколын хэрэгжилтийн байдал;
- 2) Зорчих болон онцгой зөвшөөрөл, түүний ашиглалт, хяналт шалгалтын байдал;
- 3) хилээр нэвтэрч буй зорчигч болон ачаа тээвэрлэлтийн тоо, хэмжээний үзүүлэлт;
- 4) хоёр улсын хоорондын авто замын тээвэрлэлтийн явцад үүсэн гарч буй холбогдох асуудлууд.

АРВАН НАЙМДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохи­рогч нөгөө талын зорчигч, ачаа, автомашинтай холбогдсон зам тээврийн осол гарах, давагдашгүй хүчин зүйлээс шалтгаалан авто замын тээвэрлэлт зогсох тохиолдолд нөхцөл байдал үүссэн талын эрх бүхий байгууллага бололцоотой бүх тусламж үзүүлж, нөгөө талын эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх бөгөөд өөрийн улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу асуудлыг шийдвэрлэнэ.

АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохи­рогч нэг тал нь Хэлэлцэн тохи­рогч нөгөө талын хоёр улсын хооронд авто замын тээвэрлэлт гүйцэтгэгч аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газрыг өөрийн улсад байгуулахыг зөвшөөрнө. Төлөөлөгчийн газар нь зорчигч болон ачаа тээвэрлэлтийн үйл ажиллагаа эрхлэхгүй.

Төлөөлөгчийн газар байгуулах тодорхой асуудлыг тухайн газрыг бүртгэх улсын хууль тогтоомжоор зохицуулна.

ХОРЬДУГААР ЗҮЙЛ

Энэхүү Хэлэлцээр нь Хэлэлцэн тохи­рогч талуудаас бусад улстай байгуулсан гэрээ, хэлэлцээрт заасан эрх, үүргийг үл хөндөнө.

ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ

Хэрэв энэхүү Хэлэлцээрийг тайлбарлах болон хэрэгжүүлэх явцад маргаан гарвал Хэлэлцэн тохи­рогч талуудын эрх бүхий байгууллагууд хэлэлцэн шийдвэрлэнэ.

ХОРИН ХОЁРДУГААР ЗҮЙЛ

Хэлэлцэн тохирогч талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү Хэлэлцээрт хэдийд ч нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

ХОРИН ГУРАВДУГААР ЗҮЙЛ


1. Хэлэлцэн тохирогч талууд энэхүү Хэлэлцээрийг хүчин төгөлдөр болгоход шаардагдах дотоодын хууль тогтоомжийн шаардлагыг хангасан тухайгаа бичгээр харилцан мэдэгдэх бөгөөд сүүлчийн мэдэгдэлийг хүлээн авсан өдрөөс хойш 30 дахь хоногоос эхлэн хүчин төгөлдөр болно.

2. Энэхүү Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн 1991 оны 6 дугаар сарын 24-ний өдөр Бээжин хотноо байгуулсан "БНМАУ-ын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын Автотээврийн хэлэлцээр" хүчингүй болно.

3. Энэхүү хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа нь 5 жил байна. Хэрэв хүчин төгөлдөр байх хугацаа дуусахаас 6 сарын өмнө Хэлэлцэн тохирогч аль нэг тал нь Хэлэлцэн тохирогч нөгөө талдаа хүчингүй болгох саналаа бичгээр мэдэгдээгүй бол энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр байх хугацаа 5,5 жилээр аяндаа сунгагдана.

Энэхүү Хэлэлцээрийг 2011 оны 6 дугаар сарын 16-ны өдөр Бээжин хотноо монгол, хятад хэлээр тус бүр хоёр эх хувь үйлдэж, гарын үсэг зурсан бөгөөд эх бичвэрүүд нь адил хүчинтэй байна.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН
ГАЗРЫГ ТӨЛӨӨЛЖ**



**БҮГД НАЙРАМДАХ ХЯТАД АРД
УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫГ
ТӨЛӨӨЛЖ**



ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ТУХАЙ КОНВЕНЦ

Хэлэлцэн тохирогч Талууд, хөдөлгөөний нэгдсэн дүрэм батлах замаар замын хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэх, мөн олон улсын замын хөдөлгөөнийг хөнгөвчлөхийн тулд доорхи зүйлсийг тохиролцов:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл. Тодорхойлолт

Энэ Конвенцид хэрэглэгдэх доорхи нэр томъёонуудыг энэ зүйлд заасан утгаар ойлгоно:

а) **“Үндэсний хууль тогтоомж”** - гэдэгт Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр дээр үйлчилж буй үндэсний буюу орон нутгийн хууль, дүрмийн цогц нийлбэрийг ойлгоно:

б) **“Олон улсын хөдөлгөөн”** - д оролцож байгаа тээврийн хэрэгсэл гэдэгт аливаа улсын нутаг дэвсгэр дээр байгаа тээврийн хэрэгсэл нь:

i) энэ улсын хувьд гадаадын харъяат гэгдэх бие хүн буюу хуулийн этгээдэд харъяалагдаж байвал:

ii) энэ улсад бүртгэгдээгүй бол:

iii) энэ улсад түр хугацаагаар орж ирсэн байвал:

тооцох бөгөөд гэхдээ Хэлэлцэн тохирогч аль ч Тал өөрийн нутаг дэвсгэр дээр нэгээс дээш жил (үргэлжлэх хугацааг Хэлэлцэн тохирогч Тал өөрөө тогтоож болно) тасралтгүй оршин байгаа аливаа тээврийн хэрэгслийг “Олон улсын хөдөлгөөн”-д оролцож байгаа гэж тооцохгүй байх эрхтэй.

Тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүнээс дор хаяж нэг нь энэ тодорхойлолтод нийцэж байвал уг тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүнийг “Олон улсын хөдөлгөөн”-д оролцож байна гэж үзнэ:

с) **“Суурин газар”** - гэдэгт түүн рүү орох, гарах хэсэг нь зохих тэмдгүүдээр тусгайлан тэмдэглэгдсэн буюу эсвэл үндэсний хууль тогтоомжид бусад байдлаар тодорхойлогдсон, барилгажсан нутаг дэвсгэрийг ойлгоно;

д) **“Зам”** - гэдэгт гудамж, замын хөдөлгөөнд нээлттэй зурвас газрыг ойлгоно;

е) **“Зорчих хэсэг”** - гэдэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулсан замын хэсгийг ойлгоно. Зам нь тусгаарлах зурвасаар зааглагдсан буюу өөр өөр түвшинд байрласан хэд хэдэн зорчих хэсэгтэй байж болно;

ф) **“Зорчих хэсгийн зах”** - гэдэгт захын эгнээ буюу унадаг дугуйн зам нь тодорхой тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнд зориулагдсан зорчих хэсэг дээр бусад хөдөлгөөнд оролцогчдын хувьд замын үлдэж байгаа хэсгийн захыг ойлгоно;

г) **“Эгнээ”** - гэдэгт мотоциклоос бусад автомашины хөдөлгөөнийг нэг эгнээгээр

явуулах боломж бүхий өргөнтэйгөөр зорчих хэсгийг дагуу хуваасан тэмдэглэлтэй буюу тэмдэглэлгүй зурвасыг ойлгоно;

h) **“Уулзвар”** - гэдэгт замууд нэг түвшинд нийлсэн буюу салсан аливаа огтлолцлыг ойлгоно;

i) **“Төмөр замын гарам”** - гэдэгт тус тусын зурвас бүхий төмөр зам буюу трамвайн замтай замын нэг түвшин дэх аливаа огтлолцлыг ойлгоно;

j) **“Тууш зам”** - гэдэгт замын дагуух эзэмшилд үйлчилдэггүй, автотээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулж тусгайлан байгуулсан замыг ойлгоно. Энэ зам нь:

i) зарим хэсэгтээ буюу түр зуурын горимоос бусад тохиолдолд эсрэг хөдөлгөөнтэй бөгөөд хоёр талын хөдөлгөөний зорчих хэсгүүд нь хоорондоо тусгаарлах зурвас буюу онцгой тохиолдолд бусад хэрэгслээр зааглагдсан байна;

ii) зам, төмөр зам, трамвайн зам, явган хүний замын алинтай ч нэг түвшинд огтлолцоогүй байна;

iii) тууш зам тусгайлан тэмдэглэгдсэн байна;

k) Үүнд:

i) **“Түр зогсолт”** - гэдэгт хүн буулгах, суулгах буюу ачаа ачих, буулгахад шаардагдах хугацаагаар тээврийн хэрэгслийг хөдөлгөөнгүй байлгахыг ойлгоно;

ii) **“Удаан зогсолт (зогсоолд байлгах)”** - гэдэгт хүн буулгах, суулгах буюу ачаа ачих, буулгахад шаардагдах хугацаагаар хязгаарлагдаагүй бөгөөд ямар нэг саадыг мөргөхөөс зайлсхийх буюу дүрмийн заалтыг биелүүлэхээс өөр шалтгаанаар тээврийн хэрэгслийг хөдөлгөөнгүй байлгахыг ойлгоно.

Гэхдээ тээврийн хэрэгслийг хөдөлгөөнгүй байлгасан хугацаа нь үндэсний хууль тогтоомжоор тогтоосон хугацаанаас хэтрээгүй бол Хэлэлцэн тохирогч Талууд энэ хэсгийн “ii”-т тодорхойлсон байдлаар тээврийн хэрэгслийг хөдөлгөөнгүй байлгасныг ч “түр зогссон” гэж тооцож болно. Түүнчлэн тээврийн хэрэгслийг хөдөлгөөнгүй байлгасан хугацаа нь үндэсний хууль тогтоомжоор тогтоосон хугацаанаас хэтэрч байвал Хэлэлцэн тохирогч Талууд энэ хэсгийн “i”-д тодорхойлсон байдлаар тээврийн хэрэгслийг хөдөлгөөнгүй байлгасныг ч “удаан зогссон” гэж тооцож болно;

l) **“Унадаг дугуй”** - гэдэгт унаж яваа хүний булчингийн хүчээр, тодруулбал дөрөөний буюу залуурын тусламжтайгаар явдаг, дор хаяж хоёр дугуйтай тээврийн хэрэгслийг ойлгоно;

m) **“Мопед (хөдөлгүүртэй унадаг дугуй)”** - гэдэгт 50 см³-ээс илүүгүй цилиндрийн багтаамж бүхий дотоод шаталтат хөдөлгүүрээр тоноглогдсон, техникийн дээд хурд нь 50 км/цаг-аас илүүгүй, хоёр буюу гурван дугуйтай тээврийн хэрэгслийг ойлгоно.

Гэхдээ Хэлэлцэн тохирогч Тал нь өөрийн үндэсний хууль тогтоомжид нийцүүлэх үүднээс ашиглагдах боломжийнхоо (тухайлбал дөрөөний тусламжтайгаар түүнийг хөдөлгөөнд оруулах боломж) хувьд унадаг дугуйн үзүүлэлтэд тохирохгүй, эсвэл техникийн дээд хурд, жин, хөдөлгүүрийнхээ зарим үзүүлэлтүүдээр тогтоосон хязгаараас давж байгаа тээврийн хэрэгслийг “мопед”-д тооцохгүй байж болно. Энэхүү тодорхойлолтын аль ч заалт нь Хэлэлцэн тохирогч Талуудаас замын хөдөлгөөнтэй холбоотой өөрийн үндэсний хууль тогтоомжийг хэрэгжүүлэхдээ мопедыг унадаг дугуйтай бүрэн адилтгаж үзэхэд нь саад болж

буй мэтээр ойлгогдох ёсгүй;

п) **“Мотоцикл”** - гэдэгт шаахайтай буюу шаахайгүй, хөдөлгүүрээр тоноглогдсон, хоёр дугуйтай аливаа тээврийн хэрэгслийг ойлгоно.

Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн үндэсний хууль тогтоомжид ачаалалгүй жин нь 400 кг-аас илүүгүй, гурван дугуйтай тээврийн хэрэгслийг мотоциклтой адилтгаж болно. “Мотоцикл” нэр томъёонд мопедыг хамааруулахгүй боловч Хэлэлцэн тохирогч Тал нь энэхүү Конвенцийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу зохих мэдэгдэл гаргасны үндсэн дээр мопедыг мотоциклтой адилтган үзэж болно;

о) **“Механикжсан тээврийн хэрэгсэл”** - гэдэгт мопед (мопедыг мотоциклтой адилтган үзэхгүй Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд) болон төмөр замаар явдаг тээврийн хэрэгслээс бусад өөрөө явдаг аливаа зам тээврийн хэрэгслийг ойлгоно;

р) **“Автомашин”** - гэдэгт хүн ба ачааг замаар тээвэрлэхэд зориулсан буюу ийм зориулалттай тээврийн хэрэгслийг замаар чирэхэд зориулсан механикжсан тээврийн хэрэгслийг ойлгоно. Энэ нэр томъёонд троллейбусыг, өөрөөр хэлбэл цахилгаан шугамтай холбогддог боловч төмөр замаар явдаггүй тээврийн хэрэгслийг мөн хамааруулах ба харин хөдөө аж ахуйн трактор зэрэг хүн ба ачааг замаар тээвэрлэх болон тэдгээрийг чирэх зориулалт нь туслах чанарын үүрэгтэй тээврийн хэрэгслийг хамааруулахгүй;

q) **“Чиргүүл”** - гэдэгт механикжсан тээврийн хэрэгслээр чирэхэд зориулагдсан аливаа тээврийн хэрэгслийг ойлгоно. Энэ нэр томъёонд хагас чиргүүлийг ч хамааруулна;

r) **“Хагас чиргүүл”** - гэдэгт түүний зарим хэсэг нь чирэгч автомашин дээр тулгуурласан байдлаар холбогдож ачаа болон чиргүүлийн жингийн нилээд хэсэг нь автомашинд ногдож явдаг чиргүүлийг ойлгоно;

s) **“Хөнгөн чиргүүл”** - гэдэгт бүх жин нь 750 кг-аас илүүгүй бүх төрлийн чиргүүлийг ойлгоно;

t) **“Тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн”** - гэдэгт замын хөдөлгөөнд нэгэн бүхэл цогц байдлаар оролцдог, холбогдсон тээврийн хэрэгслүүдийг ойлгоно;

u) **“Хагас чиргүүлтэй тээврийн хэрэгсэл”** - гэдэгт автомашин болон түүнтэй холбогдсон хагас чиргүүлийн бүрэлдэхүүнийг ойлгоно;

v) **“Жолооч (мал туугч)”** - гэдэгт автомашин, унадаг дугуй гэх мэт тээврийн хэрэгслийг жолоодож яваа буюу түүнчлэн замаар мал, сүрэг тууж яваа болон ердийн хөсөг (уналга, ачилгын мал амьтан) унаж, хөтөлж яваа хүнийг ойлгоно;

w) **“Бүх жин”** - гэдэгт тухайн тээврийн хэрэгслийг бүртгэсэн улсын эрх бүхий байгууллагаас тогтоосон тээврийн хэрэгслийн ачаатай дээд жинг ойлгоно;

x) **“Ачаалалгүй жин”** - гэдэгт ачаа, жолооч (экипаж), зорчигчгүй боловч шаардлагатай багаж хэрэгслийн бүрдэл, түлш шатахууны бүрэн нөөцтэй тээврийн хэрэгслийн жинг ойлгоно;

y) **“Ачаалалтай жин”** - гэдэгт ачаа, жолооч (экипаж), зорчигчтой тээврийн хэрэгслийн бодит жинг ойлгоно;

z) **“Хөдөлгөөний тухайн чиг”** ба **“Хөдөлгөөний батлагдсан тал”** - гэдэгт үндэсний хууль тогтоомжид тээврийн хэрэгслийн жолооч өөдөөсөө яваа бусад тээврийн хэрэгслийг

зүүн гар талаараа өнгөрөөж байхаар заасан тохиолдолд хөдөлгөөний баруун гар талыг, эсрэг тохиолдолд зүүн гар талыг ойлгоно;

аа) Жолооч бусад тээврийн хэрэгсэлд “**Зам тавьж өгөх**” гэдэгт бусад тээврийн хэрэгслийн жолоочийг хөдөлгөөний хурд ба чигээ гэнэт өөрчлөхөд хүргэхээр бол хөдөлгөөнөө эхлэхгүй буюу үргэлжлүүлэхгүй, эсвэл ямар нэг үйлдэл хийхгүй байхыг ойлгоно.

2 дугаар зүйл. Конвенцийн хавсралт

Энэ Конвенцийн дор дурдсан хавсралтууд нь түүний салшгүй хэсэг болно:

1 дүгээр хавсралт: Олон улсын хөдөлгөөнд автомашин ба чиргүүлийг оролцуулах үүргээс түдгэлзэх;

2 дугаар хавсралт: Олон улсын хөдөлгөөнд оролцож буй автомашин ба чиргүүлийн бүртгэлийн дугаар;

3 дугаар хавсралт: Олон улсын хөдөлгөөнд оролцож буй автомашин ба чиргүүлийн ялгах тэмдэг;

4 дүгээр хавсралт: Олон улсын хөдөлгөөнд оролцож буй автомашин ба чиргүүлийн таних шошго;

5 дугаар хавсралт: Автомашин ба чиргүүлд тавигдах техникийн нөхцөл;

6 дугаар хавсралт: Үндэсний жолоочийн үнэмлэх;

7 дугаар хавсралт: Олон улсын жолоочийн үнэмлэх.

3 дугаар зүйл. Хэлэлцэн тохирогч Талуудын хүлээх үүрэг

1. а) Хэлэлцэн тохирогч Талууд нь өөрийн нутаг дэвсгэр дээр мөрдөгдөж буй замын хөдөлгөөний дүрмийн утга санааг энэхүү Конвенцийн 2 дугаар бүлгийн заалтуудад нийцүүлэх талаар зохих арга хэмжээ авна. Уг дүрэм нь аль ч талаараа дээрх заалтуудтай зөрчилдөөгүй тохиолдолд:

i) уг дүрэмд тухайн Хэлэлцэн тохирогч Талын нутаг дэвсгэрт хамаарахгүй заалтуудыг оруулахгүй байж болно;

ii) уг дүрэм нь Конвенцийн 2 дугаар бүлэгт тусгагдаагүй заалтуудыг агуулсан байж болно.

б) Замын хөдөлгөөний дүрэмдээ энэхүү Конвенцийн 2 дугаар бүлгийн аль нэг заалтыг зөрчсөн заалт оруулсан Хэлэлцэн тохирогч Талуудад шийтгэл хүлээлгэхийг энэ хэсгийн заалтууд албадаагүй болно.

2. а) Хэлэлцэн тохирогч Талууд нь өөрийн нутаг дэвсгэр дээр үйлчлэх автомашин ба чиргүүлд тавигдах техникийн нөхцөлийн дүрмийг энэхүү Конвенцийн 5 дугаар хавсралтын заалтад нийцүүлэх талаар зохих арга хэмжээ авна. Энэ дүрэм нь 5 дугаар хавсралтад тусгагдаагүй боловч уг хавсралтын заалтаар тодорхойлсон аюулгүй байдлын зарчимтай зөрчилдөөхөөргүй заалтуудыг агуулсан байж болно. Мөн Хэлэлцэн тохирогч Талууд нь өөрийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй, олон улсын хөдөлгөөнд оролцох автомашин ба чиргүүлийг энэхүү Конвенцийн 5 дугаар хавсралтын заалтуудыг хангасан байх талаар

зохих арга хэмжээ авбал зохино.

б) Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр дээр үйлчилж буй дүрмийн хувьд энэ хэсгийн заалт нь энэхүү Конвенцоор автомашин гэж тооцоогүй механикжсан бусад тээврийн хэрэгслүүдэд тавигдах техникийн нөхцөлүүдийн талаар ямар нэг үүрэг хүлээлгээгүй болно.

3. Хэлэлцэн тохирогч Талууд нь энэхүү Конвенцийн 1 дүгээр хавсралтын түдгэлзсэн заалтуудыг харгалзан, энэхүү Конвенцийн 3 дугаар бүлгийн шаардлагуудыг хангасан автомашин, чиргүүл болон 4 дүгээр бүлгийн шаардлагыг хангасан жолооч нарыг өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулах үүрэг хүлээнэ. Мөн түүнчлэн Хэлэлцэн тохирогч Талууд нь 3 дугаар бүлгийн заалтын дагуу олгогдсон бүртгэлийн гэрчилгээ мөн бүлэгт заасан нөхцөлүүдэд нийцэж буй тээврийн хэрэгсэлд олгогдсон байвал түүнийг хүлээн зөвшөөрөх үүрэгтэй.

4. Энэхүү Конвенцийн 3 дугаар бүлэгт заасан нөхцөлийг бүрэн хангаагүй автомашин, чиргүүлийг өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулах, түүнчлэн бусад аль нэг Хэлэлцэн тохирогч Талаас 4 дүгээр бүлэгт зааснаас бусад тохиолдолд олгогдсон жолоочийн үнэмлэхийг өөрийн нутаг дэвсгэр дээр хүчинтэйд тооцох зорилгоор Хэлэлцэн тохирогч Тал бие дааж буюу хоёр Талын ба олон Талын хэлэлцээр байгуулах замаар авсан, эсвэл авах гэж буй арга хэмжээнүүдийг энэ Конвенцийн зорилгод тохирч байна гэж үзнэ.

5. Хэлэлцэн тохирогч Талууд нь энэхүү Конвенцийн 5 дугаар бүлэгт заасан техникийн нөхцөлийг хангасан унадаг дугуй, мопедыг жолоодож яваа, бусад Хэлэлцэн тохирогч Талын харъяат иргэдийг өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулах үүрэгтэй. Хэлэлцэн тохирогч аль ч Тал олон улсын хөдөлгөөнд оролцож яваа унадаг дугуй ба мопедын жолоочоос жолоочийн үнэмлэх шаардах ёсгүй. Гэхдээ энэхүү Конвенцийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мопедыг мотоциклтой адилтгаж үзэх мэдэгдэл хийсэн Хэлэлцэн тохирогч Тал нь олон улсын хөдөлгөөнд оролцож яваа мопедын жолоочоос жолоочийн үнэмлэх шаардаж болно.

5-бис. Хэлэлцэн тохирогч Талууд нь бүх шатны сургуулиудад замын хөдөлгөөний дүрмийн сургалтыг системтэй, байнга тогтмол явуулж байх талаар шаардлагатай арга хэмжээ авна.

5-тер. Хэрэв жолоодлогын сургалт нь мэргэжлийн жолооч бэлтгэх байгууллагад явагддаг бол сургалт явуулах багш нарын мэргэжлийн түвшин, сургалтын арга ажиллагаанд тавигдах наад захын шаардлагуудыг үндэсний хууль тогтоомжид тусгах хэрэгтэй.

6. Өөрийн улсын нутаг дэвсгэрт бүртгэгдсэн механикжсан тээврийн хэрэгсэл, чиргүүл нь зам тээврийн осолд холбогдсон буюу жолооч нь замын хөдөлгөөний дүрэм ноцтой зөрчсөн, үүний улмаас жолоодох эрх хасагдсан буюу бусад шийтгэл хүлээсэн байдлыг тодруулах талаар Хэлэлцэн тохирогч аль нэг Талаас гаргасан хүсэлтийн дагуу Хэлэлцэн тохирогч нөгөө Тал уг тээврийн хэрэгслийн жолоочийн нэр, шаардлагатай мэдээллийг тогтоож өгөх үүрэгтэй.

7. Хэлэлцэн тохирогч Талууд гааль, цагдаа, эрүүл ахуйн болон бусад ийм төрлийн хяналт бүрдүүлэлтийн журмыг хялбарчлах байдлаар олон улсын замын хөдөлгөөнийг хөнгөвчлөх зорилгоор хоёр Талын болон олон Талын хэлэлцээр байгуулах замаар авсан буюу авах гэж буй арга хэмжээнүүдийг энэхүү Конвенцийн зорилгод нийцсэнд тооцно.

8. Энэ зүйлийн 3, 5, 7 дахь хэсгийн заалтууд нь Хэлэлцэн тохирогч аль ч Тал өөрийн

орны хүн ба ачаа тээвэрлэх бизнесийн ажлын дүрэм, жолоочийн хариуцлагын даатгалын болон гаалийн дүрэм, түүнчлэн замын хөдөлгөөнд холбогдолгүй бусад салбарын дүрмийн заалтын дагуу автомашин, чиргүүл, унадаг дугуй, мопед болон тэдгээрийн жолооч, зорчигчдыг өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулах эрхийг хэрэгжүүлэхэд саад болохгүй.

4 дүгээр зүйл. Замын тэмдэг ба дохио

Вена хотноо гарын үсэг зурах үед энэхүү Конвенцтэй зэрэг нээлттэй болсон “Замын дохио, тэмдгийн тухай Конвенц”-д Хэлэлцэн тохирогч Тал болж оролцоогүй, энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд нь дараахь үүргийг хүлээнэ:

a) нутаг дэвсгэр дээрээ тавигдсан замын бүх тэмдэг, гэрлэн дохио, тэмдэглэл зэргийг нэгдсэн системд байлгах, тэдгээрийг хялбар танигдах байдлаар бүтээх, суурилуулах;

b) тэмдэг дохионы төрлийн тоо нь хязгаарлагдмал байх бөгөөд тэдгээр нь зөвхөн үр ашигтай гэж тооцогдсон газруудад тавигдсан байх;

c) анхааруулах тэмдгүүд нь жолоочид саадыг тухайн үед нь урьдчилан анхааруулахын тулд түүнээс хангалттай зайд тавигдсан байх;

d) Хориглох нь:

i) замын тэмдэг буюу түүний тулгуур, хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгсэл дээр уг тэмдэг, хэрэгслийн зорилгод хамааралгүй бусад зүйл байрлуулах; Гэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд ба тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь материаллаг ашиг хонжоо олох зорилгогүй ямар нэг эвсэл, холбоонд мэдээллийн чанартай тэмдэг тавихыг зөвшөөрч байгаа бол тэмдэг болон түүний тулгуур дээр (тэмдгийг зөв ойлгоход хүндрэл учруулахааргүй бол) тухайн эвсэл холбооны эмблемийг тэмдэглэхийг зөвшөөрч болно;

ii) замын тэмдэг буюу хөдөлгөөн зохицуулах бусад хэрэгсэлтэй андуурагдах, эсвэл тэмдэг дохионы үзэгдэлт ба үр дүнг бууруулах, мөн хөдөлгөөнд оролцогчдыг гялбуулах, тэдний анхаарлыг сарниулах, ингэснээр хөдөлгөөний аюулгүй байдлыг алдагдуулах үзүүлэн чимэглэлийн зүйл, зар сурталчилгааны самбар зэрэг хэрэгслүүд байрлуулах;

iii) явган хүний зам ба хөвөөн дээр явган зорчигчдын, ялангуяа өндөр настан, тахир дутуу хүмүүсийн хөдөлгөөнд саад болох байгууламж, тоног хэрэгсэл байрлуулах.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ ДҮРЭМ

5 дугаар зүйл. Замын тэмдэг, дохионы утга

1. Замын хөдөлгөөнд оролцогч нь замын гэрлэн дохио болон тэмдэг, тэмдэглэлийн заалтуудыг биелүүлэх үүрэгтэй төдийгүй түүнийг хөдөлгөөний бусад журамтай зөрчилдөж байсан ч мөрдөх ёстой.

2. Замын гэрлэн дохионы заалт нь хөдөлгөөний дараалал тогтоодог тэмдгийн заалтаас давуу байна.

6 дугаар зүйл. Замын хөдөлгөөн зохицуулах эрх бүхий ажилтны дохио

1. Замын хөдөлгөөн зохицуулах эрх бүхий ажилтан нь өдөр, шөнийн аль ч цагт тодорхой зайнаас сайн харагдаж, танигдаж байх ёстой.

2. Замын хөдөлгөөнд оролцогчид нь хөдөлгөөн зохицуулах эрх бүхий ажилтны өгсөн аливаа дохиог нэн даруй биелүүлэх үүрэгтэй.

3. Замын хөдөлгөөн зохицуулах эрх бүхий ажилтны дараахь дохионуудыг үндэсний хууль тогтоомжид тусгахыг зөвлөж байна:

а) гараа эгц дээш өргөх: энэ дохио нь аюулгүй байдалтайгаар нэгэнт зогсож амжихгүй болсон жолоочоос бусад бүх хөдөлгөөнд оролцогчийн хувьд “анхаар, зогс” гэсэн утгатайгаас гадна энэ дохиог өгөх үед түүнээс өмнө уулзварт нэгэнт орсон жолооч хөдөлгөөнөө үргэлжлүүлж болно;

б) нэг буюу хоёр гараа алдлах: алдалсан гарыг хөндлөн огтлох чигт яваа бүх хөдөлгөөнд оролцогчийн хувьд тэдгээрийн хөдөлгөөний чигээс үл хамааран “зогс” гэсэн утгатай байна. Зохицуулагч нь энэ дохиог өгчихөөд нэг буюу хоёр гараа буулгаж болох бөгөөд энэ тохиолдолд зохицуулагчийн ар буюу өвөр талаас хандсан жолоочид энэ дохио нь мөн “зогс” гэсэн утгатай байна;

с) улаан гэрлээр дохих: энэ дохио нь уг гэрэл рүү чиглэж яваа хөдөлгөөнд оролцогчийн хувьд “зогс” гэсэн утгатай байна.

4. Замын хөдөлгөөн зохицуулах эрх бүхий ажилтны дохио нь замын гэрлэн дохио, тэмдэг, тэмдэглэл буюу түүнчлэн замын хөдөлгөөний дүрмийн бусад заалтуудаас давуу байна.

7 дугаар зүйл. Нийтлэг журмууд

1. Замын хөдөлгөөнд оролцогч нь улс, нийгмийн болон амины өмчид хохирол учруулахгүй, хүмүүст аюул хүргэхгүй, хөдөлгөөнд саад, бэрхшээл, осолтой байдал бий болгохгүйгээр зорчино.

2. Замын хөдөлгөөнд оролцогч нь хөдөлгөөнийг түгжрүүлэх, зам дээр эд зүйл орхих, хаях, тавих буюу ямар нэгэн саад бий болгох зэргээр хөдөлгөөний аюулгүй байдлыг алдагдуулахыг хориглох тухай үндэсний хууль тогтоомжид тусгахыг зөвлөж байна. Ийм саад, аюултай байдал бий болгосон этгээд түүнийг аль болох нэн даруй арилгах, яаралтай арилгах боломжгүй бол энэ тухай бусад хөдөлгөөнд оролцогчдод анхааруулах талаар шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй.

3. Жолооч нь замын хөдөлгөөний эмзэг оролцогч болох явганаар болон унадаг дугуйгаар зорчигч, ялангуяа хүүхэд, өндөр настан, тахир дутуу хүмүүст илүү сонор сэрэмж, анхаарал, болгоомжлол тавих ёстой.

4. Жолооч нь замын хөдөлгөөнд оролцогчид ба замын дагуух оршин суугчдын тав тухыг алдагдуулахгүй, тухайлбал хэт чимээ шуугиан гаргахгүй, шороо тоос босгохгүй, боломжтой бол тээврийн хэрэгслээс хорт хий (утаа) гаргуулахгүй байхыг хичээх ёстой.

5. Хамгаалах бүсээр тоноглогдсон автомашины жолооч, зорчигчид нь үндэсний хууль тогтоомжид зааснаас бусад тохиолдолд хамгаалах бүс заавал хэрэглэнэ.

8 дугаар зүйл. Жолооч

1. Хөдөлгөөнд оролцож яваа тээврийн хэрэгсэл буюу тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн бүр жолоочтой байх ёстой.

2. Уналга, ачилгын мал амьтан, түүнчлэн мал, сүрэг нь (зохих ёсоор тэмдэглэгдсэн бүсээс бусад газарт) хариулга, эзэн (мал туугч)-тэй байх ёстой гэж үндэсний хууль тогтоомжид тусгахыг зөвлөж байна.

3. Жолооч нь биеийн болон сэтгэл зүйн зохих чадварыг эзэмшсэн байх ёстой бөгөөд түүний биеийн болон оюун ухааны байдал нь тээврийн хэрэгсэл жолоодох чадамжтай байвал зохино.

4. Механикжсан тээврийн хэрэгслийн жолооч нь тээврийн хэрэгсэл жолоодоход шаардагдах мэдлэг, дадлагатай байх ёстой. Гэхдээ энэ заалт нь үндэсний хууль тогтоомжид заасны дагуу жолоодлогын сургалт явуулахад саад болохгүй.

5. Жолооч (мал туугч) нь тээврийн хэрэгслээ (мал амьтнаа) ямагт өөрийн жолоодлого (хариулга)-д байлгана.

9 дүгээр зүйл. Мал сүрэг

Үндэсний хууль тогтоомжид мал туухыг хөнгөвчлөх зорилгоор сүргийг тохиромжтой тоогоор хэсэгчлэн хуваах, эдгээр хэсгүүдийн хоорондын зай нь хөдөлгөөнд нэн хялбар байхаар сонгох талаар тусгахыг зөвлөж байна.

10 дугаар зүйл. Зорчих хэсгээр байрлан явах

1. Хоёр улсын хоорондох хилийг дамжин өнгөрөхөд зориулагдсан буюу тусгай байдлаар ашиглагддаг замаас бусад бүх зам нь тухайн улсын хувьд хөдөлгөөний ижил чигтэй байна.

2. Замаар мал сүргийг туухдаа зорчих хэсгийн хөдөлгөөний батлагдсан талын захад аль болох ойрхон тууж явна.

3. Тээврийн хэрэгслийн жолооч нь энэхүү Конвенцийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг болон бусад эсрэг шинж чанартай зарим нэг заалтуудыг зөрчихгүйгээр зорчих хэсгийн хөдөлгөөний батлагдсан талын захад аль болох ойр байрлаж явна. Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжүүд нь ачааны тээврийн хэрэгслүүдийн зорчих хэсгээр байрлан явах журмын талаар илүү тодорхой зохицуулж болно.

4. Хоёр буюу гурван зорчих хэсэгтэй зам дээр тээврийн хэрэгслийн жолооч нь хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талын хөдөлгөөний зорчих хэсэгт нэвтрэн орох ёсгүй.

5. а) эсрэг хөдөлгөөнтэй дөрөв буюу түүнээс олон эгнээтэй зам дээр тээврийн хэрэгслийн жолооч нь эсрэг талын хөдөлгөөний эгнээнд нэвтрэн орох ёсгүй.

б) эсрэг хөдөлгөөнтэй гурван эгнээтэй зам дээр тээврийн хэрэгслийн жолооч нь эсрэг талын хөдөлгөөний захын эгнээнд нэвтрэн орох ёсгүй.

6. Хэрэв хөдөлгөөний нэмэлт эгнээ нь зохих тэмдгээр тэмдэглэгдсэн бол 11 дүгээр зүйлийн заалтыг зөрчихгүйгээр удаан явдалт тээврийн хэрэгслийн жолооч энэ эгнээг ашиглах ёстой.

11 дүгээр зүйл. Гүйцэж түрүүлэх ба зэрэгцэн явах

1. а) Гүйцэж түрүүлэх үйлдлийг хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талаар гүйцэтгэнэ.

б) Хэрэв гүйцэгдэж байгаа жолооч (мал туугч) нь хөдөлгөөний батлагдсан талын эсрэг тал руу эргэхээр дохио өгөөд тээврийн хэрэгслээ (малаа) тэр тал руу, замаас гаргахаар юмуу өөр зам руу оруулахаар, эсвэл тэр талд зогсоохоор чиглүүлсэн байвал гүйцэж түрүүлэх үйлдлийг хөдөлгөөний батлагдсан талаар нь гүйцэтгэнэ.

2. Жолооч гүйцэж түрүүлэхийн өмнө энэ Конвенцийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалт болон 14 дүгээр зүйлийн заалтыг зөрчихгүйгээр дараахь нөхцөлүүдийг анхаарч мэдсэн байвал зохино:

а) араас яваа жолооч гүйцэж түрүүлэх үйлдэл хийж эхлээгүй байгааг;

б) уг эгнээгээр урд яваа жолооч өөр тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэхээр дохио өгөөгүй болохыг;

в) өөдөөс яваа тээврийн хэрэгсэлд саад, аюул учруулахгүй байх боломжтой эсэх, тодруулбал орох гэж буй эгнээнд хоёр тээврийн хэрэгслийн хурдыг харьцуулахад богино хугацаанд гүйцэж түрүүлэх үйлдлийг хийхэд хангалттай зай чөлөөтэй байгаа эсэх;

д) сөрөг хөдөлгөөнийг хориглосон эгнээ рүү орохоос бусад тохиолдолд жолооч нь гүйцэгдэж байгаа болон бусад хөдөлгөөнд оролцогчдод саад учруулахгүйгээр энэ Конвенцийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан байраа эзэлж болохыг.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг хэдийгээр биелүүлсэн ч замын өгсүүр хэсгийн төгсгөлд буюу үзэгдэлт хангалтгүй эргэлтэн дээр (замын энэ хэсэг нь эсрэг урсгалыг тусгаарласан тэмдэглэлтэй бөгөөд гүйцэж түрүүлэх үйлдлийг эсрэг урсгал сөрөхгүйгээр гүйцэтгэх боломжтойгоос бусад тохиолдолд) гүйцэж түрүүлэх үйлдэл хийхийг хориглоно.

4. Гүйцэж түрүүлж байх үедээ гүйцэгдэж байгаа болон бусад хөдөлгөөнд оролцогчдод хангалттай хэмжээний хажуугийн зай үлдээнэ.

5. а) Тухайн чигт хоёр буюу түүнээс олон эгнээтэй замд гүйцэж түрүүлэх үйлдэл хийсэн жолооч дахин ийм үйлдлийг шууд угсруулан хийх юмуу энэ Конвенцийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтын дагуу буцаж эгнээндээ орох боловч даруй дахин гүйцэж түрүүлэх үйлдэл хийх хэрэгтэй бол энэ үйлдлийг хийхийн тулд араасаа хурдтай яваа тээврийн хэрэгслийн жолоочид ноцтой хүндрэл учруулахгүй гэдгийг урьдчилан мэдсэний үндсэн дээр эхний гүйцэж түрүүлэх үйлдэл хийсэн эгнээндээ үлдэж болно.

б) Гэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжүүд нь энэ зүйлийн заалтыг унадаг дугуй, мопед, мотоцикл болон энэхүү Конвенцоор автомашин гэж тооцдоггүй тээврийн хэрэгсэл, мөн түүнчлэн бүх жин нь 3500 кг-аас илүү буюу техникийн дээд хурд нь 40 км/цаг-аас илүүгүй автомашины жолооч нарт хамааруулахгүй байж болно.

6. Энэ зүйлийн 5 дахь хэсгийн “а” заалтыг хэрэгжүүлж байгаа болон тээврийн хэрэгслүүд хөдөлгөөний тухайн чигийн зорчих хэсгийн бүх өргөнийг эзэлсэн, тээврийн хэрэгслүүдийн хурд нь урд яваа тээврийн хэрэгслийн хурдаас хамааралтай, хөдөлгөөний эрчим ихтэй байгаа үед:

а) нэг эгнээний тээврийн хэрэгслүүд нь зэрэгцээ эгнээнд яваа тээврийн хэрэгслээс илүү хурдтай явж байгааг гүйцэж түрүүлэх үйлдэл гэж энэхүү зүйлийн дагуу үзэхгүй (энэхүү заалт нь энэ зүйлийн 9 дэх хэсгийн заалтыг үгүйсгээгүй болно);

b) зорчих хэсгийн хөдөлгөөний батлагдсан талын захад аль болох ойрхон эгнээнд яваагаас бусад тээврийн хэрэгслийн жолооч нар зөвхөн баруун, зүүн гар тийш эргэх буюу зогсоол руу орохын тулд уг эгнээнээс гарч болно. Гэхдээ энэ зүйлийн 5 дахь хэсгийн “b”-г үндэслэн гаргасан үндэсний хууль тогтоомжийн заалтын дагуу жолооч нэг эгнээнээс нөгөө рүү орох бол энэ шаардлагыг баримтлахгүй.

7. Хэрэв зорчих хэсэг дээр эгнээнүүдийг тэмдэглэлээр заагласан байвал энэ зүйлийн 5, 6 дахь хэсэгт заасны дагуу эгнээ байр эзэлж яваа жолооч уг тэмдэглэлийг унуулж явахыг хориглоно.

8. Нэг ч тээврийн хэрэгслийн жолооч дараахь тохиолдлуудад хоёр дугуйтай унадаг дугуй, мопед, шаахайгүй мотоциклоос бусад тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэх хориотой /Энэхүү заалт нь энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалт болон бусад хязгаарлалтууд (Үүнд: Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс уулзвар буюу төмөр замын гарам дээр гүйцэж түрүүлэхтэй холбогдсон заалт гаргаж болно)-ыг үгүйсгээгүй болно/:

a) тойрох хөдөлгөөнтэй уулзвараас бусад уулзвар дээр буюу уулзварын шууд өмнө доорхи тохиолдлуудаас бусад үед:

i) энэ зүйлийн 1 дэх хэсгийн “b”-д заасан тохиолдол;

ii) уулзвар дээр давуу эрхтэй нэвтрэх замаас гүйцэж түрүүлэх тохиолдол;

iii) уулзвар дээрх хөдөлгөөн нь зохицуулагч буюу замын гэрлэн дохиогоор зохицуулагдаж байгаа тохиолдол;

b) төмөр замын хаалтгүй гарам дээр буюу түүний шууд өмнө; Гэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс хөдөлгөөн нь гэрлэн дохиогоор зохицуулагдаж байгаа төмөр замын гарам дээр зөвшөөрсөн гэрэл дохиогоор дээрх үйлдэл хийхийг зөвшөөрч болно.

9. Замын тэмдэг буюу тэмдэглэлээр тэмдэглэгдсэн явган хүний гарцад ойртож очсон буюу түүний шууд өмнө зогсож байгаа тээврийн хэрэгслийг хэрэв гарц дээр явган зорчигч гарч ирвэл даруй зогсоох боломж бүхий бага хурдтайгаар гүйцэж түрүүлж болно. Энэ хэсгийн нэг ч заалт Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс гүйцэж түрүүлэх үйлдэл эхлэхийг явган хүний гарц хүртэл тодорхой зайнаас хориглох, эсвэл явган хүний гарцын өмнө зогссон тээврийн хэрэгслийг гүйцэж түрүүлэх гэж байгаа жолоочид илүү өндөр шаардлага тавихад нь саад болохгүй.

10. Араас яваа жолооч өөрийг нь гүйцэж түрүүлэх гэж байгааг мэдсэн жолооч энэ Конвенцийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “b”-д зааснаас бусад тохиолдолд зорчих хэсгийн хөдөлгөөний батлагдсан талын зах руу ойртож, хурдаа нэмэлгүй явна.

Хэрэв зорчих хэсгийн өргөн, нөхцөл байдал хангалтгүйгээс, түүнчлэн эсрэг хөдөлгөөний эрчмээс шалтгаалан удаан явдалт буюу овор ихтэй, мөн тодорхой хурдтай явах зайлшгүй шаардлагатай тээврийн хэрэгслийг шуурхай, аюулгүй гүйцэж түрүүлэх боломжгүй бол эдгээр тээврийн хэрэгслийн жолооч нар хөдөлгөөнөө удаашруулж, зайлшгүй тохиолдолд эхний боломж гарангуут араас яваа тээврийн хэрэгслийг өнгөрүүлэхийн тулд зам тавьж өгнө.

11. a) Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь нэг чигийн хөдөлгөөнтэй зам дээр болон суурин газарт нэг чигтээ хоёр буюу түүнээс олон, суурин газрын гаднах замд нэг чигтээ гурав буюу түүнээс олон эгнээтэй (эгнээ нь

тэмдэглэлээр тэмдэглэгдсэн), эсрэг хөдөлгөөнтэй зам дээр:

i) нэг эгнээгээр яваа тээврийн хэрэгсэл нь өөр эгнээгээр яваа тээврийн хэрэгслийг хөдөлгөөний батлагдсан талаар нь гүйцэж түрүүлэхийг зөвшөөрч болно;

ii) энэ Конвенцийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг хэрэглэхгүй байж болно (бусад эгнээ рүү орох боломжийг хязгаарласан зохих заалт байгаа тохиолдолд);

b) энэ хэсгийн “а” заалтын “i”-д тусгагдсан үйлдлийг энэхүү Конвенцийн утгаар “гүйцэж түрүүлэх үйлдэл”-д тооцохгүй (энэ заалт нь энэхүү зүйлийн 9 дэх хэсгийн заалтыг үгүйсгээгүй болно).

12 дугаар зүйл. Зөрж өнгөрөх

1. Жолооч өөдөөс яваа тээврийн хэрэгсэлтэй зөрж өнгөрөхдөө хажуу талдаа хангалттай хэмжээний зайг үлдээх бөгөөд шаардлагатай тохиолдолд зорчих хэсгийн хөдөлгөөний батлагдсан талын захад ойр байрлаж явна. Хэрэв энэ үйлдэл нь ямар нэгэн саад буюу бусад хөдөлгөөнд оролцогчоос шалтгаалан хүндрэлтэй байвал хөдөлгөөнөө удаашруулж, зайлшгүй тохиолдолд өөдөөс яваа тээврийн хэрэгслийг өнгөрүүлэхийн тулд зогсоно.

2. Зөрж өнгөрөхөд бэрхшээлтэй буюу боломжгүй уулын болон өгсүүр, уруу замд өгсөж яваа тээврийн хэрэгслийн хурд ба байрлал нь түүнийг зөрж өнгөрөх газрын өмнө зогсоход илүү бололцоотой болгосон буюу аль тээврийн хэрэгсэл нь ухрах илүү боломжтойгоос хамаарах тохиолдлоос бусад үед уруудаж яваа тээврийн хэрэгслийн жолооч өгсөж яваа аливаа тээврийн хэрэгсэлд зогсож, зам тавьж өгнө. Зөрж өнгөрөхийн тулд аль нэг тээврийн хэрэгсэл нь ухрах шаардлагатай болбол өгсөж яваа тээврийн хэрэгслийн жолоочид уг үйлдлийг хийхэд илт хялбар байхаас бусад тохиолдолд уруудаж яваа жолооч уг үйлдлийг гүйцэтгэх үүрэгтэй.

Гэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь зарим нэг тээврийн хэрэгслийн хувьд буюу зарим зам, замын хэсэгт хамааруулан энэхүү хэсгийн заалтаас ялгаатай тусгай журам гаргаж болно.

13 дугаар зүйл. Хурд ба хоорондын зай

1. Жолооч нь анхаарал болгоомжтой байж, шаардлагатай ямар ч үйлдлийг хийхэд бэлэн байхын тулд аль ч тохиолдолд жолоодож яваа тээврийн хэрэгслээ байнгын хяналт, удирдлагадаа байлгана. Жолооч нь хөдөлгөөний хурдаа өөрчлөхдөө тухайн нөхцөл байдал, тодруулбал тээврийн хэрэгслийн байдал, тээж яваа ачаа, зам болон цаг агаарын нөхцөл, хөдөлгөөний эрчим, хөдөлгөөний дагуух үзэгдэлтийг харгалзан, хөдөлгөөнд ямар нэгэн саад бий болох үед түүнийг урьдчилан харах, улмаар саадын өмнө тээврийн хэрэгслээ зогсоох бололцоог хангасан байна. Тухайн нөхцөл байдал шаардсан, ялангуяа үзэгдэлт муудсан тохиолдол бүрд жолооч тээврийн хэрэгслийн хурдыг хасаж, зайлшгүй тохиолдолд зогсоно.

2. Үндэсний хууль тогтоомжоор бүх төрлийн зам дээрх хурдны дээд хязгаарыг тогтоосон байх ёстой. Үүнээс гадна жин, ачаалал зэргээс шалтгаалан онц аюултай байж болзошгүй зарим төрлийн тээврийн хэрэгслийн хувьд үндэсний хууль тогтоомжоор тусгайлан хурдны хязгаарлал тогтоож өгөх шаардлагатай. Ийм заалт нь зарим ангиллын жолооч, тухайлбал шинэ жолооч нарын хувьд байж болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгийн эхний өгүүлбэрийн заалт нь 34 дүгээр зүйлийн 2 дахь

хэсэгт дурдсан давуу эрх бүхий тээврийн хэрэгслийн жолооч буюу үндэсний хууль тогтоомжоор тэдэнтэй адилтгаж үзэх жолооч нарын хувьд үйлчлэхгүй.

4. Жолооч нь шалтгаангүйгээр хэт удаан явж бусад тээврийн хэрэгслийн хэвийн хөдөлгөөнийг хүндрүүлж болохгүй.

5. Тээврийн хэрэгслийн араас яваа жолооч нь урдаа яваа тээврийн хэрэгслийг гэнэт тоормослох буюу зогсох үед түүнийг мөргөхөөс зайлсхийхийн тулд зохих хэмжээний хоорондын зай барьж явах үүрэгтэй.

6. Суурин газрын гаднах замд бүх жин нь 3500 кг-аас илүү буюу нийт урт нь 10 метрээс илүү тээврийн хэрэгсэл ба тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний жолооч нь гүйцэж түрүүлэх үйлдэл хийх гэж байгаа буюу ийм үйлдэл хийж байгаагаас бусад тохиолдолд өөрийг нь гүйцэж түрүүлэх жолооч ямар нэг аюулгүйгээр урд нь орж зохих байраа эзэлж болохуйц (гүйцэж түрүүлэх үйлдлийг хөнгөвчлөх зорилгоор) хэмжээний хоорондын зайг урд яваа механикжсан тээврийн хэрэгслээс барьж явна. Гэхдээ энэ заалт нь хөдөлгөөний эрчим ихтэй үед буюу гүйцэж түрүүлэхийг хориглосон замын хэсэгт хамаарахгүй. Үүнээс гадна:

а) эрх бүхий байгууллага нь зарим тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний хувьд энэ заалтаас түдгэлзэх буюу тухайн чигт хоёр эгнээ зориулагдсан замд энэ заалтыг хэрэглэхгүй байх тухай зааж болно.

б) энэ хэсгийн заалтыг Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь уг хэсэгт зааснаас ялгаатай үзүүлэлт бүхий тээврийн хэрэгсэлд хамааруулан тогтоож болно.

14 дүгээр зүйл. Хөдөлгөөний үйлдэл (маневр) хийхтэй холбогдсон нийтлэг заалтууд

1. Жолооч нь ямар нэгэн үйлдэл, тухайлбал зогсоол дээрээс хөдөлгөөнөө эхлэх буюу түүн рүү зогсох, зорчих хэсэг дээр баруун буюу зүүн гар тийш шилжих, замаас гарах буюу өөр зам руу орохын тулд баруун буюу зүүн гар тийш эргэх зэрэг үйлдлүүдийг хийхдээ ард, урд болон өөдөөс яваа хөдөлгөөнд оролцогчдод аюул учруулахгүй гэдгийг бүрэн мэдсэн үедээ, тэдний байрлал, хөдөлгөөний чиг, хурдыг тооцоолсны үндсэн дээр гүйцэтгэнэ.

2. Буцаж эргэх буюу ухрах үйлдэл хийх гэж буй жолооч нь бусад хөдөлгөөнд оролцогчдод аюул, саад учруулахгүйгээр уг үйлдлийг гүйцэтгэж чадна гэдгээ бүрэн мэдсэн байх ёстой.

3. Жолооч нь хөдөлгөөний чиг өөрчлөхтэй холбогдсон үйлдэл хийхийн өмнө тээврийн хэрэгслийнхээ эргэх чиг заадаг гэрлээр дохио өгөх бөгөөд ийм хэрэгсэл байхгүй тохиолдолд боломжтой бол гараараа зохих дохиог өгч урьдчилан анхааруулах үүрэгтэй. Эргэх чиг заадаг гэрлээр өгч буй дохиог үйлдэл хийж байх хугацаандаа тасралтгүй өгөх бөгөөд үйлдлээ хийж дуусмагц даруй зогсооно.

15 дугаар зүйл.

Хотын тээврийн байнгын шугамд тээвэр хийж буй тээврийн хэрэгслүүдэд хамаарах тусгай заалтууд

Суурин газарт хотын тээврийн байнгын шугамд тээвэрлэлт хийдэг тээврийн хэрэгслүүдийн хөдөлгөөнийг хөнгөвчлөх зорилгоор, эдгээр нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслүүдийг зогсоол (зохих ёсоор тэмдэглэгдсэн)-оос хөдлөхийн тулд шаардлагатай үйлдлийг гүйцэтгэхэд нь бололцоо олгох үүднээс бусад тээврийн хэрэгслийн жолооч нар

энэ Конвенцийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтыг баримтлан хөдөлгөөнөө удаашруулах буюу зайлшгүй тохиолдолд зогсох үүрэг хүлээх талаар үндэсний хууль тогтоомжид тусгахыг зөвлөж байна. Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжийн гаргасан ийм заалтууд нь нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн жолооч нарыг зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх зайлшгүй арга хэмжээ авах үүргээс ямар ч хэмжээгээр чөлөөлөхгүй.

16 дугаар зүйл. Хөдөлгөөний чиг өөрчлөх

1. Жолооч зам руу орох буюу замаас гарахын тулд баруун, зүүн гар тийш эргэхийн өмнө энэ Конвенцийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон 14 дүгээр зүйлийн заалтыг зөрчихгүйгээр:

а) хэрэв хөдөлгөөний батлагдсан тал руу замаас гарах гэж байгаа бол зорчих хэсгийн хөдөлгөөний тухайн чигийн захад бололцооныхоо хирээр ойртож, аль болох богино үйлдлийг хийнэ;

б) хэрэв хөдөлгөөний нөгөө тал руу замаас гарах гэж байгаа бол (Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс унадаг дугуй, мопедын хувьд өөр заалт гаргах боломжтой нөхцөлтэй) эсрэг хөдөлгөөнтэй замын хувьд зорчих хэсгийн тэнхлэгт, харин нэг чигийн хөдөлгөөнтэй замын хувьд хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талын захад бололцооныхоо хирээр ойртож үйлдлийг гүйцэтгэнэ. Хэрэв эсрэг хөдөлгөөнтэй өөр зам руу орох гэж байгаа бол тэр замынхаа хөдөлгөөний батлагдсан талын зорчих хэсэг рүү орохоор эргэх үйлдлийг гүйцэтгэнэ.

2. Хөдөлгөөний чигийг өөрчлөхтэй холбоотой үйлдлийг хийхдээ жолооч нь энэ Конвенцийн 21 дүгээр зүйлийн заалт (явган зорчигчид хамаарах)-ыг зөрчихгүйгээр өөрийн орхин гарах гэж буй зорчих хэсгийн эсрэг талаас яваа тээврийн хэрэгсэл, түүнчлэн өөрийн орох гэж буй зорчих хэсэгтэй огтлолцсон унадаг дугуйн замаар яваа унадаг дугуй, мопедыг өнгөрөөнө.

17 дугаар зүйл. Хөдөлгөөнөө удаашруулах

1. Хэрэв огцом тоормослох нь аюулгүй байдлын эрх ашигт нийцэж байгаа биш бол жолооч энэ үйлдлийг хийх ёсгүй.

2. Хөдөлгөөний хурдаа мэдэгдэхүйц бууруулах гэж буй жолооч (хэрэв энэ нь аюулаас шууд үүдэлтэй биш бол) энэ үйлдэл нь бусад хөдөлгөөнд оролцогчдод аюул учруулахгүй, тэдний хөдөлгөөнийг ямар нэгэн байдлаар хүндрүүлэхгүй гэдгийг урьдчилан мэдсэн байх ёстой. Үүнээс гадна араас яваа тээврийн хэрэгсэлгүй буюу эсвэл тэр нь хангалттай хол зайтай яваагаас бусад тохиолдолд жолооч хурдаа мэдэгдэхүйц удаашруулах гэж байгаагаа зохих журмын дагуу гараар урьдчилан ойлгомжтойгоор дохиж мэдэгдэх ёстой. Харин хурд бууруулах дохиог тээврийн хэрэгслийн тоормосны гэрлээр (энэ Конвенцийн 5 дугаар хавсралтын 31 дүгээрт дурдсан) өгч байгаа бол энэ заалт үйлчлэхгүй.

18 дугаар зүйл. Уулзвар ба зам тавьж өгөх үүрэг

1. Жолооч уулзварт ойртон очихдоо тухайн орчны нөхцөл байдлаас хамааран онц анхаарал болгоомжтой байх ёстой. Тухайлбал давуу эрх бүхий тээврийн хэрэгслийг зогсож өнгөрөөх боломж бүхий хурдтайгаар тээврийн хэрэгслээ жолоодвол зохино.

2. Шороон зам буюу хөдөөгийн замаас шороон бус зам буюу хөдөөгийн бус зам руу орох гэж байгаа жолооч тэр замаар явж буй тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө. Энэхүү зүйлийн заалтыг илэрхийлэх зорилгоор “шороон зам” ба “хөдөөгийн зам” гэсэн нэр

томъёоны утгыг үндэсний хууль тогтоомжид тодорхойлж болно.

3. Замын дагуух эзэмшлээс зам руу орох гэж буй жолооч тэр замаар яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

4. Энэ зүйлийн 7 дахь хэсгийн заалтыг биелүүлж буй нөхцөлд:

а) баруун гар талын хөдөлгөөнтэй улсын хувьд уулзвар дээр (энэ зүйлийн 2 дахь хэсэг болон энэхүү Конвенцийн 25 дугаар зүйлийн 2 ба 4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд) тээврийн хэрэгслийн жолооч нь баруун гар талаасаа ирж яваа тээврийн хэрэгсэлд зам тавьж өгнө.

б) зүүн гар талын хөдөлгөөнтэй Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нэгж нь нутаг дэвсгэртээ уулзвар нэвтрэх дарааллын журмыг өөрсдийн үзэмжээр тогтоох эрхтэй.

5. Хөндлөн замаас яваа тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад бэрхшээл үүсгэн, тээврийн хэрэгслээ уулзвар дээр зайлшгүй зогсоох нь илэрхий түгжрэл, саатал бий болсон үед гэрэл дохио зөвшөөрч байсан ч жолооч уулзвар руу орох ёсгүй.

6. Хөдөлгөөн нь гэрэл дохиогоор зохицуулагдаж буй уулзварт орсон жолооч хөдөлгөөний нээлттэй талаас яваа бусад хөдөлгөөнд оролцогчдод саад болохгүй бол өөрийнхөө явж байгаа чигт хөдөлгөөн нээгдэхийг хүлээлгүйгээр уулзвараас гарч болно.

7. Төмөр замын бус тээврийн хэрэгслийн жолооч нар төмөр замын тээврийн хэрэгслүүдэд зам тавьж өгнө.

19 дүгээр зүйл. Төмөр замын гарам

Замын хөдөлгөөнд оролцогч бүр төмөр замын гарамд ойртох үедээ болон түүгээр нэвтрэн гарахдаа онцгой анхаарал болгоомжтой байх ёстой. Тухайлбал:

а) тээврийн хэрэгслийн жолооч нь хурдаа хасаж явбал зохино;

б) гэрэл ба дуут дохионы хориглосон заалтыг харгалзан, гармын хаалт хаагдсан буюу хаагдаж байхад, эсвэл хаалт өргөгдөж байх үед хөдөлгөөнд оролцогчдын нэг нь ч төмөр замын гармаар нэвтрэх ёсгүй;

в) хэрэв төмөр замын гарам нь хаалт буюу гэрлэн дохиогоор тоноглогдоогүй байвал хөдөлгөөнд оролцогчдын нэг нь ч төмөр замын ямар нэг тээврийн хэрэгсэл гарамд ойртож ирээгүйг мэдээгүй тохиолдолд түүгээр нэвтрэх ёсгүй;

г) жолооч төмөр замын гарам дээр зайлшгүй зогсолт хийхгүй гэдэгтээ бүрэн итгээгүй тохиолдолд түүн рүү орох ёсгүй;

д) замын хөдөлгөөнд оролцогчид нь төмөр замын гарам дээр саатахгүйгээр нэвтрэх ёстой; Тээврийн хэрэгсэл зайлшгүй зогсолт хийсэн тохиолдолд жолооч түүнийг төмөр замаас гаргахыг хичээх ёстой ба хэрэв гаргаж чадахгүй бол төмөр замын тээврийн хэрэгслийн машинчинд аюулыг анхааруулах талаар шаардлагатай бүхий л арга хэмжээг нэн даруй авбал зохино.

20 дугаар зүйл. Явган зорчигчид хамаарах заалтууд

1. Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжүүд нь зорчих хэсгээр явж буй явган зорчигчдын хөдөлгөөн нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хүндрэл,

аюул учруулахуйц нөхцөлд энэхүү зүйлийн заалтуудыг хэрэгжүүлэхээр зааж болно.

2. Хэрэв зорчих хэсгийн хажууд явган зорчигчийн хөдөлгөөнд ашиглаж болохуйц явган хүний зам буюу хөвөө байвал тэдгээрийг явган зорчигчид ашиглана. Гэхдээ зайлшгүй шаардлагатай болгоомжлох арга хэмжээг авах бөгөөд,

а) овор ихтэй зүйл зөөж, тээж яваа явган зорчигчид нь явган хүний зам буюу хөвөөгөөр явахад бусад явган зорчигчдод ноцтой саад учруулахаар бол зорчих хэсгээр явж болно;

б) удирдагчтай бүлэг явган зорчигчид буюу жагсаалаар яваа хүмүүс зорчих хэсгээр явж болно.

3. Явган хүний зам, хөвөө байхгүй буюу түүнийг ашиглах боломжгүй тохиолдолд явган зорчигчид нь зорчих хэсгээр явж болно; Хэрэв унадаг дугуйн зам байгаа бөгөөд хөдөлгөөний эрчим нь боломжийн бол явган зорчигчид нь унадаг дугуй болон мопедын хөдөлгөөнд хүндрэл учруулахгүйгээр түүгээр явж болно.

4. Энэ зүйлийн 2 ба 3 дахь хэсэгт заасны дагуу зорчих хэсгээр яваа явган зорчигчид зорчих хэсгийн захад аль болох ойр явах ёстой.

5. Дараахь заалтуудыг үндэсний хууль тогтоомжид тусгахыг зөвлөж байна:

Зорчих хэсгээр яваа явган зорчигчид нь хөдөлгөөний чигийн эсрэг талыг (хэрэв энэ нь тэдний аюулгүй байдлыг алдагдуулахааргүй бол) барьж явна; Гэхдээ мотоцикл, унадаг дугуй, мопед хөтөлж яваа хүмүүс ямагт зорчих хэсгийн хөдөлгөөний батлагдсан талыг барьж явна; Энэ заалт нь удирдагчтай бүлэг явган зорчигчид буюу жагсаалаар яваа хүмүүст ч мөн хамаарна; Жагсаалаар яваагаас бусад явган зорчигчид шөнийн цагт буюу үзэгдэлт хангалтгүй үед, түүнчлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчим шаардаж байвал өдрийн цагт ч аль болох ар араасаа цуварч явна.

6. а) явган зорчигчид нь анхаарал болгоомжгүйгээр зорчих хэсгийг хөндлөн гарч болохгүй; Хэрэв явган хүний гарц ойрхон байвал түүнийг ашиглах ёстой;

б) тэмдэг буюу тэмдэглэлээр тэмдэглэгдсэн явган хүний гарцаар гарахдаа;

i) хэрэв явган хүний гарц нь явган зорчигчид зориулсан гэрлэн дохиотой бол тэд энэ дохионы заалтыг мөрдлөг болгоно;

ii) хэрэв явган хүний гарц нь ийм дохиогүй боловч тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь гэрлэн дохио буюу зохицуулагчийн дохиогоор зохицуулагдаж байвал эдгээр дохио тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг зөвшөөрч байгаа тохиолдолд явган зорчигч зорчих хэсэг рүү орох ёсгүй.

iii) бусад гарцууд дээр явган зорчигч ойртон ирж байгаа тээврийн хэрэгсэл хүртэлх зай, түүний хурдыг тооцолгүйгээр зорчих хэсэг рүү орох ёсгүй.

с) тэмдэг, тэмдэглэлээр тэмдэглэгдсэн явган хүний гарцаас бусад хэсгээр зорчих хэсгийг хөндлөн гарахдаа явган зорчигч нь тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хүндрүүлэхгүй гэдэгтээ бүрэн итгээгүй тохиолдолд зорчих хэсэг рүү орох ёсгүй.

д) зорчих хэсэг рүү орсон явган зорчигч нь шалтгаангүйгээр нэвтрэх замаа уртасгах, зогсох, саатахыг хориглоно.

7. Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжүүд нь зорчих

хэсгийг хөндлөн гарах явган зорчигчдод зориулан илүү өндөр шаардлага бүхий дүрэм гаргаж болно.

21 дүгээр зүйл. Жолооч ба явган зорчигчдын харилцаанд хамаарах дүрэм

1. Жолооч нь явган зорчигчдод аюул учруулж болохуйц үйлдэл хийх ёсгүй.

2. Тэмдэг буюу тэмдэглэлээр тэмдэглэгдсэн явган хүний гарц дээр дараахь заалтууд биелэгдэх ёстой (Энэхүү заалт нь энэ Конвенцийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг үгүйсгээгүй болно):

а) гэрэл буюу зохицуулагчийн дохиогоор зохицуулагдаж байгаа явган хүний гарц дээр жолооч хориглосон дохиогоор гарцын өмнө буюу түүний өмнө тавигдсан хөндлөн тэмдэглэлийн өмнө зогсох бөгөөд зөвшөөрсөн дохио өгөгдөх үед хөдөлгөөнөө үргэлжлүүлэхдээ гарц руу нэгэнт орчихсон яваа явган зорчигчдод саад бэрхшээл учруулахгүй байвал зохино; Хэрэв жолооч явган хүний гарцтай өөр зам руу орохоор эргэх үйлдэл хийх бол тэрээр энэ үйлдлийг бага хурдтайгаар хийх шаардлагатай бөгөөд гарц дээр явж байгаа болон түүн рүү орж байгаа явган зорчигчдыг (шаардлагатай бол зогсож) өнгөрөөнө;

б) гэрэл буюу зохицуулагчийн аль ч дохиогоор зохицуулагддаггүй гарц руу ойртон очихдоо жолооч гарцаар гарч яваа буюу түүн рүү орж байгаа явган зорчигчдод аюул учруулахгүйн тулд хурдаа хасаж, шаардлагатай бол зогсож явган зорчигчдыг өнгөрөөнө.

3. Энэ зүйлийн нэг ч заалт Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс тээврийн хэрэгслийн жолооч нь энэхүү Конвенцийн 20 дугаар зүйлд заасан нөхцөлөөр тэмдэг, тэмдэглэлээр тэмдэглэгдсэн явган хүний гарцаар явган зорчигч яваа буюу түүн рүү орж яваа тохиолдол бүрд заавал зогсож өнгөрөөх, түүнчлэн уулзвар дээр буюу түүний ойролцоох зорчих хэсэг рүү (явган хүний гарцгүй байсан ч) нэгэнт орчихсон яваа явган зорчигчийн хөдөлгөөнд саад болохыг жолоочид хориглох тухай заалт гаргахад саад болохгүй.

4. Тэмдэглэгдсэн зогсоол дээр зогсож байгаа нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн дэргэдүүр хөдөлгөөний батлагдсан талаар явж өнгөрөх жолооч хурдаа хасаж, нийтийн тээврийн зорчигчдод буух, суух боломж олгохын тулд шаардлагатай бол зогсоно.

22 дугаар зүйл. Аюулгүйн арал

Энэ Конвенцийн 10 дугаар зүйлийн заалтуудыг зөрчихгүйгээр доорхи нөхцөлүүдээс бусад тохиолдолд жолооч нь аюулгүйн арлыг болон зорчих хэсэг дээр байрласан шон (тумба) буюу бусад хэрэгслүүдийг баруун ба зүүн гар талаар нь тойрон гарч болно:

а) аюулгүйн арал, шон (тумба) буюу бусад хэрэгслүүдийг аль талаар нь тойрон гарахыг тэмдгээр заасан бол;

б) аюулгүйн арал, шон (тумба) буюу бусад хэрэгслүүд нь эсрэг хөдөлгөөнтэй замын зорчих хэсгийн тэнхлэг дээр байрласан бол; Энэ тохиолдолд жолооч нь аюулгүйн арал, шон (тумба) буюу бусад хэрэгслүүдийг хөдөлгөөний батлагдсан талаар тойрч гарна.

23 дугаар зүйл. Түр ба удаан зогсолт

1. Суурин газрын гаднах замд тээврийн хэрэгсэл ба тэжээвэр амьтдыг удаан зогсооходоо аль болох зорчих хэсгийн гадна талд байрлуулна. Ингэхдээ үндэсний хууль тогтоомжид зөвшөөрснөөс бусад тохиолдолд суурин газарт болон суурин газрын гаднах

замд явган хүний ба унадаг дугуйн зам, түүнчлэн явган зорчигчийн хөдөлгөөнд зориулагдсан хөвөөн дээр байрлуулахгүй.

2. а) Зорчих хэсэг дээр тээврийн хэрэгсэл ба тэжээвэр амьтдыг түр буюу удаан зогсоохдоо зорчих хэсгийн захад аль болох ойр байрлуулна. Жолооч нь тээврийн хэрэгслээ зорчих хэсэг дээр түр буюу удаан зогсоохдоо хөдөлгөөний зөвхөн батлагдсан талд байрлуулж болно; Харин төмөр зам байгаагаас шалтгаалан хөдөлгөөний батлагдсан талд зогсоох боломжгүй бол зорчих хэсгийн нөгөө талд түр буюу удаан зогсоохыг зөвшөөрнө. Үүнээс гадна Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжүүд нь:

i) тодорхой нөхцөлүүдийн хувьд, тухайлбал хөдөлгөөний батлагдсан талд зогсохыг хориглосон тэмдэг байгаа тохиолдолд зорчих хэсгийн нөгөө талд түр буюу удаан зогсоохыг зөвшөөрч болно;

ii) нэг чигийн хөдөлгөөнтэй замын зорчих хэсэг дээр түр буюу удаан зогсоохыг зөвхөн нөгөө талд юмуу эсвэл хөдөлгөөний батлагдсан тал ба нөгөө талын аль алинд зөвшөөрч болно;

iii) тусгайлан тэмдэглэгдсэн газарт зорчих хэсгийн дунд түр буюу удаан зогсоохыг зөвшөөрч болно.

б) Үндэсний хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хоёр дугуйтай унадаг дугуй, мопед, шаахайгүй мотоциклоос бусад тээврийн хэрэгслүүд нь зорчих хэсэг дээр хоёр эгнээгээр (зэрэгцэж) түр ба удаан зогсохгүй. Тээврийн хэрэгслийг түр буюу удаан зогсоохдоо зорчих хэсгийн захад зэрэгцээ (параллель) байдлаар (өөрөөр байрлуулж болох хэлбэртэй газраас бусад хэсэгт) байрлуулна.

3. а) Зорчих хэсэг дээр тээврийн хэрэгслийг дараахь тохиолдолд түр ба удаан зогсоохыг хориглоно:

i) явган хүний гарц, унадаг дугуйн гарц болон төмөр замын гарам дээр;

ii) замын дундуур байрласан трамвай болон галт тэрэгний төмөр зам дээр буюу тэдгээрийн хөдөлгөөнийг хүндрүүлж болохуйц төмөр замд ойрхон зайд; Түүнчлэн явган хүний зам буюу унадаг дугуйн зам дээр (энэ заалтын хувьд Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь эсрэг заалт гаргаж болох нөхцөлтэй).

б) Аюул осол бий болгож болзошгүй аливаа газарт тээврийн хэрэгслийг түр буюу удаан зогсоохыг хориглоно. Тухайлбал:

i) тусгайлан тэмдэглэгдсэнээс бусад тохиолдолд гүүрэн доор ба хонгил дотор;

ii) тээврийн хэрэгсэл аюулгүйгээр тойрон гарахад (замын энэ хэсгээр явах тээврийн хэрэгслийн хурдыг тооцсоноор) үзэгдэлт хангалтгүй байх замын эргэлт, тойрууд ойр зорчих хэсэг дээр;

iii) зорчих хэсэг дээр зогсож байгаа тээврийн хэрэгслээс давахыг хориглосон тэмдэглэл (дагуу шугам) хүртэл 3 метрээс бага зайтай газарт;

iv) тээврийн хэрэгсэл нь замын тэмдэг, гэрлэн дохиог хөдөлгөөнд оролцогчдоос халхлах газарт;

v) удаан явдалт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд зориулан тэмдгээр тэмдэглэсэн

нэмэгдэл эгнээ дээр.

с) Дараахь тохиолдолд тээврийн хэрэгслийг зорчих хэсэг дээр удаан зогсоохыг хориглоно:

i) автобус, троллейбус буюу төмөр замын тээврийн хэрэгслийн буудал, түүнчлэн уулзвар, төмөр замын гармын ойролцоо үндэсний хууль тогтоомжоор тогтоосон зайд;

ii) хаалганаас гарах гарцын эсрэг талд;

iii) бусад тээврийн хэрэгсэл зогсоолд байрлах, зогсоолоос гарахад саад болох аливаа газарт;

iv) гурван эгнээтэй замын зорчих хэсгийн голын эгнээнд, мөн суурин газрын гадна зохих тэмдгээр “гол зам” гэж тэмдэглэгдсэн замын зорчих хэсэг дээр.

4. Жолооч нь тээврийн хэрэгслээ (мал туугч нь мал амьтнаа) зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд зайлшгүй шаардлагатай арга хэмжээг авалгүйгээр орхиж явах ёсгүй; Автомашины тухайд түүнийг зохих зөвшөөрөлгүйгээр ашиглах боломжгүй болгох арга хэмжээ авна.

5. Дор дурдсан тохиолдолд хоёр дугуйтай мопед, шаахайгүй мотоциклоос бусад механикжсан тээврийн хэрэгсэл, түүнчлэн чирэгчтэй холбогдсон, холбогдоогүй чиргүүл бүрийг суурин газрын гаднах замд зорчих хэсэг дээр зогсоохдоо ойртон ирж яваа жолооч нарт цаг тухайд нь анхааруулах үүднээс ядаж нэг хэрэгслийг тодорхой зайнд байрлуулж тэмдэглэсэн байх ёстойг үндэсний хууль тогтоомжид тусгахыг зөвлөж байна:

a) шөнийн цагт зорчих хэсэг дээр зогссон тээврийн хэрэгсэл нь ойртон ирж яваа жолооч нарт анзаарагдахааргүй бол;

b) зогсохыг хориглосон газарт жолооч зайлшгүй зогсолт хийсэн бол.

6. Энэхүү зүйлийн нэг ч заалт Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс түр буюу удаан зогсохыг хориглосон бусад заалт гаргахад нь саад болохгүй.

24 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийн хаалга

Бусад замын хөдөлгөөнд оролцогчдод аюул учруулахгүй гэдгийг бүрэн шалгаж мэдэлгүйгээр тээврийн хэрэгслээс гарах буюу хаалгаа нээх, түүнийг онгорхой орхихыг хориглоно.

25 дугаар зүйл. Тууш зам ба түүнтэй адил төрлийн замууд

1. Тууш зам дээр болон хэрэв үндэсний хууль тогтоомжид заасан бол түүн рүү нийлэх буюу салахад зориулсан тусгай хэсэг дээр:

a) явган зорчигч, мал амьтан, унадаг дугуй, мопед (хэрэв мотоциклтой адилтгаж үзээгүй бол), мөн автомашинаас бусад бүх төрлийн тээврийн хэрэгсэл ба тэдгээрийн чиргүүл, түүнчлэн техникийн дээд хурд нь тэгш зам дээр үндэсний хууль тогтоомжоор тогтоосон хэмжээнд хүрдэггүй автомашин ба түүний чиргүүлийн хөдөлгөөнийг хориглоно;

b) жолоочид хориглох нь:

i) тусгайлан тэмдэглэгдсэн зориулалтын зогсоолоос бусад хэсэгт тээврийн хэрэгслээ түр буюу удаан зогсоох. Өөрөөс нь шалтгаалахгүйгээр зайлшгүй зогсолт хийсэн жолооч тээврийн хэрэгслээ зорчих хэсэг болон тухайн эгнээнээс зайлуулахыг хичээх ёстой бөгөөд хэрэв зайлуулж чадахгүй бол ойртон ирж яваа жолооч нарт цаг тухайд нь анхааруулахын тулд хангалттай зайнд нэн даруй тээврийн хэрэгслээ тэмдэглэнэ;

ii) буцаж эргэх буюу ухрах үйлдэл хийх, эсвэл голын тусгаарлах зурвасын хоёр зорчих хэсгийг холбосон хөндлөн холбоос руу орох.

2. Жолооч тууш зам руу орохдоо түүгээр яваа тээврийн хэрэгслүүдэд зам тавьж өгнө. Хурд авах эгнээтэй үед түүнийг ашиглана.

3. Жолооч тууш замаас гарахдаа зэргэлдээх гарах эгнээ рүү цаг тухайд нь орох ба хэрэв хурд хасах эгнээ байвал түүн рүү аль болох түргэн орно.

4. Энэ зүйлийн 1, 2, 3 дахь хэсгийн заалтыг хэрэглэхдээ замын дагуух эзэмшилд үйлчилдэггүй байдлаар тэмдэглэгдсэн, автомашины хөдөлгөөнд зориулагдсан бусад замыг тууш замтай адилтгаж үзнэ.

25-бис дугаар зүйл. Замын тэмдгээр тусгайлан тэмдэглэгдсэн хонгилд хамаарах тусгай дүрэм

Замын тэмдгээр тусгайлан тэмдэглэгдсэн хонгил (тоннель) дотор доорхи журам үйлчилнэ:

1. Бүх жолоочид хориглох нь:

a) ухрах үйлдэл хийх;

b) буцаж эргэх;

c) зориулагдсан газраас бусад хэсэгт түр буюу удаан зогсох.

2. Хонгил гэрэлтүүлэгтэй байлаа ч жолооч холын буюу ойрын гэрлээ асаана.

3. Удаан хугацаагаар зогсох тохиолдолд жолооч хөдөлгүүрээ унтраана.

26 дугаар зүйл. Жагсаалаар яваа ба тахир дутуу хүмүүст хамаарах тусгай дүрэм

1. Замын хөдөлгөөнд оролцогчид нь цэргийн жагсаал, эгнээгээр яваа удирдагчтай сургуулийн хүүхдийн бүлэг болон бусад жагсаалын дундуур нэвтрэхийг хориглоно.

2. Тахир дутуу хүний тэргэнцэртэй (явган хүний хурдаар явдаг) хүмүүс явган хүний замаар эсвэл хөдөлгөөнд нь дөхөмтэй бол хөвөөгөөр явж болно.

27 дугаар зүйл. Унадаг дугуй, мопед, мотоциклын жолооч нарт хамаарах тусгай дүрэм

1. Энэхүү Конвенцийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн заалтыг харгалзахгүйгээр, Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь унадаг дугуйгаар зорчигчдыг нэг эгнээнд хэд хэдээрээ зэрэгцэж явахыг нь хориглохгүй байж болно.

2. Унадаг дугуйн жолооч нь жолоогоо ядаж нэг гараараа барихгүйгээр явах, бусад тээврийн хэрэгслийг чирэгч болгон ашиглах, мөн бусад хөдөлгөөнд оролцогчдод аюул учруулахуйц, тэдний жолоодлогод саад болохуйц зүйлийг зөөж, чирч, түрж явахыг хориглоно. Энэ заалт нь мопед ба мотоциклын жолооч нарт мөн адил хамаарах төдийгүй, харин ч (энэхүү Конвенцийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу гараар дохио өгөхөөс бусад тохиолдолд) жолоог заавал хоёр гараараа барьж явах үүрэг хүлээнэ.

3. Унадаг дугуй ба мопедоор зорчигч тээвэрлэхийг хориглоно; Гэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь энэ заалтаас түдгэлзэж, тухайлбал унадаг дугуйг нэмэлт суудлаар тоноглож зорчигч тээвэрлэхийг зөвшөөрч болно. Мотоциклын зөвхөн шаахайнд (шаахайтай бол) буюу жолоочийн ард байрласан нэмэлт суудал дээр зорчигч тээвэрлэхийг зөвшөөрнө.

4. Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь унадаг дугуйн жолооч унадаг дугуйн зам байгаа тохиолдолд уг замаас гадуур, зорчих хэсгээр явахыг хориглож болно. Энэ тохиолдолд мопедын жолоочид унадаг дугуйн замаар явахыг зөвшөөрч болох бөгөөд хэрэв шаардлагатай гэж үзвэл түүнийг уг замаас гадуур зорчих хэсгээр явахыг нь хориглож болно.

28 дугаар зүйл. Дуут болон гэрэл дохио

1. Дуут ба гэрэл дохиог зөвхөн дараахь нөхцөлд хэрэглэж болно:

а) зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэхийн тулд;

б) суурин газрын гаднах замд гүйцэж түрүүлэх гэж байгаагаа нөгөө жолоочид анхааруулах зорилгоор.

Дуут дохиог шаардагдах хэмжээнээс илүү сунжруулж өгөхийг хориглоно.

2. Харанхуй болохоос үүр цайх хүртэл (энэхүү Конвенцийн 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу) жолооч дуут дохионы оронд гэрэл дохио хэрэглэж болно. Хэрэв тухайн нөхцөл байдалд илүү тохиромжтой байвал энэ дохиог энэ зүйлийн 1 дэх хэсгийн "b"-д заасан зорилгоор хэрэглэхдээ өдрийн цагт ч өгч болно.

3. Гэрэл дохиог энэ зүйлийн 1 дэх хэсгийн "b"-д заасан зорилгоор тэрчлэн суурин газарт ч өгөхийг Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс зөвшөөрч болно.

29 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн хэрэгсэл

1. Төмөр зам зорчих хэсгээр байрлаж байгаа тохиолдолд замын хөдөлгөөнд оролцогч бүр трамвай болон бусад төмөр замын тээврийн хэрэгсэл ойртон ирж яваа үед тэдгээрийг өнгөрөөхийн тулд төмөр замыг аль болох түргэн чөлөөлөх ёстой.

2. Автомашины замаар зорчих төмөр замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөн, тэдгээртэй зөрж өнгөрөх болон тэднийг гүйцэж түрүүлэх журмын талаар Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь энэхүү бүлэгт зааснаас ялгаатай тусгай журам гаргаж болно. Гэхдээ энэ Конвенцийн 18 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн заалттай зөрчилдөх заалт гаргаж болохгүй.

30 дугаар зүйл. Тээврийн хэрэгслийн ачаа

1. Бүх жингийн хэмжээг нь тогтоосон тээврийн хэрэгслийн ачаалалтай жин нь хэдийд

ч бүх жингээсээ хэтрэх ёсгүй.

2. Аливаа ачааг дор дурдсан нөхцөлийг хангахаар байрлуулж, шаардлагатай бол бэхэлсэн байна:

а) хүмүүст аюул учруулахааргүй, улс нийгмийн болон амины өмчид хор уршиг тарихааргүй, тухайлбал зам дээр унахааргүй, чирэгдэхээргүй;

б) харах боломж, үзэгдэлтийг хязгаарлахгүй, тээврийн хэрэгслийн тогтворжилтыг алдагдуулахгүй, жолоодлогыг хүндрүүлэхгүй;

с) чимээ шуугиан гаргахгүй, тоос шороо босгохгүй буюу бусад таагүй байдал (зайлсхийж болохуйц) үүсгэхээргүй;

д) гэрэлтүүлэх хэрэгсэл, тоормосны гэрэл, эргэх дохионы гэрэл, гэрэл ойлгуур, улсын бүртгэлийн дугаар, ялгах тэмдэг, гараар өгөх дохио зэргийг халхлахгүй байхаар.

3. Ачааг хамгаалж, бэхлэхэд зориулагдсан туслах бүх хэрэгслүүд (таталга, гинж, бүтээлэг) нь сайтар чангалагдсан, бат бөх бэхлэгдсэн байна. Ачааг хамгаалахад зориулагдсан туслах бүх хэрэгслүүд нь ачааны нэгэн адил энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

4. Тээврийн хэрэгслийн овроос урагшаа, хойшоо, хажуу тийшээ илүү гарсан ачаа нь бусад тээврийн хэрэгслийн жолооч нарт ажиглагдахааргүй байж болзошгүй бүх тохиолдолд тэмдэглэгдсэн байх ёстой; Шөнийн цагт энэ анхааруулах дохио нь урд талаасаа цагаан, ард талаасаа улаан өнгийн гэрэл буюу гэрэл ойлгуураар хийгдсэн байвал зохино.

Ялангуяа механикжсан тээврийн хэрэгслийн хувьд:

а) тээврийн хэрэгслийн овроос урагшаа, хойшоо 1 метрээс илүү гарсан ачааг заавал тэмдэглэнэ;

б) тээврийн хэрэгслийн овроос өргөөшөө илүү гарсан ачаа нь жижиг гэрлээс гадагшаа 0.4 метрээс илүү гарсан байвал шөнийн цагт урд талаасаа, үүний адилаар ачаа нь арын оврын улаан гэрлээс гадагшаа 0.4 метрээс илүү гарсан байвал шөнийн цагт ард талаасаа тэмдэглэгдсэн байна.

5. Энэ зүйлийн 4 дэх хэсгийн нэг ч заалт Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс ачаа нь тээврийн хэрэгслийн овроос дээрх заалтад тусгагдсанаар илүү гарсан бол түүнийг тээвэрлэхийг хориглох буюу хязгаарлах, эсвэл тусгай зөвшөөрөл шаардах заалт гаргахад нь саад болж буй мэтээр ойлгогдох ёсгүй.

30-бис дугаар зүйл. Зорчигч тээвэрлэх

Тээвэрлэх зорчигчдын тоо болон тэдгээрийг тээвэрлэсэн байдал нь жолоочийн харах боломжийг хязгаарлахаар буюу жолоодлогод саад учруулахаар байж болохгүй.

31 дүгээр зүйл. Зам тээврийн осол гарсан үед жолоочийн авах арга хэмжээ

1. Зам тээврийн осолд холбогдсон жолооч болон бусад хөдөлгөөнд оролцогч аливаа этгээд нь осолд нэрвэгдсэн хүнд тусламж үзүүлэх үүргийн талаар тусгасан үндэснийхээ

хууль тогтоомжийн заалтыг зөрчихгүйгээр дараахь үүргийг хүлээнэ:

а) хөдөлгөөнд нэмэлт аюул үүсгэхгүйгээр аль болох түргэн зогсоно;

б) зам тээврийн осол гарсан газарт хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах талаар арга хэмжээ авч, хэрэв уг ослын улмаас нас барсан буюу хүнд гэмтсэн хүн гарвал хөдөлгөөний аюулгүй байдалд нөлөөлөхөөргүйгээр осол гарсан газарт ямар нэг зүйлийг хөдөлгөх, хариуцлага тогтооход ашиглаж болох ул мөрийг баллахаас зайлсхийнэ;

с) зам тээврийн осолд холбогдсон бусад этгээдийн шаардсанаар өөрийгөө нэрлэж танилцуулна;

д) хэрэв зам тээврийн ослын улмаас хүн гэмтсэн буюу нас барсан бол энэ тухай замын хөдөлгөөний албанд мэдэгдэх бөгөөд хэрэв замын хөдөлгөөний албанаас осол гарсан газрыг орхиж явахыг зөвшөөрөөгүй, эсвэл гэмтсэн хүмүүст тусламж үзүүлэх буюу өөрөө эмнэлгийн тусламж авах шаардлагагүй бол осол гарсан газарт эргэн ирэх буюу замын хөдөлгөөний албаны ажилтанг иртэл тэндээ үлдэнэ.

2. Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн үндэсний хууль тогтоомжид хэрэв хэний ч биед ноцтой гэмтэл учраагүй бөгөөд осолд орсон этгээдүүдээс нэг нь ч энэ тухай цагдаагийн газарт мэдэгдэхийг шаардаагүй бол энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн "d"-д заасан үүргийг хүлээлгэхгүй байж болно.

32 дугаар зүйл. Гэрэл хэрэглэх нөхцөл

1. Харанхуй болохоос үүр цайх хүртэлх хугацаанд, түүнчлэн үзэгдэлт хангалтгүй болсон бусад аливаа нөхцөл (тухайлбал: манан будан татах, цас буюу ширүүн бороо орох)-д тээврийн хэрэгслүүд нь дараахь байдлаар гэрлээ асааж явна:

а) механикжсан тээврийн хэрэгслүүд ба мопед нь холын буюу ойрын гэрэл, түүнчлэн ар талын оврын гэрэл (энэхүү Конвенцид тээврийн хэрэгслийн ангилал бүрд заасан гэрэлтүүлэх хэрэгслүүдээс хамааран)-ийг;

б) чиргүүлийн хувьд урд талын оврын гэрлүүд (хэрэв энэхүү Конвенцийн 5 дугаар хавсралтын 30 дугаар хэсгийн заалтын дагуу ийм гэрэл байгаа бол), түүнчлэн ард талын оврын хоёроос цөөнгүй гэрлийг.

2. Дараахь тохиолдолд холын гэрлийг унтрааж, оронд нь ойрын гэрэл асаана:

а) суурин газарт зам нь хангалттай гэрэлтүүлэгдсэн байвал; түүнчлэн суурин газрын гаднах замд зорчих хэсэг нь жигд гэрэлтүүлэгдсэн бөгөөд энэ гэрэлтүүлэлт нь жолоочид үзэгдэлтийг боломжийн зайнд хангаж өгч байгаа ба бусад хөдөлгөөнд оролцогчдод уг тээврийн хэрэгслийг хангалттай зайнаас харах боломжийг олгож байвал;

б) зөрж өнгөрөхдөө өөдөөс яваа жолоочийг гялбуулахгүй, түүнийг тайван, аюулгүй хөдөлгөөнөө үргэлжлүүлэхэд нь боломж олгохын тулд хангалттай зайнаас;

с) бусад хөдөлгөөнд оролцогчид буюу замын дагуу байрласан усан зам ба төмөр замаар явагчдыг гялбуулахаас зайлсхийх бүх нөхцөлд.

3. Хэрэв тээврийн хэрэгсэл өөр тээврийн хэрэгслийн араас холгүй явж байгаа бол 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу гүйцэж түрүүлэх дохиог гэрлээр өгөхдөө холын

гэрлийг ашиглаж болно.

4. Манангийн гэрлийг зөвхөн цас, ширүүн бороо орж байгаа буюу өтгөн манан будантай үед, эсвэл үүнтэй адил төстэй бусад нөхцөлд хэрэглэж болно; Эдгээр тохиолдлуудад урд талын манангийн гэрлийг ойрын гэрлийн оронд ч хэрэглэж болно. Үндэсний хууль тогтоомжид урд талын манангийн гэрлийг ойрын гэрлийн хамт, түүнчлэн уг гэрлийг тахирласан нарийн замд асааж явахыг зөвшөөрч болно.

5. Урд талдаа оврын гэрлээр тоноглогдсон тээврийн хэрэгслийн хувьд энэ гэрлийг холын буюу ойрын гэрэл, эсвэл урд талын манангийн гэрлийн хамт асаах ёстой.

6. Өдрийн цагт замаар яваа аливаа мотоцикл урд талдаа дор хаяж нэг ойрын гэрэл, ард талдаа улаан өнгийн гэрэл асааж явна. Үндэсний хууль тогтоомжид ойрын гэрлийн оронд өдрийн гэрэл (үүнийг “өдрийн цагаар явахдаа хэрэглэдэг гэрэл” гэж ойлгоно /орч/) ашиглахыг зөвшөөрч болно.

7. Үндэсний хууль тогтоомжоор автомашины жолоочид өдрийн цагт ойрын гэрэл буюу өдрийн гэрэл асааж явахыг үүрэг болгож болно. Энэ тохиолдолд урд талын гэрлийн хамт ард талын оврын гэрлийг заавал асаах ёстой.

8. Харанхуй болохоос үүр цайх хүртэлх хугацаанд, түүнчлэн үзэгдэлт хангалтгүй болсон бусад аливаа нөхцөлд механикжсан тээврийн хэрэгсэл болон чиргүүл нь зам дээр түр буюу удаан зогсож байхдаа урд болон ард талын оврын гэрлээ асаасан байх ёстой. Өтгөн манан будантай буюу цас, ширүүн бороо орж байгаа, түүнчлэн үүнтэй адил төстэй бусад нөхцөлд ойрын гэрэл юмуу урд талын манангийн гэрлээ асааж болно. Энэ тохиолдолд ард талын оврын гэрэлд нэмэлт болгож арын манангийн гэрлээ асааж болно.

9. Суурин газарт дараахь нөхцөлүүдэд энэ зүйлийн 8 дахь хэсгийн заалтаас гажиж урд болон ард талын оврын гэрлийн оронд зогсоолын гэрлийг асааж болно:

a) тээврийн хэрэгслийн урт нь 6 метрээс, өргөн нь 2 метрээс илүүгүй бол;

b) тээврийн хэрэгсэл нь чиргүүлгүй бол;

c) тээврийн хэрэгслийн зогсоолын гэрэл нь түүний шахаж зогсож байгаа зорчих хэсгийн захын эсрэг талд байгаа бол.

10. Дараахь тохиолдолд энэ зүйлийн 8 ба 9 дэх хэсгийн заалтаас гажиж тээврийн хэрэгсэл нь ямар нэг гэрэл асаахгүйгээр түр буюу удаан зогсож болно:

a) замын гэрэлтүүлэг нь тээврийн хэрэгслийг хангалттай зайнаас сайн харагдуулахуйц байвал;

b) тээврийн хэрэгсэл нь зорчих хэсэг болон хатуу хучилттай хөвөөний гадна талд зогсож байгаа бол;

c) аккумулятороор тоноглогдоогүй мопед ба шаахайгүй мотоцикл нь суурин газарт зорчих хэсгийн хамгийн захад зогсож байгаа бол.

11. Үндэсний хууль тогтоомжоор суурин газарт гудамж замын хөдөлгөөн сийрэг үед түр буюу удаан зогсож байгаа тээврийн хэрэгслийн хувьд энэ зүйлийн 8 ба 9 дэх хэсгийн заалтаас гажсан заалт гаргаж болно.

12. Ухрахын гэрлийг тээврийн хэрэгсэл зөвхөн ухарч байхдаа буюу ухрах гэж байхдаа

асааж болно.

13. Ослын дохиог бусад хөдөлгөөнд оролцогчдод дор дурдсан онцгой аюулыг анхааруулах зорилгоор асааж болно. Үүнд:

а) зам тээврийн осол буюу техникийн эвдрэлээс шалтгаалан зогссон тээврийн хэрэгслийг нэн даруй холдуулах (чирэх) боломжгүй бөгөөд тэр нь бусад хөдөлгөөнд оролцогчдод саад учруулж байвал;

б) бусад хөдөлгөөнд оролцогчдод ноцтой аюулыг анхааруулахын тулд.

14. Анхааруулах тусгай гэрлүүд:

а) хөх өнгийн гэрлийг зөвхөн яаралтай яваа, давуу эрх бүхий тээврийн хэрэгсэлд хэрэглэх буюу эсвэл ийм тээврийн хэрэгслийг бусад хөдөлгөөнд оролцогчдод анхааруулах шаардлагаар хэрэглэнэ;

б) шар (улбар) өнгийн гэрлийг зөвхөн тусгай үүрэг даалгавар (ийм гэрлээр тоноглогдсон байгаагийн учир шалтгаантай нь холбоотой) биелүүлэхэд зориулагдсан техникийн онцлогтой тээврийн хэрэгсэлд хэрэглэх буюу эсвэл зам дээр байгаа ийм тээврийн хэрэгсэл нь бусад хөдөлгөөнд оролцогчдод тааламжгүй буюу аюултай байдал бий болгохоор байвал хэрэглэнэ.

Үндэсний хууль тогтоомжоор өөр өнгийн анхааруулах гэрлүүд ашиглахыг зөвшөөрч болно.

15. Энэ Конвенцийн 5 дугаар хавсралтын 61 дүгээр хэсэгт зааснаас бусад ямар ч тохиолдолд тээврийн хэрэгсэл нь урд талдаа улаан, ард талдаа цагаан өнгийн гэрэлтэй байх ёсгүй. Тээврийн хэрэгслийн бүтцэд хийсэн өөрчлөлт буюу нэмэлт гэрлүүдээр тоноглогдсон байдал нь энэхүү шаардлагыг зөрчсөн байхыг зөвшөөрөхгүй.

33 дугаар зүйл. 32 дугаар зүйлд тусгагдаагүй тээврийн хэрэгсэл ба зарим хөдөлгөөнд оролцогчдын гэрэлтүүлгийн нөхцөл

1. Харанхуй болохоос үүр цайх хүртэлх хугацаанд зам дээр байгаа аливаа тээврийн хэрэгсэл буюу тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн (энэ Конвенцийн 32 дугаар зүйлийн заалтад хамаарагдаагүй) нь урд талдаа дор хаяж нэг ширхэг цагаан буюу цайвар шар өнгийн, ард талдаа дор хаяж нэг ширхэг улаан өнгийн гэрэлтэй байвал зохино. Хэрэв эдгээр гэрлийг урд буюу ард талд зөвхөн нэг ширхгээр байрлуулах гэж буй бол түүнийг тээврийн хэрэгслийн голд, эсвэл хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талд байрлуулна.

а) Гар тэргэнцрүүд, өөрөөр хэлбэл гараар түрдэг тэргэнцрүүд нь урд талдаа дор хаяж нэг ширхэг цагаан буюу цайвар шар өнгийн, ард талдаа дор хаяж нэг ширхэг улаан өнгийн гэрэлтэй байвал зохино. Энэ хоёр гэрлийн эх үүсгүүр нь нэг гэрэл байж болох бөгөөд тэр нь хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талд байрлана. Өргөн нь 1 метрээс илүүгүй тэргэнцэрт энэ гэрлүүд заавал байхыг шаардахгүй.

б) Ердийн хөсөг нь урд талдаа хоёр ширхэг цагаан буюу цайвар шар өнгийн, ард талдаа хоёр ширхэг улаан өнгийн гэрэлтэй байвал зохино. Гэхдээ үндэсний хууль тогтоомжоор ийм тээврийн хэрэгсэлд урд талдаа зөвхөн нэг ширхэг цагаан буюу цайвар шар гэрэл, ард талдаа мөн нэг ширхэг улаан гэрэлтэй байхыг зөвшөөрч болно. Эдгээр гэрлүүдийг хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талд байрлуулна.

Хэрэв дээр дурдсан гэрлүүдийг тээврийн хэрэгсэлд бэхэлж болохооргүй байвал

түүнийг хэн нэгэн хүн (хамгаалагч этгээд) бариад тээврийн хэрэгслийн архан талд дагаж явж болно. Түүнээс гадна ердийн хөсгийн ард талд хоёр ширхэг улаан өнгийн гэрэл ойлгуурыг түүний хоёр талын ирмэгт аль болох ойрхон байрлуулсан байна. Ердийн хөсгийн өргөн 1 метрээс илүүгүй бол заавал гэрэлтэй байхыг шаардахгүй. Харин энэ тохиолдолд түүний голд буюу хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талд нэг ширхэг гэрэл ойлгуур байрлуулсан байвал зохино.

2. а) Шөнийн цагт зорчих хэсгээр явахдаа:

i) удирдагчтай явган зорчигчдын бүлэг буюу жагсаал нь хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талынхаа урд дор хаяж нэг ширхэг цагаан буюу цайвар шар өнгийн гэрэл, ардаа дор хаяж нэг ширхэг улаан өнгийн гэрэл, эсвэл урд, хойд талдаа улбар шар гэрэлтэй байна;

ii) уналга, ачлагын мал амьтан буюу мал, сүрэг тууж яваа хүмүүс (мал туугчид) хөдөлгөөний батлагдсан талын эсрэг талынхаа урд дор хаяж нэг ширхэг цагаан буюу цайвар шар өнгийн гэрэл, ардаа дор хаяж нэг ширхэг улаан өнгийн гэрэл, эсвэл урд, хойд талдаа улбар шар гэрэлтэй байна. Эдгээр гэрлийн эх үүсгүүр нь нэг хэрэгсэл байж болно.

б) Энэ хэсгийн “а”-д заасан гэрлүүд нь зохих байдлаар гэрэлтүүлэгдсэн суурин газарт заавал шаардагдахгүй.

34 дүгээр зүйл. Гажилт

1. Тусгай дуут болон гэрэл дохио ажиллуулсан, давуу эрх бүхий тээврийн хэрэгсэл ойртон ирж яваа үед хөдөлгөөнд оролцогч бүр зорчих хэсэг дээр түүнд зай тавьж өгөх ёстой бөгөөд шаардлагатай бол зогсоно.

2. Тусгай дохио ажиллуулсан, давуу эрх бүхий тээврийн хэрэгслийн жолооч бусад хөдөлгөөнд оролцогчдод аюул учруулахааргүй тохиолдолд энэхүү 2 дугаар бүлгийн бүх заалт (6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтаас бусад) болон зарим заалтыг мөрдөхгүй байж болох талаар үндэсний хууль тогтоомжид зааж болно.

3. Зам барих, засах, ашиглах зэргээр ажил эрхэлж буй хүмүүс болон эдгээр ажилд хэрэглэгдэж буй механизмын жолооч нар ажил үүргээ гүйцэтгэх явцдаа урьдчилан сэргийлэх зохих арга хэмжээг авсан тохиолдолд энэхүү 2 дугаар бүлгийн заалтуудыг ямар нэг хэмжээгээр мөрдөхгүй байж болох талаар үндэсний хууль тогтоомжид зааж болно.

4. Бусад тээврийн хэрэгслийн жолооч нар энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан механизмыг (замын ажилд хэрэглэгдэж байх үед нь) гүйцэж түрүүлэх буюу тэдэнтэй зөрж өнгөрөхдөө шаардлагатай болгоомжлох бүхий л арга хэмжээг авсны үндсэн дээр энэхүү Конвенцийн 11 ба 12 дугаар зүйлийн заалтуудыг мөрдөхгүй байж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

АВТОМАШИН БА ЧИРГҮҮЛИЙГ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦУУЛАХ НӨХЦӨЛ

35 дугаар зүйл. Бүртгэл

1. а) Энэхүү Конвенцийн заалтуудыг Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс бүртгэгдсэн, олон улсын хөдөлгөөнд оролцох чиргүүл (хөнгөн чиргүүлээс бусад) ба автомашинд хэрэглэнэ. Автомашины жолооч нь Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжийн зохих эрх мэдэл бүхий байгууллагаас буюу эдгээр Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжийн нэрийн өмнөөс төлөөлөхүйц тусгай эрх бүхий нийгэмлэгээс баталгаажуулан олгогдсон бүртгэлийн гэрчилгээтэй байна. Бүртгэлийн гэрчилгээнд дор хаяж дараахь зүйлүүд тусгагдсан байх ёстой:

энэхүү Конвенцийн 2 дугаар хавсралтад заасан бүртгэлийн дугаарын тоо, үсэг;

тээврийн хэрэгслийг анх бүртгэсэн огноо;

гэрчилгээ эзэмшигчийн овог, нэр, оршин суугаа хаяг;

тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн заводын нэр буюу түүний фабрикийн марк;

арал (шасси)-ын дугаар (үйлдвэрээс тавьсан серийн дугаар);

ачааны тээврийн хэрэгслийн хувьд бүх жингийн хэмжээ;

ачааны тээврийн хэрэгслийн хувьд ачаалалгүй жингийн хэмжээ;

гэрчилгээний хүчинтэй байх хугацаа (хэрэв хязгаарлалт тогтоосон бол).

Өгөгдсөн заалтууд нь гэрчилгээнд гагцхүү латин үсгээр юмуу үгээр, эсвэл энэ хоёр аргын аль алианаар нь (давтагдаж) бичигдсэн байна.

б) Харин Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь өөрсдийн нутаг дэвсгэрт олгогдсон гэрчилгээнд: анх бүртгэгдсэн огноотой хамт үйлдвэрлэсэн оныг бичих эсэхийг дотооддоо шийднэ.

с) Энэхүү Конвенцийн 6 ба 7 дугаар хавсралтаар тодорхойлсон А ба В ангиллын автомашины хувьд, түүнчлэн боломжтой бол бусад автомашинуудын хувьд:

i) гэрчилгээний эхний хуудсанд улсын бүртгэлийн ялгах тэмдэг (энэхүү Конвенцийн 3 дугаар хавсралтад заасан)-ийг багтаасан байна;

ii) бүртгэлийн гэрчилгээнд тусгагдвал зохих энэ хэсгийн "а"-д заасан найман заалтын өмнө буюу хойно нь А, В, С, D, E, F, G, H үсгүүд харгалзан тавигдсан байх ёстой;

iii) бүртгэсэн улсын үндэсний хэл дээр бичигдсэн гэрчилгээний гарчгийн дээд буюу доод талд францаар «Certificat d'immatriculation» (бүртгэлийн гэрчилгээ) гэсэн үг бичигдсэн байна.

d) замаар чирч оруулж ирэхээс бусад аргаар тухайн улсад түр оруулж ирсэн чиргүүл ба хагас чиргүүлүүдийн хувьд бүртгэлийн гэрчилгээний хуулбар (захиргааны байгууллагаар баталгаажуулсан) байхад хангалттай.

2. Олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа хагас чиргүүлтэй тээврийн хэрэгслийн хувьд энэхүү зүйлийн 1 дэх хэсгийн заалтаас гажиж чирэгч, хагас чиргүүл хоёр хамт

бүртгэгдсэн бөгөөд зөвхөн нэг бүртгэлийн гэрчилгээтэй байлаа ч энэ Конвенцийн заалтууд үйлчилнэ.

3. Энэхүү Конвенцийн нэг ч заалт нь Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс олон улсын хөдөлгөөнд оролцож яваа тээврийн хэрэгсэл нь жолоодож яваа этгээдийнхээ нэр дээр бүртгэгдээгүй байвал уг жолоочоос тухайн тээврийн хэрэгслийг эзэмших эрхийн баталгааг шаардах эрхийг хязгаарлахгүй.

4. Ашиглалтанд байгаа автомашиныг улсын болон бүс нутгийн хэмжээнд бүртгэдэг, түүнчлэн бүртгэлийн гэрчилгээтэй тээврийн хэрэгсэл бүрээр төвлөрсөн тооллого хөтлөн явуулдаг байгууллага байгуулахыг (хараахан байгуулж амжаагүй бол) Хэлэлцэн тохирогч Талуудад зөвлөж байна.

36 дугаар зүйл. Бүртгэлийн дугаар

1. Олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа автомашин бүр урд болон ард талдаа (мотоциклын хувьд зөвхөн ард талдаа) бүртгэлийн дугаарыг байрлуулсан байна.

2. Олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа, бүртгэгдсэн чиргүүл бүр ард талдаа бүртгэлийн дугаартай байна. Хэрэв бүртгэгдээгүй чиргүүлүүд чирсэн бол сүүлийн чиргүүл нь (ганц чиргүүлтэй бол тэр нь) чирэгч автомашиныхаа бүртгэлийн дугаартай ижил дугаартай байна.

3. Бүртгэлийн дугаарыг тавих арга, түүний бүрдэл хэсгүүд нь энэхүү Конвенцийн 2 дугаар хавсралтын заалтад нийцсэн байвал зохино.

37 дугаар зүйл. Улсын бүртгэлийн ялгах тэмдэг

1. Олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа автомашин бүр ард талдаа бүртгэлийн дугаараас гадна бүртгэгдсэн улсынхаа ялгах тэмдгийг байрлуулсан байна.

2. Энэхүү Конвенцийн 36 дугаар зүйлд заасны дагуу ард талдаа бүртгэлийн дугаар байрлуулах ёстой аливаа чиргүүл нь мөн ард талдаа бүртгэлийн дугаар олгосон улсынхаа ялгах тэмдгийг байрлуулсан байвал зохино. Энэ заалт нь чирэгч тээврийн хэрэгслийнхээ бүртгэгдсэн улсаас өөр улсад бүртгэгдсэн чиргүүлд ч мөн үйлчилнэ; хэрэв чиргүүл нь бүртгэгдээгүй бол тухайн улсынхаа нутаг дэвсгэрээр зорчихоос бусад тохиолдолд чирэгч тээврийн хэрэгслийн ялгах тэмдгийг ард талдаа байрлуулсан байна.

3. Ялгах тэмдгийг тавих арга, түүний бүрдэл хэсгүүд нь энэхүү Конвенцийн 3 дугаар хавсралтын заалтад нийцсэн байвал зохино.

38 дугаар зүйл. Таних шошго

Олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа автомашин, чиргүүл бүр энэхүү Конвенцийн 4 дүгээр хавсралтад заасан таних шошготой байна.

39 дүгээр зүйл. Тээврийн хэрэгслийн үзлэг ба техникийн шаардлага

1. Олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа автомашин, чиргүүл, тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн бүр энэхүү Конвенцийн 5 дугаар хавсралтын заалтыг хангасан байна. Түүнээс гадна техникийн бүрэн бүтэн байдалтай байвал зохино.

2. Үндэсний хууль тогтоомжид дараахь тээврийн хэрэгслүүдэд техникийн үзлэгийг тогтмол явуулж байхаар заах ёстой:

а) жолоочоос гадна 8-аас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин;

б) бүх жин нь 3500 кг-аас их ачааны автомашин, түүнчлэн ийм тээврийн хэрэгслийн чиргүүл.

3. Үндэсний хууль тогтоомжид энэ зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг бусад ангиллын тээврийн хэрэгслээр боломжийнхоо хэрээр өргөтгөж болно.

40 дүгээр зүйл. Шилжилтийн заалтууд

1. 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу энэ Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш 10 жилийн хугацаанд олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа чиргүүлүүдэд бүх жингээс нь үл хамааран, хэдийгээр эдгээр нь бүртгэгдэхгүй ч энэ Конвенцийн заалт үйлчилнэ.

2. Бүртгэлийн гэрчилгээг 35 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн нэмэлт засварт, түүнийг хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн хугацаанд нийцүүлсэн байх ёстой. Энэ хугацааны явцад олгогдсон гэрчилгээг түүний хүчинтэй хугацааг дуусах хүртэл харилцан хүлээн зөвшөөрөх ёстой.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

АВТОМАШИНЫ ЖОЛООЧ

41 дүгээр зүйл. Жолоочийн үнэмлэх

1. а) Автомашины жолооч бүр жолоочийн үнэмлэхтэй байна;

б) Хэлэлцэн тохирогч Талууд нь жолоочийн үнэмлэхийг тухайн жолоочийн эзэмшсэн байвал зохих мэдлэг, дадлагыг эрх мэдэл бүхий байгууллагаар шалгуулсны дараа олгох үүрэгтэй;

с) Үндэсний хууль тогтоомжид жолоочийн үнэмлэхийг авахад тавигдах шаардлагыг тусгасан байна;

д) Энэхүү Конвенцийн нэг ч заалт Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс автомашинаас бусад механикжсан тээврийн хэрэгсэл болон мопедыг жолоодох эрхийн үнэмлэхтэй байхыг шаардахыг нь хориглож буй мэтээр ойлгогдох ёсгүй.

2. Хэлэлцэн тохирогч Талууд нь дараахь заалтыг хүлээн зөвшөөрнө:

а) өөрийнх нь үндэсний хэл дээр бичигдсэн буюу эсвэл ийм хэл дээр бичигдээгүй боловч баталгаат орчуулгатай аливаа үндэсний жолоочийн үнэмлэхийг,

б) энэ Конвенцийн 6 дугаар хавсралтын заалтад нийцэж буй аливаа үндэсний жолоочийн үнэмлэхийг, мөн

с) энэ Конвенцийн 7 дугаар хавсралтын заалтад нийцэж буй аливаа олон улсын жолоочийн үнэмлэхийг

бусад Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс буюу эсвэл тэрхүү Хэлэлцэн тохирогч Талууд болон тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжийг төлөөлөх тусгай эрх бүхий нийгэмлэгээс олгосон бөгөөд хүчин төгөлдөр (хуурамч биш /орч/) байвал

өөрийн нутаг дэвсгэр дээр уг үнэмлэхээр тухайн ангиллын (уг үнэмлэхэд заагдсан) тээврийн хэрэгслийг жолоодоход нь хүчинтэйд тооцно. Энэ хэсгийн заалт нь жолооны суралцагчдад хамаарахгүй.

3. Дээр дурдсан хэсгийн заалтаас хамаарахгүйгээр:

а) хэрэв жолоочийн үнэмлэх дээр тухайн этгээдийг биедээ ямар нэгэн төхөөрөмж өмсөж хэрэглэсэн буюу эсвэл тээврийн хэрэгслээ тахир дутуу хүнд зориулан ямар нэг байдлаар өөрчилсөн үед хүчинтэй байхаар заасан болзолтой тусгай тэмдэглэгээ хийгдсэн байвал уг үнэмлэхийг зөвхөн энэ заасан болзлыг хангасан нөхцөлд хүчинтэйд тооцно;

б) Хэлэлцэн тохирогч Тал нь 18 нас хүрээгүй хүмүүсийн жолоочийн үнэмлэхийг өөрийн нутаг дэвсгэр дээр хүчингүйд тооцож болно;

с) Хэлэлцэн тохирогч аль ч Тал энэхүү Конвенцийн 6 ба 7 дугаар хавсралтад заасан С, D, E ангиллын тээврийн хэрэгсэл буюу түүний бүрэлдэхүүнийг жолоодож буй 21 нас хүрээгүй этгээдийн жолоочийн үнэмлэхийг өөрийн нутаг дэвсгэр дээр хүчингүйд тооцож болно.

4. Хэлэлцэн тохирогч Тал нь өөрийн үндэсний хууль тогтоомжид энэхүү Конвенцийн 6 ба 7 дугаар хавсралтад заасан тээврийн хэрэгслийн ангиллыг дэд ангилалд хувааж болно. Хэрэв жолоочийн үнэмлэхний үйлчлэх хүрээ ямар нэг ангиллын хүрээнд тодорхой тээврийн хэрэгслүүдээр хязгаарлагдаж байгаа бол уг ангиллыг тэмдэглэсэн үсэг нь нэмэлт тоотой байхаас гадна уг хязгаарлалтын байдал заагдсан байх ёстой.

5. Энэ зүйлийн 3 дахь хэсгийн “с” ба 2 дахь хэсгийн заалтыг хэрэглэхдээ:

а) энэ Конвенцийн 6 ба 7 дугаар хавсралтад заасан В ангиллын автомашин нь хөнгөн чиргүүл чирч болно; түүнчлэн хэрэв бүрэлдэхүүний нийт бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй бол 750 кг-аас илүү бүх жинтэй (гэхдээ чирэгчийнхээ ачаалалгүй жингээс хэтрэхгүй) чиргүүлийг ч чирч болно.

б) энэ Конвенцийн 6 ба 7 дугаар хавсралтад заасан С ба D ангиллын автомашин нь хөнгөн чиргүүл чирч болох бөгөөд ийм бүрэлдэхүүн нь С буюу D ангилалд хамаарагдсан хэвээр байна.

6. Олон улсын жолоочийн үнэмлэх нь зөвхөн үндэсний жолоочийн үнэмлэх (энэ Конвенцид заагдсан наад захын шаардлагыг хангасан) дээр үндэслэгдэн олгогдож болно. Олон улсын жолоочийн үнэмлэх нь түүн дээр дугаар нь тэмдэглэгдсэн үндэсний жолоочийн үнэмлэхний хугацаа дуусахад хүчингүй болно.

7. Энэ зүйлийн заалтууд нь Хэлэлцэн тохирогч Талуудыг дараахь зүйлүүдэд албадаагүй болно:

а) уг жолоочийн үнэмлэхийг Хэлэлцэн тохирогч бусад Талуудаас олгох үед өөрийн нутаг дэвсгэрт оршин сууж байсан буюу олгосны дараа өөрийн нутаг дэвсгэрт оршин суухаар шилжиж ирсэн этгээдийн үндэсний буюу олон улсын жолоочийн үнэмлэхийг хүчинтэйд тооцохыг;

б) үнэмлэхийг олгох үед тэрхүү олгож буй улсын нутаг дэвсгэрт оршин сууж байгаагүй буюу олгосны дараа өөр улсын нутаг дэвсгэр рүү шилжин суурьшсан этгээдийн дээр дурдсан үнэмлэхийг хүчинтэйд тооцохыг.

42 дугаар зүйл. Жолоочийн үнэмлэхийг хүчингүй болгох

1. Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгж нь өөрийн нутаг дэвсгэр дээр дүрэм зөрчсөн жолоочийн жолоодох эрхийг үндэсний хууль тогтоомжийн дагуу хасах үндэслэлтэй байвал уг этгээдийн үндэсний буюу олон улсын жолоочийн үнэмлэх ашиглах эрхийг өөрийн нутаг дэвсгэр дээр хасаж болно. Энэ тохиолдолд жолоочийн үнэмлэх ашиглах эрхийг хассан эрх бүхий байгууллага нь:

a) жолоочийн үнэмлэхийг хурааж, хураасан хугацааг дуустал буюу тухайн жолоочийг нутаг дэвсгэрээсээ гартал (аль хугацаа нь түрүүлж дуусахаас хамааран) уг үнэмлэхийг саатуулж болно;

b) үнэмлэх ашиглах эрх хассан тухайгаа уг үнэмлэхийг олгосон байгууллагад мэдээлж болно;

c) олон улсын жолоочийн үнэмлэхний тухайд бол түүний тусгай тэмдэглэгээ хийх зориулалттай хуудсанд уг үнэмлэх өөрийн нутаг дэвсгэр дээр хүчингүй болсон тухай тэмдэглэгээ хийж болно;

d) энэ хэсгийн “a”-д заасан арга хэмжээг аваагүй тохиолдолд “b”-д заасны дагуу мэдээлэл хийхдээ: уг этгээдэд шийдвэрлэх гэж буй арга хэмжээнийхээ тухай түүнд мэдэгдэхийг үнэмлэх олгосон байгууллагаас хүсч болно.

2. Хэлэлцэн тохирогч Талууд нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн “d”-д заасан хүсэлтийн дагуу уг жолоочид өөрт нь холбогдуулж буй шийдвэрийн талаар мэдэгдэхийг хичээх ёстой.

3. Энэ Конвенцийн нэг ч заалт Хэлэлцэн тохирогч Талууд буюу тэдгээрийн нутаг дэвсгэрийн нэгжээс тухайн жолооч (үндэсний буюу олон улсын жолоочийн үнэмлэхтэй)-ийн байдал нь түүнийг хөдөлгөөнд аюул учруулахгүйгээр тээврийн хэрэгсэл жолоодож чадахгүй болохыг илт харуулж байгаа буюу эсвэл тэрээр оршин суудаг улсдаа тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан болох нь батлагдвал уг этгээдэд автомашин жолоодохыг хориглоход нь саад болохгүй.

43 дугаар зүйл. Шилжилтийн заалтууд

1. 1949 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Женев хотод батлагдсан замын хөдөлгөөний тухай Конвенцийн заалтад нийцсэн бөгөөд энэхүү Конвенцийг 47 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныхаа дагуу хүчин төгөлдөр болсноос хойш таван жил хүртэлх хугацаанд олгогдсон олон улсын жолоочийн үнэмлэхийг энэ Конвенцийн 41 ба 42 дугаар зүйлүүдийг хэрэглэхдээ энэхүү Конвенцид заасан олон улсын жолоочийн үнэмлэхтэй адилтгаж үзнэ.

2. Үндэсний жолоочийн үнэмлэхийг 6 дугаар хавсралтын нэмэлт засварт, түүнийг хүчин төгөлдөр болсноос хойш таван жилийн хугацаанд нийцүүлсэн байх ёстой. Энэ хугацааны явцад олгогдсон үнэмлэхийг түүний хүчинтэй хугацааг дуусах хүртэл харилцан хүлээн зөвшөөрөх ёстой.

ТАВДУГААР БҮЛЭГ

УНАДАГ ДУГУЙ БА МОПЕДЫГ ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦУУЛАХ НӨХЦӨЛ

44 дүгээр зүйл

1. Олон улсын хөдөлгөөнд оролцож буй хөдөлгүүргүй унадаг дугуй нь дараахь шаардлагыг хангасан байх ёстой:

а) идэвхжил бүхий тоормостой;

б) хангалттай зайнаас сонсогдохуйц хонхтой (үүнээс бусад аливаа дуут дохионы хэрэгсэлтэй байхыг хориглоно);

с) урд талдаа цагаан буюу цайвар шар өнгийн, ард талдаа улаан өнгийн гэрэлтэй байх ба түүнчлэн ард талдаа улаан өнгийн гэрэл ойлгууртай байх.

2. Энэхүү Конвенцийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мопедыг мотоциклтой адилтгаж үзэх мэдэгдэл хийгээгүй Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт олон улсын хөдөлгөөнд оролцож буй мопед нь дараахь шаардлагыг хангасан байх ёстой:

а) нэг нэгнээсээ үл хамаарах хоёр тоормостой;

б) хангалттай зайнаас сонсогдохуйц хонх буюу бусад дуут дохиотой;

с) идэвхжил бүхий дуу намсгууртай;

д) урд талдаа цагаан буюу цайвар шар өнгийн, ард талдаа улаан өнгийн гэрэлтэй байх ба түүнчлэн ард талдаа улаан өнгийн гэрэл ойлгууртай байх;

е) энэ Конвенцийн 4 дүгээр хавсралтад заасан таних шошготой байх.

3. Энэхүү Конвенцийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу мопедыг мотоциклтой адилтгаж үзэх мэдэгдэл хийсэн Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэрт мопедыг олон улсын хөдөлгөөнд оролцуулах нөхцөл нь энэхүү Конвенцийн 5 дугаар хавсралтаар мотоциклд тодорхойлсон нөхцөл болно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

45 дугаар зүйл

1. Энэхүү Конвенц нь Нью-Йорк дахь НҮБ-ын Төв байранд 1969 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэл НҮБ-ын гишүүн орнууд болон Олон улсын атомын эрчим хүчний агентлагийн гишүүн буюу түүний төрөлжсөн аливаа байгууллагын гишүүн орнууд, мөн Олон улсын Шүүхийн Дүрэмд нэгдэн орсон Талууд, түүнчлэн энэ Конвенцийн Хэлэлцэн тохирогч Талууд болохоор НҮБ-ын Ерөнхий Асамблейгаас уригдсан аливаа бусад улс гарын үсэг зурахад нээлттэй байна.

2. Энэхүү Конвенцийг соёрхон батална. Соёрхон баталсан бичгүүд НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалагдахаар шилжинэ.

3. Энэхүү Конвенц нь энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аль ч улсыг нэгдэн ороход нээлттэй хэвээр үлдэнэ. Нэгдэн орох тухай баримт бичгийг Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулахаар шилжүүлнэ.

4. Аливаа улс нь энэхүү Конвенцид гарын үсэг зурахдаа буюу батламж бичиг, нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар илгээх үедээ өөрийн улсад бүртгэгдсэн олон улсын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэлд байрлуулахаар сонгосон ялгах тэмдэг (энэхүү Конвенцийн 3 дугаар хавсралтын заалтад нийцэх)-ээ Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх ёстой. Цаашид Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр нот бичиг илгээх

замаар аливаа улс нь урьд өмнө сонгосон ялгах тэмдгээ өөрчилж болно.

46 дугаар зүйл

1. Аливаа улс нь энэ Конвенцийг соёрхон баталж гарын үсэг зурахдаа буюу нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар илгээх үедээ, эсвэл Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр нот бичиг илгээх замаар хэдийд ч энэхүү Конвенцийг тус улсын гадаад харилцааг хариуцдаг нутаг дэвсгэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хэрэглэхээр болсноо мэдэгдэж болно. Конвенц нь нот бичигт заагдсан нутаг дэвсгэрт Ерөнхий нарийн бичгийн дарга уг нот бичгийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дараагаас, эсвэл тухайн улс (нот бичиг илгээсэн)-д энэ Конвенц хүчин төгөлдөр үйлчилж эхлэх үеэс (хэрэв энэ огноо нь дээрх нот бичиг илгээснээс хожуу байгаа бол) хэрэгжиж эхэлнэ.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсэн аливаа улс дараа нь хэдийд ч Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр нот бичиг илгээх замаар энэ Конвенц нь уг нот бичигт дурдагдсан нутаг дэвсгэр дээр хэрэгжихгүй болсныг мэдэгдэж болох бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга уг нот бичгийг хүлээн авснаас хойш 1 жилийн дараагаас тухайн нутаг дэвсгэр дээр энэ Конвенц хүчингүй болно.

3. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мэдэгдэл хийсэн аливаа улс нь тухайн нот бичигт дурдагдсан нутаг дэвсгэр дээр бүртгэгдсэн олон улсын хөдөлгөөнд оролцох тээврийн хэрэгсэлд байрлуулахаар сонгосон ялгах тэмдэг (энэхүү Конвенцийн 3 дугаар хавсралтын заалтад нийцэх)-ээ Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэнэ. Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр нот бичиг илгээх замаар аливаа улс нь урьд өмнө сонгосон ялгах тэмдгээ өөрчилж болно.

47 дугаар зүйл

1. Энэхүү Конвенц нь түүнийг соёрхон баталсан буюу түүнд нэгдэн орсон тухай арван тав дахь баримт бичиг хадгалагдахаар ирсэн өдрөөс хойш арван хоёр сарын дараагаас хүчин төгөлдөр болно.

2. Соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай арван тав дахь баримт бичиг хадгалагдахаар ирснээс хойш энэ Конвенцийг соёрхон батлах буюу түүнд нэгдэн орох аливаа улсын хувьд эдгээр улсын соёрхон баталсан бичиг буюу нэгдэн орсон тухай баримт бичиг хадгалагдахаар ирснээс хойш арван хоёр сарын дараагаас хүчин төгөлдөр болно.

48 дугаар зүйл

Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсон үеэс эхлэн Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд 1926 оны 4 дүгээр сарын 24-ний өдөр Парис хотноо гарын үсэг зурагдсан замын хөдөлгөөний тухай Олон улсын конвенц ба автомашины хөдөлгөөний тухай Олон улсын конвенц, түүнчлэн 1943 оны 12 дугаар сарын 15-ны өдөр Вашингтон хотноо гарын үсэг зурагдаж нээлттэй болсон америкийн орнуудын хоорондох автомашины хөдөлгөөний дүрмийн тухай Конвенц, мөн 1949 оны 9 дүгээр сарын 19-ний өдөр Женев хотноо гарын үсэг зурагдаж нээлттэй болсон замын хөдөлгөөний тухай Конвенц хүчингүй болж энэхүү Конвенцоор солигдоно.

49 дүгээр зүйл

1. Энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсноос хойш нэг жилийн дараагаас Хэлэлцэн тохирогч аливаа Талаас Конвенцид нэг буюу хэд хэдэн засвар хийх санал оруулж болно. Засвар оруулахаар санал болгосон бичгээ тайлбар меморандум (*дипломат бичиг /орч/-ын хамт Ерөнхий нарийн бичгийн даргад явуулах ба тэрээр түүнийг бүх Хэлэлцэн тохирогч*

Талуудад илгээнэ. Хэлэлцэн тохирогч Талууд нь энэ бичгийг хүлээн авснаас хойш арван хоёр сарын дотор: а) энэ засварыг хүлээн авч байгаа эсэх, б) энэ засвараас татгалзаж байгаа эсэх, с) энэ засварыг авч хэлэлцэхийн тулд бага хурал хийлгэхийг хүсч байгаа эсэх талаар Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэх боломжтой.

Засвар оруулахаар санал болгосон бичгийг Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Конвенцийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдагдсан бүх улсад илгээнэ.

2. а) Дээрх заалтын дагуу тараагдсан аливаа санал болгосон засварыг хэрэв дээр дурдсан арван хоёр сарын хугацаанд Хэлэлцэн тохирогч Талуудын гуравны нэгээс цөөхөн нь уг засвараас татгалзсан буюу уг засварыг авч хэлэлцэхийн тулд бага хурал хийлгэхийг хүсч байгаагаа Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэн бол уг засварыг хүлээж авсанд тооцно. Ерөнхий нарийн бичгийн дарга нь аливаа санал болгосон засварыг хүлээн авч байгаа буюу татгалзаж байгаа тухай, эсвэл бага хурал хийлгэх тухай хүсэлтийг бүх Хэлэлцэн тохирогч Талуудад мэдэгдэнэ. Хэрэв тогтоосон арван хоёр сарын хугацаанд Хэлэлцэн тохирогч бүх Талуудын гуравны нэгээс цөөхөн нь татгалзсан буюу хурал хийлгэхийг хүссэн мэдэгдэл ирүүлбэл Ерөнхий нарийн бичгийн дарга өмнөх хэсэгт заасан арван хоёр сарын хугацаа дууссанаас хойш зургаан сарын дараа эдгээр татгалзсан буюу хүсэлт гаргасан Талуудаас бусад Талуудын хувьд уг засвар хүчин төгөлдөр болж байгаа тухай Хэлэлцэн тохирогч бүх Талуудад мэдэгдэнэ.

б) Дээр заасан арван хоёр сарын туршид уг засвараас татгалзаж байсан буюу уг засварыг авч хэлэлцэхийн тулд бага хурал хийлгэхийг хүсч байсан Хэлэлцэн тохирогч аливаа Талууд нь энэ хугацаа дууссанаас хойш хэдийд ч Ерөнхий нарийн бичгийн даргад уг засварыг хүлээн авч байгаа тухайгаа мэдэгдэж болох бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү мэдэгдлийг бусад Хэлэлцэн тохирогч бүх Талуудад тараана. Ийм мэдэгдэл явуулсан Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд уг засвар нь Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг авснаас хойш зургаан сарын дараагаас хүчин төгөлдөр болно.

3. Хэрэв энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу уг засварыг хүлээн аваагүй бөгөөд хэрэв энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан арван хоёр сарын хугацаанд Хэлэлцэн тохирогч бүх Талуудын тал хувиас цөөхөн нь Ерөнхий нарийн бичгийн даргад уг засвараас татгалзаж байгаагаа мэдэгдэж байгаа, түүнчлэн хэрэв Хэлэлцэн тохирогч бүх Талуудын дор хаяж гуравны нэг (гэхдээ арваас цөөнгүй) нь уг засварыг хүлээн авч байгаа буюу хурал хийлгэхийг хүсч байгаагаа мэдэгдэж байгаа бол санал болгосон засвар болон бусад аливаа санал (тухайлбал, энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу дэвшүүлж буй санал байж болно)-ыг авч хэлэлцэхийн тулд Ерөнхий нарийн бичгийн дарга бага хурал хийлгэнэ.

4. Хэрэв энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу бага хурал хийлгэх гэж байгаа бол Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Конвенцийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заагдсан бүх улсыг урина. Хурал эхлэхээс дор хаяж зургаан сарын өмнө Ерөнхий нарийн бичгийн дарга бага хуралд уригдсан орнуудад хандан санал оруулсан засвар дээр нэмж уг хурлаар хэлэлцэж болох аливаа саналаа танилцуулахыг хүсч, эдгээр саналуудыг хуралд уригдсан бүх улсад хурал эхлэхээс дор хаяж гурван сарын өмнө мэдэгдэнэ.

5. а) Энэхүү Конвенцид оруулах гэж буй аливаа засварыг бага хуралд оролцож буй улсуудын гуравны хоёрын олонхи нь хүлээн зөвшөөрч байгаа бөгөөд энэ олонхи нь хуралд оролцож буй Хэлэлцэн тохирогч бүх Талуудын дор хаяж гуравны хоёрыг багтааж байгаа нөхцөлд уг засварыг хүлээн зөвшөөрсөнд тооцно. Ерөнхий нарийн бичгийн дарга Хэлэлцэн тохирогч бүх Талуудад уг засварыг хүлээж авсныг мэдэгдэх бөгөөд ийнхүү мэдэгдсэнээс хойш арван хоёр сарын дараа Хэлэлцэн тохирогч бүх Талууд (гэхдээ Ерөнхий нарийн бичгийн даргад энэ хугацаанд засвар оруулахыг татгалзсанаа мэдэгдсэнээс бусад)-ын хувьд хүчин төгөлдөр болно.

б) Дээр заасан арван хоёр сарын туршид уг засвараас татгалзаж байсан Хэлэлцэн тохирогч аливаа Талууд нь хэдийд ч Ерөнхий нарийн бичгийн даргад уг засварыг хүлээн авч байгаа тухайгаа мэдэгдэж болох бөгөөд Ерөнхий нарийн бичгийн дарга энэ тухай бусад Хэлэлцэн тохирогч бүх Талуудад зарлана. Ийм мэдэгдэл явуулсан Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд уг засвар нь Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг авснаас хойш зургаан сарын дараагаас буюу хэрэв дээр заасан арван хоёр сарын хугацаа нь түүнээс хойш дуусч байвал түүнийг дууссанаас хойш хүчин төгөлдөр болно.

6. Хэрэв засвар хийхээр оруулсан санал нь энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хүлээн зөвшөөрөгдөөгүй ба энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан бага хурлыг хийх нөхцөл бүрдээгүй бол уг засвараас татгалзсанд тооцно.

50 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч аливаа Тал Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр нот бичиг илгээх замаар энэ Конвенцоос татгалзаж болно. Ерөнхий нарийн бичгийн дарга тэрхүү нот бичгийг хүлээн авсан өдрөөс хойш нэг жилийн хугацаа өнгөрсний дараа Конвенц цуцлагдана.

51 дүгээр зүйл

Дараалсан арван хоёр сарын туршид Хэлэлцэн тохирогч Талуудын тоо таваас доош байвал энэ Конвенц хүчингүй болно.

52 дугаар зүйл

Энэ Конвенцийг тайлбарлах буюу хэрэгжүүлэхтэй холбогдсон Хэлэлцэн тохирогч Талуудын хоорондын аливаа маргааныг Талууд хэлэлцээрийн замаар буюу бусад зохицуулах арга замаар шийдэж чадахгүй бол тэдгээрийн аль нэг Талын хүсэлтээр Олон улсын Шүүхэд шилжүүлж болно.

53 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн нэг ч заалт Хэлэлцэн тохирогч аль нэг Талаас НҮБ-ын Дүрэмд нийцүүлэн өөрийн улсын гадаад болон дотоодын аюулгүй байдлыг хангахад зайлшгүй шаардлагатай гэж үзсэн хязгаарлалтын арга хэмжээ авахад нь саад болох мэтээр ойлгогдох ёсгүй.

54 дүгээр зүйл

1. Аливаа улс нь энэ Конвенцид гарын үсэг зурахдаа буюу батламж бичиг, нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үедээ энэхүү Конвенцийн 52 дугаар зүйлтэй холбогдолгүй гэж үзэж байгаагаа мэдэгдэж болно. Ийм мэдэгдэл гаргасан Хэлэлцэн тохирогч аливаа Талуудын хувьд бусад Хэлэлцэн тохирогч Талууд 52 дугаар зүйлээр холбогдолгүй байна.

2. Аливаа улс нь батламж бичиг буюу нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөх үедээ Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр нот бичиг илгээх замаар энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхдээ мопедыг мотоциклтой адилтгаж үзэх тухай мэдэгдэл хийж болно (1 дүгээр зүйлийн "n").

Хэдийд ч Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр нот бичиг илгээх замаар мэдэгдлээ буцааж болно.

3. Энэ зүйлийн 2 дахь хэсгээр заасан мэдэгдэл нь Ерөнхий нарийн бичгийн дарга уг нот бичгийг хүлээн авснаас хойш зургаан сарын дараа буюу тухайн улсын хувьд Конвенц хүчин төгөлдөр болох үеэс (хэрэв энэ огноо нь дээрх нот бичиг илгээснээс хожуу байгаа бол) эхлэн хүчинтэй болно.

4. Энэ Конвенцийн 45 дугаар зүйлийн 4 дэх хэсэг буюу 46 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хийсэн мэдэгдэл (урьд нь сонгосон ялгах тэмдгээ өөрчилсөн тухай) нь Ерөнхий нарийн бичгийн дарга уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш гурван сарын дараа хүчин төгөлдөр болно.

5. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт тусгагдсан мэдэгдлээс бусад энэхүү Конвенц ба түүний хавсралтад нэмж хийх тайлбаруудыг хэрэв батламж бичиг буюу нэгдэн орох тухай баримт бичгээ хадгалуулахаар өгөхөөсөө өмнө бичгийн хэлбэрт оруулан, батламж бичиг буюу нэгдэн орох тухай баримт бичигтээ баталж оруулсан нөхцөлд зөвшөөрнө. Ерөнхий нарийн бичгийн дарга уг тайлбаруудын тухай энэхүү Конвенцийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдагдсан бүх улсад мэдэгдэнэ.

6. Энэ зүйлийн 1 буюу 4 дэх хэсэгт заасны дагуу тайлбар буюу мэдэгдэл хийсэн Хэлэлцэн тохирогч Тал нь хэдийд ч Ерөнхий нарийн бичгийн даргын нэр дээр нот бичиг илгээх замаар тайлбараа буцааж болно.

7. Энэ зүйлийн 5 дахь хэсгийн дагуу хийгдсэн аливаа тайлбар нь:

а) дээрх тайлбарыг хийсэн Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд Конвенцийн холбогдох заалт нь уг тайлбарын хүрээнд өөрчлөгдөнө;

б) дээрх тайлбарыг хийсэн Хэлэлцэн тохирогч Талуудтай харилцаа холбоотой бусад Хэлэлцэн тохирогч Талуудын хувьд ч уг заалт нь мөн тэр хэмжээгээр өөрчлөгдөнө.

55 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн 49 ба 54 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, нот бичиг, мэдээллээс гадна Ерөнхий нарийн бичгийн дарга 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдагдсан бүх улсад доорхи мэдээллийг хийнэ:

а) 45 дугаар зүйлийн дагуу Конвенцид гарын үсэг зурсан, соёрхон баталсан, нэгдэн орсон тухай;

б) 45 дугаар зүйлийн 4 дэх хэсэг ба 46 дугаар зүйлд хамаарах нот бичиг ба мэдэгдлүүдийн тухай;

с) 47 дугаар зүйлийн дагуу энэхүү Конвенц хүчин төгөлдөр болсон огнооны тухай;

д) 49 дүгээр зүйлийн 2 ба 5 дахь хэсгийн дагуу энэхүү Конвенцид оруулсан засвар хүчин төгөлдөр болсон огнооны тухай;

е) 50 дугаар зүйлийн дагуу цуцалсан тухай;

ф) 51 дүгээр зүйлийн дагуу энэхүү Конвенц хүчингүй болсон тухай.

56 дугаар зүйл

Бүгд адил хүчинтэйд тооцогдох англи, испани, орос, франц, хятад хэлээр нэг нэг хувь үйлдэгдсэн энэхүү Конвенцийн жинхэнэ эх бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад

хадгалуулах ба тэрээр энэхүү эх бичгээс зохих журмын дагуу баталгаат хуулбар хийж энэ Конвенцийн 45 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт дурдагдсан бүх улсад хүргүүлнэ.

ҮҮНИЙГ БАТАЛЖ, өөр өөрсдийн засгийн газраас зохих бүрэн эрх олгогдсоныхоо дагуу дор гарын үсгээ зурах төлөөлөгчид энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

Нэгэн мянга есөн зуун жаран найман оны арван нэгдүгээр сарын наймны өдөр Вена хотод ҮЙЛДЭВ.

ХАВСРАЛТУУД

НЭГДҮГЭЭР ХАВСРАЛТ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨНД АВТОМАШИН БА ЧИРГҮҮЛИЙГ ОРОЛЦУУЛАХ ҮҮРГЭЭС ТҮДГЭЛЗЭХ

1. Хэлэлцэн тохирогч Талууд нь өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцож байгаа автомашин, чиргүүл ба тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний нийт жин буюу тэнхлэгт ногдох ачаалал, эсвэл оврын хэмжээ нь үндэсний хууль, тогтоомжоор тогтоосон хязгаар (өөрийн нутаг дэвсгэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслүүдэд тогтоосон хязгаар)-аас хэтэрч байвал дээрх тээврийн хэрэгслүүдийг нутаг дэвсгэр дээрээ олон улсын хөдөлгөөнд оролцуулахгүй байж болно. Хэлэлцэн тохирогч Талууд нь хүнд даацын тээврийн хэрэгслүүд олон улсын хөдөлгөөнд оролцуулах нутаг дэвсгэр дээр бүс орнуудын хэлэлцээр байгуулах замаар уг нутаг дэвсгэрийн зам (хангалтгүй үзүүлэлт бүхий замаас бусад) дээр тухайн хэлэлцээрээр тогтоосноос хэтрэхгүй жин болон оврын хэмжээтэй тээврийн хэрэгсэл буюу түүний бүрэлдэхүүнийг олон улсын хөдөлгөөнд оролцуулж байхыг хичээх ёстой.

2. Энэхүү хавсралтын 1 дүгээр хэсгийн заалтыг хэрэглэхдээ тээврийн хэрэгслийн оврын өргөний дагуух хэмжээнээс дор дурдсан зүйлүүд илүү гарч байгааг зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтэрч байна гэж тооцохгүй:

a) дугуйн замтай харьцаж буй цэгийн хажуугийн хэсэг ба дугуйн хийн даралт заагч эд ангиудын бэхэлгээ;

b) дугуйг бүрсэн халтиргаанаас хамгаалах хэрэгсэл;

c) ар талыг харах толь (түүнийг ялимгүй хүчээр түлхэхэд хоёр тал руугаа чөлөөтэй нугардаг бөгөөд ингэснээрээ тэр нь тээврийн хэрэгслийн өргөний зөвшөөрөх дээд хэмжээнээс илүү гардаггүй бол);

d) эргэх чиг заадаг хажуугийн гэрэл ба оврын гэрлүүд (эдгээр нь тээврийн хэрэгслийн овроос үл ялих илүү гарч байгаа бол);

e) ачаанд тавигдсан гаалийн ломбо ба уг ломбыг хамгаалахад зориулагдсан хэрэгсэл.

3. Дор дурдсан тээврийн хэрэгслүүдийг Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр (хэрэв үндэсний хууль тогтоомжоороо хориглодог бол) олон улсын хөдөлгөөнд оролцуулахгүй байж болно:

a) чиргүүлтэй мотоцикл;

b) хэд хэдэн чиргүүлтэй тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн;

c) хүн тээвэрлэхэд зориулсан хагас чиргүүлтэй тээврийн хэрэгсэл.

4. Энэ Конвенцийн 5 дугаар хавсралтын 60 дугаар хэсэгт заасны дагуу уг хавсралтын заалтуудаас гажсан автомашин, чиргүүлүүдийг Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулахгүй байж болно.

5. Хамгаалах малгай өмсөөгүй жолооч ба зорчигчтой мотоцикл буюу мопедыг Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулахгүй байж болно.

6. Хэлэлцэн тохирогч Талууд нь хоёр дугуйтай мопед, шаахайгүй мотоциклоос бусад аливаа автомашины хувьд энэ Конвенцийн 5 дугаар хавсралтын 56 дугаар хэсэгт заасан хэрэгсэлтэй байх, мөн энэ хэрэгслийг зорчих хэсэг дээр зогсохдоо уг тээврийн хэрэгсэл нь аюул үүсгэж болзошгүйг анхааруулахын тулд хэрэглэж байх болзолтойгоор өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулж болно.

7. Хэлэлцэн тохирогч Талууд нь өөрийн нутаг дэвсгэрийн зарим бартаатай хэсэгт буюу зарим хүнд нөхцөлтэй замууд дээр бүх жин нь 3500 кг-аас илүү автомашиныг үндэсний хууль тогтоомжид тусгагдсан тусгай зүйл, заалтууд (энэ нутаг дэвсгэрт бүртгэгдсэн, дээрхийн адил бүх жинтэй тээврийн хэрэгсэл тухайн бартаатай хэсэг буюу хүнд нөхцөлтэй замаар явахдаа баримтлахаар тусгагдсан)-ыг сахин баримтлах болзолтойгоор олон улсын хөдөлгөөнд оролцуулж болно.

8. Ойрын гэрлийн тусгал нь тэгш бус хэмтэй байрласан бөгөөд түүний тохиргоо нь тухайн нутаг дэвсгэрийн хөдөлгөөний чигт нийцэхээргүй бол уг автомашиныг Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулахгүй байж болно.

9. Энэ Конвенцийн 37 дугаар зүйлд зааснаас өөр ялгах тэмдэг бүхий автомашин буюу чиргүүлийг Хэлэлцэн тохирогч Талууд өөрийн нутаг дэвсгэр дээр олон улсын хөдөлгөөнд оролцуулахгүй байж болно.

ХОЁРДУГААР ХАВСРАЛТ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БУЙ АВТОМАШИН БА ЧИРГҮҮЛИЙН БҮРТГЭЛИЙН ДУГААР

1. Энэхүү Конвенцийн 35 ба 36 дугаар зүйлд заасан бүртгэлийн дугаар нь тоо, эсвэл тоо ба үсэгнээс бүрдсэн байна. Тоонууд нь араб, үсгүүд нь латин цагаан толгойн том үсгүүд байна. Гэхдээ өөр тоо, үсэг хэрэглэж болох бөгөөд ийм тохиолдолд бүртгэлийн дугаар нь араб тоо болон латин үсгээр давтагдсан байна.

2. Бүртгэлийн дугаар нь цэлмэг өдөр 40 метрээс багагүй зайнаас тод ялгарч харагдахуйцаар тэмдэглэгдэж байрласан байна; Гэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд нь өөрийн нутаг дэвсгэрт бүртгэлтэй мотоцикл ба зарим онцлог ангиллын автомашины хувьд дээрх шаардлагыг хангахуйц хэмжээтэй бүртгэлийн дугаар олгоход хүндрэлтэй (тохиромжгүй) байвал заасан хязгаарыг багасгаж болно.

3. Хэрэв бүртгэлийн дугаар нь тусгай самбар дээр хийгдсэн бол энэ самбар нь хавтгай бөгөөд тээврийн хэрэгслийн дагуу огтлолд перпендикуляр байрлалтайгаар босоо (эсвэл босоо шахуу) бэхлэгдсэн байвал зохино. Хэрэв бүртгэлийн дугаарыг тээврийн хэрэгслийн гадаргууд шууд будаж тэмдэглэх бол уг тэмдэглэгдэх гадаргуу нь хавтгай (эсвэл бараг хавтгай) бөгөөд тээврийн хэрэгслийн дагуу огтлолд перпендикуляр босоо (эсвэл босоо шахуу) байвал зохино.

4. 32 дугаар зүйлийн 5 дахь хэсэг (*Конвенцид засвар оруулахдаа энэ дугаарыг нийцүүлэлгүй орхигдуулжээ /Орч/-*)-т заасныг харгалзан тооцсоны үндсэн дээр уг бүртгэлийн дугаар тэмдэглэгдсэн самбар буюу гадаргууг гэрэл цацруулагч материалаар хийж болно.

ГУРАВДУГААР ХАВСРАЛТ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БУЙ АВТОМАШИН БА ЧИРГҮҮЛИЙН ЯЛГАХ ТЭМДЭГ

1. Энэхүү Конвенцийн 37 дугаар зүйлд дурдагдсан ялгах тэмдэг нь латин цагаан толгойн нэгээс гурван том үсгээс бүрдэнэ. Үсэг нь 0.08 метрээс багагүй өндөртэй байх ба 0.01 метрээс багагүй өргөнтэй зураасаар цагаан өнгийн дэвсгэр дээр хар өнгийн будгаар тэмдэглэгдсэн байна. Дэвсгэр нь зуйван дугуй (эллипс) хэлбэртэй, гол тэнхлэг нь хэвтээ байрлалтай байна.

2. Ялгах тэмдэг нь зөвхөн ганц үсгээс бүрдсэн бол зуйван дугуйн гол тэнхлэг босоо байж болно.

3. Ялгах тэмдэг нь бүртгэлийн дугаар дотор байх ёсгүй бөгөөд дотор нь байлаа гэхэд түүний амархан уншигдах байдлыг муутгахаар байж болохгүй.

4. Мотоцикл ба түүний чиргүүлийн хувьд зуйван дугуйн тэнхлэгүүдийн урт нь 0.175 метр ба 0.115 метрээс багагүй байна. Бусад автомашин болон тэдгээрийн чиргүүлийн хувьд зуйван дугуйн тэнхлэгүүдийн урт нь дор дурдсанаас багагүй байна:

а) ялгах тэмдэг нь гурван үсгээс бүрдсэн бол 0.24 метр ба 0.145 метр;

б) ялгах тэмдэг нь гурваас цөөн үсгээс бүрдсэн бол 0.175 метр ба 0.115 метр.

5. Хоёрдугаар хавсралтын 3 дугаар хэсгийн заалтыг тээврийн хэрэгслийн ялгах тэмдэгт мөн хэрэглэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР ХАВСРАЛТ

ОЛОН УЛСЫН ХӨДӨЛГӨӨНД ОРОЛЦОЖ БУЙ АВТОМАШИН БА ЧИРГҮҮЛИЙН ТАНИХ ШОШГО

1. Таних шошгод доорхи зүйлс хамаарагдана:

а) автомашины хувьд:

i) тээврийн хэрэгслийг үйлдвэрлэсэн заводын нэр буюу марк;

ii) автомашины арал буюу бүхээг (хэрэв аралгүй бол) дээрх заводын дугаар буюу заводын серийн дугаар;

iii) хөдөлгүүр дээрх түүний заводын дугаар (хэрэв заводаас ийм дугаар тэмдэглэх бол);

б) чиргүүлийн хувьд дээр заасан "i" ба "ii"-г тусгагдсан тэмдэглэгээ;

с) мопедын хувьд хөдөлгүүрийн ажлын багтаамжийн заалт ба «СМ» марк.

2. Энэ хавсралтын 1 дүгээр хэсэгт заасан таних шошгын үсэг ба тоонууд нь хялбар харж болохуйц газар байрласан байхаас гадна тэдгээрийг өөрчлөх буюу арилгахад хэцүү байхаар тавигдсан байна. Таних шошгууд нь зөвхөн латин үсэг буюу үгээр ба араб тоогоор, эсвэл ийм маягаар давтан тавигдсан байх ёстой.

ТАВДУГААР ХАВСРАЛТ

АВТОМАШИН БА ЧИРГҮҮЛД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

1. Энэхүү Конвенцийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “а” ба 39 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчихгүйгээр Хэлэлцэн тохирогч аливаа Тал нь бүртгэгдэж байгаа автомашинуудын хувьд болон түүнчлэн өөрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу хөдөлгөөнд оролцож байгаа чиргүүлүүдийн хувьд энэ хавсралтын заалтад нэмэлт болгох буюу энэ хавсралтын заалтыг илүү чангатгах үүднээс бусад заалт гаргаж болно. Олон улсын хөдөлгөөнд оролцож буй аливаа тээврийн хэрэгсэл нь анх ашиглалтанд оруулахад бүртгэсэн улсын тавьсан техникийн шаардлагыг хангаж байх ёстой.

2. Энэ хавсралтад байгаа “чиргүүл” гэсэн нэр томъёог зөвхөн автомашинаар чирэхэд зориулагдсан чиргүүлд хамаатуулж хэрэглэнэ.

3. Энэхүү Конвенцийн 1 дүгээр зүйлийн “n”-д заасны дагуу ачаалалгүй жин нь 400 кг-аас илүүгүй, гурван дугуйтай тээврийн хэрэгслийг мотоциклтой адилтгах тухай мэдэгдэл хийсэн Хэлэлцэн тохирогч Талууд нь уг тээврийн хэрэгслээр энэхүү хавсралтад заасан мотоцикл болон бусад автомашинд холбогдох заалтуудыг өргөтгөх ёстой.

I бүлэг. Тоормос

4. Энэхүү бүлэгт:

a) “нэг тэнхлэгийн дугуйнууд” - гэдэгт тээврийн хэрэгслийн голын дагуух огтлолтой харьцангуй тэгш хэмтэй байрласан дугуйнуудыг (хэдийгээр эдгээр дугуйнууд нь нэг гол дээр суурилагагүй байсан ч) ойлгоно;

b) “ажлын тоормос” - гэдэгт тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг удаашруулах ба зогсооход хэрэглэгддэг хэрэгслийг ойлгоно;

c) “зогсоолын тоормос” - гэдэгт жолоочгүй тээврийн хэрэгслийг буюу салгаж тавьсан чиргүүлийг хөдөлгөөнгүй байдалд барихад хэрэглэгддэг хэрэгслийг ойлгоно;

d) “ослын тоормос” - гэдэгт ажлын тоормос ажиллагаагүй болсон тохиолдолд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг удаашруулах ба зогсооход зориулагдсан хэрэгслийг ойлгоно;

A. Мотоциклоос бусад автомашины тоормослолт

5. Мотоциклоос бусад автомашин бүр жолоочоос хялбар удирдагддаг тоормосуудтай байх ёстой. Эдгээр тоормосууд нь дор дурдсан тоормослолтын гурван үйлдлийг гүйцэтгэх ёстой:

a) ажлын тоормос нь - тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түүний ачааллын нөхцөл болон өгсөж, уруудаж яваагаас үл хамааран удаашруулах ба найдвартай, түргэн, идэвхтэй зогсоох;

b) зогсоолын тоормос нь - тээврийн хэрэгслийг түүний ачааллын нөхцөлөөс үл хамааран, мэдэгдэхүйц налуу бүхий өгсүүр буюу уруу газарт хөдөлгөөнгүй байдалд гагцхүү механик хэрэгслээр тогтоон барих;

c) ослын тоормос нь - тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг түүний ачааллын нөхцөлөөс үл хамааран удаашруулах, ажлын тоормос ажиллагаагүй болсон үед ч хангалттай богино зайд зогсоох.

6. Энэхүү хавсралтын 5 дугаар хэсэгт заасан тоормослолтын гурван үйлдэл (ажлын, ослын, зогсоолын)-ийг гүйцэтгэх төхөөрөмж нь нэгдмэл байж болно; гэхдээ дор хаяж хоёр тусдаа дамжуулгатай байгаа тохиолдолд хавсарсан дамжуулгыг зөвшөөрнө.

7. Ажлын тоормос нь тээврийн хэрэгслийн бүх дугуйнд үйлчлэх ёстой.

8. Ослын тоормос нь тээврийн хэрэгслийн голын дагуух огтлолын тал бүрд дор хаяж нэг дугуйнд үйлчлэх ёстой; зогсоолын тоормосын хувьд ч мөн адил байна.

9. Ажлын ба зогсоолын тоормос нь хангалттай бат бөх зүйлээр дугуйтай байнгын холбоотой байдаг тоормослох гадаргууд үйлчлэх ёстой.

10. Тоормослох ямар ч гадаргуу нь дугуйнаас салдаг бүтэцтэй байх ёсгүй. Харин дараахь нөхцөлд зарим тоормослох гадаргуу нь салгагдаж болно:

а) түр зуурын хугацаанд, жишээ нь дамжуулах тоог өөрчлөхөд;

б) зогсоолын тоормосны хувьд жолоочийн үйлчлэлийн үр дүнд;

с) ажлын буюу ослын тоормосны хувьд энэ хавсралтын 5 дугаар хэсэгт заагдсан идэвхжилтэйгээр тоормослолт үргэлжилж байгаа нөхцөлд.

10-бис. Тээврийн хэрэгслийн тоормослолтын туслах төхөөрөмжүүд нь ажлын тоормослолт явагдсаны дараа түүний идэвхжилийг хангахаар бүтээгдсэн байх ёстой.

10-тер. Ажлын тоормосны үйлчлэл нь тээврийн хэрэгслийн өөр өөр тэнхлэгүүдэд жигд хуваарилагдах ёстой.

10-кватер. Хэрэв ажлын тоормосны удирдлага бүхэлдээ буюу түүний зарим хэсэг нь ямар нэг хүч (жолоочийн биеийн хүчээс бусад)-ний үүсгүүрээр ажилладаг бол уг хүчний үүсгүүр ажиллагаагүй болсон тохиолдолд ч тээврийн хэрэгслийг хангалттай богино зайд зогсоох боломж хангагдсан байх ёстой.

В. Чиргүүлийн тоормослолт

11. Энэхүү хавсралтын 17 дугаар хэсгийн “с” заалтыг биелүүлж буй нөхцөлд хөнгөн чиргүүлээс бусад аливаа чиргүүл нь дор дурдсан зүйлүүдтэй байх ёстой:

а) тээврийн хэрэгслийн ачааллын нөхцөл болон өгсөж, уруудаж яваагаас үл хамааран түүний хөдөлгөөнийг удаашруулах ба найдвартай, түргэн, идэвхтэй зогсоох ажлын тоормос;

б) тээврийн хэрэгслийн ачааллын нөхцөлөөс үл хамааран, мэдэгдэхүйц налуу бүхий өгсүүр буюу уруу газарт түүнийг гагцхүү механик хэрэгслээр хөдөлгөөнгүй тогтоон барьж байх зогсоолын тоормос. Энэ заалт нь тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүнд байхдаа зогсоолын тоормослолтод орох шаардлага тавигддаг, багаж хэрэгслийн тусламжгүйгээр чирэгчээсээ салдаггүй чиргүүлд хамаарахгүй.

12. Энэ хоёр үйлдэл (ажлын ба зогсоолын тоормослолт)-ийг гүйцэтгэх төхөөрөмж нь нэгдмэл байж болно.

13. Ажлын тоормос нь чиргүүлийн бүх дугуйнд үйлчлэх ёстой. Тоормосны үйлчлэл нь чиргүүлийн өөр өөр тэнхлэгүүдэд жигд хуваарилагдах ёстой.

14. Ажлын тоормос нь чирэгчийн ажлын тоормосны дамжуулгын үйлчлэлээр ажилладаг байх ёстой; Харин бүх жин нь 3500 кг-аас илүүгүй чиргүүлийн ажлын тоормос нь хөдөлгөөний үед уг чиргүүл чирэгчтэйгээ ойртсон нөхцөлд ажилладаг (инерцийн хүчээр тоормослох) бүтэцтэй байж болно.

15. Ажлын ба зогсоолын тоормос нь хангалттай бат бөх зүйлээр дугуйтай байнгын холбоотой байдаг тоормослох гадаргууд үйлчлэх ёстой.

16. Хөдөлгөөний үед чиргүүлийн холбоос тасарсан тохиолдолд тоормослох хэрэгслүүд нь чиргүүлийг автоматаар зогсоох шаардлагыг хангасан байх ёстой. Гэхдээ энэ заалт нь чирэх холбоосныхоо хажуугаар холболтын нэмэлт төхөөрөмжтэй (хагас чиргүүлээс бусад), бүх жин нь 1500 кг-аас илүүгүй, тэнхлэгүүдийн хоорондын зай нь 1 метрээс бага нэг буюу хоёр тэнхлэгтэй чиргүүлүүдэд хамаарахгүй.

C. Тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний тоормослолт

17. Энэхүү бүлгийн А ба В хэсэгчлэлд тусгагдсан хоорондоо холбогдоогүй тээврийн хэрэгсэл (автомашин ба чиргүүл)-үүдэд хамаарах заалтууд дээр нэмэлт болгож холбогдсон тээврийн хэрэгслүүдийн бүрэлдэхүүний хувьд дараахь заалтуудыг хамааруулна:

а) аливаа тээврийн хэрэгслийн тоормосны хэрэгслүүд нь хоорондоо нийцэж байх ёстой;

б) ажлын тоормосны үйлчлэл нь бүрэлдэхүүний өөр өөр тэнхлэгүүдэд жигд хуваарилагдах ёстой;

с) ажлын тоормосоор тоноглогдоогүй чиргүүлийн бүх жингийн хэмжээ нь чирэгч тээврийн хэрэгслийн ачаалалгүй жин ба жолоочийн жин хоёрын нийлбэрийн хагасаас илүү байх ёсгүй.

D. Мотоциклын тоормослолт

18. а) Мотоцикл бүр тоормосны хоёр хэрэгсэлтэй (урд болон хойд дугуйнд) байна; шаахайтай бол шаахайны дугуйнд тоормос шаардахгүй. Эдгээр тоормосны хэрэгслүүд нь мотоциклын хөдөлгөөнийг түүний ачааллын нөхцөл болон өгсөж, уруудаж яваагаас үл хамааран удаашруулах ба найдвартай, түргэн, идэвхтэй зогсоож чаддаг байх ёстой.

б) Энэ хэсгийн “а” заалтад нэмэлт болговол: тээврийн хэрэгслийн голын дагуух огтлолтой тэгш хэмтэй байрласан гурван дугуйтай мотоцикл нь энэхүү хавсралтын 5 дугаар хэсгийн “b”-д заасны дагуу зогсоолын тоормосоор тоноглогдсон байвал зохино.

II бүлэг. Тээврийн хэрэгслийн гэрэл дохио ба гэрэлтүүлэх хэрэгсэл

19. Энэ бүлэгт дараахь нэр томъёонуудыг хэрэглэхдээ:

“Холын гэрэл” - гэдэгт тээврийн хэрэгслийн өмнөх замыг хол зайд гэрэлтүүлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Ойрын гэрэл” - гэдэгт өөдөөс яваа тээврийн хэрэгслийн жолооч болон бусад хөдөлгөөнд оролцогчдыг гялбуулахгүй, тэдний тайван байдлыг алдагдуулахгүйгээр тээврийн хэрэгслийн өмнөх замыг гэрэлтүүлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Урд талын оврын гэрэл” - гэдэгт тээврийн хэрэгслийн урд тал болон түүний оврын өргөнийг мэдээлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Ард талын оврын гэрэл” - гэдэгт тээврийн хэрэгслийн ар тал болон түүний оврын өргөнийг мэдээлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Тоормосны гэрэл” - гэдэгт тээврийн хэрэгслийн ард яваа бусад хөдөлгөөнд оролцогчдод жолооч ажлын тоормослолт хийж байгааг мэдээлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Урд талын манангийн гэрэл” - гэдэгт өтгөн манан будантай буюу цас, ширүүн бороо орж байгаа, эсвэл үүнтэй адил төстэй бусад нөхцөлд замыг сайн гэрэлтүүлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Ард талын манангийн гэрэл” - гэдэгт өтгөн манан будантай буюу цас, ширүүн бороо орж байгаа, эсвэл үүнтэй адил төстэй бусад нөхцөлд тээврийн хэрэгслийн ар талын үзэгдэлтийг сайжруулахад зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Ухрахын гэрэл” - гэдэгт тээврийн хэрэгсэл ухрах гэж байгаа буюу ухарч байгааг бусад хөдөлгөөнд оролцогчдод анхааруулах, мөн тээврийн хэрэгслийн ардах замыг гэрэлтүүлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Эргэх дохионы гэрэл” - гэдэгт жолооч баруун, зүүн гар тийш хөдөлгөөний чигээ өөрчлөх гэж байгааг бусад хөдөлгөөнд оролцогчдод мэдээлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Зогсоолын гэрэл” - гэдэгт удаан зогсож байгаа тээврийн хэрэгслийг мэдээлэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно; энэ гэрэл нь урд болон ард талын оврын гэрлүүдийг орлож болно;

“Оврын хязгаарын гэрэл” - гэдэгт тээврийн хэрэгслийн оврын өргөний захын цэгт аль болох дээш байрлуулсан, тээврийн хэрэгслийн оврын өргөнийг яв цав тэмдэглэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно; Зарим автомашин ба чиргүүлд энэ дохио нь оврын гэрэлд нэмэлт болж уг тээврийн хэрэгслийн оврын хэмжээг улам тодруулна;

“Ослын дохио” - гэдэгт эргэх дохионы бүх гэрэл нэгэн зэрэг ажиллаж буй дохиог ойлгоно;

“Хажуугийн оврын гэрэл” - гэдэгт тээврийн хэрэгслийн хажуу талд байрлаж, уг тээврийн хэрэгслийг хажуугаараа хандсан байгааг тэмдэглэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Анхааруулах тусгай гэрэл” - гэдэгт давуу эрх бүхий тээврийн хэрэгсэл буюу эсвэл бусад хөдөлгөөнд оролцогчдоос онцгой анхаарал болгоомж шаардах тээврийн хэрэгслүүд (тухайлбал: зам дээр байгаа хэт их овортой тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цуваа, эсвэл зам барих, засвар үйлчилгээ хийхэд ашиглагдаж буй тээврийн хэрэгсэл, машин механизм гэх мэт)-ийг тэмдэглэхэд зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Ард талын дугаарын гэрэл” - гэдэгт тээврийн хэрэгслийн ард талд байрласан бүртгэлийн дугаарын тэмдгийг гэрэлтүүлэхэд зориулагдсан хэрэгслийг ойлгоно; Энэ хэрэгсэл нь хэд хэдэн оптик элементээс бүрдсэн байж болно;

“Өдрийн гэрэл” - гэдэгт өдрийн цагаар явж байгаа тээврийн хэрэгслийн урд талын үзэгдэлтийг сайжруулахад зориулагдсан гэрлийг ойлгоно;

“Гэрэл ойлгуур” - гэдэгт тухайн тээврийн хэрэгсэлтэй холбоогүй гэрлийн эх үүсгүүрээс цацарч буй гэрлийг ойлгох замаар уг тээврийн хэрэгсэл байгааг мэдээлэхэд зориулагдсан хэрэгслийг ойлгоно;

“Гэрэлтүүлэх талбай” - гэдэгт гэрэл идэвхтэй цацаргагч гадаргуугийн хөндлөн босоо

хавтгайд бууж буй тэгш өнцөгт тусгалыг хэлнэ. Гэрэл ойлгуурын хувьд түүний оптик хэрэгслийн ойлгож буй гэрлийн тусгал нь идэвхтэй гадаргууд үзэгдэхүйц байна.

20. Энэ бүлэгт заагдсан гэрлүүдийн өнгө нь энэ хавсралтын нэмэлтэд тусгагдсан тодорхойлолтой аль болох нийцэж байх ёстой.

21. Тэгш зам дээр цагт 40 км-ээс илүү хурдтай явах бололцоотой аливаа автомашин (мотоциклоос бусад) нь урд талдаа шөнийн цэлмэг үед замыг зохих хэмжээнд гэрэлтүүлж чадах, тэгш тоотой цагаан буюу цайвар шар өнгийн холын гэрэлтэй байх ёстой. Холын гэрлийн гэрэлтүүлэх талбайн гадна зах нь ямар ч тохиолдолд тээврийн хэрэгслийн оврын өргөний зах руу, ойрын гэрлийн гэрэлтүүлэх талбайн гадна захаас ойрхон (дотогшоо) байх ёсгүй.

22. Тэгш зам дээр цагт 10 км-ээс илүү хурдтай явах бололцоотой аливаа автомашин (мотоциклоос бусад) нь урд талдаа шөнийн цэлмэг үед замыг зохих хэмжээнд гэрэлтүүлж чадах, тэгш тоотой цагаан буюу цайвар шар өнгийн ойрын гэрлээр тоноглогдсон байх ёстой. Автомашин нь нэгэн зэрэг хоёроос илүүгүй ойрын гэрэл асдаг байхаар тоноглогдсон байна. Ойрын гэрэл нь энэхүү хавсралтын 19 дүгээр хэсэгт тодорхойлсны дагуу тохируулагдсан байна.

23. Хоёр дугуйтай шаахайгүй мотоциклоос бусад аливаа автомашин нь урд талдаа цагаан өнгийн хоёр ширхэг оврын гэрэлтэй байх ёстой; Гэхдээ цайвар шар өнгийн гэрэл цацруулдаг холын буюу ойрын гэрэлтэй хамт тавигдсан урд талын оврын гэрэл нь цайвар шар өнгөтэй байж болно.

Эдгээр урд талын оврын гэрлүүд нь дангаараа асаалттай явах тохиолдолд тэр нь бусад хөдөлгөөнд оролцогчдыг гялбуулахгүй, тэдний тайван байдлыг алдагдуулахгүйгээр, шөнийн цэлмэг үед сайн үзэгдэж байвал зохино.

24. а) Хоёр дугуйтай шаахайгүй мотоциклоос бусад аливаа автомашин нь ард талдаа тэгш тоотой улаан өнгийн оврын гэрэлтэй байх ба тэр нь бусад хөдөлгөөнд оролцогчдыг гялбуулахгүй, тайван байдлыг нь алдагдуулахгүйгээр, шөнийн цэлмэг үед сайн үзэгдэж байх ёстой;

б) Чиргүүл бүр нь ард талдаа тэгш тоотой улаан өнгийн оврын гэрэлтэй байх ба тэр нь бусад хөдөлгөөнд оролцогчдыг гялбуулахгүй, тайван байдлыг нь алдагдуулахгүйгээр, шөнийн цэлмэг үед сайн үзэгдэж байх ёстой; Гэхдээ хоёр дугуйтай шаахайгүй мотоциклоор чирэгдэж яваа 0.8 метрээс илүүгүй оврын өргөнтэй чиргүүлд дээрх гэрэл нь нэг ширхэг байж болно.

25. Ард талдаа дугаарын тэмдэгтэй аливаа автомашин, чиргүүл нь шөнийн цэлмэг үед уг дугаарыг хялбар уншиж болохуйцаар гэрэлтүүлэх ард талын дугаарын гэрлээр тоноглогдсон байх ёстой.

26. Аливаа автомашин (мотоциклыг оролцуулан), чиргүүл, тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний цахилгаан холболт нь автомашины холын буюу ойрын гэрэл, урд талын оврын буюу манангийн гэрэл, түүнчлэн ард талын дугаарын гэрлийг асаахад автомашины буюу бүрэлдэхүүний сүүлчийн тээврийн хэрэгслийн ард талын оврын гэрэл нэгэн зэрэг асдаг байхаар бүтээгдсэн байх ёстой.

Ард талын манангийн гэрлийг холын буюу ойрын гэрэл эсвэл урд талын манангийн гэрэлтэй нэгэн зэрэг асаах бололцоотой байвал зохино.

Гэхдээ энэ заалт нь холын буюу ойрын гэрлийг дохио өгөх зорилгоор ашиглаж байгаа

(энэхүү Конвенцийн 32 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан) тохиолдолд хэрэглэгдэхгүй. Үүнээс гадна цахилгаан холболт нь автомашины холын буюу ойрын гэрэл, эсвэл манангийн гэрлийг асаахад урд талын оврын гэрэл ямагт хамт асдаг байхаар бүтээгдсэн байх ёстой.

27. Хоёр дугуйтай шаахайгүй мотоциклоос бусад аливаа автомашин нь ард талдаа дор хаяж хоёр ширхэг, гурвалжин биш хэлбэртэй, улаан гэрэл ойлгууртай байвал зохино. Эдгээр гэрэл ойлгуур нь шөнийн цэлмэг үед бусад тээврийн хэрэгсэл холын буюу ойрын гэрэл, эсвэл манангийн гэрлээ асаах үед түүний жолоочид үзэгдэж байх ёстой.

28. Чиргүүл бүр ард талдаа дор хаяж хоёр ширхэг улаан гэрэл ойлгууртай байвал зохино. Эдгээр гэрэл ойлгуур нь адил талт гурвалжин (орой нь дээш чиглэсэн) хэлбэртэй байна. Энэ гурвалжингийн дотор ямар нэгэн дохионы гэрэл байрлах ёсгүй. Эдгээр гэрэл ойлгуур нь дээрх 27 дугаар хэсэгт заасан үзэгдэлтийн шаардлагыг хангаж байвал зохино. Харин хоёр дугуйтай шаахайгүй мотоциклоор чирэгдэж яваа 0.8 метрээс илүүгүй оврын өргөнтэй чиргүүл нь зөвхөн нэг ширхэг гэрэл ойлгууртай байж болно.

29. Чиргүүл бүр урд талдаа хоёр ширхэг, гурвалжин биш хэлбэртэй, цагаан гэрэл ойлгууртай байвал зохино. Эдгээр гэрэл ойлгуур нь дээрх 27 дугаар хэсэгт заасан үзэгдэлтийн нөхцөлийг хангаж байвал зохино.

30. 1.6 метрээс илүү өргөнтэй чиргүүл нь урд талдаа хоёр ширхэг цагаан өнгийн оврын гэрэлтэй байвал зохино. Эдгээр урд талын оврын гэрлүүд нь чиргүүлийн оврын өргөний захад аль болох ойр байрласан байх ёстой.

31. Тэгш зам дээр цагт 25 км-ээс илүү хурдтай явах бололцоотой аливаа автомашин (хоёр дугуйтай шаахайтай, шаахайгүй мотоциклоос бусад) нь ард талдаа дор хаяж хоёр ширхэг улаан өнгийн тоормосны гэрэлтэй байх бөгөөд түүний гэрэлтүүлэх хүч нь ард талын оврын гэрлийнхээс илүү байвал зохино. Энэ заалт нь тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүний сүүлийн чиргүүл бүхэнд хамаарна.

32. Энэхүү Конвенцийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу мопедыг мотоциклтой адилтгаж үзэх тухай мэдэгдэл хийсэн Хэлэлцэн тохирогч Талууд нь мопедыг доорхи заалтууд буюу түүний зарим нэг хэсгээс чөлөөлж болно гэсэн нэмэлт тайлбартайгаар заах нь:

а) шаахайтай буюу шаахайгүй хоёр дугуйтай аливаа мотоцикл нь нэг буюу хоёр ширхэг ойрын гэрэл (дээрх 22 дугаар хэсэгт заасан өнгө ба үзэгдэлтийн шаардлагыг хангасан)-ээр тоноглогдсон байх ёстой;

б) тэгш зам дээр цагт 40 км-ээс илүү хурдтай явах бололцоотой, шаахайтай буюу шаахайгүй хоёр дугуйтай аливаа мотоцикл нь ойрын гэрлээс гадна дор хаяж нэг ширхэг холын гэрэл (энэ хавсралтын 21 дүгээр хэсэгт заасан өнгө ба үзэгдэлтийн шаардлагыг хангасан)-тэй байх ёстой. Хэрэв ийм мотоцикл нь нэгээс олон холын гэрэлтэй бол эдгээр гэрлүүд нь аль болох хоорондоо ойрхон байрлаж байвал зохино.

33. Хоёр дугуйтай шаахайгүй аливаа мотоцикл нь урд талдаа нэг буюу хоёр ширхэг оврын гэрэл (энэ хавсралтын 23 дугаар хэсэгт заасан өнгө ба үзэгдэлтийн шаардлагыг хангасан)-тэй байж болно. Хэрэв ийм мотоцикл нь хоёр ширхэг урд талын оврын гэрэлтэй бол эдгээр гэрлүүд нь аль болох хоорондоо ойрхон байрлаж байвал зохино.

34. Хоёр дугуйтай шаахайгүй аливаа мотоцикл нь ард талдаа нэг ширхэг оврын гэрэл (энэ хавсралтын 24 дүгээр хэсгийн “а”-д заасан өнгө ба үзэгдэлтийн шаардлагыг хангасан)-тэй байх ёстой.

35. Хоёр дугуйтай шаахайгүй аливаа мотоцикл нь ард талдаа гурвалжин биш хэлбэртэй, нэг ширхэг гэрэл ойлгуур (энэ хавсралтын 27 дугаар хэсэгт заасан өнгө ба үзэгдэлтийн шаардлагыг хангасан)-той байх ёстой.

36. Шаахайтай, шаахайгүй хоёр дугуйтай аливаа мотоцикл нь энэ хавсралтын 31 дүгээр хэсэгт заасан шаардлагыг хангасан тоормосны гэрэлтэй байх ёстой; Нэмж хэлэхэд, энэхүү Конвенцийн 54 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн дагуу мопедыг мотоциклтой адилтгаж үзэх тухай мэдэгдэл хийсэн Хэлэлцэн тохирогч Талууд нь энэ заалтыг шаахайтай, шаахайгүй хоёр дугуйтай мопедод хамааруулахгүй байж болно.

37. Шаахайгүй мотоциклын хувьд заагдсан гэрэл ба хэрэгслийн талаархи заалтуудыг үгүйсгэхгүйгээр, хоёр дугуйтай мотоциклд холбогдсон аливаа шаахай нь нэг ширхэг урд талын оврын гэрэл (энэ хавсралтын 23 дугаар хэсэгт заасан өнгө ба үзэгдэлтийн шаардлагыг хангасан), мөн нэг ширхэг ард талын оврын гэрэл (энэ хавсралтын 24 дүгээр хэсгийн "а"-д заасан өнгө ба үзэгдэлтийн шаардлагыг хангасан), түүнчлэн нэг ширхэг гэрэл ойлгуур (энэ хавсралтын 27 дугаар хэсэгт заасан өнгө ба үзэгдэлтийн шаардлагыг хангасан)-той байх ёстой. Цахилгаан холболт нь мотоциклын ард талын оврын гэрэл асахад шаахайны урд ба ард талын оврын гэрэл нэгэн зэрэг асдаг байхаар бүтээгдсэн байх ёстой. Ямар ч тохиолдолд шаахай нь холын буюу ойрын гэрэлтэй байх ёсгүй.

38. Тээврийн хэрэгслийн голын дагуух огтлолтой тэгш хэмтэй байрласан гурван дугуйтай автомашин (энэхүү Конвенцийн 1 дүгээр зүйлийн "n"-д заасан тодорхойлолтын дагуу мотоциклд хамаарагдсан) нь энэ хавсралтын 21, 22, 23, 24 "а", 27, 31 дүгээр хэсгүүдэд тусгагдсан хэрэгслүүдээр тоноглогдсон байвал зохино. Харин 1.3 метрээс илүүгүй өргөнтэй, цагт 40 км-ээс ихгүй хурдтай цахилгаан тээврийн хэрэгслийн хувьд холын буюу ойрын гэрэл тус бүр нэг ширхгийг суурилуулсан бол хангалттайд тооцно.

39. Мопедоос бусад аливаа автомашин ба чиргүүлүүд нь өдөр, шөнийн аль ч цагт хөдөлгөөнд оролцогчдод үзэгдэхүйц, тээврийн хэрэгслийн хоёр талд хосоороо хөдөлгөөнгүй байрласан эргэх дохионы анивчдаг улбар шар өнгийн гэрэлтэй байх ёстой.

40. Хэрэв автомашин нь урд талдаа манангийн гэрэлтэй бол тэр нь цагаан буюу цайвар шар өнгөтэй хоёр ширхэг, мотоциклын хувьд нэг ширхэг байх ба түүний гэрэлтүүлэх талбайн нэг ч цэг ойрын гэрлийн гэрэлтүүлэх талбайн оройн цэгээс дээш гарахгүй байхаар суурилагдсан байх ёстой.

41. Ухрахын гэрэл нь хөдөлгөөнд оролцогчдыг гялбуулахаар, тэдний тайван байдлыг алдагдуулахаар байх ёсгүй. Хэрэв автомашин нь ухрахын гэрлээр тоноглогдсон бол тэр нь цагаан буюу цайвар шар өнгөтэй байна. Энэ гэрэл зөвхөн ухрах арааны дамжуулга залгагдсан үед л асдаг байвал зохино.

42. Эргэх дохионы гэрэл болон анхааруулах тусгай гэрлээс бусад ямар ч гэрэл анивчдаг буюу гялалздаг байх ёсгүй. Харин хажуугийн гэрэл нь эргэх дохионы гэрэлтэй хамт нэгэн зэрэг анивчдаг горимд ажилладаг байж болно.

42-бис. Анхааруулах тусгай гэрэл нь анивчдаг буюу гялалздаг байх ёстой. Энэ гэрлийн өнгө нь энэхүү Конвенцийн 32 дугаар зүйлийн 14 дэх хэсгийн заалтад нийцсэн байвал зохино.

42-тер. Мотоциклоос бусад аливаа автомашин ба чиргүүлүүд нь ослын дохио өгч чадахуйцаар тоноглогдсон байх ёстой.

42-кватер. Хэрэв автомашин ба чиргүүлүүд нь ард талын манангийн гэрлээр тоноглогдсон бол тэр нь улаан өнгөтэй байх ёстой.

42-квинквиес. 6 метрээс илүү урттай аливаа автомашин ба чиргүүлүүд нь улбар шар өнгөтэй хажуугийн гэрэл ойлгуураар тоноглогдсон байвал зохино.

42-секстиес. 1.8 метрээс илүү өргөнтэй аливаа автомашин ба чиргүүлүүд нь оврын хязгаарын гэрлээр тоноглогдсон байвал зохино. Ийм гэрэл нь ялангуяа 2.1 метрээс илүү өргөнтэй автомашин, чиргүүлийн хувьд заавал байх шаардлагатай. Ийм гэрлээр тоноглогдсон бол түүний тоо ширхэг нь хоёроос цөөнгүй байх ба урагшаагаа цагаан буюу улбар шар, хойшоогоо улаан өнгийн гэрэл гаргадаг байвал зохино.

42-септиес. Аливаа автомашин ба чиргүүлүүд нь хажуугийн оврын гэрэлтэй байж болно. Ийм гэрлийг суурилуулсан бол тэр нь улбар шар өнгийн гэрэл гаргадаг байвал зохино.

43. Энэхүү хавсралтын заалтыг хэрэглэхдээ дараахь зүйлсийг тооцож үзнэ:

a) зориулалт, өнгө нь ижил, хоёр ба түүнээс олон гэрлүүдийн аливаа хослол нь төсөөтэй байгаа буюу үгүй эсэхийг;

b) хос хосоороо байгаа гэрлүүдийн гэрэлтүүлэх талбай нь (тээврийн хэрэгслийн голын дагуух огтлолтой харьцангуй тэгш хэмтэй байрласан нөхцөлд) зурвас хэлбэрт нэгдмэл байгаа эсэхийг. Уг гадаргууны гэрэлтүүлгийг түүний зах руу аль болох ойр байрласан, дор хаяж хоёр гэрлийн үүсгүүрээр гүйцэтгэх ёстой.

44. Нэг тээврийн хэрэгсэл дэх ижил зориулалтай, нэг зүгт чиглэсэн гэрлүүд нь ижил өнгөтэй байна. Тэгш тоотой гэрлүүд буюу гэрэл ойлгуурууд нь тээврийн хэрэгслийн голын дагуух огтлолтой тэгш хэмтэй байрлах ёстой. Энэ заалт нь гаднах хэлбэр нь тэгш бус хэмтэй тээврийн хэрэгслүүдэд хамаарахгүй. Аливаа хос гэрлүүдийн гэрэлтүүлэх хүч нь ижил байх ёстой.

45. Энэ бүлгийн бусад хэсгийн заалтуудыг мөрдлөг болгосон нөхцөлд зориулалтаараа ялгаатай гэрлүүд ба гэрэл ойлгуурууд нь гэрэлтүүлгийн нэг хэрэгсэлд угсрагдсан буюу эсвэл эдгээр гэрэл ба гэрэл ойлгуурууд нь энэхүү хавсралтын заалтуудад нийцэж байгаа нөхцөлд уг хэрэгсэл дотор залгагдсан байж болно.

III бүлэг. Бусад заалтууд

Жолооны удирдлага

46. Аливаа автомашин нь жолоочоос тээврийн хэрэгслийнхээ хөдөлгөөний чигийг хөнгөн хялбар, түргэн шуурхай, итгэл найдвартайгаар өөрчлөх бололцоо бүхий бат бөх жолооны удирдлагатай байх ёстой.

Ар талыг харах толь

47. Аливаа автомашин нь ар талыг харах нэг буюу хэд хэдэн тольтой байх ёстой. Эдгээр толины тоо, хэмжээ, байрлал нь жолоочоос ар талынхаа замын хөдөлгөөнийг чөлөөтэй харж болохуйц байна.

Дуут дохионы хэрэгсэл

48. Аливаа автомашин нь хангалттай чадал бүхий дор хаяж нэг ширхэг дуут дохионы хэрэгсэлтэй байх ёстой. Дуут дохио нь хэт янгинсан биш, нэгэн жигд, үргэлжилсэн дуу

авиатай байвал зохино. Давуу эрх бүхий тусгай тээврийн хэрэгсэл болон нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгсэл нь энэ шаардлагад нийцэхээргүй нэмэгдэл дуут дохионы хэрэгсэлтэй байж болно.

Шил арчуур

49. Жолооч талаас урдах замаа чөлөөтэй харж болохуйц хэлбэр, хэмжээтэй, тунгалаг элемент бүхий шил (салхины шил)-ээр тоноглогдсон аливаа автомашин нь жолоочийн байнгын оролцоогүйгээр ажилладаг, бат бөх, дор хаяж нэг ширхэг (зохих талд байрласан) шил арчууртай байх ёстой.

Шил угаагуур

50. Дор хаяж нэг ширхэг шил арчууртай байвал зохих аливаа автомашин нь мөн шил угаагууртай байх ёстой.

Салхины шил ба бусад шил

51. Аливаа автомашин ба чиргүүлийн хувьд:

а) тээврийн хэрэгслийн гадна талын элемент (салхины шил гэх мэт) болон дотор талын тусгаарлавч элементэд хийгдсэн тунгалаг материалууд нь хагарч эвдрэх тохиолдолд аль болох бага бэртэл гэмтэл учруулахуйц байх ёстой;

б) салхины шил нь тунгалаг чанараа алддаггүй материалаар хийгдсэн бөгөөд дүрсийг ямар нэгэн хэв гажилтгүйгээр нэвтрүүлдэг, мөн эвдрэлд орох тохиолдолд жолооч замаа зохих хэмжээнд харж болохуйцаар бүтээгдсэн байх ёстой.

Ухрахад зориулсан төхөөрөмж

52. Аливаа автомашин нь ухрах хөдөлгөөнд зориулагдсан төхөөрөмж (жолооч суудлаасаа удирдаж болохуйц)-өөр тоноглогдсон байх ёстой. Энэ төхөөрөмж нь тээврийн хэрэгслийн голын дагуух огтлолтой тэгш хэмтэй байрласан гурван дугуйтай бүх жин нь 400 кг-аас илүү мотоцикл буюу автомашинд заавал байна.

Дуу намсгуур

53. Аливаа дотоод шаталтат хөдөлгүүр бүхий автомашин нь идэвхжилтэй дуу намсгуураар тоноглогдсон байна.

Дугуй

54. Автомашин ба чиргүүлүүдийн дугуй нь нойтон зам дээр ч барьцалтыг сайн хангаж байхуйц хийтэй резинэн гадаргуутай байх ёстой. Гэхдээ энэ заалт нь Хэлэлцэн тохирогч Талуудаас хийтэй резинэн гадаргуутай дугуйнаас дутахааргүй үр дүнтэй хэрэгсэл бүхий дугуй ашиглахыг зөвшөөрөхөд нь саад болохгүй.

Хурд хэмжүүр

55. Тэгш зам дээр цагт 40 км-ээс илүү хурдтай явах бололцоотой аливаа автомашин нь хурд хэмжүүртэй байх ёстой. Гэхдээ Хэлэлцэн тохирогч Талууд нь энэ заалтыг зарим ангиллын мотоцикл ба бусад хөнгөн тээврийн хэрэгслүүдэд хамааруулахгүй байж болно.

Автомашины дохионы хэрэгсэл

56. Энэ Конвенцийн 23 дугаар зүйлийн 5 дахь хэсэг болон 1 дүгээр хавсралтын 6 дугаар хэсэгт заасан хэрэгсэл нь:

а) гэрэл ойлгогч судал бүхий улаан өнгийн хүрээтэй адил талт гурвалжин хэлбэртэй, голын хэсэг нь хөндий буюу цайвар өнгийн дэвсгэртэй байна. Үүнээс гадна улаан өнгийн талстжисан гадаргуу (флюоресцирующее покрытие)-тай буюу дотроосоо гэрэлтүүлэгтэй байж болно. Энэ хэрэгсэл нь босоо байрлалд тогтвортой тавигдахуйц байх ёстой.

б) тухайн тээврийн хэрэгслийг бүртгэсэн улсын үндэсний хууль тогтоомжид заагдсан бусад иймэрхүү үр нөлөө бүхий хэрэгсэл байж болно.

Авч зугтаахаас хамгаалах хэрэгсэл

57. Аливаа автомашин нь зогсоолд орхигдох үед түүний ямар нэгэн суурь агрегатыг ажиллагаагүй болгох буюу гацааж болохуйц, хулгайлагдахаас хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байх ёстой.

Бэртлээс хамгаалах хэрэгсэл

58. Энэхүү Конвенцийн 6 ба 7 дугаар хавсралтад заасан В ангилалд хамаарагдах тээврийн хэрэгслүүдийн урагш харсан суудлууд нь албан ёсны зориулалт бүхий хамгаалах бүс буюу түүнтэй адил үр нөлөө бүхий хамгаалах хэрэгслээр тоноглогдсон байх ёстой. Харин үндэсний хууль тогтоомжид заасан үндэслэлээр тусгай зорилгод ашиглах буюу тусгай зориулалтаар бүтээгдсэн тээврийн хэрэгслүүдийн хувьд энэ заалт хамаарахгүй.

Нийтлэг заалтууд

59. а) Автомашины механизм, төхөөрөмжүүд нь аль болох галын осолгүй, дэсэрч дэлбэрэх аюулгүй, түүнчлэн их хэмжээний хорт хий, өтгөн утаа ялгаруулахгүй, эвгүй үнэр, чимээ шуугиан гаргахгүй байх ёстой.

б) Автомашины хөдөлгүүрийн өндөр хүчдэлийн асаалтын систем нь аль болох цахилгаан соронзон долгионыг их хэмжээгээр үүсгэдэггүй байвал зохино.

с) Аливаа автомашины хийц нь жолоочийн харах боломжийг урагш болон баруун, зүүн тийш хүрэлцэхүйц хэмжээнд хангасан, автомашиныг аюулгүй жолоодох нөхцөлийг бүрдүүлсэн байх ёстой.

д) Автомашин ба чиргүүлийн хийц, тоноглолууд нь зам тээврийн осолд орох үед зорчигч болон бусад хөдөлгөөнд оролцогчдод учрах аюулыг аль болох бага байлгах нөхцөлийг хангасан байх ёстой. Тухайлбал, тээврийн хэрэгслийн дотор болон гадна талд жолооч, зорчигч болон бусад хөдөлгөөнд оролцогчдод аюул учруулж болзошгүй хурц ирмэгтэй буюу тээврийн хэрэгслийн овроос илүү гарсан ямар нэгэн чимэглэл, бусад онцын шаардлагагүй зүйлсийг байрлуулаагүй байвал зохино.

е) Бүх жин нь 3.5 тонноос илүү тээврийн хэрэгслүүд нь бололцооны хэрээр өнхрөхөөс хамгаалсан хажуугийн болон ард талын хэрэгсэлтэй байна.

IV бүлэг. Дүрмээс гажих

60. Хэлэлцэн тохирогч Талууд нь өөрийн нутаг дэвсгэрт энэхүү Конвенцийг хэрэгжүүлэхдээ дараахь тээврийн хэрэгслүүдийн хувьд энэ хавсралтын заалтуудаас гажих

болно:

а) тэгш зам дээр техникийн хурд нь цагт 30 км-ээс хэтэрдэггүй буюу үндэсний хууль тогтоомжоор зөвшөөрсөн дээд хурд нь цагт 30 км-ээс илүүгүй автомашин ба чиргүүлүүд;

б) бэртэж гэмтсэн буюу биеийн төрөлхийн согогтой хүмүүст тусгайлан зориулж бүтээгдсэн, зөвхөн эдгээр хүмүүст ашиглагддаг тахир дутуу хүний хөсөг, өөрөөр хэлбэл жижиг автомашин;

с) техникийн ололтыг нэвтрүүлэх болон аюулгүй байдлыг дээшлүүлэх зорилгоор туршилтад зориулж хийгдсэн тээврийн хэрэгслүүд;

д) онцгой төрөл, хэлбэрийн тээврийн хэрэгсэл буюу тусгай зорилгоор онцгой нөхцөлд ашиглагдах тээврийн хэрэгслүүд;

е) тахир дутуу хүмүүст зориулан тоноглогдсон тээврийн хэрэгсэл.

61. Түүнчлэн Хэлэлцэн тохирогч Талууд нь өөрийн нутаг дэвсгэр дээр бүртгэгдсэн, олон улсын хөдөлгөөнд оролцож болох тээврийн хэрэгслүүдийн хувьд ч энэ хавсралтын заалтуудаас дор дурдсан зорилгоор гажиж болно:

а) автомашин ба чиргүүлүүдийн урд талын оврын гэрэлд улбар шар өнгийг зөвшөөрөхдөө;

б) гаднах хэлбэрээс шалтгаалан энэхүү хавсралтын заалтыг биелүүлэх боломжгүй тусгай зориулалтын тээврийн хэрэгслийн гэрлүүдийн байрлалын хувьд холболтын төхөөрөмж хэрэглэхгүй бол амархан гэмтэж, тасарч болзошгүй тохиолдолд;

с) чирэгчтэйгээ шууд холбогддоггүй, зөвхөн ачаагаараа түүнтэй холбогддог, урт ачаа (гуалин, хоолой гэх мэт) тээвэрлэхэд зориулагдсан чиргүүлийн хувьд;

д) ард талд цагаан, урд талд улаан өнгийн гэрэл гаргах хэрэгсэл байрлуулахыг дараахь тохиолдолд зөвшөөрөхдөө:

- давуу эрх бүхий тээврийн хэрэгсэл дээрх эргэлддэг буюу гялалздаг гэрлүүд;

- онцгой төрлийн ачаанд зориулсан суурин гэрэл;

- хажуугийн гэрэл ба гэрэл ойлгуурууд;

- тээврийн хэрэгслийн зориулалтыг заадаг, түүний бүхээг дээр суурилагдсан гэрлэн хэрэгсэл;

е) урд болон ард талаасаа хөх гэрэл гаргаж эргэлддэг буюу гялалздаг гэрлүүдийг зөвшөөрөхдөө;

ф) онцгой нөхцөлд тусгай зорилгоор ашиглагддаг (эсвэл тусгай хэлбэр, төрлийн) тээврийн хэрэгслийн аль ч талд улаан ба цагаан өнгийн гэрэл ойлгогч судалтай туузыг хэрэглэхийг зөвшөөрөхдөө;

г) тэмдэглэгдсэн тоо, үсгүүд нь цагаан буюу өнгийн гэрэл ойлгодог, эсвэл дэвсгэр нь гэрэл ойлгодог дугаарын гэрэл, түүнчлэн гэрэл ойлгодог ялгах тэмдэг буюу үндэсний хууль тогтоомжид заасан бусад тэмдэглэгээг ард талд хэрэглэхийг зөвшөөрөхдөө;

h) ард талд байрлалтай хажуугийн гэрэл ойлгуур ба хажуугийн гэрлүүдэд улаан өнгийг зөвшөөрөхдөө.

V бүлэг. Шилжилтийн заалтууд

62. Энэхүү Конвенцийг хүчин төгөлдөр болохоос өмнө буюу хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр дээр анх бүртгэгдсэн автомашин буюу ашиглалтад орсон чиргүүлүүд нь замын хөдөлгөөний тухай 1949 оны Конвенцийн 6 дугаар хавсралтын I, II, III хэсгүүдийн шаардлагыг хангаж байгаа нөхцөлд тэдгээрт энэ хавсралтын заалтуудыг хамааруулахгүй.

62-бис. Энэхүү Конвенцийн засвар хүчин төгөлдөр болохоос өмнө буюу хүчин төгөлдөр болсноос хойш хоёр жилийн дотор Хэлэлцэн тохирогч Талуудын нутаг дэвсгэр дээр анх бүртгэгдсэн автомашин буюу ашиглалтад орсон чиргүүлүүд нь замын хөдөлгөөний тухай 1968 оны Конвенцийн 5 дугаар хавсралтын заалтуудын шаардлага (уг хавсралтад засвар болон бусад заалтууд орохоос өмнө үйлчилж байсан)-ыг хангаж байгаа нөхцөлд тэдгээрт энэ хавсралтын заалтуудыг хамааруулахгүй.

НЭМЭЛТ

Энэхүү хавсралтад заасан өнгийг гаргаж авах өнгөний шүүлтүүрийн тодорхойлолтууд (өнгөний коэффициентээр)

Улаан:	шар өнгөнд шилжих хязгаар	$y \leq 0.335$
	гүн улаан өнгөнд шилжих хязгаар	$z \leq 0.008$
Цагаан:	хөх өнгөнд шилжих хязгаар	$x \geq 0.310$
	шар өнгөнд шилжих хязгаар	$x \leq 0.500$
	ногоон өнгөнд шилжих хязгаар	$y \leq 0.150 + 0.640x$
	ногоон өнгөнд шилжих хязгаар	$y \leq 0.440$
	гүн улаан өнгөнд шилжих хязгаар	$y \geq 0.050 + 0.750x$
Улбар шар:	улаан өнгөнд шилжих хязгаар	$y \geq 0.382$
	шар өнгөнд шилжих хязгаар	$y \leq 0.429$
	улаан өнгөнд шилжих хязгаар	$y \geq 0.398$
	цагаан өнгөнд шилжих хязгаар	$z \leq 0.007$
Цайвар шар:	улаан өнгөнд шилжих хязгаар	$y \geq 0.138 + 0.580x$
	ногоон өнгөнд шилжих хязгаар	$y \leq 1.29x - 0.100$
	цагаан өнгөнд шилжих хязгаар	$y \geq -x + 0.966$
	спектрийн хэмжээнд шилжих хязгаар	$y \leq -x + 0.992$
Хөх:	ногоон өнгөнд шилжих хязгаар	$y = 0.065 + 0.805x$
	цагаан өнгөнд шилжих хязгаар	$y = 0.400 - x$
	гүн улаан өнгөнд шилжих хязгаар	$x = 0.133 + 0.600y$

Эдгээр шүүлтүүрийн колориметрийн үзүүлэлтүүдийг шалгахдаа 2854°K-ийн өнгөний температур бүхий гэрлийн үүсгүүр (Олон улсын гэрэлтүүлгийн комисс [ОУГК]-ийн стандартын А үүсгүүрт нийцэх)-ийг ашиглана.

ЗУРГАДУГААР ХАВСРАЛТ

ҮНДЭСНИЙ ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ

1. Үндэсний жолоочийн үнэмлэх нь баримт бичгийг төлөөлнө.

2. Үнэмлэх нь энэхүү баримт бичгийг олгодог буюу олгохыг үүрэг болгодог эрх мэдэл бүхий байгууллагаас тогтоосон нэг буюу хэд хэдэн хэл дээр хэвлэгдэнэ. Гэхдээ түүн дээр франц хэлээр «permis de conduire» гэсэн нэр тэмдэглэгдэх ба үүний зэрэгцээгээр бусад хэл дээр «жолоочийн үнэмлэх» гэсэн нэр дагалдах буюу дагалдахгүй байж болно. Түүнчлэн уг үнэмлэхийг олгосон улсын нэр ба ялгах тэмдэг (эсвэл нэр буюу ялгах тэмдгийн аль нэг нь) тэмдэглэгдсэн байна.

3. Үнэмлэх дэх бичиглэл нь латин цагаан толгойн үсгээр юмуу үгээр, эсвэл энэ хоёр аргын аль алианаар нь (давтагдаж) бичигдсэн байна.

4. Үнэмлэхэд дор дурдсан мэдээллүүдийг дарааллын дагуу тоочиж заасан байх ёстой; Эдгээр мэдээллүүд нь 1-ээс 11 хүртэл тоогоор дугаарлагдсан байна:

1. овог
2. нэр ба эцгийн нэр^{1/}
3. төрсөн огноо ба газар^{2/}
4. оршин суугаа хаяг^{3/}
5. үнэмлэх олгосон байгууллага
6. үнэмлэх олгогдсон огноо, газар
7. үнэмлэхний хүчинтэй хугацаа дуусах огноо^{4/}
8. үнэмлэхний дугаар
9. үнэмлэх олгосон байгууллагын тамга ба гарын үсэг (эсвэл гарын үсэг, тамгын аль нэг нь)
10. эзэмшигчийн гарын үсэг^{5/}
11. зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгслийн ангилал ба дэд ангилал (ангилал тус бүрийн олгогдсон огноо ба тэдгээрийн хүчинтэй хугацаа дуусах огноог заасан байх).

Үүнээс гадна жолоочийн үнэмлэхэд эзэмшигчийн фото зураг хавсаргагдсан байх ёстой. Үндэсний хууль тогтоомжоор жолоочийн үнэмлэхэд тусгагдах бусад нэмэлт мэдээлэл, түүнчлэн үнэмлэхний хавтасны хэлбэр, хэмжээг тогтооно.

5. Үнэмлэхэд жолоодох эрхтэйгээр олгогдож болох тээврийн хэрэгслийн ангиллууд:

А - мотоцикл;

В - “А” ангилалд заагдсанаас бусад бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй, жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай автомашин;

С - “D” ангилалд заагдсанаас бусад бүх жин нь 3500 кг-аас илүү автомашин;

D - жолоочоос гадна наймаас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин;

Е - жолоодох эрхтэйгээр олгогдсон “В”, “С”, “D” ангилалд хамаарагдах чирэгчтэй

тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн (энэ бүрэлдэхүүн нь эдгээр ангилалд дангаараа багтахгүй бол).

6. Үндэсний хууль тогтоомжид дээр дурдсан А-Е ангиллуудад хамаарахгүй тээврийн хэрэгслийн нэмэлт ангилал, эсвэл дээрх ангиллын хүрээн дотор дэд ангилал тусгаж болох бөгөөд эдгээрийг жолоочийн үнэмлэхэд тодорхой зааж өгсөн байх ёстой.

Тайлбар:

^{1/} Энэ хэсэгт эцэг буюу нөхрийн нэрийг зааж болно.

^{2/} Хэрэв төрсөн огноо нь тодорхойгүй бол үнэмлэх олгох үеийн насыг ойролцоогоор заана. Хэрэв төрсөн газар нь тодорхойгүй бол түүнийг заахгүй орхино. Төрсөн газрын оронд үндэсний хууль тогтоомжоор тодорхойлсон бусад мэдээллийг зааж болно.

^{3/} Оршин суугаа хаягийг заавал заах албагүй.

^{4/} Үнэмлэхний хүчинтэй байх хугацаа хязгаарлагдаагүй бол үүнийг заах албагүй.

^{5/} Эсвэл эрхий хурууны хээ (дардас).

ДОЛДУГААР ХАВСРАЛТ

ОЛОН УЛСЫН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ

1. Олон улсын жолоочийн үнэмлэх нь А6 (148 x 105 мм) форматын хэмжээтэй дэвтэр байна. Энэ дэвтэр нь саарал өнгийн хавтастай, дотроо цагаан өнгийн хуудаснуудтай байна.

2. Хавтасны эхний хуудсын нүүр ба дотор тал нь хуудасны загвар № 1 ба 2-т заасантай адил байна. Эдгээр нь үнэмлэх олгосон улсын үндэсний хэл дээр бичигдсэн байна. Дотор хуудаснуудын сүүлчийн хоёр зэрэгцээ хуудас нь загвар № 3-т нийцсэн байх ба франц хэл дээр бичигдэнэ. Эдгээрийн өмнөх дотор хуудаснууд дээр энэ хоёр хуудасны эхнийхийг хэд хэдэн хэл (англи, испани, орос) дээр давтсан байна.

3. Үнэмлэхэд гараар буюу бичгийн машинаар хийгдэх бичиглэл нь латин цагаан толгойн үсгээр юмуу үгээр бичигдсэн байна.

4. Англи, испани, орос, франц хэлээс өөр хэл дээр бичигдсэн олон улсын жолоочийн үнэмлэх олгодог буюу олгохыг зөвшөөрдөг Хэлэлцэн тохирогч Талууд нь загвар № 3-ын бичиглэлийн эдгээр хэл дээрх орчуулгыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад илгээх ёстой.

Хуудасны загвар № 1

(Хавтасны эхний хуудасны нүүрэн тал)

..... ^{1/}
Олон улсын автомашины хөдөлгөөн
ОЛОН УЛСЫН ЖОЛООЧИЙН ҮНЭМЛЭХ

№

1968 оны 11 дүгээр сарын 8-ны өдрийн

Замын хөдөлгөөний тухай Конвенц

Хүчинтэй хугацаа хүртэл^{2/}

Олгосон

Огноо

Үндэсний жолоочийн үнэмлэхний дугаар

.....^{3/}

4/

^{1/} Үнэмлэх олгосон улсын нэр ба ялгах тэмдэг (3 дугаар хавсралтад заасан).

^{2/} Үнэмлэх олгосон өдрөөс хойш гурваас илүүгүй жил буюу үндэсний жолоочийн үнэмлэхний хүчинтэй хугацааг дуусах огноо (энэ хоёр хугацааны аль түрүүлж дуусахаас хамааран) хүртэл байна.

^{3/} Үнэмлэх олгосон захиргааны байгууллага буюу нийгэмлэгийн гарын үсэг

^{4/} Үнэмлэх олгосон захиргааны байгууллага буюу нийгэмлэгийн тамга, тэмдэг.

Хуудасны загвар № 2

(Хавтасны эхний хуудасны дотор тал)

Энэхүү үнэмлэх нь^{1/}

нутаг дэвсгэрт хөдөлгөөнд оролцоход хүчингүй.

Энэ үнэмлэх нь Хэлэлцэн тохирогч бусад бүх Талуудын нутаг дэвсгэрт хүчинтэй. Энэхүү үнэмлэхээр жолоодох эрх олгогдож буй тээврийн хэрэгслийн ангиллыг сүүлийн хуудсанд заасан болно.

2/

Энэхүү үнэмлэх нь түүний эзэмшигчээс хөдөлгөөнд оролцож буй аливаа улсын нутаг дэвсгэрт ямар нэгэн мэргэжлээр ажиллах буюу тэнд суурьших эрхтэй холбоотой хууль, дүрмийг хэлбэрэлтгүй биелүүлэхээс чөлөөлөхгүй. Тухайлбал, энэ үнэмлэх нь түүний эзэмшигчийн оршин суухаар болсон улсад хүчингүй болно.

^{1/} Үнэмлэхний энэ хэсэгт түүний эзэмшигчийн оршин суугаа Хэлэлцэн тохирогч Талын улсын нэрийг заана.

^{2/} Хэлэлцэн тохирогч Тал болсон улсуудын нэрийн жагсаалтыг бичих зай (заавал багтаах албагүй).

Загвар № 3

(Зүүн талын хуудас)

ЖОЛООЧИД ХОЛБОГДОХ ТЭМДЭГЛЭГЭЭ	
Овог	1.
Нэр ^{1/}	2.
Төрсөн газар ^{2/}	3.
Төрсөн огноо ^{3/}	4.
Оршин суугаа хаяг	5.
ОЛГОГДСОН ҮНЭМЛЭХЭЭР ЖОЛООДОХ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН АНГИЛАЛ	
Мотоцикл	A
“А” ангилалд заагдсанаас бусад бүх жин нь 3500 кг-аас хэтрэхгүй, жолоочоос гадна наймаас илүүгүй хүний суудалтай автомашин	B
Ачаа тээвэрлэхэд зориулсан, бүх жин нь 3500 кг-аас илүү автомашин	C
Жолоочоос гадна наймаас илүү хүний суудалтай, хүн тээвэрлэхэд зориулсан автомашин	D
Жолоодох эрхтэйгээр олгогдсон “B”, “C”, “D” ангилалд хамаарагдах чирэгчтэй тээврийн хэрэгслийн бүрэлдэхүүн (энэ бүрэлдэхүүн нь эдгээр ангилалд дангаараа багтахгүй бол)	E
АШИГЛАХЫГ ХЯЗГААРЛАСАН НӨХЦӨЛҮҮД^{5/}	

1/ Энд эцэг буюу нөхрийн нэрийг зааж болно.

2/ Төрсөн газар нь тодорхойгүй бол бөглөхгүй.

3/ Хэрэв төрсөн огноо нь тодорхойгүй бол үнэмлэх олгох үеийн насыг ойролцоогоор заана.

5/ Жишээлбэл, «Зөвхөн нүдний шилтэй жолоодно», «Зөвхөн ... дугаарын тээврийн хэрэгслийг жолоодоход хүчинтэй», «Тээврийн хэрэгслийг нэг хөлгүй хүн жолоодоход зориулан тоногдсон нөхцөлд хүчинтэй».

Загвар № 3

(Баруун талын хуудас)

1	
2	
3	
4	
5	
A	4/	<div style="border: 1px solid black; padding: 10px; width: 100px; margin: 0 auto;">Фото зураг</div> <p style="text-align: center; margin-top: 10px;">4/</p>
B	4/	
C	4/	
D	4/	
E	4/	
		Эзэмшигчийн гарын үсэг ^{6/}
ХАСАЛТ:		
Эзэмшигч нь ^{7/} нутаг дэвсгэрт		
..... хүртэл жолоодох эрхээ хасуулсан болно.		
Огноо		
..... ^{8/}		

Эзэмшигч нь^{7/} нутаг дэвсгэрт

..... хүртэл жолоодох эрхээ хасуулсан болно.

Огноо

.....^{8/}

^{4/} Үнэмлэх олгосон захиргааны байгууллага буюу нийгэмлэгийн тамга, тэмдэг. Энэ тамга, тэмдгийг эзэмшигчийн жолоодох эрх бүхий тухайн тээврийн хэрэгслийн ангиллын үсгийн дэргэд дарна.

^{6/} Эсвэл эрхий хурууны хээ (дардас).

^{7/} Улсын нэр.

^{8/} Тухайн нутаг дэвсгэрт жолоочийн үнэмлэхийг хүчингүй болгосон захиргааны байгууллагын тамга, тэмдэг, гарын үсэг. Энэ хуудсан дээрх хасалтын зай ашиглагдаж дүүрсэн бол бусад хасалтыг энэ хуудасны арын нүүрэнд хийнэ.

ТИР КАРНЕЙН ХҮРЭЭНД БАРААГ ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ТЭЭВЭРЛЭХ ТУХАЙ КОНВЕНЦИ

ХЭЛЭЛЦЭН ТОХИРОГЧ ТАЛУУД.

Авто тээврийн хэрэгслээр барааг олон улсын хэмжээнд тээвэрлэх явдлыг хөнгөвчлөхийг ЭРМЭЛЗЭН,

Тээвэрлэлтийн нөхцөлийг сайжруулах нь тэдгээрийн хоорондын хамтын ажиллагааны хөгжлийн чухал хүчин зүйлийн нэг болохыг АНХААРЧ,
Олон улсын тээврийн захиргааны тухайлбал хил нэвтрүүлэхтэй холбоотой журмыг хялбарчлах, уялдуулах явдлыг дэмжиж байгаагаа МЭДЭГДЭН

Дараах зүйлсийг ХЭЛЭЛЦЭН ТОХИРОВ. Үүнд:

БҮЛЭГ I

ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

(a) ТОДОРХОЙЛОЛТ

1 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийн зорилгоор:

(a) **"ТИР үйл ажиллагаа"** гэдэгт энэхүү Конвенцид тусгагдсан "ТИР горим" гэж нэрлэгдэх горимоор илгээгч улсын гаалийн байгууллагаас хүлээн авагч улсын гаалийн байгууллага хүртэл барааг тээвэрлэхийг ойлгоно.

(b) **"импортын болон экспортын татвар, бусад татвар"** гэдэгт барааг экспортлох болон импортлох үед хураах эсвэл үүнд хамаарах гаалийн болон бусад бүх татвар, хураамж, мөн бусад төлбөрийг ойлгох ба үзүүлсэн үйлчилгээний ойролцоо өртгийн үнийн дүнгээр хязгаарлагдсан хураамж төлбөрийг үүнд оруулахгүй.

(c) **"авто тээврийн хэрэгсэл"** гэдэгт зөвхөн хөдөлгүүрээр ажилладаг авто тээврийн хэрэгслээс гадна мөн түүнд хослох зориулалт бүхий аливаа чиргүүл эсвэл хагас чиргүүлийг ойлгоно.

(d) **"тээврийн хэрэгслийн цогц"** гэж авто зам дээр нэг нэгж болон явж буй хосолсон тээврийн хэрэгслийг хэлнэ.

(e) **"чингэлэг"** гэдэг нь тээврийн тоног төхөөрөмж (өргөгч машин, салгаж болдог түлшний сав болон бусад төстэй бүтэц):

- (i) бараа хийх зориулалт бүхий бүрэн болон хэсэгчилсэн хаалттай хэсэг,
- (ii) ахин дахин хэрэглэхэд тохиромжтой байх үүднээс нэлээд бөх бат, байнгын шинжтэй,

- (iii) завсрын дахин ачилт хийхгүйгээр нэг юм уу хэд хэдэн тээврийн хэрэгслийг ашиглан бараа тээвэрлэлтийг хөнгөвчлөхөөр хийгдсэн,
- (iv) тухайлбал тээврийн нэг хэрэгслээс нөгөө рүү шилжүүлэхэд хялбар дөт байхаар хийгдсэн,
- (v) дүүргэх болон юүлэхэд хялбар байхаар хийгдсэн,
- (vi) дотор талын эзэдхүүн нь 1 куб.метр болон түүнээс дээш байна.

"салгаж болох тэвш" нь чингэлгийн нэгэн адил тооцогдоно.

(f) **"илгээгч газрын гаалийн байгууллага"** гэдэгт ТИР горимын дагуу барааны бүрэн бүтэн буюу хэсэгчилсэн ачилт хийгдэж олон улсын тээвэрлэлт эхэлсэн Хэлэлцэн тохирогч талын гаалийн аливаа байгууллагыг;

(g) **"хүрэх газрын гаалийн байгууллага"** гэдэгт ТИР горимын дагуу барааны бүтэн буюу хэсэгчилсэн ачилтаар хийгдсэн олон улсын тээвэрлэлт дуусгавар болсон Хэлэлцэн тохирогч талын гаалийн аливаа байгууллагыг;

(h) **"дамжин өнгөрөх замд байгаа гаалийн байгууллага"** гэж автотээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц буюу чингэлэгийг ТИР үйл ажиллагааны дагуу нутаг дэвсгэрээр нь дамжуулан импортолж, эсвэл экспортолж байгаа Хэлэлцэн тохирогч талын гаалийн байгууллагыг;

(j) **"этгээд"** гэдэгт бие хүн болон хуулийн этгээдийн аль алиныг;

(k) **"хүнд болон овор ихтэй бараа"** гэдэгт өөрийн жин, хэмжээ болон биет байдлын улмаас хаалттай авто тээврийн хэрэгсэл болон чингэлэгт ердийн байдлаар ачигдах боломжгүй аливаа хүнд жинтэй болон овор ихтэй зүйлсийг;

(l) **"баталгаа гаргагч холбоо"** гэдэгт ТИР горимыг хэрэглэгч этгээдэд баталгаа олгох ажиллагааг эрхэлж буй, Хэлэлцэн тохирогч талын цаалийн эрх бүхий байгууллагаас зөвшөөрөгдсөн аливаа холбоог ойлгоно.

Нэгдүгээр зүйлийн тайлбар

0.1 (b) 1 дүгээр зүйлийн дэд хэсэг (b)-д дурдсан хураамж, төлбөр гэдэгт импорт болон экспорттой холбоотойгоор Хэлэлцэн тохирогч талаас ногдуулсан импорт болон экспортын татвар, бусад татвараас бусад хураамж, төлбөрийг ойлгоно. Тэдгээр хураамж, төлбөр нь үзүүлсэн үйлчилгээний ойролцоо өртгийн үнийн дүнгээр хязгаарлагдаж болох бөгөөд энэ нь дотоодын бүтээгдэхүүнийг шууд бусаар хамгаалах эсвэл төсөв бүрдүүлэх зорилгоор импорт, экспортод ногдуулсан татварыг орлохгүй. Ийм хураамж болон төлбөрт дараах зүйлд холбогдох бусад зардал мөн орно. Үүнд:

- дамжин өнгөрөхөд шаардлагатай гарал үүслийн гэрчилгээ,
- хяналтын зорилгоор Гаалийн лабораторт хийгдсэн шинжилгээ,
- ажлын бус цагаар эсвэл Гаалийн байгууллагаас өөр газарт хийгдсэн гаалийн хяналт шалгалтын болон бүрдүүлэлтийн бусад ажиллагаа,
- эрүүл ахуй, мал эмнэлэг, хорио цээрийн зорилгоор хийгдсэн хяналт шалгалт

0.1 (e) **"салгаж болох тэвш"** гэсэн нэр томъёо нь зүтгүүрийн хэрэгсэлгүй, ачааны зориулалттай тасалгааг хэлэх бөгөөд энэ нь түүнд тусгайлан

тохируулсан хэсгийн доод хүрээний хамтаар авто тээврийн хэрэгсэл, түүний арал дээр тээвэрлэхэд зориулагдсан байна. Энэ нь мөн авто замын болон төмөр замын тээврийг хослуулахад тусгайлан зориулагдсан ачааны зориулалттай хэсэг болох солигдогч эд ангийг хамаарна.

0.1 (e) (i) "хэсэгчилсэн хаалттай" гэсэн нэр томъёо нь 1 дүгээр зүйлийн (e) (i) дэд хэсэгт дурдсан шал ба дээврийн хэсгээс бүрдэх бүтэц бүхий тоног төхөөрөмжид хамаарагдах бөгөөд хаалттай чингэлгийн ачааны хэсгийн зайтай тэнцүү ачааны хэсгийг үүсгэнэ. Дээврийн хэсэг нь чингэлгийн их биеийг үүсгэх металл хэсгүүдээс бүрдэнэ. Ийм маягийн чингэлэг нэг буюу түүнээс дээш хажуугийн болон нүүрэн талын ханатай байна. Зарим тохиолдолд дээвэр нь шалтайгаа босоо тулгуур баганаар холбогдсон байна. Ийм төрлийн чингэлэг нь голдуу овор ихтэй бараа (тухайлбал, автомашин гэх мэт)-г тээвэрлэхэд зориулагдана.

(b) ХАМРАХ ХҮРЭЭ

2 дугаар зүйл

Энэхүү Конвенци нь Хэлэлцэн тохирогч нэг талын гаалийн байгууллагаас гарч Хэлэлцэн тохирогч нөгөө талын, эсвэл мөн талын цаалийн байгууллагад хүрэх явцад нэг буюу хэд хэдэн улсын хилийг нэвтрэхдээ ТИР үйл ажиллагааны эхлэл төгсгөлийн хоорондох аяллын зарим хэсэг нь авто замаар хийгдсэн болохыг нотолсон авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, эсвэл чингэлгүүд дэх бараанд нь дахин ачилт хийгдэхгүйгээр явах тээвэрлэлтэд үйлчилнэ.

Тайлбар бичиг

0.2.1. 2 дугаар зүйлд ТИР карней хэрэглэн гүйцэтгэж байгаа тээврийн үйл ажиллагаа нь аяллын замнал гадаад улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх нөхцөлд нэг оронд эхлээд, тэндээ төгсч болно. Энэ тохиолдолд илгээгч газрын гаалийн байгууллага ТИР карнейгаас гадна барааг татваргүйгээр дахин оруулах (реимпорт) үндэсний зөвшөөрлийн бичиг баримтыг шаардахад болохгүй гэх зүйлгүй. Гэхдээ гаалийн байгууллага ийм бичиг баримтыг шаардахгүйгээр ТИР карнейд зохих тэмдэглэлийг үйлдэж болохыг зөвлөж байна.

0.2.2. Энэ зүйлийн заалт нь аяллын нэг хэсэг нь авто замаар хийгдэх тохиолдолд барааг ТИР карнейг ашиглан тээвэрлэх боломжийг олгоно. Гэхдээ энд аяллын аль хэсэг нь авто замаар хийгдэхийг заагаагүй бөгөөд ТИР үйл ажиллагааны эхлэл төгсгөлийн хоорондох аль нэг хэсэгт хийгдэнэ гэдэг нь л хангалттай. Гэхдээ урьдчилан тооцоолоогүй худалдааны болон ослын шалтгаанаар илгээгчийн төлөвлөж байсан авто замаар хийгдэх тээвэр хийгдээгүй байж болно. Ийм онцгой тохиолдолд Хэлэлцэн тохирогч талууд ТИР карнейг хүлээн авах бөгөөд баталгаа гаргагч холбоодын үүрэг хариуцлага ч хэвээр үлдэнэ.

3 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн заалтууд дараах тохиолдолд мөрдөгдөнө. Үүнд:

(a) тээвэрлэлтийн үйл ажиллагаа:

(i) Гуравдугаар бүлгийн (a)-д заагдсан нөхцөлийн дагуу тээвэрлэлт хийхээр зөвшөөрөгдсөн авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц эсвэл чингэлгээр хийгдэнэ.

(ii) Гуравдугаар бүлгийн (с)-д заагдсан нөхцөлийг хангасан авто тээврийн бусад хэрэгсэл, тээврийн хэрэгслийн бусад цогц эсвэл бусад чингэлгүүдээр хийгдэнэ.

(b) тээвэрлэлтийн үйл ажиллагааны баталгааг зургадугаар зүйлийн заалтын дагуу хүлээн зөвшөөрөгдсөн холбоод гаргаж өгөх бөгөөд тээвэрлэлт нь энэхүү Конвенцийн нэгдүгээр зүйлд тусгагдсан загварт тохирох ТИР карнейг ашиглан хийгдэнэ.

(с) ЗАРЧИМ

4 дүгээр зүйл

Дамжин өнгөрөх замд байгаа гаалийн байгууллага нь ТИР горимын дагуу тээвэрлэгдэж байгаа бараанд импорт, экспортын татвар болон бусад татварын баталгаа буюу барьцаа шаардахгүй.

5 дугаар зүйл

1. ТИР горимын дагуу битүүмжлэгдсэн авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц эсвэл чингэлэгт ачигдсан бараанд дамжин өнгөрөх замд байгаа гаалийн байгууллага нийтлэг тохиолдолд хяналт шалгалт хийхгүй.

2. Гэхдээ хууль бус үйлдлээс сэргийлэх үүднээс гаалийн байгууллагууд онцгой тохиолдолд, ялангуяа зөрчил байж болох сэжиг мэдэгдвэл тухайн бараанд гаалийн хяналт шалгалтыг хийж болно.

5 дугаар зүйлийн тайлбар бичиг

0.5. Энэ зүйл барааг тодорхой сонголтын үндсэн дээр шалгах эрхийг хэвээр үлдээх боловч ийм шалгалт нь аль болохоор хязгаарлагдмал байхыг анхааруулдаг. Олон улсын ТИР карнейн горим нь үндэсний горимоос илүү их хамгаалалтыг олгодог. Нэгдүгээрт, ТИР карней дээрх бараатай холбогдох мэдээлэл илгээгч оронд шаардагдах гаалийн бичиг баримт дахь мэдээлэлтэй тохирох ёстой. Түүнээс гадна дамжин өнгөрөх болон хүрэх улсад илгээгч улсад хийгдэж илгээгч улсын гаалийн байгууллагаар баталгаажуулсан хяналт шалгалт хамгаалалт болж өгнө. (Доорх 19 дүгээр зүйлийн тайлбар бичгийг үз)

БҮЛЭГ II

ТИР КАРНЕЙГ ОЛГОХ БАТАЛГАА ГАРГАГЧ

ХОЛБООДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

6 дугаар зүйл

1. Өөрсдийн тодорхойлсон нөхцөл баталгааг хангасан тохиолдолд Хэлэлцэн тохирогч тал бүр холбогдох холбоодтой шууд харьцан эсвэл тэдгээрээр дамжуулан баталгааг гаргагч болж ажиллан, ТИР карнейг олгох эрхийг холбоодод өгч болно.

2. Холбооны гаргаж буй баталгаа мөн тухайн холбоо өөрөө ч нэгэн адил харьяалагддаг олон улсын холбооны гишүүн гадаад орны холбооноос олгосон ТИР карнейг ашиглан үйл ажиллагаа явуулснаас үүсэх хариуцлагыг хүлээх тохиолдолд уг холбоо ямар ч оронд хүлээн зөвшөөрөгдөнө.

Тайлбар бичиг

0.6.2. Энэ хэсгийн заалтаар бол тухайн орны гаалийн байгууллага нэгээс илүү холбоонд зөвшөөрөл олгон тэдгээр нь өөрсдийн болон холбогдох холбоодын олгосон ТИР карнейгаар хийгдсэн үйл ажиллагаанаас үүсэн гарах хариуцлагыг тус бүрдээ хүлээнэ.

7 дугаар зүйл

Хилийн чанадын холбогдох холбоодоос эсвэл олон улсын байгууллагуудаас өөрийн харьяа баталгаа гаргагч холбоонд ирүүлсэн ТИР карнейгийн маягтад импорт, экспортын татвар болон бусад татвар ногдуулахгүй бөгөөд импорт, экспортын хориг, хязгаарлалтаас чөлөөлөгдөнө.

8 дугаар зүйл

1. Тухайн улсын гаалийн хууль тогтоомжоор ТИР үйл ажиллагаатай холбоотой зөрчил, дутагдал илэрсэн бол баталгаа гаргагч холбоод нь импорт, экспортын татвар болон бусад татварыг тэдгээрийн алдангийн хамт төлж барагдуулах үүрэг хүлээнэ. Дээр дурдсан нийт төлбөрийг тухайн төлбөрийг хариуцах этгээдтэй хамтран барагдуулах үүрэгтэй.

2. Дээр 1 дүгээр хэсэгт дурдсан импорт, экспортын татвар болон бусад татварын талаар Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжид тусгагдаагүй тохиолдолд баталгаа гаргагч холбоо нь импорт, экспортын татвар болон тэдгээрийн алдангийн үнийн дүнтэй тэнцэх төлбөрийг ижил нөхцөлтэйгөөр төлж барагдуулах үүрэг хүлээнэ.

3. Дээрх 1 болон 2 дугаар хэсгийн заалтын үндсэн дээр баталгаа гаргагч холбоогоор төлүүлж болох ТИР карней бүрийн хамгийн дээд үнийн дүнг Хэлэлцэн тохирогч тал бүр тогтоох ёстой.

4. Илгээгч улсын гаалийн байгууллага байрлаж буй улсын баталгаа гаргагч холбооны хүлээх үүрэг хариуцлага нь ТИР карнейг гаалийн байгууллага хүлээн зөвшөөрснөөр хэрэгжиж эхэлнэ. Нутаг дэвсгэрээр нь барааг ТИР горимоор тээвэрлэж байгаа улсын хувьд энэхүү үүрэг хариуцлага нь барааг импортолсон эсвэл 26 дугаар зүйлийн 1 болон 2 дугаар хэсгийн дагуу ТИР үйл ажиллагаа түр хойшилсон үед эсвэл ТИР үйл ажиллагааг дахин үргэлжлүүлсэн гаалийн байгууллага ТИР карнейг зөвшөөрсөн тэр үеэс хэрэгжиж эхэлнэ.

5. Баталгаа гаргагч холбоо нь зөвхөн ТИР карнейн жагсаалтад орсон бараанаас гадна энэ жагсаалтад ороогүй боловч авто тээврийн хэрэгслийн лац, ломбо бүхий хэсэгт, эсвэл лац, ломбо бүхий чингэлэгт байгаа аливаа бараатай холбогдох асуудлаар хариуцлага хүлээнэ. Өөр ямар ч барааны хувьд холбоо хариуцахгүй.

6. Энэхүү зүйлийн 1 болон 2 дугаар хэсэгт дурдагдсан татвар, төлбөрийг тодорхойлох зорилгоор ТИР карнейд орсон барааны тухай мэдээллийг эсрэг нотлох баримт байхгүй тохиолдолд хүчинтэйд тооцно.

7. Энэхүү зүйлийн 1 болон 2 дугаар хэсэгт дурдагдсан үнийн дүнтэй тэнцэх төлбөрийг барагдуулах хугацаа болсон үед эрх бүхий байгууллага нь баталгаа гаргагч холбоонд хандахаас өмнө боломжийн хэрээр тухайн төлбөрийг хариуцагч этгээдэд эсвэл шууд хариуцах этгээдэд барагдуулах шаардлага тавина.

8 дугаар Зүйлийн Тайлбар бичиг

0.8.2. 8 дугаар рүйлийн 1 дүгээрт дурдсан төрлийн зөрчил гарсан тохиолдолд Хэлэлцэн тохирогч талын хууль тогтоомжоор импорт, экспортын гаалийн татвар, бусад шийтгэлийн арга хэмжээний төлбөрийг төлөх тохиолдолд энэ хэсгийн заалтсу хэрэглэнэ. Гэхдээ холбогдох гаалийн шийдвэрийн дагуу энэ мөнгөний хэмжээ ямар нэг алдангийн хүүнээс болж нэмэгдэх бол барааг оруулж гаргахад төлөх мөнгө нь төлбөл зохих импорт, экспортын гаалийн татвар, бусад татвараас илүүгүй байна.

0.8.3. Баталгаа гаргагч холбооноос нэхэмжлэх ТИР Карней тутамд ногдох мөнгөний дээд хэмжээг 50.000 ам.доллар байхаар гаалийн байгууллага хязгаарлахыг зөвлөмж болгодог. Согтууруулах ундаа, тамхины тээврийн хувьд нарийвчилсан мэдээллийг дор өгсөн бөгөөд доорх хэмжээнээс илүү гарвал гаалийн байгууллага баталгаа гаргагч холбооноос нэхэмжлэх мөнгөний дээд хэмжээг 200.000 ам.доллар байхаар нэмэгдүүлэн тогтоохыг зөвлөсж болгодог.

(1) 80 болон түүнээс дээш хувийн хатуулагтай этилийн цэвэр спирт

(Уялдуулсан системийн код 22.07.10)

(2) 80 хувиас доош хатуулагтай этилийн цэвэр спирт, спирт, ликер

болон бусад согтууруулах ундаа үйлдвэрлэхэд хэрэглэгддэг нийлмэл бэлдмэл (Уялдуулсан системийн код 22.08)

(3) Тамхи агуулагч сигар, тайрсан тамхи, сигарило (Уялдуулсан системийн код 24.02.10)

(4) Тамхи агуулагч янжуур (Уялдуулсан системийн код 24.02.20)

(5) Тамхи орлуулагч ямар нэгэн хэмжээгээр агуулсан буюу агуулаагүй задгай (дүнсэн) тамхи

Баталгаа гаргагч холбооноос нэхэмжилж болох мөнгөний дээд хэмжээ нь 50.000 ам.доллар байхаар хязгаарлаж болох бөгөөд ингэхдээ тамхи, согтууруулах ундааны дээр дурдсан төрлүүд дараах хэмжээнээс хэтрээгүй байх ёстой.

- (1) 300 литр
- (2) 500 литр
- (3) 40.000 ширхэг
- (4) 70.000 ширхэг
- (5) 100 килограмм

Дээрх төрлийн тамхи, согтууруулах ундааны тоо хэмжээ (литр, ширхэг, килограмм)-ыг ТИР карнейн манифестэд бичиж тэмдэглэнэ.

Тайлбар бичиг

0.8.5. ТИР карнейд ороогүй байгаа бараанд баталгаа гаргасан байвал холбогдох байгууллага бараа нь авто тээврийн хэрэгслийн лац, ломботой хэсэгт, эсвэл лац, ломбо тавьсан чингэлэгт байгаа гэдэг өөрийн саналыг баримтаар нотолбол зохино.

0.8.6. 1. ТИР карнейд байгаа нарийвчилсан мэдээлэлд бараанд ногдуулах төлбөрийг тодорхойлоход хүрэлцэхүй мэдээ байхгүй бол Хэлэлцэн тохирогч талууд тэдгээр барааны онцлог шинжийн талаар нотлох баримтыг гаргаж болно.

2. Нотлох баримт байхгүй бол барааны шинж тэмдэгтэй холбоогүй дунд тарифаар бус, ТИР карнейд тэмдэглэгдсэн барааны төрөлд хамаарах барааны хамгийн өндөр тарифаар гаалийн татвар, бусад татварыг ногдуулна.

9 дүгээр зүйл

1. Баталгаа гаргагч холбоо нь ТИР карнейн хүчинтэй байх хугацааг тогтоож, дуусах өдрийг зааж өгөх бөгөөд уг хугацааг дууснаас хойш илгээгч улсын гаалийн байгууллагад карнейг гаалийн зорилгоор ашиглахгүй.

2. Энэхүү зүйлийн 1 дүгээр хэсэгт зааснаар хүчинтэй хугацаа дуусах өдөр эсвэл түүнээс өмнө үүнийг илгээгч улсын цаалийн байгууллага хүлээн зөвшөөрснийг баталж байгаа тохиолдолд хүлээн авч байгаа улсын гаалийн байгууллага дээр ТИР үйл ажиллагаа дуусгавар болох хүртэл карней нь хүчинтэй хэвээр үлдэнэ.

10 дугаар зүйл

1. ТИР карнейд гааль дээр тайлбартайгаар болон тайлбаргүйгээр бүрдүүлэлт хийж болно. Тайлбартайгаар бүрдүүлэлт хийвэл энэ нь ТИР ажиллагаатай холбоотойгоор бий болсон хөдөлшгүй баримт дээр үндэслэгдэх ёстой. Энэхүү хөдөлшгүй баримтуудын талаар ТИР карней дээр зохих тэмдэглэлийг үйлдэнэ.

2. Тухайн улсын Гаалийн эрх бүхий байгууллага нь ТИР карнейд тайлбаргүйгээр бүрдүүлэлт хийсэн тохиолдолд гааль дээр бүрдүүлэлт хийсэн гэрчилгээг хууль бус, хуурамч байдлаар олж авснаас бусад нөхцөлд тэд 8 дугаар зүйлийн 1 болон 2 дугаар хэсэгт дурдагдсан төлбөрийг баталгаа гаргагч холбооноос цаашид нэхэмжилэхгүй болно.

Тайлбар бичиг

0.9. Хэрэв ачааны тэвш буюу чингэлгийг зүй бусаар, эсвэл хуурч мэхлэх зорилгоор өөрчилж ТИР үйл ажиллагаа явуулсан, эсвэл хуурамч буюу алдаа мадагтай бичиг баримт ашиглах, барааг солих, гаалийн битүүмжлэлийг гэмтээх зэрэг гаж ажиллагаа илэрсэн, эсвэл гэрчилгээг бусад хууль бус аргаар олж авсан бол ТИР карней үүргээ гүйцэтгэснийг илтгэх тухайн гэрчилгээг зүй бусаар буюу залилж олж авсан гэж үзнэ.

11 дүгээр зүйл

1. ТИР карнейг эрх бүхий байгууллагууд хүлээн зөвшөөрснөөс хойш нэг жилийн дотор тэд баталгаа гаргагч холбоонд гааль дээр бүрдүүлэлт хийгдээгүй эсвэл

тайлбартайгаар бүрдүүлэлт хийгдсэн талаар бичгээр мэдэгдээгүй бол ТИР карнейд бүрдүүлэлт хийсэн буюу тайлбартайгаар бүрдүүлэлт хийсэн үед эрх бүхий байгууллагууд 8 дугаар зүйлийн 1, 2-т дурдсан мөнгийг баталгаа гаргагч холбооноос нэхэмжлэхгүй. Энэ заалт нь хууль бусаар, эсвэл луйврын аргаар бүрдүүлэлт хийлгэсэн тухай гэрчилгээ авсан тохиолдолд хэрэглэгдэх бөгөөд ийм нөхцөлд хугацаа нь 2 жил байна.

2. 8 дугаар зүйлийн 1, 2-т дурдсан мөнгийг төлүүлэх нэхэмжлэлийг ТИР карнейд гааль дээр бүрдүүлэлт хийсэн эсвэл тайлбартайгаар бүрдүүлэлт хийсэн эсвэл бүрдүүлэлт хийсэн тухай гэрчилгээг зүй бусаар, луйврын аргаар олж авсан гэдгийг тухайн өдрөөс хойш наад зах нь хоёр жилийн дотор, Холбоонд мэдэгдсэн өдрөөс хойш доод тал нь гурван сарын дотор баталгаа олгогч холбоонд гаргана. Гэхдээ дээр дурдсан хоёр жилийн хугацаанд уг хэргийг хуулийн дагуу шүүхээр шийдэхээр болсон төлбөрийн нэхэмжлэлийг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс хойш нэг жилийн дотор гаргана.

3. Баталгаа гаргагч холбоо төлбөрнau нэхэмжлэл хүлээн авсан өдрөөс хойш гурван сарын дотор мөнгийг төлнө. Нэхэмжилсэн төлбөрийг хийснээс хойш хоёр жилийн дотор тухайн тээврийн үйл ажиллагаатай холбогдон ямар нэг алдаа дутагдал гараагүй гэдгийг гаалийн байгууллагаас тогтоосон бол төлсөн мөнгийг нь уг холбоонд нөхөн олгоно.

Тайлбар бичиг

0.11.1. Бараа, тээврийн хэрэгслийг нэвтрүүлэх асуудлыг шийдвэрлэхдээ гаалийн байгууллага өөрсдийнх нь сонирхлыг хамгаалсан бусад хэрэгсэл хуулинд нь байгаа тохиолдолд баталгаа гаргагч холбоо карней эзэмшигч төлөх ёстой гаалийн татвар, бусад татвар болон алдангийн хүүг хариуцна гэдгийн нөлөөнд орохгүй байвал зохино.

0.11.2. 11 дүгээр зүйлд заагдсан журмын дагуу баталгаа гаргагч холбооноос 8 дугаар зүйлийн 1, 2-т заасан мөнгийг төлөхийг шаардахад Конвенцид заасан гурван сарын хугацаанд төлөхгүй байвал эрх бүхий байгууллагууд баталгаа гаргагч холбоо баталгааны гэрээгээ биелүүлэхгүй байгаа учраас холбогдох төлбөр хийхийг шаардсан үндэсний хууль тогтоомжийн дагуу шийдэж болно.

БҮЛЭГ III

ТИР КАРНЕЙ АШИГЛАН БАРААГ ТЭЭВЭРЛЭХ

(а) Авто тээврийн хэрэгсэл, чингэлэгт зөвшөөрөл олгох

12 дугаар зүйл

Энэ бүлгийн (а), (b) хэсэгт байгаа заалтад хамаарагдахын тулд авто тээврийн хэрэгсэл бүр хийц болон тоноглолын хувьд энэхүү Конвенцийн Хавсралт 2-т заагдсан нөхцөлийг хангах ёстой бөгөөд энэхүү Конвенцийн Хавсралт 3-т заасан журмын дагуу зөвшөөрөл авсан байх ёстой. Зөвшөөрлийн гэрчилгээ нь Хавсралт 4-т заагдсан загвартай тохирч байна.

13 дугаар зүйл

1. Энэ бүлгийн (a), (b) хэсэгт байгаа заалтад хамаарагдахын тулд чингэлэг нь Хавсралт 7-ийн нэгдүгээр хэсэгт заагдсан нөхцлийн дагуу хийгдсэн байх ёстой бөгөөд тэрхүү Хавсралтын хоёрдугаар хэсэгт дурдсан журмын дагуу тээвэрлэлт хийхээр зөвшөөрөгдсөн байх ёстой.

2. Чингэлгийн тухай 1956 оны Гаалийн Конвенци болон түүнтэй холбогдон гарч НҮБ-ын ивээл дор байгуулагдсан хэлэлцээрүүд, Чингэлгийн тухай 1972 оны Гаалийн Конвенци болон үүнийг хэрэгсэхгүй болгосон буюу өөрчлөх олон улсын бичиг баримтын дагуу барааг тээвэрлүүлэхээр зөвшөөрөгдсөн гаалийн битүүмжлэлтэй чингэлэг нь дээрх хэсгийн 1-д тохирч байх бөгөөд шинээр зөвшөөрөл авалгүйгээр ТИР горимоор тээвэр хийхээр хүлээн зөвшөөрөгдөх ёстой.

14 дүгээр зүйл

1. Хэлэлцэн тохирогч тал бүр дээрх 12, 13 дугаар рүйлд заасан нөхцөлийг хангаагүй авто тээврийн хэрэгсэл болон чингэлгийн зөвшөөрлийн хүчин төгөлдөр эсэхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах эрхийг хадгална. Гэхдээ Хэлэлцэн тохирогч талууд гарсан алдаа дутагдал нэг их бус бөгөөд контрабандын эрсдэлгүй байвал тээврийн хөдөлгөөнийг саатуулахаас зайлсхийнэ.

2. Барааг гаалийн битүүмжлэлтэйгээр дахин тээвэрлэж эхлэхээс өмнө аливаа авто тээврийн хэрэгсэл буюу чингэлэг нь зөвшөөрөл олгох нөхцөлийг бүрдүүлээгүй байвал хуучин хэвэнд нь буцаан оруулах, эсвэл дахин зөвшөөрөл авах ёстой.

(b) ТИР карнейг ашиглан хийх тээвэрлэлтийн журам

15 дугаар зүйл

1. ТИР горимын дагуу бараа тээвэрлэж байгаа тээврийн хэрэгслийн цогц, чингэлэг, авто тээврийн хэрэгслийг түр оруулахад гаалийн ямар нэг тусгай бичиг баримт шаардагдахгүй. Чингэлэг, тээврийн хэрэгслийн цогц, авто тээврийн хэрэгсэлд ямар нэг баталгаа шаардагдахгүй.

2. Энэ зүйлийн 1 дүгээр хэсгийн заалт нь ТИР тээвэрлэлт дууссанаар авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, чингэлэг нь реэкспортоор гарна гэдгийг баталгаажуулах үүднээс үндэсний хууль тогтоомжийн дагуу гаальд хийгдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Хэлэлцэн тохирогч талд саад учруулахгүй.

Тайлбар бичиг

0.15. Зарим оронд чиргүүл, хагас чиргүүл зэрэг нь бүртгэлд ороогүй байдаг болон тээврийн хэрэгслийн хувьд түр горимоор оруулах үед гаалийн бичиг баримтыг шаарддаггүй учраас зарим нэг бэрхшээл гарч болох юм. Ийм тохиолдолд 15 дугаар рүйлийн заалтыг дагуу эдгээр тээврийн хэрэгслийн талаар мэдээллийг (хийц, дугаар гэх мэт) тухайн оронд хэрэглэгдэж байгаа ТИР карнейн 1, 2 дугаар ваучер, холбогдох тасалбарт тэмдэглэгээ хийж гаалийн хувьд шаардлагатай хамгаалалтыг баталгаажуулна.

16 дугаар зүйл

ТИР тээвэрлэлтийг гүйцэтгэж байгаа авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц нь энэ Конвенцийн Хавсралт 5-д заасан үзүүлэлтэд тохирсон "ТИР" гэсэн бичээстэй дөрвөлжин пайзыг урд талдаа, өөр нэгийг авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогцын ард хадна. Эдгээр пайзыг тод ялгарч харагдахуйц байдлаар байрлуулна. Эдгээрийг

авч болох, эсвэл эдгээр пайзыг тааруулж, нөгөө талаар нь харуулж болохоор хийж, бүрж, нугалж, эсвэл ТИР тээвэрлэлт хийгдээгүй байна гэдгийг аль нэгэн байдлаар харуулж болохоор хийсэн байх ёстой.

17 дугаар зүйл

1. Авто тээврийн хэрэгсэл, чингэлэг тус бүрт нэг ТИР карней олгож болно. Гэхдээ нэг ТИР карней тээврийн хэрэгслийн цогц, эсвэл хэд хэдэн чингэлэгт зориулагдаж болох ба чингэлгүүд нь нэг авто тээврийн хэрэгсэл, эсвэл тээврийн хэрэгслийн цогцод ачигдах ёстой. Энэ тохиолдолд ТИР карнейд хамаарах ачааны манифестэд тээврийн хэрэгслийн цогцын тээврийн хэрэгсэл тус бүрт болон чингэлэг тус бүрийн доторх зүйлсийг тус тусад нь жагсаасан байвал зохино.

2. ТИР карней зөвхөн нэг аялалд хүчинтэй. Үүнд наад зах нь Гаалийн байгууллагад хүлээлгэн өгөх болон гаалийн бүрдүүлэлт хийхд тухайн тээвэрлэлтийн үйл ажиллагаанд зайлшгүй шаардагдах таслан авч болох хэд хэдэн ваучер байх ёстой.

Тайлбар бичиг

0.17.1. ТИР карнейд хамаарах барааны манифест нь тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, чингэлэг тус бүрийн ачааг тус тусад нь харуулах ёстой гэсэн заалт нь тээврийн хэрэгсэл чингэлэг нэг бүрийн ачааг шалгах гаалийн хяналтыг хялбарчлах ганцхан зориулалттай. Энэ заалтыг ийм учраас тээврийн хэрэгсэл, чингэлгийн ачаа тус бүр манифест дээр зааснаас өөр байх нь Конвенцийн энэ заалтыг зөрчсөн мэтээр хатуу тайлбарлаж болохгүй.

Хэрэв тээвэрлэгч саяных шиг өөрчлөлтөөс бусад манифест дээрх бүх бараа ТИР карнейд хамаарч байгаа тээврийн хэрэгслийн цогц, бүх чингэлэгт байгаа барааны нийт дүнтэй тохирч байгаа гэдгээр холбогдох байгууллагуудын сэтгэлд нийцэж байх юм бол үүнийг гаалийн шаардлагыг зөрчсөн гэж тооцохгүй.

0.17.2. Гэр ахуйн хэрэгслийг тээвэрлэсэн тохиолдолд ТИР карнейг хэрэглэх дүрмийн 10 (с) дугаарт заасан журам үйлчлэх бөгөөд холбогдох зүйлийн жагсаалт тохирох байдлаар богиносох юм.

18 дугаар зүйл

ТИР үйл ажиллагаа илгээгч болон хүрэх газартаа хэд хэдэн гаалийн байгууллагыг дамжих бөгөөд илгээгч болон хүрэх газрын гаалийн байгууллагын унам тоо дөрвөөс илүүгүй байна. Илгээгч улсын гаалийн байгууллагууд хүлээн зөвшөөрсөн тэмдэглэгээ хийсэн тохиолдолд ТИР карнейг хүрэх газрын гаалийн байгууллагад өгнө.

Тайлбар бичиг

0.18.1. ТИР үйл ажиллагааг жигд байлгах үүднээс нэг орны гаалийн байгууллага энэхүү Конвенцийн хэлэлцэн тохирогч хөрш зэргэлдээ орны нутаг дэвсгэрт үргэлжлэх тээвэрлэлтийн хил гарах гаалийн байгууллага хүрэх газрын гаалийн байгууллага болох хүсэлтийг зөвтгөх тусгайлсан нөхцөл байхгүй тохиолдолд уг хүсэлтийг биелүүлэхээс татгалзаж болно.

0.18.2. 1. Барааг ачихдаа тээврийн хэрэгсэл, чингэлгийн ачааг буулгах эхний цэгт буулгахдаа бусад газар очих ёстой ачааг тээврийн хэрэгсэл болон чингэлэгээ дахин дахин буулгахгүй байхаар бодож ачвал зохино.

1. Тээврийн үйл ажиллагаа нэгээс дээш газарт буулгах ачааг хамарч байвал ачааны хагасыг буулгасны дараа ТИР карнейн үлдсэн манифест дээрх 12 дугаар хүснэгтэд тэмдэглэгээ хийж мөн үлдсэн ваучерт холбогдох тасалбарт шинээр лац, ломбо тавьсан болохыг тэмдэглэнэ.

19 дүгээр зүйл

Бараа, авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, чингэлэг нь илгээгч газрын гаалийн байгууллагад ТИР карнейтайгаа ирнэ. Илгээгч улсын гаалийн байгууллага барааны манифестын үнэн зөв эсэхийг шалгах, гаалийн лац, ломбыг тавих, гаалийн байгууллагын хариуцлагын хүрээнд тусгай эрх олгогдсон хүмүүс гаалийн лац, ломбыг тавьсан эсэхийг нягтлах зэрэг шаардлагатай бүх арга хэмжээг авна.

Тайлбар бичиг

- 1.18. Илгээгчийн гаалийн байгууллага барааны манифестийн үнэн зөв эсэхийг шалгавал зохино гэсэн шаардлага нь барааны манифестийн бүртгэл дэх мэдээлэл нь экспортын баримт бусад тээврийн болон худалдааны бичиг баримтынхтай таарч байгаа эсэхийг нягталж үзэх хэрэгтэй гэдгийг хэлж байгаа юм. Мөн илгээгчийн гаалийн барааг шалгаж болно. Илгээгч газрын гаалийн байгууллага битүүмжлэхээсээ өмнө авто тээврийн хэрэгсэл, чингэлгийн байдлыг шалгаж бүрхүүлтэй тээврийн хэрэгсэл, чингэлгийн хувьд зөвшөөрлийн гэрчилгээнд эдгээр тоноглол нь дурдагдаагүй бол бүрээс түүний бэхэлгээний байдлыг шалгана.

20 дугаар зүйл

Өөрсдийн нутаг дэвсгэрт болох аялалд гаалийн байгууллага цаг хугацааны хязгаарлалт тогтоож, авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц болон чингэлэгт явах замын маршрутыг нь урьдчилан тодорхойлж өгч болно.

Тайлбар бичиг

- 1.19. Өөрийн орны нутаг дэвсгэрт барааг тээвэрлэх цаг хугацааны хязгаарлалтыг тогтооходоо гаалийн байгууллага тээвэрлэгч ямар нэг журмыг мөрдөж байгаа эсэх, ялангуяа авто тээврийн хэрэгслийн жолооч нарын ажлын цаг, заавал амрах хугацаатай холбогдох журмыг баримталж байгаа эсэхийг анхааралдаа авах ёстой. Эдгээр байгууллагууд өөрсдийн хувьд зайлшгүйд тооцогдсон замын маршрутыг сонгох эрхээ эдэлбэл зохино..

21 дүгээр зүйл

Замд байгаа гаалийн бүх байгууллага болон хүрэх газрын гаалийн байгууллагад авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, чингэлэг нь ачаа болох холбогдох ТИР карнейн хамт гаалийн хяналтад байна.

Тайлбар бичиг

- 0.21.1. Энэ зүйлийн заалт нь гаалийн байгууллагаас ачааны лац, ломбо тавьсан хэсгээс бусад тээврийн хэрэгслийн бүх эд ангийг шалгах эрхийг хязгаарлахгүй.

0.21.2. Зэргэлдээ орны хилээр гаргах гаалийн байгууллага ТИР карнейд холбогдох тэмдэглэгээ хийгээгүй, эсвэл шаардлагатай байдлаар тэмдэглэгээ бүрэн хийгдээгүй гэдэг нь тогтоогдвол хилээр оруулах гаалийн байгууллага тээвэрлэгчийг буцааж болно.

0.21.3. Шалгах явцдаа гаалийн байгууллага барааны дээжийг авсан бол барааны онцлог шинжийн талаарх бүрэн дүүрэн тэмдэглэгээг ТИР карнейн барааны манифест дээр хийнэ.

22 дугаар зүйл

1. 5 дугаар зүйлийн 2-т заасны дагуу гаалийн байгууллага шалгалт хийснээс бусад тохиолдолд Хэлэлцэн тохирогч тус бүрийн зам дагуух гаалийн байгууллагад Хэлэлцэн тохирогч бусад талуудын гаалийн лац, ломбо хөдлөөгүй байгааг нь нотлогдож байвал хүлээн авна. Гэхдээ хяналтын үүднээс шаардлагатай гэж үзвэл гаалийн ажилтнууд өөрсдийн лац, ломбыг нэмж тавьж болно.

2. Хэлэлцэн тохирогч талын хүлээн зөвшөөрсөн гаалийн лац, ломбо нь тухайн Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт үндэсний лац, ломбын нэгэн адил эрх зүйн хамгаалалтад байна.

23 дугаар зүйл

Гаалийн байгууллагууд зөвхөн онцгой тохиолдлоос бусад үед:

- авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, чингэлгийг тухайн орны нутаг дэвсгэрт тээвэрлэгчийн зардлаар дагалдан хамгаалалттай явахыг шаардахгүй.

- авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, чингэлэг, тэдгээрийн ачааг замд шалгаж үзлэг хийлгэхийг шаардахгүй.

24 дүгээр зүйл

Хэрэв гаалийн байгууллагууд замын дагуух гаалийн байгууллагад авто тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, чингэлгийн ачааг шалгасан бол өөрийн оронд хэрэглэгдэж байгаа ТИР карнейн ваучер болон холбогдох тасалбарт тэмдэглэх бөгөөд тавьсан хяналтын тухай болон шинээр тавьсан лац, ломбоны онцлог шинжийг ТИР карнейд үлдсэн ваучерт бичиж тэмдэглэнэ.

25 дугаар зүйл

24, 35 дугаар зүйлд заасан тохиолдлоос өөр байдлаар гаалийн лац, ломбо замдаа эвдэрсэн, эсвэл лац, ломбо эвдрээгүй ч бараа устгагдсан буюу гэмтсэн байвал үндэсний хууль тогтоомжийн заалтыг хэрэглэхгүйгээр энэ Конвенцийн ТИР карнейг хэрэглэх тухай Хавсралт 1-д дурдсан журмыг хэрэглэх бөгөөд ТИР карней доторхи баталгаажсан мэдээг бөглөнө.

26 дугаар зүйл

1. ТИР карней ашиглан хийгдэж байгаа тээвэрлэлт энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч бус улсын нутаг дэвсгэрт хэсэг нь хийгдвэл аяллын уг хэсэгт ТИР үйл ажиллагааг түр зогсооно. Энэ тохиолдолд аялал цаашид өөрийнх нь нутаг дэвсгэрт үргэлжлэх Хэлэлцэн тохирогч талын гаалийн байгууллага гаалийн лац, ломбо болон бусад таних

тэмдэг нь хөдлөөгүй хэвээр байх юм бол ТИР үйл ажиллагааг сэргээхээр ТИР карнейг хүлээн авна.

2. Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт ТИР карнейг эзэмшигч нь гаалийн дамжин өнгөрөх энгийн горим хэрэглэгддэг эсвэл гаалийн дамжин өнгөрөх горим шаардлагагүй учраас карнейг хэрэглээгүй замын маршрутад мөн дээрх заалт үйлчлэнэ.

3. Энэ тохиолдолд ТИР үйл ажиллагаа түр тасарсан эсвэл сэргээгдсэн гаалийн байгууллага нь хилээр орох, гарах гаалийн байгууллага байлаа ч гэсэн замын дагуух завсрын гаалийн байгууллага болно.

27 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн заалт, тухайлбал 18 дугаар зүйлд хамаарах эхнээсээ тогтоогдсон хүрэх газрын гаалийн байгууллага гэдэг нь хүрэх газрын өөр нэг гаалийн байгууллага гэж солигдож болно.

28 дугаар зүйл

Ачаа ирэхэд хүрэх газрын гаалийн байгууллага бараа хяналтын өөр тогтолцоонд хамаарах, эсвэл бүрмөсөн оруулах горимоор орох нь тогтоогдвол түргэн хугацаанд ТИР карнейд гаалийн бүрдүүлэлт хийнэ.

Тайлбар бичиг

0.28.1. 1. 28 дугаар зүйлд хүрэх газрын гаалийн байгууллага бараа гаалийн бусад горимд хамаарах, эсвэл бүрмөсөн оруулах горимоор бүрдүүлэлт хийх нөхцөлд ТИР карнейд яаралтай бүрдүүлэлт хийнэ.

2. ТИР карнейг ашиглах нь зөвхөн түүний хамаарах дамжин өнгөрөх үйл ажиллагаагаар хязгаарлагдана. ТИР карнейг жишээлбэл, хүрэх газарт гаалийн хяналтад барааг хадгалах зориулалтаар ашиглаж болохгүй. Зөрчил гарсан тохиолдолд хүрэх газрын гаалийн байгууллага ТИР карнейд хамаарагдах бараа гаалийн өөр горимд шилжих юмуу, эсвэл бүрмөсөн оруулах горимоор бүрдүүлэлт хийлгэсний дараа шууд ТИР карнейд бүрдүүлэлт хийнэ. Барааг шууд реэкспортоор гаргасны дараа (жишээлбэл, боомт дээр ирэнгүүт ачих гэх мэт) эсвэл хүрэх газарт гаалийн зорилгоор мэдүүлэг бичих үед, эсвэл хадгалах зорилгоор барааг хүлээн аваад гаалийн мэдүүлэг өгөхөөр хүлээх үед (жишээлбэл, дамжин өнгөрөх газарт) хүрэх газрын улс оронд хүчин төгөлдөр байгаа журам, дүрмийн дагуу ТИР карнейд хойшлуулалгүйгээр гол төлөв бүрдүүлэлт хийдэг.

(с) Хүнд болон овор ихтэй барааны тээвэрлэлттэй

холбоотой заалтууд

29 дүгээр зүйл

1. Энэ Конвенцийн 1 дүгээр рүйлийн дэд хэсэг К-д дурдсан хүнд эсвэл овор ихтэй барааны тээвэрлэлтэд энэ хэсгийн заалт үйлчилнэ.

2. Энэ хэсгийн заалт үйлчлэх хүнд эсвэл овор ихтэй бараа нь илгээгч газрын гаалийн байгууллагын шийдвэрээр битүүмжлээгүй тээврийн хэрэгсэл буюу чингэлгээр тээвэрлэгдэж болно.

3. Илгээгчийн гаалийн байгууллагын саналаар хүнд эсвэл овор ихтэй бараа болон тэдгээрийн хамт тээвэрлэгдэх туслах хэрэгсэл нь өгсөн үзүүлэлтийн дагуу хялбархан таньж ялгагдах эсвэл гаалийн лац, ломбо, ялгах тэмдэгтэй явснаар өөр зүйлээр солигдох, барааг өөр тийш шилжүүлэх зэрэг нь лац, ломбогүйгээр байсан ч харагдахаар байх тохиолдолд зөвхөн энэ хэсгийн заалт үйлчилнэ.

Тайлбар бичиг

0.29. Хүнд буюу овор ихтэй барааг тээвэрлэж байгаа авто тээврийн хэрэгсэл, чингэлгийн хувьд зөвшөөрлийн гэрчилгээ шаардагдахгүй. Гэхдээ ийм төрлийн тээврийн ажиллагаанд зориулан энэ зүйлд заасан бусад нөхцөлийг хангаж байгаа эсэх талаар шалгах нь илгээгчийн гаалийн байгууллагын үүрэг юм. Хэлэлцэн тохирогч бусад талын гаалийн байгууллага илгээгчийн гаалийн байгууллагын шийдвэрийг 29 дүгээр зүйлд заасантай зөрчилдөөгүй гэж үзэж байгаа бол хүлээн авна.

30 дугаар зүйл

Энэ хэсгийн тусгай заалтуудаас бусад энэ Конвенцийн бүх заалт нь ТИР горимоор хүнд буюу овор ихтэй барааг тээвэрлэхэд хамаарна.

31 дүгээр зүйл

Баталгаа гаргагч холбооны хүлээх хариуцлага нь ТИР карнейд дурдсан бараа төдийгүй карнейд заагдаагүй боловч ТИР карнейд дурдсан бараан дотор байгаа болон ачааны тэвшин дээр байгаа бараанд мөн хамаарна.

32 дугаар зүйл

ТИР карнейн хавтас болон бүх ваучер нь англи, франц хэл дээр дармал үсгээр "хүнд буюу овор ихтэй бараа" гэсэн бичигтэй байна.

33 дугаар зүйл

Илгээгчийн гаалийн байгууллага баглаа боодлын жагсаалт, гэрэл зураг, зураг гэх мэт ТИР карнейд хавсаргасан байвал зохих тээвэрлэж байгаа барааг ялгаж танихад шаардлагатай зүйлийг шаардаж болно. Энэ тохиолдолд тэд эдгээр бичиг баримтыг баталж, дурдсан бичиг баримтын нэг хувийг ТИР карнейн гаднах хавтасны завсар хийж хавсаргах бөгөөд ТИР карнейн бүх манифест мөн нэгэн адил дурдсан бичиг баримтын талаарх мэдээллийг агуулна.

34 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч тал бүрийн замын дагуух гаалийн байгууллага Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагын тавьсан гаалийн лац, ломбо болон ялгах тэмдгийг хүлээн зөвшөөрнө. Тэд нэмэлт лац, ломбо, эсвэл ялгах тэмдэг тавьж болох бөгөөд өөрийн оронд хэрэглэж байгаа ТИР карнейн ваучер, ТИР карнейд үлдэж байгаа ваучер болон холбогдох тасалбарт шинэ лац, ломбо ялгах тэмдгийн талаарх онцлогийг тэмдэглэнэ.

35 дугаар зүйл

Замын дагуух болон аяллын замд байгаа гаалийн байгууллагад ачаанд шалгалт хийж лац, ломбыг эвдэх, эсвэл ялгах тэмдгийг авах үүрэгтэй бол тэд шинэ лац, ломбо

болон бусад ялгах тэмдгийн талаарх тэмдэглэгээг өөрийн оронд хэрэглэгдэж байгаа ТИР карнейн ваучер, холбогдох тасалбар болон ТИР карнейд үлдэж байгаа ваучерт хийнэ.

БҮЛЭГ IV

КОНВЕНЦИЙН ЗААЛТЫГ ЗӨРЧИХ

36 дугаар зүйл

Энэхүү Конвенцийн заалтыг зөрчсөн аливаа зөрчлийг гаргагч этгээдэд зөрчил гарсан оронд тухайн орны хууль тогтоомжид заагдсан шийтгэл ногдуулна.

37 дугаар зүйл

Алдаа зөрчлийн нутаг дэвсгэрийг тогтоох боломжгүй үед алдаа зөрчил илэрсэн Хэлэлцэн тохирогч талын нутаг дэвсгэрт гарсан гэж тооцно.

38 дугаар зүйл

1. Хэлэлцэн тохирогч тал бүр барааг олон улсын хэмжээнд тээвэрлэхтэй холбогдсон гаалийн хууль тогтоомж, журмыг ноцтойгоор зөрчиж буруутай нь тогтоогдсон этгээдийг энэхүү Конвенцийн заалтын дагуу хийгдэх үйл ажиллагаанаас түр хугацаагаар буюу бүрмөсөн гаргах эрхтэй.

2. Энэ шийдвэрийг тухайн этгээдийн байгаа буюу оршин суугаа нутаг дэвсгэрийн Хэлэлцэн тохирогч тал болон зөрчил үйлдэгдсэн орны баталгаа гаргагч холбоонд яаралтай мэдэгдэнэ.

Тайлбар бичиг

0.38.1. Бизнесийн байгууллагын удирдлага нь мэдээгүй байхад жолоочийн гаргасан зөрчлөөс болж ТИР системийг ашиглах эрхээ хасуулах ёсгүй.

0.38.2. Хэлэлцэн тохирогч тал өөрийнх нь нутаг дэвсгэрт байдаг буюу оршин суудаг этгээд гадаад орны нутаг дэвсгэрт зөрчил гаргасан гэсэн мэдэгдлээр тухайн этгээдэд ТИР карней олгохоо зогсоох шаардлагагүй.

39 дүгээр зүйл

ТИР үйл ажиллагааг дараах тохиолдолд зөв явуулсан гэж хүлээн зөвшөөрнө:

1. Хэлэлцэн тохирогч талууд цаг хугацааны хязгаарлалт буюу замын маршрутыг дагаж мөрдөхтэй холбогдон гарсан жижиг зөрүүг анхаарч үзээгүй.

2. ТИР карнейн барааны манифест дээр мэдээ болон авто замын тээврийн хэрэгсэл, тээврийн хэрэгслийн цогц, чингэлгийн доторх бодит хэмжээ зөрж байгааг ТИР карнейг эзэмшигчээс Конвенцийг зөрчиж байгаа гэж үзэхгүй байгаа тохиолдолд нотлох баримт нь эрх бүхий байгууллагад эдгээр зөрөө нь санаатай гаргасан алдаанаас буюу барааг ачих, буулгах үед манифест олгохдоо тоомсоргүй хандсанаас шалтгаалаагүй болохыг харуулсан үед Конвенцийг зөрчсөн гэж үзэхгүй.

Тайлбар бичиг

0.39. "Тоомсоргүйгээс гаргасан алдаа" хэмээх үг хэллэгийг санаатайгаар үйлдээгүй, бүгдийг мэдэж байсан боловч хийсэн үйлдэлд хамааруулах бөгөөд энэ нь аливаа онцгой тохиолдолд хийх зүйлээ яг таг гүйцэтгэхийн тулд шаардлагатай, тохирох арга хэмжээг аваагүйгээс гарсан үйлдэл юм.

40 дүгээр зүйл

Илгээгч болон хүлээн авах орнуудын Гаалийн байгууллагууд ТИР карнейг эзэмшигчийг тухайн орнуудад гарч болох зөрүүг хариуцах ёстой гэж үзэхгүй ба зөрүү нь үнэндээ ТИР үйл ажиллагаанаас өмнө буюу түүний дараах гаалийн горимтой холбоотой байх бөгөөд үүнд карней эзэмшигч оролцоогүй болно.

41 дүгээр зүйл

ТИР карнейн манифестэд тусгагдсан бараа устгагдсан эсвэл осол, давагдашгүй хүчин зүйлийн улмаас нөхөшгүйгээр алдагдсан буюу барааны онцлогоос болон дутсан гэдэг нь Гаалийн байгууллагад ойлгомжтой байвал төлбөл зохих гаалийн татвар, бусад татварыг нэхэмжлэхгүй.

42 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч талаас зохих шалтгааныг тодруулах хүсэлт гаргавал ТИР үйл ажиллагаан холбогдох Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагууд тухайн Хэлэлцэн тохирогч талыг 39, 40, 41 дүгээр рүйлийн заалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах боломжтой мэдээллээр хангана.

БҮЛЭГ Ү

ТАЙЛБАР БИЧИГ

43 дугаар зүйл

Гуравдугаар хэсгийн Хавсралт 6, 7-д орсон Тайлбар бичиг нь энэ Конвенцийн болон түүний Хавсралтын зарим заалтыг тайлбарлана. Тэнд мөн зарим нэг практик алхмыг санал болгоно.

БҮЛЭГ ҮІ

БУСАД ЗААЛТУУД

44 дүгээр зүйл

Хэлэлцэн тохирогч тал бүр холбогдох баталгаа гаргагч холбоог дараах боломжоор хангана:

- (a) Энэхүү Конвенцийн 8 дугаар зүйлийн заалтын дагуу Хэлэлцэн тохирогч талуудын эрх бүхий байгууллагуудаас нэхэмжилсэн үнийн төлбөрийг валютаар шилжүүлэх,

- (b) баталгаа гаргагч холбоонд холбогдох гадаадын холбоо эсвэл олон улсын байгууллагаас ТИР карнейн маягтын төлбөрт шаардагдах валютыг шилжүүлэх.

45 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч тал бүр ТИР үйл ажиллагааг хэрэгжүүлэх үүднээс зөвшөөрөл авсан илгээгч улсын гаалийн байгууллага, замын дагуух гаалийн байгууллага болон хүрэх газрын гаалийн байгууллагын жагсаалтыг хэвлүүлнэ. Зэргэлдээ орших нутаг дэвсгэр бүхий Хэлэлцэн тохирогч талууд холбогдох хилийн боомтын гаалийн байгууллагад болон тэдгээрийн ажиллах цагийн тухайд харилцан зөвлөлдөж тохиролцоно.

Тайлбар бичиг

- 0.45. Хэлэлцэн тохирогч талууд ТИР үйл ажиллагааг эрхлэх боломжтой гүний болон хилийн аль болох олон тооны гаалийн байгууллагыг бий болговол зохино.

46 дугаар зүйл

1. Хэвийн үйл ажиллагаа явуулахаар тогтоосон цаг хугацаа, өдрүүдээс бусад тохиолдолд энэхүү Конвенцид дурдсан гаалийн үйл ажиллагаатайгаар холбоотойгоор гаалийн ажилтнуудад үүргээ биелүүлсний төлөө ямар нэг хөлс олгохгүй.

2. Хэлэлцэн тохирогч талууд хялбар гэмтэх, муудах барааны хувьд гаалийн ажиллагааны боломжтой хөнгөлөлтийг гаалийн байгууллагын зүгээс үзүүлэх талаар боломжтой бүх арга хэмжээг авна.

47 дугаар зүйл

1. Энэхүү Конвенцийн заалтууд нийгмийн ёс суртахуун, нийгмийн аюулгүй байдал, ариун цэвэр буюу хүн амын эрүүл мэнд, мал эмнэлгийн болон эрүүл ахуйн шалтгаанаар үндэсний хууль тогтоомжоор тогтоосон хяналт, хязгаарлалтыг хэрэглэх болон дээрх журмын дагуу ногдуулах хураамжийг тогтооход хамаарахгүй.

2. Энэхүү Конвенцийн заалтууд нь тээврийг зохицуулах үндэсний болон олон улсын бусад заалтыг хэрэглэхийг хязгаарлахгүй.

48 дугаар зүйл

Гаалийн болон эдийн засгийн холбоог үүсгэж байгаа Хэлэлцэн тохирогч талуудын тээврийн үйл ажиллагааг эхлэх болон дуусгах, өөрийн нутаг дэвсгэрээр өнгөрүүлэх тухай тусгай заалтыг хэрэгжүүлэхэд энэ Конвенцийн дотор саад болох зүйл байхгүй бөгөөд эдгээр заалтууд нь Конвенциор олгогдсон хөнгөлөлтийг огт хязгаарлахгүй.

49 дүгээр зүйл

Энэхүү Конвенци Хэлэлцэн тохирогч талууд ихээхэн хэмжээний хөнгөлөлт эдлүүлэх эсвэл нэг талын заалт хоёр талт болон олон талт хэлэлцээрүүдээр ийм хөнгөлөлтийг олгохыг хязгаарлахгүй бөгөөд эдгээр хөнгөлөлт нь энэ Конвенцийн заалтыг хэрэгжүүлэх болон тухайлбал ТИР үйл ажиллагааны хэрэгжилтэд саад учруулахгүй.

50 дугаар зүйл

Хэлэлцэн тохирогч талууд энэхүү Конвенцийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон шаардлагатай мэдээллийг хүсэлт гаргасан тохиолдолд бие биедээ харилцан өгөх ба тухайлбал авто тээврийн хэрэгсэл, чингэлэгт зөвшөөрөл олгосон тухай болон тэдний хийцийн техникийн үзүүлэлт зэрэг мэдээллийг солилцоно.

51 дүгээр зүйл

Энэхүү Конвенцийн бүх Хавсралт нь Конвенцийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг мөн.

БҮЛЭГ ҮИ

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

52 дугаар зүйл

Гарын үсэг зурах, соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэх

1. НҮБ-ийн гишүүн бүх улс орон, төрөлжсөн аливаа байгууллага, Олон улсын атомын эрчим хүчний байгууллагын гишүүд, хууль зүйн олон улсын шүүхийн бичиг баримтад нэгдсэн талууд, НҮБ-ын Ерөнхий Ассамблейн урьсан аливаа бусад улс орон дараах байдлаар энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч тал болж болно:

- (a) соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах тухай тайлбаргүйгээр гарын үсэг зурж;
- (b) соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах тухай батламж бичгийг хадгалуулан, гарын үсэг зурсны дараагаар соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах тайлбартайгаар эсвэл,
- (c) нэгдэн орсон батламж бичгийг хадгалуулах замаар.

2. Энэхүү Конвенци энэхүү зүйлийн 1 дэх хэсэгт заагдсан улс орнуудын хувьд Женев хотноо НҮБ-ын байранд гарын үсэг зурахад 1976 оны 1 дүгээр сарын 1-нээс 1976 оны 12 дугаар сарын 1 хүртэл нээлттэй. Үүнээс хойш Конвенцид нэгдэн ороход нээлттэй.

3. Гаалийн болон эдийн засгийн холбоо нь өөрсдийн гишүүн орнуудын хамт, эсвэл тэдгээр гишүүн орнууд нь энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч тал болсны дараагаар энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу мөн энэ Конвенцийн Хэлэлцэн тохирогч тал болно. Гэхдээ эдгээр холбоо нь санал өгөх эрхгүй.

4. Соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах тухай батламж бичгийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулна.

53 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

1. Энэхүү Конвенци нь тавин хоёрдугаар зүйлийн нэг дэх хэсэгт дурдсан улсуудаас таван улс орон соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, тайлбаргүйгээр гарын үсэг зурсан эсвэл соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх батлах, нэгдэн орох тухай өөрсдийн батламж бичгийг хадгалуулсан тэр өдрөөс хойш зургаан сарын дараа хүчин төгөлдөр болно.

2. 52 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт дурдсан улсуудаас таван улс орон соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах тухай тайлбаргүйгээр энэхүү Конвенцид гарын үсэг зурсан буюу соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах тухай өөрсдийн батламж бичгийг хадгалуулсны дараа энэхүү Конвенци дараачийн Хэлэлцэн тохирогч талуудын хувьд соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орон тухай батламж бичгийг хадгалуулсан өдрөөс хойш зургаан сарын дотор хүчин төгөлдөр болно.

3. Энэхүү Конвенцид өөрчлөлт орж хүчин төгөлдөр болсноос хойш соёрхон батлах, хүлээн зөвшөөрөх, батлах, нэгдэн орох тухай батламж бичгээ хадгалуулсан бол энэ Конвенцид өөрчлөлт орсон байдлаар нь хамаарагдсанд тооцно.

4. Өөрчлөлт орсноос хойш хадгалуулахаар өгсөн, гэхдээ орсон өөрчлөлт нь хараахан хүчин төгөлдөр болоогүй байсан бол энэ өөрчлөлт хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн өөрчлөлт орсон Конвенцид хамаарагдахаар тооцно.

54 дүгээр зүйл

Дангаараа цуцлах

1. Хэлэлцэн тохирогч аливаа тал НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл өгч энэхүү Конвенцид нэгдсэнээ цуцалж болно.

2. Нэгдсэнээ цуцлахаар Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдсэнээс хойш арван таван сарын дотор цуцлалт хүчин төгөлдөр болно.

3. Цуцлахаас өмнөх хугацаанд илгээгчийн гаалийн байгууллагын зөвшөөрсөн ТИР карней үүнд хамаарахгүй бөгөөд баталгаа гаргагч холбооны баталгаа нь энэхүү Конвенцийн заалтын дагуу барааг хариуцна.

55 дугаар зүйл

Хүчингүй болгох

Хэрвээ энэхүү Конвенци хүчин төгөлдөр болсноос хойш Хэлэлцэн тохирогч талууд болох улс орны тоо дараах арван хоёр сарын хугацаанд таваас доош буурах юм бол арван хоёр сарын хугацаа дуусахад энэхүү Конвенци хүчингүй болно.

56 дугаар бүлэг

1959 оны ТИР Конвенцийн үйл ажиллагааг

зогсоох

1. Энэхүү Конвенци хүчин төгөлдөр болсноор энэхүү Конвенцид нэгдсэн Хэлэлцэн тохирогч талуудын хувьд 1959 оны ТИР Конвенци цуцлагдана.

2. 1959 оны ТИР Конвенцийн нөхцөлөөр авто тээврийн хэрэгсэл, чингэлгийн хувьд олгогдсон зөвшөөрлийн гэрчилгээг тэдгээр авто тээврийн хэрэгсэл, чингэлэг нь анх эхлээд зөвшөөрөл авсан үүргээ үргэлжлүүлэн биелүүлж байгаа бол энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч талуудаас гаалийн битүүмжлэлтэйгээр барааг тээвэрлэх хүчин төгөлдөр хугацааны туршид болон сунгасан хугацаанд хүлээн зөвшөөрөгдөнө

57 дугаар зүйл

Маргаантай асуудлыг шийдвэрлэх

1. Хоёр буюу түүнээс дээш Хэлэлцэн тохирогч талын хооронд энэхүү Конвенцийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдсон гарсан аливаа маргаантай асуудлыг тэдний хооронд аль болохоор яриа хэлэлцээний замаар, эсвэл маргааныг таслах бусад арга хэрэгслээр шийднэ.

2. Энэхүү зүйлийн 1-д заасан арга хэрэгслээр энэхүү Конвенцийг тайлбарлах, хэрэглэхтэй холбогдон хоёр буюу түүнээс дээш Хэлэлцэн тохирогч талын хооронд гарсан аливаа маргааныг шийдвэрлэж чадахгүй бол тэдний аль нэг талын хүсэлтээр дараах байдлаар байгуулагдсан арбитрын шүүхэд хандана. Маргаанд оролцогч тал бүр арбитрчийг томилон эдгээр арбитрч нар нь өөр нэг арбитрчийг дарга болгон томилно. Хүсэлт хүлээн авснаас хойш гурван сарын дотор аль нэг тал нь арбитрчийг томилох, эсвэл арбитрч нар нь даргаа сонгох үүргээ биелүүлээгүй бол аль нэг тал нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргыг арбитрч, арбитрын шүүхийн даргаас томилж өгөхийг хүсч болно.

3. Маргаанд оролцогч талуудын хувьд хоёр дахь хэсгийн заалтын дагуу байгуулагдсан арбитрын шүүхийн шийдвэр заавал биелүүлэх шийдвэр болно.

4. Арбитрын шүүх өөрийн үйл ажиллагааны журмыг тодорхойлно.

5. Арбитрын шүүхийн шийдвэрийг олонхийн саналаар гаргана.

6. Маргаанд оролцогч талуудын хооронд шүүхийн эцсийн шийдвэрийг ойлгох хэрэгжүүлэх талаар үүсч болох саналын зөрөлдөөнийг талуудын аль нэг нь уг шийдвэрийг гаргасан арбитрын шүүхээр шийдүүлэхээр хүсэлт гаргаж болно.

58 дугаар зүйл

Тайлбар хийх

1. Энэхүү Конвенцид гарын үсэг зурах, соёрхон батлах, нэгдэн орох үедээ энэхүү Конвенцийн 57 дугаар зүйлийн 2-6 дахь хэсгийн заалтыг заавал биелүүлэх ёстой гэж үзэхгүй байгаагаа ямар ч улс орон зарлаж болно. Ийм тайлбартайгаар нэгдэж байгаа Хэлэлцэн тохирогч аливаа талын хувьд эдгээр хэсгийн заалтыг заавал биелүүлэх ёстой гэж Хэлэлцэн тохирогч бусад талууд үзэхгүй.

2. Энэ зүйлийн 1-д заасны дагуу тайлбар хийсэн Хэлэлцэн тохирогч аливаа тал НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэн тайлбар хийснээ хэзээ ч цуцалж болно.

3. Энэ зүйлийн 1-д заасан тайлбараас өөр тайлбарыг энэхүү Конвенцид хийхийг хориглоно.

59 дүгээр зүйл

Энэхүү Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах журам

1. Энэхүү зүйлд тодорхойлсон журмын дагуу Хэлэлцэн тохирогч талын саналаар энэхүү Конвенци, түүний Хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулж болно.

2. Хавсралт 8-д заасан үйл ажиллагааны дүрмийн дагуу Хэлэлцэн тохирогч бүх талуудаас бүрдсэн Захиргааны хороо энэхүү Конвенцид нэмэлт өөрчлөлт оруулах аливаа саналыг авч хэлэлцэнэ. Захиргааны хорооны хурлын үеэр авч хэлэлцэгдэн бэлтгэгдсэн, уг хуралд оролцсон гишүүдийн гуравны хоёрын саналаар батлагдсан нэмэлт өөрчлөлтийг

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Хэлэлцэн тохирогч талуудад хүлээн зөвшөөрүүлэхээр мэдэгдэнэ.

3. 60 дугаар зүйлд зааснаас бусад, өмнөх хэсгийн дагуу мэдэгдсэн санал болгосон аливаа нэмэлт өөрчлөлт нь НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад санал болгосон өөрчлөлтийн талаар хэлэлцэн тохирогч талууд болох улс орнууд ямар нэг өөр байр суурь уг нэмэлт өөрчлөлтийг мэдэгдсэнээс хойш 12 сарын хугацаанд илэрхийлээгүй бол Хэлэлцэн тохирогч нийт талуудын хувьд хүчин төгөлдөр болно.

4. Энэхүү зүйлийн 3-т заасны дагуу санал болгосон нэмэлт өөрчлөлтийг эсэргүүцсэн бол нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн эсвэл нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсон гэж үзэхгүй.

60 дугаар зүйл

Хавсралт 1, 2, 3, 4, 5, 6, 7-д нэмэлт өөрчлөлт

оруулах тусгай журам

1. Захиргааны хорооноос тэр үед нь урьдчилсан цаг хугацааг зааж өгч тавны нэг буюу Хэлэлцэн тохирогч талууд болох таван улсаас цөөн улс НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад нэмэлт өөрчлөлт оруулахын эсрэг саналтай байгаагаа мэдэгдээгүй бол 59 дүгээр зүйлийн 1, 2-т заасны дагуу авч үзэж Хавсралт 1, 2, 3, 4, 5, 6, 7-д оруулахаар санал болгосон нэмэлт өөрчлөлт нь Захиргааны хорооноос уг нэмэлт өөрчлөлтийг баталсан өдөр тодорхойлсон өдрөөс хүчин төгөлдөр болно.

2. Дээрх 1 дүгээр хэсэгт заасан журмын дагуу батлагдсан аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болсноор Хэлэлцэн тохирогч нийт талуудын хувьд уг нэмэлт өөрчлөлтөд хамааралтай өмнөх заалтуудыг хүчингүй болгон орлоно.

61 дүгээр зүйл

Хүсэлт, мэдэгдэл болон эсрэг санал

НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга энэхүү Конвенцийн 52 дугаар зүйлийн 1-д дурдсан Хэлэлцэн тохирогч бүх талууд, бүх улс оронд дээрх 59 болон 60 дугаар зүйлийн талаар болон аливаа нэмэлт өөрчлөлт хүчин төгөлдөр болох өдрийн тухайд аливаа хүсэлт, мэдэгдэл, эсрэг саналын талаар мэдэгдэнэ.

62 дугаар зүйл

Хяналтын бага хурал

1. Хэлэлцэн тохирогч тал болох аливаа улс орон НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад мэдэгдэл хүргүүлж энэхүү Конвенцийг дахин хянах зорилгоор бага хурал хуралдуулах талаар хүсэлт гаргаж болно.

2. 52 дугаар зүйлийн 1-д заагдсаны дагуу Хэлэлцэн тохирогч бүх талууд, бүх улс орон хяналтын бага хурлыг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга хуралдуулах бөгөөд Ерөнхий нарийн бичгийн даргаас мэдэгдсэнээс хойш зургаан сарын дотор Хэлэлцэн тохирогч талуудын дөрөвний нэгээс доошгүй нь хүсэлтийг хүлээн зөвшөөрч байгаагаа мэдэгдвэл хуралдуулна.

3. 52 дугаар рүйлийн 1-д хамаарах Хэлэлцэн тохирогч бүх талууд болон бүх улс орон уригдан оролцох хяналтын бага хурлыг Захиргааны хорооны хүсэлт гарган мэдэгдсэнээр НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга хуралдуулна. Захиргааны хороо тус хороонд одоо байгаа болон санал өгөх гишүүдийн олонх нь зөвшөөрсөн тохиолдолд хүсэлт гаргана.

4. Энэхүү зүйлийн 1, 3-т заасны дагуу бага хурлыг хуралдуулбал НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Хэлэлцэн тохирогч бүх талуудыг уг бага хурлаар ямар асуудлыг хэлэлцэх саналтай байгаагаа гурван сарын дотор гаргаж өгөхийг хүснэ. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга бага хурал болохоос наад зах нь гурван сарын өмнө эдгээр саналыг бага хурлаар хэлэлцэх асуудлын хамтаар хэлэлцэн тохирогч бүх талуудад хүргүүлнэ.

63 дугаар зүйл

Мэдэгдэл

61, 62 дугаар зүйлд заасан мэдэгдэл, мэдээлэл хүргүүлэхээс гадна НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга 52 дугаар зүйлд хамаарах бүх улс оронд дараах зүйлийг мэдэгдэнэ:

(a) 52 дугаар рүйлийн дагуу гарын үсэг зурсан, соёрхон баталсан, хүлээн зөвшөөрсөн, баталсан, нэгдсэн орсон тухай

(b) 53 дугаар зүйлийн дагуу энэхүү Конвенци хүчин төгөлдөр болсон он, сар, өдөр

(c) 54 дүгээр зүйлийн дагуу дангаар цуцалсан тухай,

(d) 55 дугаар зүйлийн дагуу энэхүү Конвенцийг хүчингүй болсон тухай,

(e) 58 дугаар зүйлийн дагуу тайлбар хийсэн тухай

64 дүгээр зүйл

Адил хүчинтэй эх бичвэр

1976 оны 12 дугаар сарын 31-нээс хойш энэхүү Конвенцийн эх хувийг НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн даргад хадгалуулан Хэлэлцэн тохирогч тал бүр болон 52 дугаар зүйлийн 1-д хамаарах Хэлэлцэн тохирогч тал бүх улс орнуудад НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга баталгаажуулсан хуулбарыг хүргүүлнэ.

Дээрхийг гэрчилж, өөрсдийн бүрэн эрхийнхээ дагуу дор гарын үсэг зурагсад энэхүү Конвенцид гарын үсэг зурав.

Нэгэн мянга есөн зуун далан таван оны арван нэгдүгээр сарын арван дөрөвний өдөр, Женев хотноо англи, франц, орос хэлээр эх бичвэр тус бүр нь адил хүчинтэй байхаар нэг хувь үйлдсэн болно.

1975 ТИР КОНВЕНЦИЙН ХАВСРАЛТУУД

Хавсралт 1

ТИР КАРНЕЙГИЙН ЗАГВАР ХУВИЛБАР 1

1. ТИР карнейн хавтасны 1 дүгээр хуудасны хүснэгтэд байгаа үгсийг англи, франц хэлээр, бусад хуудсыг франц хэлээр хэвлэнэ. "ТИР карнейг хэрэглэх дүрэм" хавтасны 2 дугаар хуудсан дээр франц хэлээр, 3 дугаар хуудсан дээр англи хэлээр бичигдэнэ. Хуудасны ар талд "Баталгаажсан мэдээ"-г франц хэлнээс бусад аль тохиромжтой хэлээр бичнэ.

2. Бүсийн хэмжээний баталгааны сүлжээнд явагдах ТИР үйл ажиллагаанд хэрэглэх карнейгийн 1 дүгээр хуудаснаас бусад хуудсыг НҮБ-ын албан ёсны аль нэг хэлээр хэвлэж болох бөгөөд 1 дүгээр хуудсыг зөвхөн англи, франц хэлээр хэвлэнэ. "ТИР карнейг хэрэглэх дүрэм"-ийг 2 дугаар хуудас НҮБ-ын албан ёсны хэлээр, 3 дугаар хуудас англи, франц хэлээр хэвлэгдэнэ.

ХУВИЛБАР 2

2. Согтууруулах ундаа болон тамхины тээвэрлэлтийн хувьд Баталгаа гаргагч холбооноос нэмэлт баталгааг гаргуулж болох бөгөөд Хавсралт 6 болон Тайлбар бичиг 0.8.3-ын дагуу гаалийн байгууллага нь СОГТУУРУУЛАХ УНДАА/ТАМХИ ("TOBACCO/ALCOHOL", "TAVAC/ALCOOL") гэсэн тэмдгийг ТИР карнейгийн хуудсууд болон бүх ваучер дээр тавьсан байхыг шаардаж болно. Мөн эдгээр карнейгийн согтууруулах ундаа болон тамхины төрлийн тухай нарийвчилсан мэдээллийг наад зах нь англи, франц хэл дээр хийх бөгөөд батлагдсан карнейн хувьд 2 дугаар хуудсанд нэмэлт хийж хавсаргана.

Тайлбар бичиг

1.10 (с) ТИР карнейг хэрэглэх дүрэм

Барааны манифестэд хавсаргасан ачааны жагсаалт

ТИР Карнейг хэрэглэх дүрмийн 10 (с) нь тээвэрлэж байгаа бүх барааг ачааны манифестэд бичих хангалттай зай байсан ч ачааны жагсаалтыг ТИР карнейд хавсаргахыг зөвшөөрдөг. Гэхдээ энэ нь зөвхөн ачааны жагсаалт нь барааны манифестэд шаардлагатай мэдээллээс бүрдсэн гаргадахуйц, хялбар танигдах байхаас гадна дүрмийн 10(с)-ийн бүх заалтуудыг мөрдөж байгаа нөхцөлд зөвшөөрөгдөнө.

Хавсралт 2

ГААЛИЙН БИТҮҮМЖЛЭЛТЭЙГЭЭР ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД
ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙХИЙГ ЗӨВШӨӨРЧ БОЛОХ АВТО ТЭЭВРИЙН
ХЭРЭГСЭЛД ТАВИГДАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛҮҮДИЙН ТУХАЙ

ЖУРАМ

1 дүгээр зүйл

Үндсэн зарчмууд

Барааг гаалийн битүүмжлэлтэйгээр олон улсын хэмжээнд тээвэрлэх зөвшөөрлийг зөвхөн дараах байдлаар зохион бүтээсэн болон тоногосон ачааны тэвш бүхий тээврийн хэрэгсэлд олгоно.

(a) Гаалийн лац, ломбыг эвдэлгүйгээр, эсхүл эвдсэн ул мөр үлдээхгүйгээр тээврийн хэрэгслийн битүүмжилсэн хэсгээс бараа авах, түүнд бараа хийх боломжгүй байх,

(b) Гаалийн лац, ломбыг хялбар аргаар, жинхэнэ ёсоор нь тавих боломжтой байх,

(c) Барааг нуун далдлах нууц зай завсаргүй байх,

(d) Бараа байрлуулах бүх хэсэгт гаалийн үзлэг хийхээр нэвтрэх боломжтой байх.

2 дугаар зүйл

Ачааны зориулалтын хэсгийн бүтэц

1. Энэхүү журмын 1 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангах үүднээс:

(a) Ачааны зориулалтын хэсгийн бүрдэл хэсгүүд (хана, шал, хаалга, дээвэр, тулгуур багана, хүрээ, хөндөл гэх мэт)-ийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр гаднаас нь авч, солих боломжгүй зүйлээр, эсвэл илэрхий ул мөр үлдээхгүйгээр өөрчлөх боломжгүй бүтэц бий болгох аргаар угсарсан байна. Хана, шал, хаалга болон дээвэр нь янз бүрийн хэсгүүдээр хийгдсэн бол эдгээр нь дээрх шаардлагыг адилхан хангасан бөгөөдхангалттай бат бөх байна.

Тайлбар бичиг

2.2.1 (a) Бүрдэл хэсгийг угсрах

(a) Хэрэв холбох хэрэгсэл (тавтай хадаас, шураг, боолт, гайк гэх мэт) хэрэглэх бол хангалттай тооны тийм хэрэгслийг бүрдэл хэсгүүдийн гаднаас нь углаж, дотроо цухуйтал нь нэвт шургуулж, дотроос нь бэхэлнэ. (тавлана, гагнана, бүрээслэнэ, эсвэл эрэгдэж эргийг цохиж хэвлүүрдэх буюу гагнана). Гэвч ердийн тавтай хадаас (өөрөөр хэлбэл, бүрдэл хэсгүүдийн хоёр талд тавьдаг тав)-ыг дотроос нь углаж болно. Дээрхийг үл харгалзан, тэвшний шалыг дотроо өөрөө тасрагч шураг, өөрөө нүхлэгч тавтай хадаас, эсвэл дэлбэрэлт болон хийн шахуургаар бууддаг тавтай хадаасаар бэхэлж болно. Хэрэв бэхлэлтийг дотроос нь хийсэн бөгөөд тэр нь шал, доодох металл хөндийг тэгш өнцгөөр нэвтрэн гарсан бол дотроо өөрөө тасрагч шураг хэрэглэснээс бусад тохиолдолд гадагш гарсан зарим үзүүрийг хөндлийн гадна талтай тэгшилсэн байх буюу түүнтэй хамт гагнасан байна.

(b) Энэхүү тайлбарын (a) заалтын шаардлагыг хангах үүднээс холболтын ямар хэрэгсэл, хичнээн тоогоор хэрэглэхийг эрх бүхий байгууллага тодорхойлно, ингэхдээ тийнхүү угсарсан бүрдэл хэсгүүдийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр шилжүүлэн байрлуулах, солих боломжгүй байх нөхцөлийг хангана. Холболтын бусад хэрэгслийг сонгох, байршуулахад аливаа хязгаарлалт байхгүй.

(c) Илэрхий ул мөр үлдээхгүйгээр авч, сольж болох өөрөөр хэлбэл, угсрах бүрдэл хэсгүүдийн хоёр талаас хийж болох холболтын хэрэгсэл хэрэглэхийг энэхүү тайлбарын (a) заалт зөвшөөрөхгүй. Тийм хэрэгслийн жишээ гэвэл суугагшдаг тавтай хадаас, mg.uoa хадаас зэрэг болно.

(d) Дээр заасан угсралтын аргуудыг хэрэв тэдгээр нь тухайн тээврийн хэрэгслийн техникийн шаардлагад нийцэж байвал тээврийн тусгай хэрэгсэлд, тухайлбал тусгаарлагчтай, хөргөгчтэй, мөн түүнчлэн цистернтэй тээврийн хэрэгсэлд хэрэглэнэ. Хэрэв техникийн шалтгаанаар, бүрдэл хэсгүүдийг энэхүү Тайлбар бичгийн (a)-д заасан аргаар холбох боломжгүй бол тэдгээрийг энэхүү тайлбарын (c)-д заасан хэрэгслээр холбож болно. Гэхдээ ханын дотроос нь хийсэн хэрэгсэлд гаднаас нь хүрэх боломжгүй байх ёстой.

(b) хаалга болон хаалтын бусад бүх хэрэгсэл (хашлага, цоргоны хаалт, нээлхийний таг гэх мэт) нь гаалийн лац, ломбо тавих хэрэгсэлтэй байна. Уг хэрэгслийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр тээврийн хэрэгслийн гадна талаас авч, солих боломжгүй байх эсвэл уг хэрэгсэл нь гаалийн лац, ломбыг эвдэлгүйгээр хаалга буюу бэхэлгээг онгойлгож болохооргүй байх ёстой. Гаалийн лац ломбо нь зохих ёсоор хамгаалагдсан байна. Дээвэр нь онгойдог байхыг зөвшөөрнө.

Тайлбар бичиг

(b) Хаалга болон хаалтын бусад систем

(a) Гаалийн лац, ломбо тавих хэрэгсэл нь:

(b) Гагнагдсан эсвэл Тайлбар бичгийн 2.2.1 (a)-ийн (a)-д заасантай тохирох хоёроос доошгүй холболтын хэрэгслээр тогтоогдсон байх ёстой,

(i) ачааны тэвхийг хааж, лацдаж ломбодсон үед илэрхий мөр үлдээлгүйгээр уг хэрэгслийг салгаж болохооргүйгээр зохион бүтээгдсэн байх ёстой,

Уг хэрэгсэл нь бас:

(ii) 11-ээс доошгүй мм-ийн диаметртэй нүхнүүдтэй эсвэл багаар бодоход 11 мм-ийн урттай, 3 мм-ийн өргөнтэй цоорхойнуудтай байх ёстой, мөн

(iii) ямарч төрлийн лац, ломбо тавьсан адилхан найдвартай байх ёстой.

(b) Дүүжин хаалга зэргийг тогтоох төрөл бүрийн нугас (ухархайн нугас, гогцоот нугас, хадааст нугас) болон бусад хэрэгслийг энэхүү тайлбарын (a)-ийн (i), (ii)-т заасан шаардлагад нийцэхээр найдвартай хийсэн байна. Түүнээс гадна тийм хэрэгслийн янз бүрийн бүрдэл хэсгүүд (жишээлбэл, нугасны нуруу, гол хадаас, холболт) нь ачааны тэвшний гаалийн үүднээс баталгаатай байх байдлыг хангахын зэрэгцээ уг тэвхийг хааж, лацдаж, ломбодсоны дараа илэрхий ул мөр үлдээлгүйгээр салгах, задлах боломжгүй байна (Хавсралт 6-д зүүсэн Зураг 1a-г үз). Гэвч гаалийн лац, ломбо тавих хэрэгсэл нь хаалга буюу түүнтэй ижилтгэх зүйлийг хааж, лацдаж, ломбодсоны дараа гаднаас нь хүрэх боломжгүй бол илэрхий ул мөр үлдээлгүйгээр түүнийг нугас буюу түүнтэй ижилтгэх хэрэгслээс салгаж болохгүй байхад хангалттай. Хэрэв хаалга буюу хаалтын хэрэгсэл нь хоёроос илүү нугастай бол хаалганы зөвхөн хоёр захад ойрхон байгаа хоёр нугасыг дээрх (a) заалтын (i), (ii)-т заасан шаардлагын дагуу тогтоосон байн

(с) Ялангуяа, тусгаарлагч бүхий ачааны тэвштэй тээврийн хэрэгсэл байх тохиолдолд гаалийн лац, ломбо тавих хэрэгсэл, нугас болон бусад тогтоогчийг салгаж авбал тухайн тэвшний дотогш эсвэл бараа нуун далдалж болох бусад орон зайд нэвтрэх боломжтой тул тэдгээрийг тийм ачааны тэвшний хаалганд дараах системийг ашиглан тогтооно:

(i) Гаднаас нь оруулах боловч Тайлбарын 2.2.1 (а)-д заасан шаардлага өөрөөр хангахааргүй эрэг эсвэл шургаар дараах нөхцөлтэйгээр:

- эрэг шурагны үзүүрийг хаалганы давхарга буюу давхаргуудын цаана бэхэлсэн таслагч ялтас буюу түүнтэй ижилтгэх хэрэгсэлд тогтооно, мөн

-шаардлагатай тооны эрэг буюу шурагны толгойг гаалийн лац, ломбо тавих хэрэгсэл, нугас гэх мэт зүйлтэй гагнаж, хэвийн нь алдагдуулж, мэдэгдэхүйц шинж тэмдэг үлдээлгүйгээр эрэг, шургийг эвдэж салгах боломжгүй болно. (Хавсралт 6-д зүүсэн Зураг 1-г үз)

(ii) Тусгаарлагчтай хаалганы дотор талаас нь оруулдаг бэхлэгч хэрэгслээр дараах нөхцөлтэйгээр:

Уг хэрэгслийн бэхлэгч хадаас болон хамгаалалтын даравчийг хийн буюу шингэн шахуургын тоног төхөөрөмжөөр угсарч, хаалганы гадна давхарга болон тусгаарлагч хоёрын дунд байрлуулсан ялтас буюу түүнтэй ижилтгэх хэрэгслийн ард тогтооно, бэхлэгч хадаасны толгойд ачааны тэвшний дотор талаас хүрэх боломжгүй болгоно, мөн хангалттай тооны хамгаалалтын даравч, бэхлэгч хадаасыг хооронд нь гагнаж, уг хэрэгслийг мэдэгдэхүйц шинж тэмдэг үлдээлгүйгээр салгах боломжгүй болгоно. (Хавсралт 6-д зүүсэн зураг 5-ыг үз)

“Тусгаарлагч бүхий тэвш ачааны тэвш” гэдэгт хөргөгчтэй болон изотермийн үйлчлэлтэй тэвш хамаарна.

(d) Олон тооны цорго, цоргоны хаалт, нээлхийний таг, хашлага болон тэдгээртэй адилтгах хаалттай тээврийн хэрэгслийг хамгийн цөөн тооны гаалийн лац, ломбо тавих боломжтой болгоно. Энэ зорилгоор зэрэгцээ байрласан хаалтуудыг зөвхөн гаалийн лац, ломбо тавихаар нэг хэрэгслээр хооронд нь холбоно эсвэл ижил зориулалттай нэг хаалтаар хаана.

(e) Онгойдог дээвэр бүхий тээврийн хэрэгслийг хамгийн цөөн тооны гаалийн лац, ломбо тавих боломжтой болгосон байна.

(с) агааржуулагчийн болон бохирын нүхэнд тээврийн хэрэгслийн дотор талд орох боломжийг хаах хэрэгсэл байрлуулсан байна. Уг хэрэгслийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр гаднаас нь авч, солих боломжгүй хийцтэй байна.

Тайлбар бичиг

2.2.1 (с)-1 Агааржуулагчийн нүх

(a) Энэ нь зарчмын хувьд 400 мм-ээс хэтрэхгүй хэмжээтэй байна.

(b) Ачааны хэсэгт шууд орох боломжтой нүхийг дараах байдлаар хаана:

(i) төмөр утсан тор буюу олон нүхтэй сараалжин хаалтаар (аль ч тохиолдолд нүхнүүдийн хамгийн том нь 3 мм-ийн хэмжээтэй байна) хааж, гагнасан төмөр ханаар давхар хамгаална. (Нүхнүүдийн хамгийн том нь 10 мм-ийн хэмжээтэй байна)

(ii) нэг нүхтэй бөгөөд хангалттай бөх чанарын төмөр хаалтаар хаах (нүхний хамгийн том нь 3 мм-ийн хэмжээтэй, хаалтын зузаан нь багаар бодоход 1 мм байна)

(c) ачааны тэвшинд шууд орох боломжгүй нүх (жишээлбэл, тохой хэлбэртэй эсвэл мухар системийн нүх)-ийг (b)-д заасан хэрэгслээр хаах боловч тагны нүх нь 10 мм-ийн хэмжээтэй (төмөр утсан тор буюу төмөр хаалтын хувьд) байна.

(d) бүрээсэнд эдгээр нүхийг гаргасан бол, энхүү Тайлбар бичгийн (b)-д заасан хэрэгслийг зарчмын хувьд тохируулан хийж өгнө. Гэвч, нүхтэй металл хаалтын хэлбэртэй хаах хэрэгслийг гадна нь төмөр утас буюу бусад торыг дотор нь байрлуулж болно.

(e) шаардлагатай хэмжээ бүхий нүхнүүдтэй бөгөөд нүдэнд үзэгдэхээргүй байдлаар эвдэж нүхийг нь томруулах боломжгүй бөх бат материалтай бол металл бус нэг төрлийн хэрэгслийг ашиглаж болно. Түүнээс гадна агааржуулагч хэрэгслийг бүрээсний зөвхөн нэг талаас авч солих боломжгүй байвал зохино.

(f) агааржуулагчийн нүхийг хамгаалалтын хэрэгслээр хааж болно. Түүнийг уг нүхэнд гаалийн үзлэг хийх боломжтой байдлаар бүрээсэнд тогтооно. Тэрхүү хамгаалалтын хэрэгслийг агааржуулагчийн нүхний хаалтаас 5 см-ээс доошгүй зайтай бүрээсэнд тогтооно.

Тайлбар бичиг

2.2.1 (c)-2 Бохир усны нүх

(a) Энэ нь зарчмын хувьд 35 мм-ээс томгүй хэмжээтэй байна.

(b) Ачааны хэсэгт шууд орох боломжтой нүхийг агааржуулагчийн нүхний тухай Тайлбар бичгийн 2.2.1-ийн (b)-д заасан хэрэгслээр тоноглоно.

(c) Бохир усны нүх ачааны хэсэгт орох боломжгүй үед эдгээр нүх нь ачааны хэсгийн дотор талаас амархан хүрч болох дефлекторын найдвартай системээр тоноглогдсон тохиолдолд энэхүү Тайлбар бичгийн (b)-д заасан хэрэгсэл шаардагдахгүй.

2. Энэхүү журмын 1 дүгээр рүйлийн (c) заалтыг үл харгалзан, практик шаардлагын үүднээс хоосон зай (жишээлбэл, давхар хананы хооронд) бүхий тээврийн хэрэгслийн бүрдэл хэсэг байж болно. Уг зайд бараа нуун далдлах боломж олгохгүй байх үүднээс:

- (i) Хэрэв дотуур хана нь шалнаас дээвэр хүртэлх нийт өндөртэй тэнцүү эсвэл бусад тохиолдолд, уг хана болон гадуур хананы хоорондох зай ямарч нүх сүвгүй битүү байх тохиолдолд ачааны тэвшний дотуур ханыг илэрхий ул мөр үлдээлгүйгээр салгаж, солих боломжгүй байдлаар хийгдсэн байна, мөн
- (ii) Хэрэв дотуур хана нь нийт өндрөөс бага бөгөөд уг хана, гадуур хананы хооронд зай ямарч нүх сүвгүй битүү биш, мөн ачааны тэвш нь зай завсартай байх бусад бүх тохиолдолд тийм зай завсрын тоог аль болох бага болгож, тэдгээрт гаалийн үзлэг хийх боломжтой байлгана.

3. Ачааны тэвшинд цонх хийхийг зөвшөөрөх бөгөөд тэдгээр нь маш бат бөх материалаар хийгдэж, илэрхий ул мөр үлдээхгүйгээр гадна талаас нь хөдөлгөх, солих боломжгүй байх ёстой. Шил хийсэн байж болох боловч хамгаалалтын шилнээс бусад шилийг хэрэглэхэд цонх нь гадна талаас нь хөдөлгөх боломжгүй металл сараалжаар бүрхэгдсэн байх бөгөөд сараалжны нүхний хэмжээ нь 10 мм-ээс хэтрэхгүй байна.

Тайлбар бичиг

2.2.3 Аюулгүй шил

Хэрэв тээврийн хэрэгслийг ашиглах жирийн нөхцөлд ердийн байдлаар тохиолдох аливаа хүчин зүйлийн нөлөөгөөр эвдэрч гэмтэх аюулгүй шил гэж үзнэ. Уг шил нь түүний аюулгүй шил болохыг гэрчилсэн таних тэмдэгдэгтэй байна.

4. Шал нь тосолгоо, засвар үйлчилгээ хийх болон элсний сав дүүргэх зэрэг техникийн зориулалттай онгорхойтой байж болно. Энэ тохиолдолд уг онгорхой нь ачааны тэвшинд гаднаас орох боломжгүй байдлаар тогтоосон тагтай байна.

3 дугаар зүйл

Бүрээстэй тээврийн хэрэгсэл

1. Энэхүү журмын 1, 2 дугаар зүйлүүдийн заалтуудыг хэрэв тохирохоор бол бүрээстэй тээврийн хэрэгсэлд мөрдөнө. Түүнээс гадна эдгээр тээврийн хэрэгсэл нь энэхүү рүйлийн заалтуудад тохирсон байна.

2. Бүрээс нь бөх бат зотон даавуу, эсвэл бөх бат бөгөөд сунадаггүй хуванцар буюу резинэн хучлагатай эдийн аль нэг байж болно. Бүрээс нь муудаагүй байхын зэрэгцээ хаах хэрэгслийг нэгэнт битүүмжилсэн бол илэрхий ул мөр үлдээхгүйгээр ачааны хэсэгт нэвтрэн орох боломжгүй байхаар хийгдсэн байна.

3. Хэрэв бүрээс нь хэд хэдэн хэсгээс бүрдсэн бол тэдгээр хэсгүүдийн захуудыг зөрүүлэн нугалж, 15 мм-ээс доошгүй зайтай давхар оёдол хийсэн байна. Уг давхар оёдлыг энэхүү журамд хавсаргасан бүдүүвч зураг 1-д үзүүлсний дагуу хийнэ, гэхдээ бүрээсний хэсэг (жишээлбэл, даруулга, бөхөлгөөтэй булан гэх мэт)-ийг дээрх байдлаар зүйж хийх боломжгүй бөгөөд энэ тохиолдолд дээд талын хэсгийг нугалж, энэхүү журамд хавсаргасан бүдүүвч зураг 2 буюу 2(a)-д үзүүлсний дагуу оёдол хийнэ. Давхар оёдлын нэг нь зөвхөн дотроосоо үзэгдэхүйц байх бөгөөд түүний утасны өнгө нь бүрээсний өнгө болон нөгөө оёдлын утасны өнгөнөөс өөр өнгөтэй байна. Бүх оёдлыг машинаар хийсэн байна.

Тайлбар бичиг

2.3.3 Хэд хэдэн зүйдэл бүхий бүрээс

(a) Бүрээсний зүйлүүд нь 2 дугаар Хавсралтын 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтад тохирсон өөр өөр материалаар хийгдсэн байж болно.

(b) Зүйдлүүдийг 2 дугаар Хавсралтын 3 дугаар рүйлийн шаардлагад нийцүүлэн хийсэн бол бүрээс нь аюулгүй байдлыг зохих ёсоор хангасан ямар ч зохилдолгоотой зүйдэлтэй байж болно.

4. Хэрэв бүрээсийг хуванцар бүрхүүлтэй эдээр хийсэн бөгөөд тэр нь хэд хэдэн зүйдэлтэй бол уг зүйдлүүдийг энэхүү журамд хавсаргасан бүдүүвч зураг 3-д үзүүлсний дагуу хайлуулж наасан байж болно. Хэсгүүдийн захыг 15 мм-ээс доошгүйгээр хэмжээтэй зөрүүлсэн байна. Хэсгүүдийг хооронд нь зөрүүлсэн өргөний хэмжээгээр хамтад нь хайлуулж наасан байна. Бүрээсийн гадна хэсгийн захыг 7 мм-ээс багагүй өргөнтэй хуванцар туузаар дарж, мөн адил хайлуулж наана. Хуванцар тууз болон түүний хоёр талаас 3 мм-ээс доогүй бүрээсийн хэсгийг тодорхой дүрслэл бүхий нэг загварын мөр гаргаж тамгална. Хэсгүүдийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр салгаж, буцаан наах боломжгүй байдлаар хайлуулж наасан байна.

5. Засварыг энэхүү журамд зүүсэн зураг 4-д үзүүлсэн аргатай нийцүүлэн хийнэ: захыг зөрүүлэн нугалж, 15 мм-ээс доошгүй зайтай, нүдэнд үзэгдэх давхар оёогоор хамтад нь оёно, дотроос нь үзэгдэх утасны өнгө гаднаас нь үзэгдэх утасны өнгө болон бүрээсийн өнгөнөөс өөр байна, бүх оёдлыг машинаар хийсэн байна. Хэрэв бүрээс нь захиараа гэмтсэн бол гэмтсэн хэсэгт нөхөөс тавьж бүрээсийг засах бөгөөд оёдлыг энэхүү зүйлийн 3 дугаар хэсэг болон энэхүү журамд зүүсэн зураг 1-д үзүүлсний дагуу хийж гүйцэтгэнэ. Хэрэв бүрээс нь хуванцар хучлагатай эд бол

түүнийг энэхүү зүйлийн 4 дэх хэсэгт заасан аргаар засна. Гэвч энэ тохиолдолд, хуванцар туузыг бүрээсний хоёр талд наах бөгөөд нөхөөсийг бүрээсний дотор талд байрлуулсан байна.

б.Бүрээсийг тээврийн хэрэгсэлд тогтоохдоо энэхүү журмын 1 дүгээр зүйлийн (а), (b)-д заасан нөхцөлүүдийг хатуу баримтална. Дараах системүүдийг хэрэглэж болно. Үүнд:

(а) Бүрээсийг дараах зүйлээр бэхэлнэ:

- (i) ачааны тэвшинд тогтоосон металл цагирагаар,
- (ii) бүрээсний захаар гаргасан нүхээр, мөн
- (iii) бүх цагирган дундуур орж, бүрээсэн дээгүүр гүйн, гаднаасаа бүхэлдээ харагдах бэхэлгээгээр,

Тухайн тээврийн хэрэгслийн хийц нь өөрөө ачааны тэвшинд нэвтрэх бүх боломжийг хаасан байхаас бусад тохиолдолд бүрээс нь бэхлэлтийн цагирагны төвөөс 250 мм-ээс доошгүй хэмжээгээр чингэлгийн цул хэсгийг давсан байна.

Тайлбар бичиг

2.3.6 (а) -1 Гүйдэг цагираг бүхий тээврийн хэрэгсэл

Тээврийн хэрэгсэлд тогтоосон металл хөндлөвчийн дагуу гүйдэг бэхлэлтийн металл цагирагийг энэхүү хэсгийн зорилгоор дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө (6 дугаар Хавсралтад зүүсэн Зураг 2-ыг үз):

(а) хөндлөвчийг хооронд нь 60 см-ээс илүүгүй зайтай, илэрхий ул мөр үлдээлгүйгээр тэдгээрийг салгаж солих боломжгүйгээр тээврийн хэрэгсэлд тогтоосон байна,

(b) цагираг нь хос нүхтэй буюу гол хөндлөвчтэй, гагнуургүйгээр цулгай хийгдсэн байна, мөн бүрээсийг тээврийн хэрэгсэлд тогтоохдоо энэхүү Конвенцийн 2 дугаар Хавсралтын 1 дүгээр рүйлийн (а)-д заасан нөхцөлийг хатуу баримтална.

2.3.6 (а)-2 Эргэдэг цагираг бүхий тээврийн хэрэгсэл

Тээврийн хэрэгсэлд бэхэлсэн металл халхавчны дотор эргэлддэг металл цагирагаийг энэхүү хэсгийн зорилгоор дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө (6 дугаар Хавсралтад зүүсэн Зураг 2а-г үз):

(а) Халхавч бүрийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр салгаж, солих боломжгүйгээр тээврийн хэрэгсэлд тогтоосон, мөн

(b) Халхавчийн пүршийг хонх хэлбэрийн металл тагаар битүүлж хаасан байна.

(b) Хэрэв бүрээсний аль нэг ирмэг чингэлэгт байнгын бэхэлгээтэй байна гэвэл хоёр гадаргыг нь хооронд нь нийлүүлж бөх бат хэрэгслээр тогтооно.

Тайлбар бичиг

2.3.6 (b) Байнгын бэхэлгээтэй бүрээс

Хэрэв бүрээсний нэг буюу хэд хэдэн ирмэгийг тээврийн хэрэгслийн их биед байнгын байдалтай бэхэлсэн бол 6 дугаар хавсралтын Тайлбар 2.2.1 (а)-ын (а) заалтын шаардлагад нийцсэн холбох хэрэгслийг ашиглан, тээврийн хэрэгслийн их биед бэхэлсэн нэг буюу хэд хэдэн гонзгой металлаар буюу тохирох өөр бусад металлаар бүрээсийг тогтоосон байна.

(с) Хэрэв бүрээс түгжин бэхлэх систем ашигласан бол тэр нь түгжигдсэн байх тохиолдолд бүрээсийг ачааны тэвшний гадна талтай шахаж хавчсан байна. (Зураг 6-г үз)

7. Бүрээсийг зохих бүтцийг (багана, хана, нум, хөндөл гэх мэт) ашиглан тулгаж босгосон байна.

8. Цагирагнуудын хоорондын зай болон нүхнүүдийн хоорондын зай нь 200 мм-ээс илүүгүй байна. Хэрэв тээврийн хэрэгслийн хийц болон бүрээс нь ачааны тэвшинд нэвтэрч орох боломжийг хаасан бол уг зай нь арай хол байж болох боловч баганын хоёр талд байгаа цагирагнууд болон бүрээсний нүхнүүд хоорондоо 300 мм-ээс холгүй байна. Бүрээсний нүхнүүдийг бөхөлсөн байна.

Тайлбар бичиг

2.3.8 Хэрэв цагирагнууд хажуу хашлаганд зүүлттэй бөгөөд бүрээсний нүхнүүд зууван хэлбэртэй, дөнгөж цагираг багтах жижигхэн зайтай бол 200 мм-ээс илүү боловч 300 мм-ээс хэтрэхгүй багана давсан зайг хүлээн зөвшөөрнө.

9. Дараах бэхэлгээний төрлийг ашиглана:

(a) 3 мм-ээс багагүй диаметртэй ган утсан татлага эсвэл

(b) сунадаггүй тунгалаг бүрхүүлтэй, 8 мм-ээс багагүй диаметртэй олсон буюу сизаль татлага,

Төмөр утсан татлага нь сунадаггүй тунгалаг хуванцар бүрхүүлтэй байж болно.

Бусад тохиолдолд энэхүү рүйлийн 6 (a) заалттай нийцэж буй хийц системийн раманд бүрээсийг тогтоох шаардлагатай бол бэхэлгээний зүйлээр бүслүүр (ремень) хэрэглэж болно. (тийм хийц системийн жишээг энэхүү Хавсралтад Зураг 7-д үзүүлэв) Бүслүүр нь хийсэн материал, хэмжээ, хэлбэрийн хувьд 11 (a) (111)-д заасан шаардлагад нийцэж байвал зохино.

Тайлбар бичиг

2.3.9 Энэхүү заалтын зорилгоор, хөвөн эдлэлээр хийсэн голтой, гадуураа дөрвөөс доошгүй хэлхээ ган утсан бүрээстэй татлагыг хэрэв тэр нь (хэрэв тунгалаг хуванцар бүрхүүлтэй бол түүнийг үл оролцуулан) 3 мм-ээс багагүй диаметртэй бол зөвшөөрч болно.

10. Татлага бүр залгаасгүй байхын зэрэгцээ хоёр үзүүртэй хатуу металлээр хийсэн төгсгөлтэй байна. Хоёр металл төгсгөлийг бэхлэх зүйлд тавтай хөндий хадаас орох бөгөөд түүгээр татлагыг нэвт цоолж гаалийн лац, ломбоны утас буюу гогцоо орох боломжийг бүрдүүлнэ. Татлага нь тавтай хөндий хадаасны хоёр талаар ил харагдаж, уг татлага, залгаасгүй болохыг мэдэх боломжтой байна. (Энэхүү журамд зүүсэн Зураг 5-ыг үз)

11. Ачаа ачих, буулгах зориулалттай бүрээсийн онгорхой дээр 2 гадаргуу нь нийлэх ёстой. Дараах системийг ашиглаж болно:

(a) Бүрээсний хоёр ирмэгийг зохих ёсоор зөрүүлсэн байна. Түүнийг дараах зүйлээр бэхэлнэ:

- (i) энэхүү зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу оёсон буюу гагнасан даруулгаар,
- (ii) энэхүү зүйлийн 8 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангасан цагираг болон бүрээсний нүхээр, цагирагийг металлээр хийсэн байна, мөн
- (iii) зохих материалаар хийсэн, залгаасгүй, сунадаггүй, 20 мм-ээс багагүй өргөнтэй, 3 мм-ээс багагүй зузаантай бүслүүрээр. Тэр нь цагирган дундуур орж, бүрээс болон даруулгын хоёр ирмэгийг хамтад нь дарсан байна, бүслүүрийг бүрээсний дотор бэхэлж, дараах зүйлийн аль нэгэнд тогтоосон байна:

энэхүү зүйлийн 9 дэх хэсэгт заасан татлагыг ашиглах үүднээс бүрээсний нүхэнд, эсхүл энэхүү рүйлийн 6 дахь хэсэгт заасан металл цагираг углаж энэхүү рүйлийн 9 дэх хэсэгт заасан татлагаар бэхэлж болох бүрээсний нүхэнд тогтооно.

Хэрэв илэрхий ул мөр үлдээлгүйгээр ачааны тэвшинд нэвтрэх боломжийг хааж байгаа хамгаалалтын хаалт зэрэг тусгай хэрэгсэл байрлуулсан бол даруулга хэрэглэх шаардлагагүй.

(b) Ачааны тэвшийг хааж ломбодсон үед бүрээсний ирмэгүүдийг сайн шахаж

түгжих тусгай систем. Уг систем нь энэхүү рүйлийн 6 дахь хэсэгт заасан металл цагираг орох нүхтэй, мөн энэхүү зүйлийн 9 дэх хэсэгт заасан татлагаар бэхлэх боломжтой байна. Тийм системийг энэхүү Хавсралтад зүүсэн Зураг 8-д дүрслэн үзүүлсэн болно.

11 (a) заалтын тайлбар бичиг

2.3.11 (a)-1 Бүрээс чангалах даруулга

Олон тээврийн хэрэгслийн бүрээс гадна талдаа тээврийн хэрэгслийн хажуу хашлаганы уртааш гаргасан аяган нүх бүхий хэвтээ даруулгатай байдаг. Чангалагч даруулга хэмээх тэр даруулгыг чангалагч олс буюу түүнтэй ижилтгэх хэрэгслээр бүрээсийг татаж чангалахад хэрэглэдэг. Тийм даруулгыг бүрээсэнд байгаа хэвтээ зай завсрыг нуун далдлахад ашиглаж, тухайн тээврийн хэрэгслээр тээвэрлэж буй бараанд хууль бусаар нэвтрэх боломж олгож байсан. Тиймээс энэ маягийн даруулгыг ашиглахыг зөвшөөрөхгүй байх нь зүйтэй. Түүний оронд дараах хэрэгслийг ашиглаж болно:

- (a) дээрх загварын чангалагч даруулгыг бүрээсний дотор талд байрлуулах эсвэл
- (b) ганц аяган нүх бүхий жижигхэн дан даруулгыг бүрээсийг зохих ёсоор чангалахад шаардлагатай хэмжээгээр алслалттайгаар гадна гадаргууд байрлуулах. Нөгөө талаас, зарим тохиолдолд чангалагч даруулгыг бүрээсэнд хэрэглэхээс зайлсхийж болно.

2.3.11(a)-2 Бүрээсний бүслүүр

Бүслүүрийг дараах материалаар хийх нь тохиромжтой:

- (a) сур,
- (b) хуванцар хучлагатай буюу резинжүүлсэн эдийг оролцуулан тасардаггүй материал. Гэхдээ тийм материалыг тасалсны дараа илэрхий ул мөр үлдээлгүйгээр гагнах буюу холбох боломжгүй байх ёстой. Түүнээс гадна бүслүүрийг хучсан хуванцар материал нь өнгөгүй тунгалаг, гөлгөр гадаргуутай байна.

2.3.11(a)-3 6 дугаар Хавсралтад зүүсэн Зураг 3-т үзүүлсэн хэрэгсэл нь 2 дугаар Хавсралтын 3 дугаар рүйлийн 11 (a) заалтын сүүлийн хэсгийн шаардлагыг хангаж байна. Тэр нь бас 2 дугаар Хавсралтын 3 дугаар зүйлийн 6 (a), 6(b) заалтуудын шаардлагыг хангаж байна.

ХАВСРАЛТ 3

ХАВСРАЛТ 2-Т ЗААСАН ЖУРМЫН ДАГУУ ТЕХНИКИЙН

НӨХЦӨЛ ХАНГАСАН АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

ЕРӨНХИЙ ЗАРЧИМ

1. Автотээврийн хэрэгсэлд дараах журммын аль нэгээр зөвшөөрөл олгоно:

(b) тээврийн хэрэгслийг тусгайлан заах эсвэл

(c) тээврийн хэрэгслийг загвараар (автотээврийн хэрэгслийн төрлөөр) нь ерөнхийлөн заах.

2. Хавсралт №4-ийн стандарт маягтын дагуу үйлдсэн Зөвшөөрлийн цэрчилгээг зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэлд олгоно. Энэхүү гэрчилгээг түүнийг олгосон улсын хэл болон франц, англи хэлний аль нэгээр үйлдсэн байна. Зөвшөөрөл олгосон байгууллага шаардлагатай гэж үзвэл, тухайн байгууллагаас баталгаажуулсан гэрэл зураг буюу жишиг зургийг Гэрчилгээнд хавсаргана. Тухайн байгууллага эдгээр бичиг баримтын тоог Зөвшөөрлийн Гэрчилгээний 6 дугаар хүснэгтэд бичнэ.

3. Зөвшөөрлийн Гэрчилгээ холбогдох автотээврийн хэрэгсэлтэй хамт явна.

4. Автотээврийн хэрэгслийг тухайн тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн улсын эсвэл бүртгэлгүй тээврийн хэрэгслийн хувьд - өмчийн эзэн буюу эзэмшигчийн оршин суугаа улсын эрх бүхий байгууллага дээр үзлэгт оруулах, шаардлагатай бол зөвшөөрлийг шинэчлэх зорилгоор хоёр жил тутам хамруулна.

5. Хэрэв автотээврийн хэрэгсэл зөвшөөрөл олгоход шаардагдах техникийн нөхцөлийг хангахаа байсан бол түүнийг ТИР Карнейг ашиглан бараа тээвэрлэхэд ашиглахаас өмнө дээр дурдсан техникийн нөхцөлийг дахин хангахаар шинэчлэн засч, зөвшөөрөл олгосон нөхцөлийг бүрдүүлнэ.

6. Хэрэв автотээврийн хэрэгслийн үндсэн үзүүлэлтүүд өөрчлөгдсөн бол тухайн тээврийн хэрэгслийн зөвшөөрөл түүнд хамааралгүй болох бөгөөд түүнийг ТИР карнейг ашиглан бараа тээвэрлэхэд ашиглахаас өмнө эрх бүхий байгууллагаас дахин зөвшөөрөл авна.

7. Тухайн байдлаас шалтгаалан, тухайн тээврийн хэрэгсэл бүртгэгдсэн улсын эрх бүхий байгууллага, эсхүл бүртгүүлэх шаардлагагүй тээврийн хэрэгслийн хувьд өмчийн эзэн буюу эзэмшигч нь тогтоогдсон улсын эрх бүхий байгууллага энэхүү Конвенцийн 14 дүгээр зүйл болон энэхүү Хавсралтын 4, 5, 6 дахь хэсэгт заасан тохиолдолд Зөвшөөрлийн гэрчилгээг цуцалж, сэргээж эсхүл шинээр олгож болно.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛД ТУСГАЙЛАН ЗААСАН

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

8. Өмчийн эзэн, тээврийн байгууллага, эсхүл тэдгээрийн аль нэгнийх нь бие төлөөлөгч тээврийн хэрэгслийг тусгайлан заасан зөвшөөрөл авахаар эрх бүхий байгууллагад өргөдөл гаргаж болно. Эрх бүхий тухайн байгууллага дээрх 1-7 дахь хэсэгт заасан нийтлэг дүрмийн дагуу хүргэж ирүүлсэн авто тээврийн хэрэгслийг шалгаж, тухайн тээврийн хэрэгсэл Хавсралт 2-т заасан техникийн нөхцөлийг хангаж байгаа эсэхийг тогтоож, зөвшөөрсний дараа Хавсралт 4-т заасан загвар бүхий гэрчилгээг олгоно.

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙГ ЗАГВАРААР НЬ

(АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТӨРЛӨӨР)

ЕРӨНХИЙЛӨН ЗААСАН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ЖУРАМ

9. Хэрэв автотээврийн хэрэгслийг нэр төрлөөр нь цуврал байдлаар үйлдвэрлэдэг бол тухайн үйлдвэрлэгч тээврийн хэрэгслийг загвараар нь ерөнхийлөн заасан зөвшөөрөл авахаар өөрийн орны эрхий бүхий байгууллагад өргөдөл гаргаж болно.

10. Үйлдвэрлэгч зөвшөөрөл авахаар гаргасан өргөдөлд хамаарах авто тээврийн хэрэгслийн тухайн нэр төрлийн ялгах дугаар буюу үсгүүдийг уг өргөдөлд дурдана.

11. Зөвшөөрөл авах авто тээврийн хэрэгслийн тухайн нэр төрлийн зураасан зураг, загварын дэлгэрэнгүй тодорхойлолтыг өргөдөлд хавсаргасан байна.

12. Үйлдвэрлэгч дараах амлалтыг бичгээр үйлдэн авсан байна.

(a) тухайн төрлийн холбогдох тээврийн хэрэгслээс эрх бүхий байгууллага шалгахыг хүссэн тээврийн хэрэгслийг хүргэж авчрах;

(b) тухайн төрлийн холбогдох тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн явцад өөр бусад нэгжийг дуртай үедээ шалгах боломжийг эрх бүхий байгууллагад олгох;

(c) тухайн загвар буюу тодорхойлолтод оруулах аливаа өөрчлөлт үл ялих эсэхийг үл харгалзан, тэдгээрийг тийнхүү өөрчлөхөөс өмнө уг өөрчлөлтийн талаар эрх бүхий байгууллагад зөвлөх;

(d) тухайн загварын ялгах дугаар буюу үсгүүд, мөн тухайн тээврийн хэрэгслийн төрлийн дугаар (үйлдвэрлэгчийн дугаар)-ыг уг авто тээврийн хэрэгслийн нүдэнд үзэгдэхүйц газар тэмдэглэх;

(e) зөвшөөрөгдсөн загвараар үйлдвэрлэсэн тээврийн хэрэгслийн талаар бүртгэл хөтлөх.

13. Санал болгосон загварт зөвшөөрөл олгохын тулд өөрчлөлт оруулах

шаардлагатай бол ямар өөрчлөлт оруулахыг эрх бүхий байгууллага зааж өгнө.

14. Холбогдох загварын дагуу үйлдвэрлэсэн нэг буюу хэд хэдэн тээврийн хэрэгслийг шалгахад уг нэр төрлийн тээврийн хэрэгсэл Хавсралт 2-т заасан техникийн нөхцөлийг хангаагүй гэж эрх бүхий байгууллага үзсэн бол тээврийн хэрэгслийг загвараар нь ерөнхийлөн заасан зөвшөөрөл олгохгүй.

15. Тээврийн хэрэгслийг загвараар нь ерөнхийлөн заасан зөвшөөрөл олгох эсэх талаар гаргасан шийдвэрийг эрх бүхий байгууллага үйлдвэрлэгчид бичгээр мэдэгдэнэ. Уг шийдвэр нь он, сар, өдөр, дугаартай байна. Тухайн шийдвэрийг гаргасан байгууллага (албан тушаалтан)-ыг тодорхой заасан байна.

16. Эрх бүхий байгууллага зөвшөөрөгдсөн загварын дагуу үйлдвэрлэгдсэн тээврийн хэрэгсэл бүрийн Зөвшөөрлийн иэрчилгээг зохих ёсоор гарын үсэг зурж олгохдоо шаардлагатай арга хэмжээг үе шаттай авна.

17. Зөвшөөрлийн иэрчилгээ эзэмшигч ТИР Карней ашиглан бараа тээвэрлэхээр холбогдох тээврийн хэрэгслийг ашиглахаас өмнө, шаардлагатай бол, уг Зөвшөөрлийн иэрчилгээнд дараах зүйлсийг бичнэ:

- тухайн тээврийн хэрэгслийн бүртгэлийн дугаар (1 дүгээр хүснэгт), эсвэл

- бүртгүүлэх шаардлагагүй тээврийн хэрэгслийн хувьд - өөрийн нэр болон ажлын газрын хаяг (8 дугаар хүснэгт).

Тайлбар бичиг

3.0.17 Зөвшөөрөл олгох журам

1. Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага өөрийн улсын нутаг дэвсгэрт үйлдвэрлэсэн тээврийн хэрэгсэлд Зөвшөөрлийн иэрчилгээ олгож болох бөгөөд тухайн тохиолдлоос хамааран, уг тээврийн хэрэгслийг бүртгэсэн улс буюу өмчийн эзэн оршин суугаа улсад дээрх тээврийн хэрэгсэлтэй холбогдуулан зөвшөөрөл олгох нэмэлт шаардлага тавихгүй байх тухай Хавсралт 3-т заасан болно.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг тухайн тээврийн хэрэгслийг импортлох үед эсвэл импортолсны дараа түүнийг бүртгэх, хяналт тавих зорилгоор эсвэл үүнтэй ижилтгэх хуулийн шаардлагын дагуу гаргаж үзүүлэхийг тухайн тээврийн хэрэгслийг бүртгэсэн улс буюу өмчийн эзэн оршин суугаа Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллага шаардах эрхийг эдгээр заалтууд хязгаарлахгүй.

18. Загвараар нь ерөнхийлөн зөвшөөрсөн тээврийн хэрэгслийг энэхүү Конвенцийн Хэлэлцэн тохирогч тал болох нөгөө улсад экспортолсон бол уг тээврийн хэрэгслийг импортолсон гэдэг утгаар тухайн улсад зөвшөөрөл олгох нэмэлт шаардлага тавихгүй.

ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭГ БАТАЛГААЖУУЛАХ ЖУРАМ

19. ТИР Карней хэрэглэн бараа тээвэрлэж буй зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгсэл ноцтой гэмтэлтэй болох нь тогтоогдвол, Хэлэлцэн тохирогч Талын эрх бүхий байгууллага тухайн тээврийн хэрэгсэл ТИР Карнейг ашиглан аяллаа үргэлжлүүлэхийг болиулж эсвэл аюулгүй байдлыг хангах шаардлагатай арга хэмжээ авч, өөрийн улсын нутаг дэвсгэрт ТИР Карнейг ашиглан аяллаа үргэлжлүүлэхийг зөвшөөрч болно. Зөвшөөрөгдсөн тээврийн хэрэгслийг аль болох түргэн хугацаанд, гэхдээ ямарч тохиолдолд түүнийг ТИР Карнейг ашиглан бараа тээвэрлэхэд дахин хэрэглэхээс өмнө хангалттай хэмжээнд хүртэл шинэчлэн заасан байвал зохино.

20. Эдгээр тохиолдол бүрийг гаалийн байгууллага тухайн тээврийн хэрэгслийн Зөвшөөрлийн гэрчилгээний 10 дугаар хүснэгтэд тэмдэглэж, зохих ёсоор баталгаажуулна. Хэрэв тухайн тээврийн хэрэгслийг зөвшөөрөл олгосон нөхцөл бүрдтэл шинэчлэн зассан бол түрүүчийн илэрсэн зүйлсийг хүчингүй болгож, 11 дүгээр хүснэгтэд тэмдэглэн баталгаажуулах замаар гэрчилгээг дахин сэргээх Хэлэлцэн тохирогч талын эрх бүхий байгууллагад уг тээврийн хэрэгслийг хүргэж өгнө. Өмнөх хэсгийн заалтын дагуу гэрчилгээний 10 дугаар хүснэгтэд тэмдэглэл хийж баталгаажуулсан тээврийн хэрэгслийг хангалттай нөхцөл бүрдтэл шинэчлэн засаагүй бөгөөд 10 дугаар хүснэгтэд хийсэн тэмдэглэлийг дээр заасны дагуу хүчингүй болгоогүй бол түүнийг ТИР Карнейн журмаар бараа тээвэрлэхэд ашиглахыг зөвшөөрөхгүй байж болно.

Тайлбар бичиг

3.0.20 Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулах журам

Тухайн тээврийн хэрэгслийг хангалттай хэмжээнд хүртэл шинэчлэн зассаны дараа гэмтлийн баталгаажуулалтыг хүчингүй болгох ёстой бол зорилгыг илэрхийлэх 11 дүгээр хүснэгтэд "гэмтэл засагдсан" гэж бичээд эрх бүхий байгууллагын нэр, (албан тушаалтны) гарын үсэг, тамга/тэмдэг байхад хангалттай.


21. Гэрчилгээнд тэмдэглэл хийсэн тухай бүр он, сар, өдрийг тавьж, эрх бүхий байгууллага баталгаажуулсан байна.

22. Хэрэв тээврийн хэрэгслийн гэмтлийг гаалийн байгууллага ач холбогдол багатай бөгөөд контрабанд хийх аюулгүй гэж үзвэл тухайн тээврийн хэрэгслийг ТИР Карнейн журмаар бараа үргэлжлүүлэн тээвэрлэхийг зөвшөөрч болно. Гэмтлийн талаар Зөвшөөрлийн иэрчилгээ эзэмшигчид мэдэгдэх бөгөөд тэр нь тодорхой хугацааны дотор өөрийн тээврийн хэрэгслийг хангалттай хэмжээнд хүртэл шинэчлэн засна.

Хавсралт 5

ТИР ТӨМӨР ПАЙЗ

1. Пайзны хэмжээ нь 250 X 400 мм байна.
2. ТИР гэсэн бичээсийг Латин үсгээр 200 мм-ийн өндөртэй бичих ба үсгийн өргөн нь 20 мм байна. Үсгүүдийг цэнхэр дэвсгэр дээр цагаан өнгөөр бичнэ.



Хавсралт 6

Тайлбар бичгийн удиртгал

- (i) Энэхүү Конвенцийн 43 дугаар рүйлийн заалтын дагуу Тайлбар бичиг нь Конвенцийн зарим нэг рүйл болон түүний Хавсралтуудыг тайлбарлана. Мөн зарим нэг практик зөвлөмжийг агуулсан болно.
- (ii) Тайлбар бичиг нь энэхүү Конвенци болон түүний Хавсралтуудыг өөрчлөхгүй боловч тэдгээрийн агуулга, утга, хамрах хүрээг илүү тодорхой болгоно.
- (iii) Гаалийн битүүмжлэлтэйгээр барааг тээвэрлэх зөвшөөрөл авах техникийн нөхцөлтэй холбогдсон Хавсралт 2 болон энэхүү Конвенцийн 12 дугаар рүйлийн заалтын тухайд шаардлагатай тохиолдолд хийцийн аргыг эдгээр заалтад нийцүүлэн Хэлэлцэн тохирогч талууд хүлээн зөвшөөрнө гэдгийг Тайлбар бичигт онцлон дурдсан. Мөн Тайлбар бичигт шаардлагатай тохиолдолд хийцийн арга нь эдгээр заалттай тохирохгүй байж болно хэмжээн заажээ.
- (iv) Тайлбар бичигт энэхүү Конвенци болон түүний Хавсралтуудын заалтыг хэрэгжүүлэхдээ технологийн хөгжил, эдийн засгийн шаардлагыг анхааралдаа авах талаар заасан

Хавсралт 7

ЧИНГЭЛГИЙН ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ

Хэсэг 1

ГААЛИЙН БИТҮҮМЖЛЭЛТЭЙГЭЭР ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ТЭЭВЭРЛЭЛТ ХИЙХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХДОО ЧИНГЭЛЭГТ ТАВИХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛИЙН ТУХАЙ ЖУРАМ

Тайлбар бичиг

Энэхүү Конвенцийн Хавсралт 2, Хавсралт 6-ын тайлбар бичиг нь энэхүү Конвенцийг хэрэгжүүлэх зорилгоор гаалийн битүүмжлэлтэйгээр тээвэрлэлт хийхэд зориулагдсан чингэлгүүдэд хэвээр мөрдөгдөнө.

1 дүгээр зүйл

Үндсэн зарчмууд

Гаалийн битүүмжлэлтэйгээр олон улсын хэмжээнд тээвэрлэлт хийх зөвшөөрөл нь зөвхөн дараах байдлаар тоноглогдсон, хийгдсэн чингэлэгт олгогдоно. Үүнд:

- (a) Гаалийн лац, ломбыг эвдэлгүйгээр, эсвэл эвдсэн ул мөр үлдээхгүйгээр тээврийн хэрэгслийн битүүмжилсэн хэсгээс бараа авах, түүнд бараа хийх боломжгүй байх.
- (b) Гаалийн лац, ломбыг хялбар аргаар, жинхэнэ ёсоор нь тавих боломжтой байх
- (c) Барааг нуун далдлах нууц зайгүй байх,
- (d) Бараа байрлуулах зориулалт бүхий зай завсарт гаалийн үзлэг хийх, үзлэг хийхээр нэвтрэх боломжтой байх.

2 дугаар зүйл

Чингэлгийн бүтэц

1. Энэхүү журмын 1 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангах үүднээс:

(a) Чингэлгийн бүрдэл хэсгүүд (хана, шал, дээвэр, хүрээ, тулгуур багана, хөндлөвч гэх мэт)-ийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр гаднаас нь авч, солих боломжгүй зүйлээр, эсвэл илэрхий ул мөр үлдээхгүйгээр өөрчлөх боломжгүй бүтэц бий болгох аргаар угсарсан байна. Хана, шал, хаалга болон дээвэр нь янз бүрийн хэсгүүдээр хийгдсэн бол эдгээр нь дээрх шаардлагыг адилхан хангасан байх бөгөөд хангалттай бат бөх байна.

(b) Хаалга болон хаалтын бусад бүх систем (хашлага, цоргоны хаалт, нээлхийн таг гэх мэт) нь гаалийн лац, ломбо тавих хэрэгсэлтэй байна. Уг хэрэгслийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр чингэлгийн гадна талаас авч, солих боломжгүй байх, эсвэл уг хэрэгсэл нь гаалийн лац, ломбыг эвдэлгүйгээр хаалга буюу бэхэлгээг онгойлгож болохооргүй байх ёстой. Гаалийн лац ломбо нь зохих ёсоор хамгаалагдсан байна. Дээвэр нь онгойдог байж болно.

(c) Агааржуулагчийн болон бохирын нүхэнд чингэлгийн дотор талд орох боломжийг хаах хэрэгсэл байрлуулсан байна. Уг хэрэгслийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр гаднаас нь авч, солих боломжгүй байна.

2. Энэхүү журмын 1 дүгээр (c) заалтыг үл харгалзан, практик шаардлагын үүднээс хоосон зай (жишээлбэл, давхар хананы хооронд) бүхий чингэлгийн бүрдэл хэсэг байж болно. Уг зайд бараа нуун далдлах боломж олгохгүй байх үүднээс:

- (i) Хэрэв доторлогоо нь шалнаас дээвэр хүртэлх нийт өндөртэй тэнцүү эсвэл бусад тохиолдолд, уг хана ба гадуур хананы хоорондох зай ямарч нүх сүвгүй битүү байх тохиолдолд чингэлгийн доторлогоо илэрхий ул мөр үлдээлгүйгээр салгаж, солих боломжгүй байдлаар хийгдсэн байна, мөн
- (ii) Хэрэв дотуур хана нь нийт өндрөөс бага бөгөөд уг доторлогоо, гадуур хананы хооронд зай завсартай, мөн чингэлгийн хийцэд өөр зай завсар байх бусад бүх тохиолдолд тийм зай завсрын тоог аль болох бага болгож, тэдгээрт гаалийн үзлэг хийх боломжтой байлгана.

3. Конвенцийн Хавсралт 6, Тайлбар бичиг 0,1 (е) -д заасны дагуу салгаж авч болдог тэвшинд цонх хийхийг зөвшөөрөх ба тэдгээр нь маш бат бөх материалаар хийгдэж, илэрхий ул мөр үлдээхгүйгээр гадна талаас нь солих боломжгүй байх ёстой. Шилийг хэрэглэхийг зөвшөөрдөг боловч хамгаалалтын шилнээс бусад шилийг хэрэглэхэд цонх нь гадна талаас нь хөдөлгөх боломжгүй металл сараалжаар бүрхэгдсэн байх бөгөөд сараалжны нүдний төмрийн хэмжээ нь 10 мм-ээс хэтрэхгүй байна. Конвенцийн Хавсралт 6, Тайлбар бичиг 0.1 (е) -д тодорхойлогдсон салгаж авч болдог тэвшнээс бусад нөхцөлд Конвенцийн 1 дүгээр зүйлд тодорхойлогдсон чингэлэгт цонх хийхийг зөвшөөрөхгүй.

3 дугаар зүйл

Эвхэгддэг болон хэсэгт задардаг чингэлэг

Эвхэгддэг болон задардаг чингэлэг нь эдгээр журмуудын 1, 2 болон 3 дугаар зүйлүүдийн нөхцөлүүдэд хамаарах бөгөөд түүнээс гадна чингэлгийг угсрах үед бүх хэсгүүд нь боолтоор хоорондоо холбогдоно. Боолт нь чингэлгийг угсрах үед гадна талд нь байх тохиолдолд гаалийн лац, ломбыг тавих боломжтой байх ёстой.

4 дүгээр зүй

Бүрээстэй чингэлэг

1. Энэхүү журмын 1, 2, 3 дугаар зүйлүүдийн заалтуудыг хэрэв тохирохоор бол бүрээстэй чингэлэгт мөрдөнө. Түүнээс гадна эдгээр чингэлгүүд нь энэ хэсгийн заалтуудад тохирсон байна.

2. Бүрээс нь бөх бат зотон даавуу, эсвэл бөх бат бөгөөд сунадаггүй хуванцар буюу резинэн хучлагатай эдийн аль нэг байж болно. Бүрээс нь муудаагүй байхын зэрэгцээ хаах хэрэгслийг нэгэнт битүүмжилсэн бол илэрхий ул мөр үлдээхгүйгээр чингэлэгт нэвтрэн орох боломжгүй байхаар хийгдсэн байна.

3. Хэрэв бүрээс нь хэд хэдэн хэсгээс бүрдсэн бол тэдгээр хэсгүүдийн захуудыг зөрүүлэн нугалж, 15 мм-ээс доошгүй зайтай давхар оёдол хийсэн байна. Уг давхар оёдлыг энэхүү журамд хавсаргасан бүдүүвч зураг 1-д үзүүлсний дагуу хийнэ, гэхдээ бүрээсний зарим хэсэг (жишээлбэл, далавч, бөхөлгөөтэй булан гэх мэт)-ийг дээрх байдлаар зүйж хийх боломжгүй бөгөөд энэ тохиолдолд дээд талын хэсгийг нугалж, энэхүү журамд зүүсэн зураг 2 буюу 2 (а)-д үзүүлсний дагуу оёдол хийнэ. Давхар оёдлын нэг нь зөвхөн дотроосоо үзэгдэхүйц байх бөгөөд түүний утасны өнгө нь бүрээсний өнгө болон нөгөө оёдлын утасны өнгөнөөс өөр өнгөтэй байна. Бүх оёдлыг машинаар хийсэн байна.

4. Хэрэв бүрээсийг хуванцар хучлагатай эдээр хийсэн бөгөөд тэр нь хэд хэдэн зүйдэлтэй бол уг зүйдлүүдийг энэхүү журамд зүүсэн зураг 3-д үзүүлсний дагуу хайлуулж наасан байж болно. Хэсгүүдийн захыг 15 мм-ээс доошгүйгээр хэмжээтэй зөрүүлсэн байна. Хэсгүүдийг хооронд нь зөрүүлсэн өргөний хэмжээгээр хамтад нь хайлуулж наасан байна. Бүрээсний гадна хэсгийн захыг 7 мм-ээс багагүй өргөнтэй хуванцар туузаар дарж, мөн адил хайлуулж наана. Хуванцар тууз болон түүний хоёр талаас 3 мм-ээс доошгүй бүрээсний хэсгийг тодорхой харагдахуйц нэг адил товгор хээ гаргаж тамгална. Хэсгүүдийг илэрхий ул мөр үлдээлгүйгээр салгаж, буцаан наах боломжгүй байдлаар хайлуулж наасан байна.

5. Засвар хийхдээ энэхүү журамд хавсаргасан бүдүүвч зураг 4-д үзүүлсэн аргад нийцүүлэн хийнэ: захыг зөрүүлэн нугалж, 15 мм-ээс доогүй зайтай, нүдэнд үзэгдэх давхар оёогоор хамтад нь оёно, дотроос нь үзэгдэх утасны өнгө гаднаас нь үзэгдэх утасны өнгө болон бүрээсний өнгөнөөс өөр байна, бүх оёдлыг машинаар хийсэн байна. Хэрэв бүрээс нь захаараа гэмтсэн бол гэмтсэн хэсэгт нөхөөс тавьж бүрээсийг засах бөгөөд оёдлыг энэхүү 3 дугаар хэсэг болон энэхүү журамд зүүсэн зураг 1-д үзүүлсний дагуу хийж гүйцэтгэнэ. Хэрэв бүрээс нь хуванцар хучлагатай эд бол түүнийг энэхүү 4 дэх хэсэгт заасан аргаар засна. Гэвч энэ тохиолдолд, хуванцар туузыг бүрээсний хоёр талд наах бөгөөд нөхөөсийг бүрээсний дотор талд байрлуулсан байна.

6. Бүрээсийг чингэлэгт тогтоохдоо энэхүү журмын 1 дүгээр рүйлийн (a), (b)-д заасан нөхцөлүүдийг хатуу баримтална. Дараах системүүдийг хэрэглэж болно. Үүнд:

- (a) Бүрээсийг дараах байдлаар бэхэлнэ:
 - (i) чингэлэгт тогтоосон металл гогцоогоор,
 - (ii) гогцоог бүрээсний ирмэгийн дагуух нүхнүүдээр, мөн
 - (iii) бэхэлгээний утсыг бүрээсийг нэвтрэн гарсан бүх цагирагаар шургуулж, гаднаас нь бүхэлдээ харагдахаар хийнэ.

Тухайн чингэлгийн хийц нь өөрөө чингэлэгт нэвтрэх бүх боломжийг хаасан байхаас бусад тохиолдолд бүрээс нь бэхэлгээний цагирагны төвөөс 250 мм-ээс доошгүй хэмжээгээр чингэлгийн цул хэсгийг давсан байна.

Тайлбар бичиг

Гаалийн үүднээс зөвшөөрөгдөж болох чингэлгийн булангийн холбоосыг тойруулж бүрээсийг тогтоох хэрэгслийн жишээг 3 дугаар хэсгийн хавсралт 7-ийн бүдүүвч зурагт үзүүлсэн байгаа.

- (b) Хэрэв бүрээсний аль нэг зах чингэлэгт байнгын бэхэлгээтэй байна гэвэл хоёр гадаргыг нь салахааргүй хооронд нь нийлүүлж бөх бат хэрэгслээр тогтооно.
- (d) Хэрэв бүрээсийг түгжин бэхлэх систем ашигласан бол тэр нь түгжигдсэн байх тохиолдолд бүрээсийг чингэлгийн гадна талтай шахаж хавсан байна. (Энэхүү журамд хавсаргасан 6 дугаар зургийг жишээ болгоу ор)

7. Бүрээсийг шалнаас дээш тохирох хэсгүүд (тулгуур багана, хана, нум, хөндлөвч гэх мэт) -ээр бэхэлнэ.

8. Гогцооны хоорондын зай болон бүрээсний ирмэгийн нүхнүүдийн хоорондын зай нь 200 мм-ээс илүүгүй байна. Хэрэв чингэлгийн хийц болон бүрээс нь чингэлгийн дотор нэвтэрч орох боломжийг хаасан бол уг зай нь арай их байж болох боловч баганын хоёр талд байгаа цагирагнууд болон бүрээсний ирмэгийн нүхнүүд хоорондоо 300 мм-ээс холгүй байна. Бүрээсний ирмэгийн нүхнүүдийг бөхөлсөн байна.

9. Бэхэлгээнд дараах зүйлийг ашиглана:

- (a) 3 мм-ээс багагүй диаметртай ган утсан татлага, эсвэл
- (b) сунадаггүй тунгалаг хуванцар бүрхүүлтэй, 8 мм-ээс багагүй диаметртай олсон болон мяндсан татлага,

Төмөр утсан татлага нь сунадаггүй, тунгалаг хуванцар бүрхүүлтэй байж болно.

Бусад тохиолдолд энэхүү 6 (a) заалттай нийцэж буй хийц системийн раманд бүрээсийг тогтоох шаардлагатай бол оосрон бүслүүрийг бэхэлгээ болгон хэрэглэж болно. (Тийм хийц системийн жишээг энэхүү Хавсралтад зүүсэн Зураг 7-д үзүүлэв). Бүслүүр оосор нь хийсэн материал, хэмжээ, хэлбэрийн хувьд 11 (a) (iii)-д заасан шаардлагад нийцсэн байвал зохино.

10. Татлага бүр залгаасгүй байхын зэрэгцээ хоёр үзүүртээ хатуу металлээр хийсэн бөхөлгөөтэй байна. Хоёр металл үзүүрийг бэхлэх зүйлд тавтай хөндий хадаас орох бөгөөд түүгээр татлагыг нэвт цоолж гаалийн лац, ломбоны утас буюу гогцоо орох боломжийг бүрдүүлнэ. Татлага нь тавтай хөндий хадаасны хоёр талаар ил харагдаж, уг татлага залгаасгүй болохыг мэдэх боломжтой байна. (Энэхүү журамд зүүсэн Зураг 5-ыг үз)

11. Ачаа ачих, буулгах зориулалттай онгорхой дээр хоёр бүрээсний гадаргуу нийлэх ёстой. Дараах системийг ашиглаж болно.

(a) Бүрээсний хоёр ирмэгийг зохих ёсоор зөрүүлсэн байна. Түүнийг бас дараах зүйлээр бэхэлнэ:

- (i) энэхүү зүйлийн 3, 4 дэх хэсэгт заасны дагуу оёсон буюу гагнасан даруулгаар,
- (ii) энэхүү 8 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангасан гогцоо болон бүрээсний нүхээр, цагирагийг металлээр хийсэн байна, мөн
- (iii) зохих материалаар хийсэн, залгаасгүй, сунадаггүй, 20 мм-ээс багагүй өргөнтэй, 3 мм-ээс багагүй зузаантай бүслүүрээр (ремень) бэхэлнэ. Тэр нь гогцоон дундуур орж, бүрээс болон даруулгын хоёр ирмэгийг хамтад нь дарсан байна, бүслүүрийг бүрээсний дотор бэхэлж, дараах зүйлсийн аль нэгэнд тогтоосон байна:

Энэхүү 9 дэх хэсэгт заасан татлагыг ашиглах үүднээс бүрээсний нүхэнд, эсвэл энэхүү 6 дахь хэсэгт заасан металл цагираг углаж, энэхүү 9 дэх хэсэгт заасан татлагаар бэхэлж болох бүрээсний нүхэнд ткутккук.

Хэрэв илэрхий ул мөр үлдээлгүйгээр ачилтын хэсэг (чингэлэг)-т нэвтрэх боломжийг хааж байгаа хаалт зэрэг тусгай хэрэгсэл байрлуулсан бол даруулга хэрэглэх шаардлагагүй.

(b) Чингэлгийг хааж ломбодсон үед бүрээсний ирмэгүүдийг сайн шахаж түгжих тусгай систем. Уг систем нь энэхүү 6 дахь хэсэгт заасан металл гогцоо орох нүхтэй, мөн энэхүү 9 дэх хэсэгт заасан татлагаар бэхлэх боломжтой байна. Тийм системийг энхүү Хавсралтад хавсаргасан бүдүүвч зураг 8-д дүрслэн үзүүлсэн болно.

12. Чингэлэг дээр тавигдах таних тэмдэг болон энэхүү Хавсралтын 2 дахь хэсэгт дурдсан зөвшөөрлийн самбар нь ямар ч нөхцөлд бүрээсээр далдлагдсан байх ёсгүй

Тавдугаар зүйл

Түр заалт

1977 оны 1 дүгээр сарын 1-н хүртэл энэхүү журамд хавсаргасан бүдүүвч зураг 5-ын дагуу үзүүрийн хэсгүүдийг зурагт өгөгдсөн хэмжээнээс бага нүхтэй, өмнө нь хэрэглэж байсан тавтай хөндий хадаастай байсан ч зөвшөөрнө.

Хавсралт 7

Хэсэг 2

ХЭСЭГ 1-Д ТАЙЛБАРЛАСАН ТЕХНИКИЙН

НӨХЦӨЛҮҮДТЭЙ ТОХИРОХ ЧИНГЭЛЭГТ

ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ГОРИМ

Ерөнхий зүйл

1. Гаалийн битүүмжлэлтэйгээр тээвэр хийх чингэлгүүдэд дараах аль нэг тохиолдолд зөвшөөрөл олгоно. Үүнд:

(a) үйлдвэрлэлийн шатанд, загварын төрлөөр (үйлдвэрлэлийн шатанд зөвшөөрөл олгох журам), эсвэл

(b) үйлдвэрлэлийн дараагийн шатанд, дангаараа эсвэл нэг төрлийн хэд хэдэн чингэлэгт (үйлдвэрлэлийн дараагийн шатанд олгох зөвшөөрөл) зэрэг болно.

Зөвшөөрлийн журмуудын нийтлэг нөхцөлүүд

2. Зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага нь хүсэлт гаргасан байгууллагад зөвшөөрөл олгосны дараа Зөвшөөрлийн гэрчилгээ нь зөвшөөрөл олгосон төрлийн болон тодорхой тоо заасан чингэлгүүдэд хүчин төгөлдөр байна.

3. Зөвшөөрөл авагч нь чингэлгээр битүүмжлэлтэйгээр тээвэрлэлт хийхээс өмнө зөвшөөрөл олгосон чингэлэгт зөвшөөрлийн пайзыг хадна.

4. Зөвшөөрлийн пайз нь байнгын зориулалтаар, сайн харагдахаар, албан зорилгоор олгосон бусад зөвшөөрлийн пайзуудтай зэргэлдээ хадагдсан байна.

5. Зөвшөөрлийн пайз нь энэхүү хэсгийн 1-д үзүүлсэн загвартай тохирч байх бөгөөд 20 см х 10 см-ээс багагүй хэмжээтэй металл ялтсан дээр хийгдсэн байна. Дараах мэдээллүүдийг пайз дээр тамгалах, эсвэл сийлж тавих, эсвэл гаргац сайтай, байнгын байх аль нэг аргаар тавьж болох бөгөөд наад зах нь англи, франц хэлээр дараах үгсийг бичнэ.

(a) "Гаалийн битүүмжлэлтэйгээр тээвэр хийхэд зөвшөөрөгдсөн" гэсэн үгийг, (Approved for transport under Customs seal).

(b) Зөвшөөрөл олгосон он болон улсын нэрийг, улсын нэрийг нэрээр нь, эсвэл олон улсын авто замын тээвэрт тээврийн хэрэгслийн бүртгэлд хэрэглэдэг ялгах тэмдгээр, эсвэл дугаараар (үсэг, тоогоор гэх мэт) илэрхийлнэ. (Жишээлбэл, "NL/26/73" гэдэг нь "Нидерланд, Зөвшөөрлийн гэрчилгээний дугаар 26, 1973 онд олгосон гэсэн үг юм.)

(c) Чингэлэгт үйлдвэрлэгчээс олгосон серийн дугаарыг (үйлдвэрлэгчийн дугаар)

(d) Хэрэв чингэлгийг төрлөөр нь зөвшөөрөл олгосон бол чингэлгийн төрлийг үсгээр тодорхойлсон дугаарыг бичнэ.

Тайлбар бичиг

Гаалийн битүүмжлэлтэйгээр тээвэр хийх зөвшөөрөл бүхий бүрээстэй хоёр чингэлэг хоорондоо холбогдон нэг чингэлэг үүсгэхдээ нэг бүрээсээр бүрхэгдэж, гаалийн нөхцөлийг хангаж байгаа бол зөвшөөрлийн тусдаа гэрчилгээ, эсвэл зөвшөөрлийн пайз тус бүр нь шаардагдахгүй.

6. Хэрэв чингэлэг нь зөвшөөрөлд заасан техникийн нөхцөлүүдийг хангахгүй болсон бол гаалийн битүүмжлэлтэйгээр тээвэр хийхээс өмнө зөвшөөрөлд заасан техникийн нөхцөлүүдэд тохируулж засварлана.

7. Хэрэв чингэлгийн гол чухал шинж чанар нь өөрчлөгдсөн бол чингэлгийн зөвшөөрлийг хүчингүй болгох бөгөөд гаалийн битүүмжлэлтэйгээр тээвэр хийх нөхцөлийг хангасан тохиолдолд зөвшөөрлийг дахин олгоно.

Үйлдвэрлэлийн шатанд загварын төрлөөр нь

зөвшөөрөл олгох тусгай нөхцөлүүд

8. Чингэлэг нь янз бүрийн төрлөөр үйлдвэрлэгддэг бол үйлдвэрлэгч нь тухайн орны эрх бүхий байгууллагад загварын төрлөөр зөвшөөрөл авах хүсэлтээ гаргана.

9. Үйлдвэрлэгч нь хүсэлт гаргахдаа зөвшөөрөл авах чингэлэгт тавьсан таних дугаар, үсгийг дурдсан байна.

10. Зөвшөөрөл авах чингэлгийн зураг болон загварын нарийвчилсан үзүүлэлтүүдийг хүсэлтэд хавсаргасан байна.

11. Үйлдвэрлэгч нь дараах үүрэг амлалтыг бичгээр өгсөн байна. Үүнд:

(a) эрх бүхий байгууллага, холбогдох чингэлгийг шалгахыг хүсвэл уг чингэлгийг үзүүлэх,

(b) эрх бүхий байгууллагад холбогдох төрлийн үйлдвэрлэлийн явцад ямар ч үед шалгалт хийхийг зөвшөөрөх,

(c) загвар, чанар болон үзүүлэлтэд ямар нэг өөрчлөлт хийхээс өмнө эрх бүхий байгууллагад мэдэгдэх,

(d) чингэлэгт тэмдэглэгээ тавихдаа харагдахуйц газар байрлуулах бөгөөд зөвшөөрлийн пайз дээрх тэмдэглэгээнд загварын төрлийн таних дугаар болон үсэг, төрлийн сери дугаар (үйлдвэрлэгчийн дугаар)-ыг тавьсан байна.

(e) Зөвшөөрөгдсөн загвараар үйлдвэрлэгдэж байгаа чингэлгүүдийн бүртгэлийг хөтлөх зэрэг болно.

12. Эрх бүхий байгууллага нь зөвшөөрөл олгох чингэлгийн загварт ямар нэг өөрчлөлт хийхийг шаардаж болно.

13. Загварын төрлөөр олгох зөвшөөрлийг эрх бүхий байгууллага холбогдох загварын төрлөөр үйлдвэрлэгдсэн нэг болон түүнээс олон чингэлгийг шалгаж тухайн загварын чингэлэг нь 1 дүгээр хэсэгт тайлбарлагдсан техникийн үзүүлэлтүүдтэй тохирч байгаа гэж үзсэн тохиолдлоос бусад үед олгохгүй.

14. Чингэлгийн төрөлд зөвшөөрөл олгосон бол хүсэлт гаргагчид энэхүү хэсгийн 2-т үзүүлсэн загвар 2-ын дагуу "Зөвшөөрлийн гэрчилгээ"-г олгох ба энэ төрлөөр үйлдвэрлэгдэж буй бүх чингэлгүүд нь зөвшөөрөл олгогдсон төрлийн үзүүлэлттэй тохирч байх ёстой. Энэхүү гэрчилгээ үйлдвэрлэгчид зөвшөөрөл олгосон төрлийн чингэлэг бүрт энэхүү хэсгийн 5-д заасан хэлбэрээр зөвшөөрлийн пайзыг хадах эрхийг олгоно.

Үйлдвэрлэлийн дараагийн шатанд

зөвшөөрөх тусгай нөхцөлүүд

15. Хэрэв зөвшөөрөл нь үйлдвэрлэлийн шатанд хамаарахааргүй бол эзэмшигч, тээврийн байгууллага, төлөөлөгчийн аль нэг нь зөвшөөрөл авах чингэлэг болон чингэлгүүдийг хангах боломжтой гэсэн нөхцөлд эрх бүхий байгууллагад хүсэлтээ гаргаж болно.

16. Энэхүү хэсгийн 15-д заасан хүсэлтийг гаргахдаа үйлдвэрлэгчээс чингэлэгт тавьсан сери дугаарыг (үйлдвэрлэгчийн дугаар) дурдсан байна.

17. Эрх бүхий байгууллага нь шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хэд хэдэн чингэлгийг шалгаж 1 дүгээр хэсэгт заасан техникийн нөхцөлүүдтэй тохирч байгаа эсэхийг баталгаажуулж, энэхүү хэсгийн 3-т заасан загвар 3-ын дагуу зөвшөөрлийн гэрчилгээг олгох ба энэ нь зөвхөн зөвшөөрөл олгосон чингэлгүүдэд хүчинтэй байна. Энэхүү гэрчилгээнд үйлдвэрлэгчийн сери дугаар эсвэл зөвшөөрөлтэй холбоотой чингэлэг болон чингэлгүүдэд олгосон дугаар байх ба хүсэлт гаргагчид энэхүү хэсгийн 5-д заасан зөвшөөрлийн пайзыг зөвшөөрөл олгогдсон чингэлэгт тавихыг зөвшөөрнө

Хавсралт 8

ЗАХИРГААНЫ ХОРООНЫ АЖИЛЛАХ ДҮРЭМ,

БҮРЭЛДЭХҮҮН

1 дүгээр зүйл

- (i) Хэлэлцэн тохирогч талууд нь Захиргааны хорооны гишүүд байна.
- (ii) Хороо нь энэхүү Конвенцийн 52 дугаар зүйлийн 1-д хамаарах олон улсын байгууллагуудын төлөөлөгчид болон Хэлэлцэн тохирогч талууд бус улсуудын эрх бүхий байгууллагууд хүсэлт гаргавал Хорооны чуулганд ажиглагчаар оролцуулахаар шийдэж болно.

2 дугаар зүйл

Хорооны Нарийн бичгийн дарга нарын газрын албыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга зохион байгуулна.

3 дугаар зүйл

Хороо нь жил бүрийн эхний чуулган дээр дарга болон дэд даргыг сонгоно.

4 дүгээр зүйл

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий нарийн бичгийн дарга нь Хорооны чуулганыг Европын эдийн засгийн комиссын ивээл дор жил бүр зохион байгуулах бөгөөд мөн таваас доошгүй Хэлэлцэн тохирогч улсуудын эрх бүхий байгууллагын хүсэлтээр хуралдуулна.

5 дугаар зүйл

Дэвшүүлсэн саналыг санал хураалтаар шийдвэрлэнэ. Чуулганд оролцож байгаа Хэлэлцэн тохирогч улс орон бүр нэг саналын эрхтэй. Конвенцид орж байгаа өөрчлөлтөөс бусад саналуудыг Хороо нь оролцож байгаа гишүүдийн олонхийн саналаар батална. Энэхүү Конвенцийн 60 болон 59 дүгээр зүйлд хамаарах шийдвэр болон Конвенцийн нэмэлт өөрчлөлтийг чуулганд оролцож байгаа гишүүдийн гуравны хоёрын саналаар батална.

6 дугаар зүйл

Шийдвэр гаргахад Хэлэлцэн тохирогч улсуудын гуравны нэгээс доошгүй гишүүд оролцсон байх шаардлагатай.

7 дугаар зүйл

Чуулганы хаалт хийхээс өмнө Хороо нь хурлын илтгэлийг баталсан байна.

8 дугаар зүйл

Энэхүү Хавсралтад холбогдох заалт ороогүй бол Хороо нь өөрөөр шийдээгүй тохиолдолд Европын эдийн засгийн комиссын журмын дүрмийг хэрэглэнэ.

Хавсралт9

ТИР ГОРИМД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ

I хэсэг

ТИР дэвтэр олголтыг Нийгэмлэгт зөвшөөрөх нь

Наад захын нөхцөл, шаардлага _____

1. Конвенцийн 6-р зүйлийн дагуу ТИР дэвтэр олгохыг Гэрээлэгч Талуудаар зөвшөөрүүлж, баталгаа гаргагч байхын тулд Нийгэмлэг нь хамгийн наад захын дараахи нөхцөл шаардлагыг хангасан байх ёстой. Үүнд:
- (a). Тээврийн салбарын ашиг сонирхолыг хамгаалахаар байгуулагдсан Нийгэмлэг нэг жилээс доошгүй хугацаанд үйл ажиллагаа явуулсан байх.

1.а зүйлийн тайлбар _____

9.1.1. (a). Байгуулагдсан Нийгэмлэг:

Хавсралт 9-ийн 1(a)-д дурдсан нөхцөлд олон улсын харилцаанд бараа гүйлгээ эрхэлдэг байгууллага, тухайлбал худалдааны танхим хамаарагдана.

- (b). Конвенцийн дагуу хүлээсэн үүргээ гүйцэтгэх зохион байгуулалт сайтай, санхүүгийн нөхцөл тогтвортой байх.
- (c). Ажиллагсад нь Конвенцийг зүй зохистой ашиглах мэдлэгтэй байх
- (d). Гаалийн болон татварын хууль, дүрмийн ноцтой буюу давтан зөрчил гаргаагүй байх
- (e). Гэрээт талын эрх бүхий байгууллага болон нийгэмлэгийн хооронд бичгээр үйлдсэн хэлэлцээр буюу хууль эрхийн өөр ямар нэгэн баримт үйлдэгдсэн байх. Тийм хэлэлцээр буюу хууль эрхийн баримтын баталгаажуулсан хуулбарыг хэрэв шаардлагатай бол Англи, Франц буюу орос хэлээр хийсэн, орчуулсан, баталгаажуулсан эх бичгийн хамтаар хадгалуулахаар ТИР-ийн Гүйцэтгэх Зөвлөлд явуулна. Бичгээр үйлдсэн ийм хэлэлцээр буюу хууль эрхийн аливаа баримтад оруулсан ямар нэгэн өөрчлөлтийн талаар тэр даруйд нь ТИР-ийн Гүйцэтгэх Зөвлөл мэдээлэх шаардлагатай.
- (f). Өмнө (e) зүйлд дурдсан бичгээр үйлдсэн хэлэлцээр буюу хууль эрхийн аливаа баримтын нөхцөл нь Нийгэмлэгт дараах үүрэг хариуцлагыг ноогдуулна. Үүнд:
- (i) Конвенцийн 8-р зүйлд дурдсан үүрэг хариуцлагыг гүйцэтгэх
 - (ii) Конвенцийн 8-р зүйлийн 3 –ын дагуу гэрээт талаас тогтоож, нийгэмлэгээс нэхэмжилж болох ТИР карней нэг бүрийн даатгалын хамгийн их хэмжээг хүлээн зөвшөөрөх
 - (iii) ТИР горимоор ажиллахыг хүссэн энэхүү хавсралтын 2-р хэсэгт наад захын нөхцөл, шаардлагыг байнга, тухайлбал хүсэлт гаргахаасаа өмнө баримталж буй эсэхийг шалгах

- (iv) Түүнийг олгосон болон түүнтэй адил тухайн олон улсын байгууллагын гишүүн гадаадын бусад орны нийгэмлэгээс олгосон ТИР дэвтрийг хэрэглэн, гүйцэтгэж буй тээвэрлэлтэнд түүнд эрх олгосон улсад өөрийн гаргасан баталгааг бүрэн хэмжээгээр хариуцах
- (v) Өөрт нь эрх олгосон гэрээт талуудын эрх бүхий байгууллагуудаас хүлээлгэсэн үүрэг хариуцлагын хэрэгжилтийг даатгалын компани, даатгагчдын нэгдсэн сан буюу санхүүгийн баталгааны гэрээ нь түүний олгосон болон түүнтэй адил тухайн олон улсын байгууллагын гишүүн гадаадын бусад орны нийгэмлэгээс олгосон ТИР дэвтрийг хэрэглэн гүйцэтгэж буй тээвэрлэлтэнд холбогдох хариуцлагыг нь бүрэн төлөөлнө. Даатгалын болон санхүүгийн баталгааны гэрээний хүчин төгөлдөр хугацаа дууссан тухай мэдээлэх хугацаа нь зүйл (е)-д дурдсан бичгээр үйлдсэн хэлэлцээр буюу хууль эрхийн аливаа баримтын хүчин төгөлдөр хугацаа дууссаныг мэдээлэх хугацаанаас өмнө байх ёсгүй. Даатгалын буюу санхүүгийн гэрээний баталгаажуулсан хуулбар, мөн түүнчлэн цаашид түүнд оруулсан бүх өөрчлөлтийг хэрэв шаардлагатай бол Англи, Франц буюу орос хэлээр хийсэн орчуулгын баталгаажуулсан эх бичгийн хамтаар хадгалуулахаар ТИР-ийн Гүйцэтгэх Зөвлөлд явуулна.

1(f),(v) зүйлд өгөх тайлбар

a/ Олон улсын даатгалын системийн үйл ажиллагаа нь түүний үйлчигээний хүрээнд хамрагддаг Нийгэмлэгт хэрхэн үйлчилж буйд нь НҮБ-ын Европын эдийн засгийн Олон Улсын Тээврийн Холбоо хяналт тавина. Тухайн нийгэмлэг нь нэг талаас олон улсын хэмжээнд өргөн хүрээтэй даатгагчид (түвшин 3) ба нөгөө талаас даатгалын үр шимийг хүртэгч болох OAX /IRU/ –ны гишүүн нийгэмлэг нэг бүрийн хооронд байгуулсан даатгалын бүрэн хэмжээний гэрээний эх бичгийн баталгаажуулсан хуулбарыг гэрээт талуудын эрх бүхий байгууллагуудад өргөн барина. Олон улсын даатгагчид, нийгэмлэг болон OAX-ны төлөөлөгчид гарын үсэг зурсан энэхүү гэрээ нь нийгэмлэгийн зүгээс эрх бүхий байгууллагуудын шаардлагыг хангах бүх харицлагыг өөртөө агуулах бөгөөд түүнд даатгалын нөхцөл, эцсийн хугацаа ба уг гэрээг цуцлах боломжийн үндэслэл зэргийг зааж өгнө. Даатгалын энэхүү бүрэн хэмжээний гэрээ нь ТИР системд оролцож буй үндэсний бүх нийгэмлэгт адилхан үйлчилнэ. Хэрэв Конвенцийн гэрээт талуудын аль нэг нь үндэсний хууль тогтоомжоор үндэсний нийгэмлэгт даатгалын бүрэн хэмжээний гэрээнд даатгуулагч болж гарын үсэг зурахыг хориглосон байвал үүнийг онцгой тохиолдол гэж үзэн, түр зуурын үндсэн дээр даатгалын бүрэн хэмжээний гэрээг OAX, түүнд оролцдог нийгэмлэг болон гуравдагч этгээдийг зөвхөн OAX-ны төлөөлөгч төлөөлөн нэг талаас, мөн түүнчлэн олон улсын даатгагчдын төлөөлөгч нөгөө талаас гэрээ байгуулж гарын үсэг зурж болно. Энэхүү түр зуурын нөхцөл нь баталгаа гаргагч нийгэмлэгийн Конвенцид тодорхойлсон хариуцлагыг өөрчлөхгүй.

b/ Гэрээт Тал тус бүрийн эрх бүхий байгууллагууд нь өмнө “a”-д дурьдсан даатгалын бүрэн хэмжээний гэрээний баталгаажуулсан хуулбарыг тэр даруйд нь Конвенцийн хавсралт 9-ийн 1р хэсгийн (1e) зүйлийн дагуу Нийгэмлэг ба Гэрээт Талуудын эрх бүхий байгууллагуудын хооронд бичгээр үйлдэж байгуулсан хэлэлцээр буюу өөр ямар нэгэн баримтын баталгаажуулсан хуулбарын хамтаар ТИР-ийн Гүйцэтгэх Зөвлөлд явуулна.

c/ Өмнөх (a)-д дурьдсан бүрэн хэмжээний гэрээнд оруулсан аливаа өөрчлөлтийн талаар холбогдох нийгэмлэгүүд болон OAX тэр даруйд нь Гэрээт Тал нэг бүрийн эрх бүхий байгууллагууд ба ТИР-ийн Гүйцэтгэх Зөвлөлд мэдээлж байх шаардлагатай.

d/ Өмнөх (a)-д дурьдсан даатгалын бүрэн хэмжээний гэрээний үйлчлэх хугацаа дууссаныг мэдээлэх хугацаа нь зургаан сар байна. (TRANS/WP. 30/AC. 2/51, зүйл 17 ба 19; TRANS/WP. 30/AC. 2/49; хавсралт-2; TRANS/WP. 30/1998/17, зүйл 6-9; TRANS/WP.

30/1998/11, зүйл 36-36; TRANS/WP. 30/1998/7)

(vi). ТИР горимоор ажилласантай холбоо бүхий гүйцэтгэлийн бүх бичиг баримт, тооцоог эрх бүхий байгууллагуудаас шалгахад тэдгээрийг саадгүй үзүүлэх

(vii). ТИР дэвтрийг зүй зохистой бусаар буюу залилангийн хэлбэрээр ашигласан тохиолдолд маргааныг үр дүнтэй зохицуулах аргыг хүлээн зөвшөөрөх

(viii). Энэхүү наад захын нөхцөл шаардлагын аль нэгийг ноцтой буюу нэг бус удаа зөрчихөд л ТИР дэвтэр олгох зөвшөөрлийг хураана гэдгийг хүлээн зөвшөөрөх

(ix). Конвенцийн 38-р зүйл болон энэхүү хавсралтын 2-р хэсгийн заалтын дагуу холбогдох этгээдийг хасах талаарх тухайн нийгэмлэгийг томилсон Гэрээт Талын эрх бүхий байгууллагын шийдвэрийг чанд баримтлах

(x). ОАХ-ны удирдлагын Хороо ба Гүйцэтгэх Зөвлөлийн бүх шийдвэрийг тухайн Нийгэмлэгийг томилсон Гэрээт Талын эрх бүхий байгууллагууд хүлээн авч байгаатай адил хэмжээнд үнэнчээр биелүүлэхээ илэрхийлэх

2. Энэхүү наад захын нөхцөл шаардлагыг ноцтой буюу нэг бус удаа зөрчсөн тохиолдолд тухайн нийгэмлэгийг томилсон Гэрээт Талууд ТИР-ийн дэвтэр олгох зөвшөөрлийг нь хураана.
3. Аливаа нийгэмлэгт дээр дурьдсан нөхцлүүдийн дагуу олгогдсон зөвшөөрөл нь Конвенцийн хүрээнд тухайн нийгэмлэгт ногдуулах үүрэг, хариуцлагад хамаарахгүй.
4. Дээр дурьдсан наад захын нөхцөл шаардлагууд нь Гэрээт Талуудаас тогтоож болох нэмэлт нөхцөл, шаардлагад хамаарахгүй.

II хэсэг

Хуулийн этгээд, бие хүмүүст ТИР дэвтэр эзэмшихийг зөвшөөрөх нь

Наад захын нөхцөл, шаардлага

1. ТИР ажиллагаанд оролцох хүсэлт бүхий этгээд нь хамгийн наад захын дараах нөхцөл, шаардлагыг хангасан байх шаардлагатай. Үүнд:
 - (a). Олон улсын харилцаанд тээвэрлэлт гүйцэтгэх туршлагатай буюу үгүй гэхэд тийм боломжтойг нь гэрчлэх нотолгоо байна. /Олон улсын тээвэрлэлт хийх лиценз г.м/
 - (b). Санхүүгийн байдал нь тогтвортой байх
 - (c). ТИР Конвенцийг ашиглах мэдлэгтэй байх
 - (d). Гаалийн дүрэм, татварын хууль тогтоомжийн ноцтой буюу давтан гаргасан зөрчилгүй байх
 - (e). Нийгэмлэгийн өмнө тухайн этгээд нь бичгээр гаргасан хүлээх үүрэгтээ доорхи зүйлийг оруулсан байх. Үүнд:
 - Конвенцид тусгагдсан гаалийн бүх горим журмыг илгээгч, завсрын болон хүрэх газрын гаальд чанд баримтлах

- Хэрэв Конвенцийн 8.7 зүйлийн дагуу эрх бүхий байгууллагууд шаардвал Конвенцийн 8.1 ба 8.2 зүйлд дурьдсан хэмжээний төлбөрийг төлөх
- Дээр дурьдсан хамгийн наад захын нөхцөл, шаардлагын тухай мэдээллийг нийгэмлэгийн зүгээс үндэсний хууль тогтоомжийн хүрээнд шалгахад нь татгалзахгүй байна.

2. Хэрэв эрх бүхий байгууллагууд нь өөрөөр шийдээгүй бол Гэрээт Талуудын эрх бүхий байгууллагууд болон нийгэмлэг өөрөө ТИР горимоор ажиллахад зориулсан нэмэгдэл ба илүү хязгаарлагдмал нөхцөл, шаардлагыг тавьж болно.

Горим

3. Өмнөх зүйл 1 ба 2-т өгөгдсөн хамгийн наад захын нөхцөл шаардлагын үндсэн дээр ТИР ажиллагаанд орох зөвшөөрөл авах зорилгоор Гэрээт Талууд нь үндэсний хууль тогтоомжийн дагуу баримтлах журмыг тодорхойлно.

3-р зүйлийн тайлбар

9.11.3 Зөвшөөрөл олгох Хороо

Эрх бүхий байгууллагууд, үндэсний Нийгэмлэг болон сонирхогч бусад байгууллагын төлөөлөл бүрэлдэхүүнд нь орсон байх зөвшөөрөл олгох үндэсний Хороо байгуулахыг зөвшөөрнө.

(ECE/ TRANS/17/Amend. 19, 1999оны 2-р сарын17нд хүчин төгөлдөр болсон)

4. ТИР дэвтэр ашиглах зөвшөөрөл олгосон буюу зөвшөөрлийг цуцалсан өдрөөс эхлэн нэг 7 хоногийн хугацаанд эрх бүхий байгууллагууд нь хавсаргаж буй зөвшөөрлийн загварын (MAF) дагуу ТИР-ийн гүйцэтгэх зөвлөлд тухайн этгээд нэг бүрийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг явуулна.
5. Нийгэмлэг нь жил бүр зөвшөөрөл авсан, мөн түүнчлэн зөвшөөрлийг нь цуцалсан этгээдүүдийн шинэчилсэн жагсаалтыг 12-р сарын 31-ний байдлаар гаргаж, нэг 7 хоногт багтаан эрх бүхий байгууллагуудад явуулна. Эрх бүхий байгууллагууд нь энэхүү жагсаалтын хуулбарыг ТИР-ийн Гүйцэтгэх Зөвлөлд явуулна.
6. ТИР горимоор ажиллах зөвшөөрөл нь Нийгэмлэгээс ТИР дэвтрийг авах эрх болохгүй.
7. Дээр дурьдсан хамгийн наад захын нөхцөл, шаардлагын дагуу хэн нэгэн этгээдэд олгосон ТИР дэвтрийг ашиглах зөвшөөрөл нь тухайн этгээдийн Конвенцийн нөхцлөөр хүлээх үүрэг, хариуцлагад хамаарахгүй.

II хэсэгт өгөх тайлбар, Горим

Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа

Конвенцийн хавсралт 9-ийн 2-р хэсгийн дагуу ТИР дэвтэр ашиглах зөвшөөрлийг хэн нэгэн тухайн этгээдэд олгохдоо тухайн этгээдийн байнга оршин суудаг буюу түүнийг суурьшуулсан газарт байрлалтай Гэрээт Талын эрх бүхий байгууллагууд нь энэхүү этгээд нь гаалийн хууль тогтоомжийг ноцтой буюу дахин давтан зөрчил гаргасан тухай гэрээт нөгөө талаас хэлэлцээрийн 38.2 зүйлийн дагуу мэдээлсэн аливаа мэдээллийг судалж үзэх шаардлагатай. Иймээс ийм мэдээлэл нь аль болох тодорхой баримтыг агуулсан байвал зохино. Энэ тохиодолд л тухайн этгээдийн байнга оршин суудаг буюу түүнийг суурьшуулсан газарт байрлалтай Гэрээт Талд асуудлыг сайтар авч үзэх боломж олгоно.

(TRANS/WP. 30/196. Зүйл76; TRANS/WP. 30/200, зүйл 68;)

Үндэсний тээвэрлэгчийг ТИР горимоос хасах нь

Өөрийн байнга оршин суудаг буюу түүнийг суурьшуулсан улсын нутаг дэвсгэрт гаалийн хууль, дүрмийн ноцтой зөрчил гаргасан гэж үзсэн үндэсний тээвэрлэгчийг ТИР горимоос хасахад хүрвэл гаалийн байгууллагаас Конвенцийн 38.1 зүйлийг харгалзахын зэрэгцээ, мөн 6.4 зүйл болон хавсралт 9-ийн II хэсгийн 1(d) зүйлийг ашиглан шийдвэрлэхийг зөвлөнө.

ЗӨВШӨӨРЛИЙН ЗАГВАР МАЯГТ (ЗЗМ)

Улс:

Нийгэмлэгийн нэр:

Эрх бүхий байгууллага:

Үндэсний Нийгэмлэг ба / буюу эрх бүхий байгууллага бөглөнө.								
Олгосон хувийн дугаар	Тээвэрлэгчийн байгууллагын нэр	Байгууллагын хаяг	Хэнтэй хэрхэн харьцах (утас, факс, цахилгаан шуудан)	Байгууллагын бизнес бүртгэлийн буюу лицензийн дугаар Бусад мэдээлэл*	Өмнө нь зөвшөөрөл авч хураалгаж байсан эсэх**	Зөвшөөрөл олгосон огноо**	Зөвшөөрлөө хураалгасан огноо**	Тамга / гарын үсэг
...								
...								
...								

* Хэрэв бий бол

** Тохиолдол бүрт

Тухайн этгээдийг дамжиж эрх бүхий байгууллагаас түүнд зөвшөөрөл олгохыг хүсч буй Нийгэмлэг нь наанадаж доорхи мэдээллийг өгвөл зохино. Үүнд:

- Тухайн этгээдэд баталгаа гаргагч нийгэмлэгээс олгосон (бүрэлдэхүүнд нь өөрөө ордог олон улсын байгууллагатай харьцаж) хувийн дугаар;
- Хувиараа хөдөлмөр эрхлэгчийн буюу байгууллагын нэр, хаяг, (бизнесийн байгууллагын хувьд мөн хариуцах менежерийн утас);
- Хэнтэй хэрхэн харьцах (ОАТ-ийн ажиллагааны тухай мэдээллийг гаалийн байгууллага ба Нийгэмлэгт явуулах эрх бүхий хүн, түүний утас, факс, цахилгаан шуудан);
- Коммерийн бүртгэлийн дугаар буюу Олон улсын тээвэрлэлт гүйцэтгэх лиценз, мөн бусад мэдээлэл (хэрэв бий бол);

- Өмнө нь зөвшөөрөл аваад түүнийг хураалгаж байсан бол хэдийд ямар хугацаагаар юунаас болсон зэргийг тохиолдол бүрээр бичих;